

GOBI

ГОВЬ ХУВЬЦААТ КОМПАНИ

# ЖИЛИЙН ТАЙЛАН

2024



# АГУУЛГА


1. **МАНАЙ КОМПАНИ**
   - Компанийн ерөнхий танилцуулга ... 7
   - Түүхэн замнал ... 8
   - ТУЗ-ийн даргын мэндчилгээ ... 10
   - Гүйцэтгэх захирлын мэндчилгээ ... 12
2. **2024 ОНД БИД**
   - Бидний амжилт, онцлох үйл явдлууд ... 16
   - Rebranding буюу брэндийн цогц шинэчлэлт ... 18
   - 2024 оны санхүүгийн үр дүн ... 20
   - Санхүүжилтийн мэдээлэл ... 26
   - Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл ... 27
3. **БИДНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА**
   - Дотоод зах зээл ... 32
   - Гадаад зах зээл ... 34
   - Программ хөгжүүлэлт, дижитал шилжилт ... 37
   - Үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн шинэ технологи, бүтээгдэхүүн хөгжүүлэлт ... 38
   - Коллекцууд ... 43
   - Брэндийн бүтэц ... 45
4. **ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ (БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЗАСАГЛАЛ)**
   - Тогтвортой хөгжлийн удирдлага ... 48
   - Байгаль орчин ... 49
   - Нийгэм ... 57
   - Засаглал ... 69
   - Засаглалын бүтэц, үйл ажиллагаа ... 70
   - Оролцогч талуудтай хамтын ажиллагаа ... 73
   - Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийн үнэлгээний үр дүн ... 76
   - Хувьцаа эзэмшигчид ... 77
   - Нэгдмэл сонирхолтой хуулийн этгээд, эцсийн өмчлөгчийн мэдээлэл ... 78
   - Хувьцаа эзэмшигчдийн хурал ... 79
   - Төлөөлөн удирдах зөвлөл ... 80
   - Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны ажлын тайлан ... 86
   - Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодын тайлан ... 90
   - Дотоод хяналтын тогтолцоо ... 95
   - Говь группийн бүтэц ... 106
   - Менежмент багийн удирдлагууд ... 108
   - Хувьцааны арилжааны мэдээлэл ... 111
   - Ногдол ашиг ... 112
5. **ГОВЬ ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУДЫН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**
   - Хараат бус аудиторын тухай мэдээлэл ... 115
   - Говь ХК болон түүний охин компаниудын аудитлагдсан нэгтгэсэн санхүүгийн тайлан ... 116



# МАНАЙ КОМПАНИ



# КОМПАНИЙН ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА

| | | |
|---|---|---|
| **Компанийн оноосон нэр:** | “Говь” Хувьцаат Компани | |
| **Үйл ажиллагааны чиглэл:** | Ямааны ноолуурт цогц боловсруулалт хийж, бүтээгдэхүүн үйлдвэрлэн борлуулах | |
| **Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр:** | Монголын Хөрөнгийн Бирж | |
| **Компанийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг:** | 780,112,500 | |
| **Компанийн удирдлага:** | ТУЗ-ийн дарга: Д.Гэрэлмаа<br>Гүйцэтгэх захирал: Б.Амарсайхан | |
| **Үүсгэн байгуулагдсан огноо:** | 1981 оны 9 сарын 5 | |
| **Ажилтнуудын тоо:** | 1,652 | |
| **Дэлгүүрийн тоо:** | **Дотоод**<br>Улаанбаатар хот 2<br>Дархан хот 1<br>Онлайн дэлгүүр 1 | **Гадаад**<br>Охин компани 5<br>Салбар дэлгүүр 2<br>Франчайз дэлгүүр 8<br>Онлайн дэлгүүр 6 |

**Үйлдвэрийн хүчин чадал:**




Жилд нийт **2.5 сая ширхэг** бэлэн бүтээгдэхүүн

# ТҮҮХЭН ЗАМНАЛ

**1981**
Ямааны ноолуур, тэмээний ноос боловсруулах үйлдвэрийн машин тоног төхөөрөмжийн угсралт, тохируулгын ажлыг гүйцэтгэн, технологийн шугамыг ашиглалтад хүлээн авч, Монгол-Японы хамтын ажиллагааны хүрээн дэх анхны байгууламж Говь үйлдвэр үүд хаалгаа нээлээ.

**1987**
Компьютерын автомат удирдлага бүхий Япон улсын SET-092сүлжих машиныг үйлдвэрт суурилуулав

**1991**
Олон улсын ISO-9000 стандартыг үе шаттайгаар нэвтрүүлж, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний 98%-ийг экспортлон Олон улсын чанарын цом,гэрчилгээ авсан Монгол улсын анхны үйлдвэр боллоо

**1993**
Монгол Улсын Засгийн газрын Өмч Хувьчлалын Комиссын тогтоолоор Говь ҮҮГ-ыг Говь ХК болгон зохион байгуулж, МХБ-д бүртгүүлэн, нийт дүрмийн сангийн 25.1% буюу 1,919,061 ширхэг хувьцаа нь хөрөнгийн биржээр арилжаалагдсан.

**1997**
Монголд анх удаа ноос ноолууран хөнжил, ноолууран давуу, драп, нарийн номерын ээрмэл утас үйлдвэрлэх "Говь-2" үйлдвэрийг ашиглалтад хүлээн авав.

**1998**
Гадаад зах зээлээ өргөжүүлэн Япон улсад "Алтай", Бельги улсад "Gobi Europe", АНУ-д "Gobi-USA" зэрэг охин компаниуд байгуулж, дэлхийн 30 гаруй оронтой түншийн харилцаа тогтоов.

**2000**
Утас будах технологи нэвтрүүлэв.Орчин үеийн компьютерын системд холбогдсон STOLL-330 сүлжих машиныг суурилуулав.

**2007**
Говь компанийн төрийн өмчлөлд байсан 73.45%-ийн хувьцааг "ЭФ СИ АЙ" ХХК Олон улсын нээлттэй дуудлага худалдаагаар худалдан авснаар Говь ХК хувийн эзэмшилд бүрэн шилжлээ.

**2008**
Үйлдвэрийн дэргэдэх Төв дэлгүүрийн барилгын дизайныг Японы алдарт архитектурч Сако Кейчиро хийж, шинэ дэлгүүр 6 сард нээлтээ хийлээ.

**2009**
Японы Токио хотод салбар дэлгүүрээ нээлээ. Италийн "VVA Consulting Company"-тай хамтран ажиллах гэрээг байгууллаа. Говь Үйлдвэрт техник, технологийн шинэчлэлтүүдийг үе шаттайгаар хийсэн.

**2010**
Говь үйлдвэр байгуулагдсаны 30 жилийн түүхт ойн хүрээнд Италийн алдарт загвар зохион бүтээгч Саверио Палателлатай хамтран ажиллах гэрээг байгууллаа. Монголын ноолуурын салбарт анх удаагаа Принт технологийг нэвтрүүлэв.

**2009**
Үйлдвэрлэлийн хүчин чадлаа 2 дахин нэмэгдүүлэв. Италийн алдарт хувцас загвар зохион бүтээгч Саверио Палателлатай хамтарсан анхны коллекци "Gobi by Saverio Palatel-la" коллекци худалдаанд гарлаа."Говь" ХК-ийн 30 жилийн ойг тэмдэглэв.

**2012**
Улаанбаатар хотын төвд Төв шуудангийн урд шинэ салбар дэлгүүрээ нээж хэрэглэгчдэдээ улам ойртлоо. Gobi by Saverio Palatella 2012 оны Намар, Өвлийн шинэ коллекцио гаргав.

**2013**
Үйлдвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлж Whole Garment буюу оёдолгүй сүлжмэл бүтээгдэхүүний шинэ технологийг нэвтрүүлэв.

**2014**
Монгол ямааны ноолуурын үндсэн 4 өнгө болох цагаан, цайвар шаргал, бор, хөх саарал өнгийн ноолуурыг цайруулж будахгүйгээр байгалийн өнгөөр нь бэлэн бүтээгдэхүүн болгон гаргасан "Gobi-Mongolian Organic Cashmere "брэндийг худалдаанд гаргалаа.

**2015**
Японы алдарт Киосера компанийн үндэслэсэн АМЁБ менежментийг бие даан нэвтрүүлж эхэллээ.

**2016**
100% ноолууран пальтоны үйлдвэрлэлээрээ дэлхийд №1 болно гэдгээ олон нийтэд зарлалаа. ХБНГУ-д анхны албан ёсны салбар дэлгүүрээ нээлээ.

**2017**
Оёмлын шинэ үйлдвэрийг ашиглалтад оруулан 100,000 ширхэг ноолууран пальто, пиджак үйлдвэрлэх хүчин чадалтай боллоо. Интернэт худалдааг эхлүүлж, өөрийн онлайн худалдааны www.gobicashmere.com гэсэн сайттай болсон.

**2018**
Ээрмэлийн үйлдвэрт Италийн Bigagli мөлхөө ээрэх машиныг шинээр нэвтрүүлж, сүлжмэлийн бүх утсыг мөлхөө ээрэхэд шилжүүлж, утасны чанарыг сайжрууллаа. Мөн ноолууран пиджакийн масс үйлдвэрлэлийг эхлүүлж, дэлхийд ноолууран пиджак үйлдвэрлэлээрээ тэргүүллээ.

**2019**
Говь ХК нь Гоёо ХХК-г нэгтгэн авч, салбарын хамгийн том нэгдлийг амжилттай гүйцэтгэлээ.

**2020**
Говь ХК нь Төрийн дээд шагнал Сүхбаатарын Одонгоор шагнуулав. Онлайн сувгуудыг шинээр Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Франц Улс, Бүгд Найрамдах Польш Улс, Норвегийн Вант Улс, Шведийн Вант Улс, Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын зах зээлд тус тус нээлээ.

**2021**
Говь ХК-ийн 1,500 ажилтан компанийнхаа хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагч ажилтан боллоо.

**2022**
Төлөөлөн удирдах зөвлөлийн зүгээс Тогтвортой хөгжлийн үүрэг амлалтыг баталж, компанийн бүхий л үйл ажиллагаанд Байгаль орчин, Нийгэм, Засаглалын (БОНЗ)-ын хүрээнд тогтвортой хөгжлийн үйл ажиллагаар өргөжүүлэн ажиллах эхлэлийг тавилаа. Нэгдсэн удирдлагын тогтолцооны ISO 14001:2015 болон ISO 45001:2018 стандартын баталгаажуулалтыг авав.

**2023**
Ноолууран бүтээгдэхүүний хөгжлийг нэг шатаар ахиулсан Монголдоо анхдагч ноолууран гутлыг үйлдвэрлэн хэрэглэгчдэд хүргэж эхлэв. Мөн хөдөө орон нутаг дах анхны салбар үйлдвэрээ Хэнтий аймагт нээлээ.

**2024**
**Олон улсад брэнд танигдалтаа нэмэгдүүлж, зах зээлээ тэлэх зорилготойгоор Rebranding хийж ГОВЬ брэнд бэлгэ тэмдэг, шинэчилсэн лого ба шинэ өнгө төрхтэй болов. Мөн компанийн хэмжээнд системийн шинэчлэлтийг хийж PLM, ERP, MES системүүдээс гадна Монгол Улсын хөнгөн үйлдвэрийн салбартаа анх удаа Conveyor Belt буюу дамжлагын системийг амжилттай нэвтрүүлэн ашиглаж эхлэв.**

# ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГЫН МЭНДЧИЛГЭЭ



Хүндэт хувьцаа эзэмшигчид та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе.

Говь ХК нь 1981 онд үүсгэн байгуулагдаж, 1993 онд нээлттэй хувьцаат компани болсон бөгөөд Монголын хөрөнгийн биржийн ТОП-20 жагсаалтад багтдаг компанийн хувьд олон улсын засаглалын сайн туршлагыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн, хувьцаа эзэмшигч болон бүхий л оролцогч талуудынхаа эрх ашгийг хамгаалж, мэдээллийн ил тод байдлыг хангаж, засаглалын тогтолцоогоо тасралтгүй сайжруулахад анхаарч ажилласаар ирсэн билээ.

Үүний үр дүнд Санхүүгийн Зохицуулах Хорооноос батлагдсан “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтээр 2024 онд Монгол Улсын нээлттэй хувьцаат компаниудыг 2 дахь жилдээ дараалан тэргүүлснийг дуулгахад таатай байна.

Өнгөрөгч оны 3-р сард компанийн удирдлагын түвшинд томоохон өөрчлөлт орж, 2008 оноос хойш Гүйцэтгэх захирлаар ажилласан Ц.Баатарсайхан өөрийн хүсэлтээр чөлөөлөгдсөн тул Говь Кашмер Европ ХХК-ийн удирдлага, Говь ХК-ийн Стратеги, өсөлт хөгжил хариуцсан захирал зэрэг удирдах албан тушаалуудыг хашсан ур чадвар болон туршлагыг үнэлж Б.Амарсайханыг томилов.

Шинээр томилогдсон Гүйцэтгэх захирал эрч хүчтэй, шинэ үеийн төлөөлөл болсон чадварлаг залуу удирдлагын хувьд ГОВЬ брэндийг дэлхийн зах зээлд шинээр таниулах зорилгоор rebranding буюу брэндийн стратегийн шинэчлэлтийг цогцоор нь хийж, бүтцийн өөрчлөлт, дижитал шилжилт, эмх цэгц болон мэдээллийн урсгалын сайжруулалт тэргүүтэй томоохон төслүүдийг хэрэгжүүлэн компанид олон дэвшилтийг гаргаж байгаа бөгөөд ТУЗ-ийн зүгээс Гүйцэтгэх захирлын үйл ажиллагаатай тухай бүр танилцан, чиг удирдлагаар хангаж ажиллалаа.

Бид 2024 онд “Хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөр”-ийнхөө хүрээнд жижиг хувьцаа эзэмшигчдэдээ зориулан шинэ коллекцитой танилцах арга хэмжээ, үйлдвэртэй танилцах аялал, компанийн удирдлага болон ТУЗ-ийн хараат бус гишүүд хувьцаа эзэмшигчдийн төлөөллийг хүлээн авч нээлттэй хэлэлцүүлэг өрнүүлэх гэх мэт үйл ажиллагааг зохион байгуулан компанийн үйл ажиллагаатай танилцуулж тэдний оролцоог нэмэгдүүлэх ажлуудыг хэрэгжүүлсэн. 2024 оны сүүлийн байдлаар манай компанийн хувьцаа эзэмшигчдийн тоо 4.8%-аар нэмэгдэж 25 мянга болж бидэнд итгэл хүлээлгэн хөрөнгө оруулж буй хувьцаа эзэмшигчдийн тоо улам өссөөр байгаад баяртай байна.

Манай компани үйл ажиллагааныхаа бүхий л шатанд тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг шингээн, байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэл явуулахыг зорьдог бөгөөд ТУЗ-ийн зүгээс байгаль орчин, нийгэм, засаглал (БОНЗ)-ын асуудлуудад нухацтай анхаарч, ТУЗ-өөс баталсан тогтвортой хөгжлийн үүрэг амлалтынхаа хэрэгжилтэд хяналт тавин, удирдлагын багийг амжилттай чиглүүлэн ажилласан.

Тус хүрээнд хэрэгжүүлсэн онцлох ажлуудын нэг бол Тогтвортой хөгжлийн цогц бодлогыг боловсруулж эхлэн, мэргэжлийн хараат бус зөвлөх компанитай хамтран ТУЗ болон менежмент багийн түвшинд шат дараалсан сургалт, уулзалтуудыг зохион байгуулж Тогтвортой хөгжлийн стратегийн бодлого боловсруулж, уур амьсгалын өөрчлөлт, хүний эрх, жендерийн тэгш байдал, нийгмийн хариуцлагын чиглэлээр бодлогуудаа тодорхойлон баталлаа.

Бид эдгээр бодлогуудынхаа нийцлийг хангах, компанийн үйл ажиллагааны үе шат бүрт тусган хэрэгжүүлж тогтвортой хөгжлийн үйл ажиллагаагаа үнэлж дүгнэн, тасралтгүй сайжруулан ажиллах зорилгоор олон улсын чиг хандлага болон засаглалын сайн туршлагуудаас суралцан ажиллаж байна.

Өнгөрсөн оны ололт амжилтаас онцлон дурдвал, хүний нөөцийн салбарын чуулган болох Mongolian Labor Market Summit: Good Workplace Awards 2024 арга хэмжээний үеэр “Эмэгтэйчүүдийн карьерын өсөлтийг дэмжигч шилдэг ажил олгогч”-оор шалгарсан нь 70 гаруй хувь нь эмэгтэй ажилтнуудаас бүрддэг манай компанийн хувьд ажилтнуудынхаа хөгжлийг дэмжих, тэгш боломжийг хангах бодлогын хэрэгжилтийг улам бүр бататгасан үнэ цэнтэй шагнал боллоо.

Манай компанийн үнэт баялаг бол ажилтнууд, хэрэглэгчид, түншүүд, хувьцаа эзэмшигчид болон оролцогч талууд билээ. Та бүхний дэмжлэг, итгэл бидний амжилтын үндэс болж, урагшлах урам зоригийг өгдөг гэдгийг энэ дашрамд онцлон тэмдэглэхийг хүсэж байна.

Цаашид бид олон улсын зах зээл дэх байр сууриа нэмэгдүүлэх, тогтвортой хөгжлийн бодлогыг тууштай хэрэгжүүлэх, хөрөнгө оруулагчидтайгаа илүү нээлттэй, үр дүнтэй хамтран ажиллах зэрэг зорилтуудыг дэвшүүлэн ажиллах болно.

Говь ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн зүгээс та бүхэнд ажлын эрүүл энх, өндөр амжилт, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе!

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

**Д.ГЭРЭЛМАА**

# ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ




Эрхэм хувьцаа эзэмшигчид, ажилтнууд, харилцагч, хамтрагчид та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе!

2024 он Говь ХК-ийн хувьд өөрчлөлт, шинэчлэл, өсөлтийн онцгой жил байлаа. 2024 оны эхэнд миний бие Гүйцэтгэх захирлын албан тушаалд томилогдож, 43 жилийн түүхтэй энэхүү компанийн удирдлагыг хүлээн авсан нь нэр төрийн хэрэг төдийгүй томоохон хариуцлага юм.

Миний хувьд компанийн суурь үнэт зүйлсийг хадгалж, шинэчлэл, өсөлтийг эрэлхийлэн, Монголын ноос ноолуурын салбарт тэргүүлэгч ГОВЬ брэндийг дэлхийд таниулж үйл ажиллагааны цар хүрээг тэлэх, тогтвортой хөгжил, технологийн шинэчлэлд суурилсан бодлого хэрэгжүүлэх зорилтыг дэвшүүлэн ажиллаж байна.

Говь ХК нь 2024 онд 247 тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой ажилласан ба үүнийг сегментээр задлавал дотоод борлуулалт 66%, экспортын борлуулалт 24%, гадаад борлуулалт 10%-ийг тус тус эзэлж байна.

Дотоод зах зээлийн хувьд борлуулалтыг дэмжих зорилгоор үнэнч хэрэглэгчдэд зориулсан урамшууллын хөтөлбөрийг нэвтрүүлж, төв дэлгүүрийн өнгө төрхийг бүрэн шинэчилж, хэрэглэгчдэд илүү ая тухтай үйлчилгээний орчин бүрдүүлсэн. Харин гадаад зах зээлийн хувьд маркетингийн стратегиа өөрчлөн, органик өсөлт, брэндийн үнэлэмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн маркетинг хийж, ашигт ажиллагаа сайжруулахад төвлөрч ажиллалаа.

2024 онд Говь ХК-ийг дэлхийн зах зээлд илүү өргөн хүрээнд таниулж, олон улсын түвшинд өрсөлдөхүйц компани болох зорилгоор Rebranding буюу брэндийн цогц шинэчлэлтийг хийснээр ГОВЬ брэнд анх удаа бэлгэ тэмдэгтэй болж, шинэчилсэн лого ба шинэ өнгө төрхтэйгөөр бүтээгдэхүүнээ хүргэж байна.

Мөн компанийн хэмжээнд 6S аргачлалыг нэвтрүүлэх замаар үйлдвэр болон оффисын орчинд эмх цэгцийг бүрдүүлж, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх, мэдээллийн урсгалыг сайжруулж, ажилтнуудын үр дүнтэй хамтын ажиллагааг бэхжүүлэх, шийдвэр гаргах хурдыг нэмэгдүүлж үр ашигтай менежментийг бий болгоход онцгойлон анхаарч ажилласан.

Бид бизнесийн үйл ажиллагаа автоматжуулж, ажлын гүйцэтгэлийг хурдасгах, бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор системийн шинэчлэлтийг дараагийн түвшинд гаргаж, нийт компанийн хэмжээнд SAP S/4 HANA-ERP системийг амжилттай нэвтрүүлэн ашиглаж эхэлсэн. Мөн Монгол Улсын хөнгөн аж үйлдвэрийн салбарын түүхэнд анх удаа MES болон дамжлагын системийг нэвтрүүлэн ашиглаж эхэлснийг дуулгахад таатай байна. Эдгээр нь үйлдвэрлэлийн үр ашиг, бүтээмжийг нэмэгдүүлэх, процессыг сайжруулах, санхүүгийн удирдлага, шийдвэр гаргалтыг оновчтой бөгөөд хурдан хийх боломжийг бүрдүүлэх юм.

Дизайн хөгжүүлэлтийн хувьд бүтээгдэхүүний нэр төрлийг өргөжүүлж, ноолууран гутлын олон шинэ загваруудаас гадна саравчтай малгай, цүнх, CashmereTECH куртка гэх мэт шинэ бүтээгдэхүүнүүдийг зах зээлд нэвтрүүлж, ноолуурын хэрэглээний цар хүрээг зогсолтгүй өргөжүүлснээр ноолуураар зөвхөн хувцас бус, олон төрлийн бүтээгдэхүүн хийж амьдралын хэв маягийг бүрдүүлэх боломжтой гэдгийг харуулж байна. Бид цаашид ч шинэлэг бөгөөд хэрэгцээнд нийцсэн бүтээгдэхүүн хөгжүүлж, зах зээлд нэвтрүүлэх зорилготой ажиллах болно.

Манай компанийн амжилт нь удирдлагын баг, ажилтан бүрийн хичээл зүтгэл, хэрэглэгчдийн итгэл, хувьцаа эзэмшигчдийн тууштай дэмжлэг, харилцагч түншүүдийн хамтын ажиллагааны үр дүн гэдгийг онцлон тэмдэглэмээр байна.

Ирээдүйд бид үнэт зүйлс болсон ажилтнуудынхаа хөгжил, оролцоог дэмжих, бүтээмж, сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх бодлогыг тууштай хэрэгжүүлж, Монголын ноолуурын салбарын тэргүүлэгчийн байр сууриа хадгалж, тогтвортой хөгжлийг эрхэмлэгч, инновацилаг компани байхын зэрэгцээ ГОВЬ брэндийг дэлхийн зах зээлд нэр хүндтэй брэнд болох зорилгодоо тууштай ажиллах болно.

Хамтдаа шинэ амжилтуудыг бүтээцгээе!

Хүндэтгэсэн,

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

**Б.АМАРСАЙХАН**



# 2024 ОНД БИД

# БИДНИЙ АМЖИЛТ, ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД

## 2-р сар



Монгол-Солонгосын политехникийн коллежтой “Говь Академи”-ийн хүрээнд хамтын ажиллагааны санамж бичиг байгуулав.

UNIDO-ийн тэтгэлгээр Олон улсын “OEKO-TEX STANDARD 100” гэрчилгээг Монголд анх удаа бэлэн бүтээгдэхүүн дээр гардан авав.



## 3-р сар



Гүйцэтгэх захирлыг шинээр томилох ёслолын арга хэмжээ болж, Гүйцэтгэх захирлаар Б.Амарсайхан томилогдов.

SAP S/4 HANA ERP системийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ашиглаж эхлэв.

Азийн Хөгжлийн Банктай хамтран “Уур амьсгалын өөрчлөлтөд малчдыг бүлгэмээр дасан зохицуулах, бэлчээрийн тогтвортой менежментийг бий болгох туршилтын төсөл”-ийг хэрэгжүүлэхээр хамтын ажиллагааны гэрээг үзэглэв.





Хөнгөн аж үйлдвэрийн 90 жилийн ойг угтсан нийт ажилтны баярын хурал зохион байгуулав.

## 4-р сар



Дотоод хяналтын лаборатори нь итгэмжлэгдсэн сорилтын лаборатори болов.

## 5-р сар

Дэлхийн №1 дэвшилтэт технологи бүхий Итали улсын “BIGAGLI” мөлхөө ээрэх машиныг амжилттай суурилуулж ээрмэлийн үйлдвэрийн хүчин чадлаа нэмэгдүүлэв.



## 6-р сар



“Flagship Store” буюу төв дэлгүүр өнгө төрхөө шинэчлэн нээлтээ хийв. Албан ёсны нээлтийн үйл ажиллагаар зохион байгуулж, хүрэлцэн ирсэн зочид үйлдвэрээр аялан бүтээгдэхүүн бий болох үйл явцтай танилцлаа.

## 7-р сар




Олон улсад брэнд танигдалтаа нэмэгдүүлж, зах зээлээ тэлэх зорилготойгоор Rebrand-ing-ийг оны эхнээс хийж эхэлсэн бөгөөд ГОВЬ брэндийн бэлгэ тэмдэг, шинэчилсэн лого ба шинэ өнгө төрхийг танилцуулав.

## 9-р сар

Хувьцаа эзэмшигчдийнээлжит үйлдвэртэй танилцах аяллыг амжилттай зохион байгуулав. Компанийн удирдлага ба ТУЗ-ийн гишүүдийн төлөөлөл хувьцаа эзэмшигчдийг хүлээн авч уулзлаа.





Хүний нөөцийн салбарын чуулган болох Mongolian Labor Market Summit: Good Workplace Awards 2024 арга хэмжээний үеэр “Эмэгтэйчүүдийн карьерын өсөлтийг дэмжигч шилдэг ажил олгогч”-оор шагнагдлаа.

## 10-р сар



Монгол Улсын хөнгөн аж үйлдвэрийн салбарын түүхэнд анх удаа MES (Manufacturing Execu-tion System) болон Conveyor Belt (дамжлагын систем)-ийг нэвтрүүлэх үйл явцыг эхлүүллээ.

Говь ХК “Ажилтан төвт байгууллага” болох зорилгоо тунхаглалаа.





Говь брэндийн 2025 оны намар, өвлийн коллекц “Шилдгийн шилдэг бүтээгдэхүүн”-ээр шагнагдлаа.

## 11-р сар



Говь брэнд FC Barcelona клубийн охин компани BLM болон түүний хамтрагч New Era компанитай албан ёсны онцгой эрх бүхий хамтын ажиллагааны гэрээ байгуулах хэлэлцээр амжилттай үргэлжилж байна.

## 12-р сар

Гаалийн Ерөнхий Газраас хэрэгжүүлж буй “Гаалийн итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжийн хөтөлбөр”-ийн хүрээнд Говь ХК албан ёсоор “Гаалийн итгэмжлэгдсэн аж ахуйн нэгж”-ийн гэрчилгээг гардан авлаа.





Говь ХК “Шилдэг шимтгэл төлөгч ажил олгогч”-оор шагнагдлаа.

## REBRANDING БУЮУ БРЭНДИЙН ЦОГЦ ШИНЭЧЛЭЛТ

Олон улсад брэнд танигдалтаа нэмэгдүүлж, зах зээлээ тэлэх зорилготойгоор 2024 онд rebranding хийж, ГОВЬ брэнд бэлгэ тэмдэг, шинэчилсэн лого ба шинэ өнгө төрхтэй болов.

GOBI

Ямаа | Малчин | Ажилтан | Хэрэглэгч

ГОВЬ-ийн шинэчлэгдсэн бэлгэ тэмдэг нь ноолууран бүтээгдэхүүн бий болох үйл явцын гол оролцогч талуудыг илтгэнэ.

**Truly Mongolian.**

Монгол улсын нийт айл өрхийн 25% нь малчин өрх байдаг.

Малчин өрхийн жилийн орлогын эх үүсвэрийн 1/3 нь ямааны ноолуураас бүрддэг.




| 1981-2005 | 2005-2012 | 2012-2018 | 2018-2014 | 2024 |
|---|---|---|---|---|

## БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО, СЕГМЕНТЭЭР /тэрбум төгрөг, %/




## БОРЛУУЛАЛТ. ЦЭВЭР АШИГ /тэрбум төгрөг/






# ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

## 2007 ОНООС ХОЙШ НИЙТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ 176.5 тэрбум төгрөг




2007 оны хувьчлалаас хойш өссөн дүнгээрээ нийт 176.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн. Үүнээс 2019 онд 60.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсний 23.2 тэрбум нь Говь ХК-ийн барилга байгууламж, тоног төхөөрөмж болон бусад хөрөнгө оруулалтад зарцуулагдсан бол үлдсэн 37.3 тэрбум төгрөг нь Гоёо ХХК-г нэгтгэсний дүнд үүссэн өсөлт байв.

## 2024 оны хөрөнгө оруулалт




2024 онд нийт 20.4 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийснээс 49% буюу 9.9 тэрбум төгрөг нь тоног төхөөрөмж, 13% буюу 2.7 тэрбум төгрөг нь барилга байгууламж, 29% буюу 5.9 тэрбум төгрөг нь биет бус хөрөнгө, 9% буюу 1.8 тэрбум төгрөг нь тавилга эд хогшил болон бусад биет хөрөнгөд зарцуулсан байна.

# ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛСЭН ТАТВАР ХУРААМЖ, ШИМТГЭЛ

Говь ХК нь 2007 оноос хойш зөвхөн Монголын татварын албанд нийт 269.9 тэрбум төгрөг төвлөрүүлсэн байна. Үүнээс 2024 онд 36.6 тэрбум төгрөгийн татвар хураамж, шимтгэлийг улсын төсөвт төлсөн. Үүнийг нэр төрөл болон онуудаар дэлгэрүүлэн харуулав.




# 2024 ОНЫ САНХҮҮГИЙН ГОЛ ҮЗҮҮЛЭЛТ

| ҮЗҮҮЛЭЛТ | Хэмжих нэгж | 2023 он | 2024 он | Өөрчлөлт | |
|---|---|---|---|---|---|
| | | | | тоо | хувь |
| **БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО** | сая.төг | 255,651 | **247,026** | (8,624) | -3% |
| Дотоод борлуулалт | сая.төг | 146,997 | **163,359** | 16,362 | 11% |
| Экспортын борлуулалт | сая.төг | 59,485 | **57,934** | (1,550) | -3% |
| Гадаад борлуулалт | сая.төг | 49,169 | **25,733** | (23,436) | -48% |
| Борлуулсан бүтээгдэхүүний тоо ширхэг | мян.ширхэг | 1,153 | **1,055** | (98) | -9% |
| **БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ӨРТӨГ** | сая.төг | 131,011 | **138,552** | 7,541 | 6% |
| **НИЙТ АШИГ** | сая.төг | 124,639 | **108,474** | (16,165) | -13% |
| Бохир ашгийн хувь | хувь | 49% | **44%** | -5% | -10% |
| Үйл ажиллагааны зардал | сая.төг | 124,142 | **110,473** | (13,670) | -11% |
| Маркетингийн зардал | сая.төг | 27,803 | **9,409** | (18,393) | -66% |
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АШИГ** | сая.төг | 497 | **(1,999)** | (2,496) | -502% |
| Үйл ажиллагааны ашгийн хувь | хувь | 0% | **-1%** | -1% | -516% |
| Үйл ажиллагааны бус зардал | сая.төг | 474 | **(425)** | (899) | -190% |
| Татварын өмнөх ашиг | сая.төг | 23 | **(1,574)** | (1,597) | -6905% |
| **ЦЭВЭР АШИГ/АЛДАГДАЛ** | сая.төг | (6,768) | **(3,657)** | 3,111 | 46% |
| Цэвэр ашгийн хувь | хувь | -3% | **-1%** | 1% | 44% |
| Нийт үйл ажиллагааны зардал | сая.төг | 255,154 | **249,025** | (6,129) | -2% |
| **ҮЙЛДВЭРЛЭЛ** | мян.ширхэг | 1,040 | **1,005** | (35) | -3% |
| Сүлжмэл бүтээгдэхүүн | мян.ширхэг | 742 | **653** | (89) | -12% |
| Нэхмэл бүтээгдэхүүн | мян.ширхэг | 264 | **323** | 59 | 22% |
| Оёмол бүтээгдэхүүн | мян.ширхэг | 34 | **29** | (5) | -14% |
| Пальто | мян.ширхэг | 18 | **16** | (2) | -9% |
| Пиджак | мян.ширхэг | 5 | **5** | (0) | -2% |
| Ээрмэл утас | тонн | 273 | **191** | (82) | -30% |
| **АЖИЛТНУУДЫН ТОО** | хүн | 1,765 | **1,652** | (113) | -6% |
| Нэг ажилтанд ногдох орлого | мян.төг | 144,844 | **149,532** | 4,687 | 3% |
| **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ** | сая.төг | 4,809 | **20,354** | 15,545 | 323% |
| **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | сая.төг | 311,950 | **304,820** | (7,130) | -2% |
| Банкны зээл | сая.төг | 237,319 | **228,136** | (9,183) | -4% |
| **НИЙТ ХӨРӨНГӨ** | сая.төг | 311,784 | **306,277** | (5,506) | -2% |
| Бараа материал | сая.төг | 142,521 | **122,708** | (19,813) | -14% |

### БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО /тэрбум төгрөг/




### ЦЭВЭР АШИГ /тэрбум төгрөг/




2024 онд 247 тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой ажилласан ба бүтцээр нь задалбал, сүлжмэл бүтээгдэхүүний борлуулалт 60%, нэхмэл болон оёмол бүтээгдэхүүн тус бүр 19%, бусад бүтээгдэхүүний борлуулалт 3%-ийг эзэлж байна. Компанийн 2024 оны цэвэр алдагдал 3.7 тэрбум төгрөг байсан ба өмнөх оноос 46%-аар алдагдлын хэмжээгээ бууруулсан үр дүнтэй байна. Тайлант үеийн алдагдал нь тайлант үеийн эцэс дэх өөрийн хөрөнгийн дүнгийн 30 хувиас хэтэрсэн байна.

### АШГИЙН ҮЗҮҮЛЭЛТ




### ӨР ТӨЛБӨР / EBITDA




2024 оны ашигт ажиллагааны гүйцэтгэлийг 2023 онтой харьцуулахад үйл ажиллагааны ашгийн хувь 1 пунктээр, EBITDA хувь 2 пунктээр, цэвэр ашгийн хувь 2 пунктээр тус бүр сайжирсан. Мөн өр төлбөр/EBITDA харьцаа сайжирч 5.7 болсон.

### НИЙТ ХӨРӨНГӨ /тэрбум төгрөг/




### БАРАА МАТЕРИАЛЫН ЭРГЭЦ /хоног/




2024 онд түүхий эдийн татан авалтыг хамгийн бага түвшинд хийж, нөөцөө бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлснээр бараа материалын эргэц хоног 2023 оноос 8%-аар буурч 349 хоног болж сайжирсан.

### ҮЙЛДВЭРЛЭСЭН ТОО /мянган ширхэг/




### БОРЛУУЛСАН ТОО /мянган ширхэг/




2024 онд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний тоо 3%, борлуулсан бүтээгдэхүүний тоо 9%-аар тус тус буурсан үзүүлэлттэй байна. Нэхмэл бүтээгдэхүүний хувьд үйлдвэрлэсэн нийт бүтээгдэхүүний 32%-г эзэлж байгаа нь өмнөх оноос 7 пунктээр өссөн үзүүлэлт юм.

### МАРКЕТИНГИЙН ЗАРДАЛ /тэрбум төгрөг/




2024 онд маркетингийн зардалд 9.4 тэрбум төгрөгийг зарцуулсан нь өмнөх оноос 66% буурсан үзүүлэлт байлаа. Нийт маркетингийн зардлын 83%-ийг гадаад зах зээлд зарцуулсан бөгөөд гадаад зах зээлийг идэвхжүүлэх маркетингийн зардлыг өмнөх оноос 70%-аар бууруулж 7.9 тэрбум төгрөгийг зарцуулсан. Гадаад зах зээлийн ROAS буюу 1 төгрөгийн маркетингийн зардлаас олж буй орлогын дүн 4.2 төгрөг болж сайжирсан. Охин компанийн ашигт ажиллагаар сайжруулах хүрээнд хямдралын хувийг 7.1 пунктээр бууруулсан.

### МӨНГӨН УРСГАЛ /тэрбум төгрөг/




2024 онд үйл ажиллагаанаас нийт 261.3 тэрбум төгрөг орсон ба 2023 онтой харьцуулахад 3% буурсан. Харин гарах мөнгөн урсгалын хувьд нийт 238.2 тэрбум төгрөг зарцуулсан ба үүнээс 92 тэрбум төгрөгийг үйл ажиллагааны зардалд, 82.6 тэрбум төгрөгийг бэлтгэн нийлүүлэгчдийн төлбөрт, 39.6 тэрбум төгрөгийг татварын зардалд, санхүүжилтийн зардалд 24.2 тэрбум төгрөг тус тус төлсөн. 2024 онд 16.7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн. Санхүүгийн цэвэр мөнгөн гүйлгээ -11.5 тэрбум төгрөг байна.

# САНХҮҮЖИЛТИЙН МЭДЭЭЛЭЛ

| Санхүүжүүлэгчийн нэр | Валют | Дуусах хугацаа | 2023.12.31 | | 2024.12.31 | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | мян.валют | мян.төг | мян.валют | мян.төг |
| **Банкны зээл** | | | | | | |
| Голомт банк (Урт хугацаат зээл) | MNT | 2025 | - | 13,333,333 | - | **3,333,333** |
| Голомт банк (Зээлийн шугам) | MNT | 2026 | - | 48,950,000 | - | - |
| | USD | 2026 | - | - | - | - |
| Голомт банк (Богино хугацаат зээл) | MNT | 2025 | - | - | - | **9,300,000** |
| Голомт банк (Богино хугацаат зээл) | MNT | 2025 | - | - | - | **10,400,000** |
| Хаан банк (Зээлийн шугам) | MNT | 2025 | - | 6,500,000 | - | - |
| Хаан банк (Урт хугацаат зээл) | MNT | 2024 | - | 4,202,775 | - | - |
| Хаан банк (Богино хугацаат зээл) | MNT | 2024 | - | 10,000,000 | - | - |
| Хас банк (Зээлийн шугам) | MNT | 2026 | - | - | - | **36,210,000** |
| Хас банк (Богино хугацаат зээл) | MNT | 2024 | - | 16,666,667 | - | - |
| Хас банк (Богино хугацаат зээл) | MNT | 2025 | - | - | - | **8,333,333** |
| Ариг банк (Богино хугацаат зээл) | MNT | 2024 | - | 14,500,000 | - | - |
| Азийн хөгжлийн банк (ADB) | USD | 2026 | - | - | **$ 14,400** | **49,251,600** |
| Азийн хөгжлийн банк (ADB) | USD | 2026 | $ 12,000 | 40,928,280 | **$ 9,600** | **32,834,400** |
| Олон Улсын Хөрөнгө Оруулалтын банк (IIB) | EUR | 2027 | € 8,000 | 30,333,280 | **€ 8,000** | **28,535,840** |
| Олон Улсын Хөрөнгө Оруулалтын банк (IIB) | EUR | 2027 | € 14,000 | 53,083,240 | **€ 14,000** | **49,937,720** |
| **Нийт /Банкны зээл/** | | | | **238,497,575** | | **228,136,227** |
| | | | | | | |
| **Бондын санхүүжилт** | | | | | | |
| Бонд (Богино хугацаат зээл) * | USD | 2025 | - | - | **$ 3,250** | **11,115,813** |
| **Нийт санхүүжилт** | | | | **238,497,575** | | **239,252,039** |

Монгол банкны ханш /төг/

| | 2023.12.31 | 2024.12.31 |
|---|---|---|
| USD | 3,410.69 | 3,420.25 |
| EUR | 3,791.66 | 3,566.98 |

* Говь ХК нь “Говь Бонд 2” санхүүжилт татах ажлын хүрээнд 2024 оны 4-р сарын 23-ны өдөр эрх бүхий байгууллагын тогтоолоор хаалттай хүрээнд эргэлтийн хөрөнгө, дахин санхүүжилт, хөрөнгө оруулалт хийх зорилгоор 12 сарын хугацаатай, жилийн 8.5%-ийн купонтой 16,800,000 ам.долларын бонд гаргах зөвшөөрөл авсан бөгөөд 2024 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаар 3,250,000 ам.долларын бондыг хөрөнгө оруулагчдаас татсан байна.



# ИХ ХЭМЖЭЭНИЙ ХЭЛЦЭЛ

Тайлант хугацаанд их хэмжээний хэлцэл хийгээгүй.

# СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ

| Огноо | Гэрээ хэлцлийн утга | Үнийн дүн | Гэрээний нөгөө тал | Гэрээний нөхцөл, болзол | Эхлэх огноо | Дуусах огноо | Хэлцэл баталсан |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2024.05.02 | Хаан банкны зээлийн эрх нээх гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах | Зээлийн эрхийн хэмжээг | Хаан Банк | Таван Богд Холдингс ХХК болон түүний охин компаниудтай хамтарсан зээлийн эрх нээх гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах | 2024.05.12 | 2025.05.25 | ТУЗ-ийн тогтоол №21 |
| 2024.12.31 | Зээлийн эрх нээх гэрээ байгуулах | 8 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсэн | Хаан банк | Таван Богд Холдингс ХХК болон түүний охин компаниудтай хамтран зээлийн эрх нээх гэрээ байгуулах | 2024.12.31 | 2027.12.31 | ТУЗ-ийн тогтоол №41 |

**Сонирхлын зөрчилтэй болон холбоотой талуудтай хийх хэлцэлд зөвшөөрөл олгох, хяналт тавих процесс**

Говь ХК-ийн “Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журам”-ын дагуу жил бүрийн эхэнд Компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай бараа, үйлчилгээ зах зээлийн үнэ, нөхцөлөөр худалдан авах болон худалдах хэлцэл хийхийг зөвшөөрсөн нэгдмэл сонирхолтой этгээдүүдийн жагсаалт, хэлцлийн төсвийг ТУЗ-ийн хараат бус гишүүдийн дийлэнх олонхын саналаар батална.

Дээрх журмын дагуу батлагдсан жагсаалтад ороогүй этгээдтэй хийх болон батлагдсан төсвөөс хэтэрсэн сонирхлын зөрчилтэй хэлцлийг хийх бүрд тухайлсан тогтоолоор ТУЗ-ийн хурлаар хэлэлцэн зөвшөөрөл олгодог.

ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэл, аудитын хороо нь Компанийн хэмжээнд хийгдэж буй сонирхлын зөрчилтэй хэлцэл нь батлагдсан төсвийн хүрээнд, зах зээлийн үнэ нөхцөлөөр, хуулийн дагуу хийгдэж байгаа эсэх дээр улирал бүрийн хорооны хурлаараа дамжуулан тогтмол хяналт тавьж ажилладаг.

2024 оны хувьд 2024 оны 1-р сарын 26-ны ТУЗ-ийн №03 тоот тогтоолоор холбоотой талуудын жагсаалт болон төсвийг батлаж, компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай бараа үйлчилгээ зах зээлийн үнэ, нөхцөлөөр худалдан авах болон худалдах зөвшөөрлийг олгосон Говь ХК-ийн нэгдмэл сонирхолтой хуулийн этгээдүүд болон эцсийн өмчлөгчийн талаарх мэдээллийг энэхүү тайлангийн 78-р хуудаснаас харж танилцах боломжтой.

## 2024 ОНЫ ХОЛБООТОЙ ТАЛУУДТАЙ ХИЙСЭН АЖИЛ ГҮЙЛГЭЭ БА ҮЛДЭГДЭЛ /мянган төгрөг/

### 1. ХОЛБООТОЙ ТАЛУУДЫН ДАНСНЫ ҮЛДЭГДЭЛ

Тайлант хугацааны эцэст холбоотой талуудын үлдэгдэл дараах байдалтай байна:

| | 2023 | 2024 |
|---|---|---|
| **Холбоотой талаас авах авлага** | | |
| Бусад холбоотой талууд | 129,632 | **70,162** |
| **Холбоотой талд өгөх өглөг /Богино хугацаат/** | | |
| Дээд шатны хяналт этгээд | 13,642,760 | **25,309,850** |
| Зэргэлдээ охин компаниуд | 10,630,000 | - |
| Бусад холбоотой талууд | 703 | - |
| **Холбоотой талд өгөх өглөг /Урт хугацаат/** | | |
| Дээд шатны хяналт этгээд | 17,032,986 | - |
| **Холбоотой талаас авсан зээл** | | |
| Бусад холбоотой талууд | 20,475,228 | - |

Холбоотой талд өгөх урт хугацаат өглөг нь Таван Богд Холдингс ХХК-аас Гоёо ХХК-ийн хувьцааг зээлээр худалдан авсантай холбоотой. Тус гэрээнд аливаа хөрөнгийг барьцаалаагүй.

Холбоотой талуудын дансны үлдэгдэлд барьцаагүй ба найдваргүй авлагын сан байгуулаагүй.

### 2. ХОЛБООТОЙ ТАЛУУДТАЙ ХИЙСЭН АЖИЛ ГҮЙЛГЭЭ

Дараах ажил гүйлгээг Группийн дээд шатны хяналт компани болох Таван Богд Холдингс ХХК-тай хийсэн байна:

| | 2023 | 2024 |
|---|---|---|
| Дээд шатны хяналт компаниас авсан урьдчилгаа | 200,750,000 | **177,957,846** |
| Дээд шатны хяналт компаниас авсан урьдчилгааны төлбөр | 200,750,000 | **183,297,808** |
| Дээд шатны хяналт компанид өгсөн урьдчилгаа | 18,950,000 | - |
| Дээд шатны хяналт компанид өгсөн урьдчилгааны төлбөр | 18,950,000 | - |
| Дээд шатны хяналт компаниас авсан худалдан авалт | 1,375,508 | **1,379,271** |
| Дээд шатны хяналт компанид хийсэн борлуулалт | 33,051 | **22,792** |
| Дээд шатны хяналт компанид төлөх хүүгийн зардал | 5,816,451 | **4,378,356** |
| Дээд шатны хяналт компанид төлсөн хүүгийн зардал | 5,816,451 | **4,378,356** |

Дараах ажил гүйлгээг Группийн нэгдсэн хяналтад байдаг бусад холбоотой талуудтай хийсэн байна:

| | 2023 | 2024 |
|---|---|---|
| Бусад холбогдох этгээдээс авсан санхүүжилт | 252,920,000 | **325,232,000** |
| Бусад холбогдох этгээдээс авсан санхүүжилтийн эргэн төлөлт | 242,290,000 | **335,862,000** |
| Бусад холбоотой талуудаас авсан худалдан авалт | 1,776,029 | **1,715,066** |
| Бусад холбоотой талаас авсан худалдан авалт | 25,932 | - |
| Бусад холбоотой талд хийсэн борлуулалт | 251,554 | **174,981** |
| Бусад холбоотой талаас авсан түрээсийн орлого | 292,062 | **304,733** |
| Бусад холбоотой талд төлөх хүүгийн зардал | 2,226,785 | **2,575,220** |
| Бусад холбоотой талд төлсөн хүүгийн зардал | 2,226,785 | **2,575,220** |



Дараах ажил гүйлгээг дээд шатны хяналт компанийн хараат компани болох ХААН банктай хийсэн байна:

| | 2023 | 2024 |
|---|---|---|
| Хаан банкнаас авсан санхүүжилт | 81,700,000 | **148,311,216** |
| Хаан банкнаас авсан санхүүжилтийн эргэн төлөлт | 70,997,225 | **169,011,431** |
| Хаан банканд хийсэн борлуулалт | 138,672 | **231,895** |
| Хаан банкинд төлөх хүүгийн зардал | 555,651 | **478,232** |
| Хаан банкинд хүүгийн төлбөр төлөх | 524,089 | **531,164** |

Бүх холбоотой талын гүйлгээ нь харилцан тохиролцсон нөхцөлөөр хийгдсэн.

### 3. ХОЛБООТОЙ ТАЛУУДТАЙ ХИЙСЭН АЖИЛ ГҮЙЛГЭЭНИЙ ХАРЬЦУУЛАЛТ

| • Санхүүжилтийн зардал | 2023 | 2024 |
|---|---|---|
| Нийт санхүүжилтийн зардал | 31,150,837 | **30,117,480** |
| Холбоотой талаас авсан санхүүжилтийн зардал | 8,598,888 | **7,431,806** |
| Эзлэх хувь /холбоотой тал/ | 28% | **25%** |




Говь ХК нь 2024 онд холбоотой талын санхүүжилтийн зардалд 7,431,806 мянган төгрөг төлсөн нь нийт санхүүжилтийн зардлын 25%-ийг эзэлж байна. Холбоотой талаас авсан санхүүжилтийн зардлын дундаж төгрөгийн хүү нь 13.2%, ам.долларын 7.7% байна.

Жич: Холбоотой тал нь олгосон санхүүжилтэд санхүүгийн харьцаа болон барьцаа хөрөнгө шаарддаггүй.

| • Худалдан авалт | 2023 | 2024 |
|---|---|---|
| Нийт худалдан авалт | 102,285,245 | **94,696,681** |
| Гадаадын худалдан авалт | 22,143,070 | **34,037,838** |
| Дотоодын худалдан авалт | 80,142,175 | **60,658,842** |
| Холбоотой талаас авсан худалдан авалт | 3,040,428 | **2,960,699** |
| Эзлэх хувь/нийт худалдан авалтад холбоотой талын эзлэх хувь/ | 3.0% | **3.1%** |
| Эзлэх хувь/дотоодын худалдан авалтад холбоотой талын эзлэх хувь/ | 3.8% | **4.9%** |

НИЙТ ХУДАЛДАН АВАЛТ




ДОТООДЫН ХУДАЛДАН АВАЛТ




Говь ХК нь 2024 онд холбоотой талаас авсан худалдан авалтын дүн 2,960,699 мянган төгрөг буюу нийт худалдан авалтад эзлэх хувь 3.1% байна /2023 онд 3.0%/.

Холбоотой талаас авсан худалдан авалт нь зах зээлийн үнээр хийгдсэн.

Жич: Бүх холбоотой талын гүйлгээ нь Говь ХК-ийн “Худалдан авалтын бодлого”, “Захиалга хүлээн авах, худалдан авах, хүлээлгэн өгөх журам”, “Ажил үйлчилгээ худалдан авах журам”, “Сонгон шалгаруулах хорооны журам”-ын дагуу үнийн харьцуулалт судалгаа хийн, сонгон шалгаруулалтын хороогоор орсны үндсэн дээр зах зээлийн үнээр хийгдсэн бөгөөд харилцан давуу байдлыг олгоогүй болно.



# БИДНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА

## ДОТООД ЗАХ ЗЭЭЛ







2024 онд дотоод зах зээл 163.4 тэрбум төгрөгийн борлуулалттай ажиллаж өмнөх оноос 11%-ийн өсөлт үзүүлэв.

2024 онд дотоод зах зээлд 659 мянган ширхэг бүтээгдэхүүн борлуулсан нь өмнөх онтой харьцуулахад 3%-ийн өсөлттэй байв.




Дотоод зах зээлийн борлуулалтыг бүтцээр нь авч үзвэл 2024 онд жуулчдын борлуулалт үнийн дүнгээр 35%-ийг эзэлж байна.

### БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ НЭР ТӨРӨЛ /мянган ширхэг/




Борлуулсан бүтээгдэхүүнийг нэр төрлөөр нь задалбал, сүлжмэл бүтээгдэхүүн 58%, оёмол бүтээгдэхүүн 4%, нэхмэл бүтээгдэхүүн 35%, бусад бүтээгдэхүүн 3%-ийг тус тус эзэлж байна.

2024 онд дотоодын зах зээлд ноолууран гутлыг олон нэр төрлийн сонголттойгоор хүргэхээс гадна, цүнх, куртка, савхин бээлий гэх мэт олон шинэлэг бүтээгдэхүүнийг борлуулж эхэлснээр outsourcing буюу гадаадад гэрээт үйлдвэрлэгчтэй хамтран үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний борлуулалт 686%-ийн өсөлтийг үзүүлсэн үр дүнтэй байлаа.



## ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД




Химийн цэвэрлэгээ, нөхөн засвар хүлээн авах шинэ салбарыг И-Мартын Хан-Уул салбар дотор нээв.



VIP хэрэглэгчид, хувьцаа эзэмшигчид болон аялал жуулчлалын компаниудын оролцогч талуудаа намар, өвлийн 2024 коллекцийг танилцуулах арга хэмжээг зохион байгуулав.



Аялал жуулчлалын улирлын нээлтийн арга хэмжээг зохион байгуулж хөтөч, жолооч, аяллын компаниудын төлөөлөл бүхий 217 зочинд жуулчны улирлын үеэр хамтран ажиллах төлөвлөгөөгөө танилцуулж мэдээлэл хүргэн хамтын ажиллагааг эхлүүлэв.



Flagship Store буюу төв дэлгүүрийн үндсэн тасгийн засвар, шинэчлэлийг хийн, албан ёсны нээлтийн үйл ажиллагаа зохион байгуулж, хүрэлцэн ирсэн зочид үйлдвэрээр аялан бүтээгдэхүүн бий болох үйл явцтай танилцав.




BARÇA-ийн албан ёсны мерчендайзинг эрхийн гэрээ байгуулах хэлэлцээр амжилттай үргэлжилж, ерөнхийлөгч Жоан Лапорта Галлериа салбар дэлгүүрт хүлээн авлаа.




Нисэх салбар дэлгүүрийн сонгон шалгаруулалтад шалгарч дэлгүүр нээх эрхээ авсан ба 2025 оны 1-р улиралд нээхээр бэлтгэл хангаж ажиллаж байна.

## ГАДААД ЗАХ ЗЭЭЛ




### ГАДААД ЗАХ ЗЭЭЛИЙН БОРЛУУЛАЛТЫН БҮТЭЦ




2024 онд гадаад зах зээлд нийт 83.7 тэрбум төгрөгийн борлуулалттай ажилласан ба энэ нь өмнөх оноос 23% буурсан үзүүлэлт байв.

Гадаад зах зээлийг бүтцээр нь аваад үзвэл 69%-ийг экспортын буюу бөөний борлуулалт, 31%-ийг гадаад дахь охин компанийн борлуулалт буюу онлайн болон биет дэлгүүрийн борлуулалт эзэлж байна.

### ЭКСПОРТЫН БОРЛУУЛАЛТ




Экспортын борлуулалтын хувьд манай компани цөөн, чанартай стратегийн харилцагчидтай хамтран ажиллах бодлогыг баримталж байгаа бөгөөд 2024 онд 50 харилцагчид бүтээгдэхүүнээ нийлүүлж, 57.9 тэрбум төгрөгийн борлуулалттай ажилласан.



2024 оны сүүлийн байдлаар 3 улсын 7 хотод 8 франчайз дэлгүүртэй үйл ажиллагаа явуулж байна.



## ГАДААД БОРЛУУЛАЛТ




### ВЕБСАЙТ

**EU**
- www.gobicashmere.com
- www.gobicashmere.com/DE
- www.gobicashmere.com/FR

**UK**
- www.gobicashmere.com/UK

**US**
- www.gobicashmere.com/US

**CN**
- www.gobicashmere.cn

### ПЛАТФОРМ

**EU**
- Zalando: DE, AUT, FR, SWE
- Nordstorm: US
- OTTO: DE

**CN**
- TMALL, JD

### САЛБАР ДЭЛГҮҮР

Germany
- Berlin
- Düsseldorf

Гадаад борлуулалтын суваг хөгжүүлэх ажлын хүрээнд 2024 оны сүүлээр Европын Холбоо болон Америкийн Нэгдсэн Улсын зах зээлд хоёр шинэ борлуулалтын сувагтай хамтран ажиллаж эхэллээ.

АНУ-д алдартай дээд зэрэглэлийн цахим дэлгүүр болох Nordstrom-д 2024 оны 10-р сард нэгдэж зорилтот үйлчлүүлэгчдэдээ нэг алхам ойртож чадлаа. Мөн Германд цахим худалдааны зах зээлд чансаагаараа хоёрт ордог OTTO-д 2024 оны 12-р сараас бүтээгдэхүүнээ байршуулан борлуулалт хийж эхэллээ. Борлуулалтын оргил үед тус сувгуудтай хамтран ажиллаж эхэлсэн нь 2024 оны нийт борлуулалтын үр дүнд эерэг нөлөө үзүүлсэн байна.

Түүнчлэн 2024 оны 11-р сард туршилтын 4 сарын хугацаатай гэрээ хийн АНУ-ын New York хотын алдарт Roosevelt Field Mall худалдааны төвд манай Pop-up дэлгүүрийг нээн ажилласан нь богино хугацаанд зорилтот хэрэглэгчдэдээ бүтээгдэхүүнээ танилцуулж чадсан хэрэг байлаа.

## БОРЛУУЛАЛТ

| Борлуулалтын суваг | Борлуулалт /сая төгрөг/ 2023 | Борлуулалт /сая төгрөг/ 2024 | Өөрчлөлт % | Борлуулалтад эзлэх % |
|---|---|---|---|---|
| Вебсайт | 43,621 | **18,047** | -59% | 70% |
| Салбар дэлгүүр | 3,894 | **4,112** | 6% | 16% |
| Платформ | 1,654 | **3,575** | 116% | 14% |
| **НИЙТ** | **49,169** | **25,733** | **-48%** | **100%** |

Гадаад борлуулалтыг сувгаар нь задлаад үзвэл вебсайтаар хийсэн онлайн борлуулалт 18.0 тэрбум төгрөг буюу өмнөх оноос 59% бууралттай, Герман улс дахь хоёр салбар дэлгүүрийн борлуулалт 4.2 тэрбум төгрөг буюу 6% өсөлттэй байсан бол худалдааны платформууд буюу Zalando, Nordstrom, OTTO-ийн онлайн борлуулалт 3.6 тэрбум төгрөг буюу өмнөх оноос 116% өсөлттэй байв.

## ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

| Зах зээл | CTR 2023 | CTR 2024 | CTR Өөрчлөлт % | CR 2023 | CR 2024 | CR Өөрчлөлт % | CPA 2023 | CPA 2024 | CPA Өөрчлөлт % |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Европ, Хойд Америк, Их Британи | 43,621 | **18,047** | +46% | 2.24% | **1.58%** | -29% | $65.15 | **$48.41** | -26% |
| Хятад | 3,894 | **4,112** | +23% | 0.70% | **0.72%** | +3% | ¥185.10 | **¥109.40** | -41% |

Үзүүлэлтүүдийн тайлбар

CTR /click through rate/
- Нийт сурталчилгаа харсан тооноос хэдэн хувь нь click буюу үйлдэл хийснийг илэрхийлэх хувь

CR /conversion rate/
- Нийт веб руу зочилсон зочлолтын хэдэн хувь нь худалдан авалт хийж буйг илэрхийлэх хувь

CPA /cost per acquisition/
- Нэг захиалга хийлгэхэд гаргаж буй дижитал маркетингийн зардал

## ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД

NP digital

### NPDI x GOBI хамтын ажиллагаа

Гадаад борлуулалтын зах зээлд 2023 оноос хойш SEO буюу Search Engine Optimization компаниудтай хамтран ажиллаж брэндийн органик хайлтыг сайжруулах зорилгоор үе шаттай арга хэмжээг авах ажиллаж байгаа бөгөөд 2024 оноос эхлэн NPDI Agency-тэй хамтын ажиллагаа эхлүүлж, шинэ түлхүүр үгсийн судалгааг хамтран хийж, ГОВЬ брэндийн органик хандалтыг өсгөхөд анхаарч ажилласан.

NORDSTROM



OTTO

### Борлуулалтын суваг хөгжүүлэлт

- 2024 оны 10-р сард АНУ-ын 120 жилийн баялаг түүхтэй, 365 салбар дэлгүүр болон онлайн худалдаагаар алдартай "Nordstrom" худалдааны онлайн платформоор бүтээгдэхүүнээ борлуулж эхэлсэн.
- 2024 оны 11-р сард АНУ-ын Нью Йорк хот дахь алдарт Roosevelt Field Mall худалдааны төвд Mongolian Gallery-ийн хамт олонтой хамтран Поп-Ап дэлгүүр нээсэн.
- 2024 оны 12-р сараас Германы онлайн худалдааны өсөлтийг дэмжих зорилгоор тус улсын тэргүүлэгч худалдааны онлайн платформуудын нэг болох OTTO-д нэгдэж бүтээгдэхүүнээ хэрэглэгчдэд хүргэж эхэлсэн.



# ПРОГРАММ ХӨГЖҮҮЛЭЛТ, ДИЖИТАЛ ШИЛЖИЛТ

Компанийн хэмжээнд системийн шинэчлэлтийн ажлыг өргөжүүлэн 2023 онд Product Lifecycle Management (PLM) системийг нэвтрүүлсэн бол 2024 оны 3-р сараас SAP S/4 HANA Enterprise Resource Management (ERP) системийг амжилттай нэвтрүүлэн ашиглаж эхэлсэн.

Мөн INA Manufacturing Execution System (MES) системийг нэвтрүүлэх бэлтгэл ажлыг 2024 оны 7-р сараас эхлүүлсэн бөгөөд 2025 оны 1-р сараас эхлэн үйл ажиллагаандаа ашиглаж эхэлсэн. Энэхүү системийг үйл ажиллагаанд нэвтрүүлснээр Говь ХК-ийн Сүлжмэл болон Оёмолын үйлдвэрүүдэд бүтээгдэхүүн үйлдвэрлэл, нэгж бүтээгдэхүүний үр ашиг, дамжлага дундын мэдээлэл, үйлдвэрлэл дундын чанар, мөшгөлт, үйлдвэрлэлтийн тухайн цаг үеийн өгөгдөл мэдээлэл, хэвийн үйл ажиллагааны хяналт удирдлага зэрэг олон үйл ажиллагааны ашигт ажиллагааг улам сайжруулах, бүтээмжийг нэмэгдүүлэхэд томоохон дэвшил авчрах юм.




## ГОЛ ХҮРЭХ ҮР ДҮНГҮҮД:

ERP

- Санхүүгийн удирдлага сайжруулалт
- Үйл ажиллагааны үр ашиг нэмэгдэх
- Эрсдэлийг удирдах
- Бодит дүн шинжилгээ
- Нэгдсэн процесс




MES

- Үйлдвэрлэлийн үр ашиг, бүтээмж нэмэгдүүлэх
- Бүтээгдэхүүний чанар сайжруулах
- Үйлдвэрлэлийн процессын сайжруулалт
- Хяналтын үйл ажиллагаа нэмэгдэх
- Ажилтнуудын үр чадвар нэмэгдэх

PLM

- Бүтээгдэхүүний зах зээлд нэвтрэх хугацаа богиносох
- Бүтээгдэхүүний хөгжүүлэлт сайжрах
- Загварын түүхэн архив үүсэх

# ҮЙЛ АЖИЛЛАГААНДАА НЭВТРҮҮЛСЭН ШИНЭ ТЕХНОЛОГИ, БҮТЭЭГДЭХҮҮН ХӨГЖҮҮЛЭЛТ

## ДАМЖЛАГЫН СИСТЕМ

Говь ХК нь 2024 онд Монгол Улсын хөнгөн үйлдвэрийн салбарт анх удаа Сүлжмэлийн үйлдвэрт Conveyor Belt буюу дамжлагын системийг нэвтрүүлж, ашиглалтад оруулсан.
Энэхүү системийг нэвтрүүлснээр үйлдвэрлэлийн ажлын урсгал автоматжиж, гар ажиллагааг багасган, ажлын гүйцэтгэлийн хяналт, үнэлгээний процессыг улам сайжруулах боломжийг бүрдүүлж байгаа бөгөөд компанийн үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлж, чанар, хурдыг илүү өндөр түвшинд хүргэх томоохон алхам болсон. Бид цаашид энэхүү шинэ технологийг ашиглан ажилтнуудын ур чадвар, бүтээмжийг дээшлүүлж, үйлдвэрлэлийн чанар стандартыг шинэ шатанд гаргах зорилготойгоор ажиллах болно.





## МАТЕРИАЛ ХӨГЖҮҮЛЭЛТ

Gobi FW 24/25 коллекцид зориулан шинээр жин нэмэгдүүлсэн 3 төрлийн драп үйлдвэрлэсэн.









## НООЛУУРАН ГУТЛЫН ШИНЭ ЗАГВАРУУД

Говь ХК нь ноолууран гуталд зориулж агаарын солилцоог бүрэн хангадаг шинэ драпыг гарган авсан бөгөөд “амьсгалдаг” гутал хэмээн нэрлэж болно. Ноолуур нь агаар нэвтрүүлдэг, амьсгалдаг чанартай тул хөлд чийг татахгүй ямар ч нөхцөлд биеийн температурыг нэгэн жигд барьдаг давуу талтай. Чийг татахгүй, хөлийг хуурай байлгаснаар хүний биеийн цусны эргэлтийг сайжруулж, булчинг суллах, хоолой өвдөхөөс сэргийлэх зэрэг эрүүл мэндийн ач холбогдолтой.

2024 онд ноолууран гутлыг хөгжүүлэн, өнгө, загварын олон сонголттой загваруудаар хэрэглэгчдэд хүргэснээр жилийн турш, ямар ч нөхцөлд, бүх төрлийн хувцаслалтад загварчлан өмсөх боломжийг бүрдүүллээ.









**CASHMERE SNEAKERS**

Гутлын ул нь “Green Eva” буюу байгальд ээлтэй резин болон чихрийн нишингийг агуулж, үдээсийг 100% хөвөн даавуун материалаар урласан. “Cashmere Sneakers”-ийн дотор улавч нь нуураас дахин боловсруулсан 15%-ийн замгийг агуулсан эко материалаар хийгдсэн нь хүрээлэн буй орчныг хамгаалахад туслах төдийгүй чийгийг шингээх давуу талтай.









**CASHMERE BALLERINA**

Амьсгалдаг технологиор бүтээсэн тул хөлийг халууцуулахгүй агаарыг бүрэн нэвтрүүлэх боломжтой.

**CASHMERE LOAFERS**

Ажил хэрэгч, өдөр тутам гээд бүх төрлийн хувцаслалтад тохиромжтой. Хөнгөн бөгөөд дулаахан үг шинэ загвар нь амьдралын алхам бүрд тав тух мэдрүүлнэ.

**CASHMERE MULE**

Их бие нь 100% ноолуураар хийгдэж, илгэн арьсаар бүрэгдсэн бөгөөд 100% хонины ноосон дотортой, арьсан оосор бүхий детальтай.

**CASHMERE SLIP-ON**

Их бие нь 100% ноолууран материалтай, агаар нэвтрүүлдэг, чийг татахгүй, дулаахан, хөнгөн. Ул нь байгальд ээлтэй PU буюу удаан эдэлгээтэй, дахин боловсруулсан материал ашиглан OrthoLite технологиор хөлийн нум дэмжигчтэй хийгдсэн.



### CashmereTECH - НООЛУУРАН ДҮҮРГЭЛТТЭЙ КУРТКА

Инновац шингэсэн шинэ бүтээгдэхүүн болох 100% ноолууран дүүргэлттэй полиэстер гадар бүхий курткаг эрэгтэй, эмэгтэй загвараар хэрэглэгчдэдээ хүргэсэн.

Энэхүү куртканы ноолууран дүүргэлт нь биеийн дулааныг жигд хадгалж, гадна талын материал нь ус болон салхины хамгаалалттай тул эдэлгээ урт, маш хөнгөн юм.



### CASHMERE TOTE BAG

100% ноолуур болон арьсан материал хослуулсан, зах ирмэг хэсгүүдээрээ арьсан хамгаалалттай тул хөнгөн бөгөөд урт эдэлгээтэй, бүх төрлийн хувцаслалтад хэрэглээндээ тохируулан загварчлах боломжтой шинэ загварын цүнхийг 2 төрлийн хэмжээгээр хэрэглэгчдэд хүргэсэн



### АНХИЛАМ ҮНЭРТ ЛАА

## ШИНЭ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮНҮҮД



### НООЛУУРАН ДОТОРТОЙ САВХИН БЭЭЛИЙ



### НООЛУУРАН САРАВЧТАЙ МАЛГАЙ

### НООЛУУРАН УЛАВЧ

Чийг шингээж, агаар чөлөөтэй нэвтрүүлэн, хүндийн төвийг тогтворжуулж, гэмтэхээс сэргийлэх U хэлбэртэй, хөлийн нум дэмжигчтэй, хүссэн хэмжээндээ тааруулан, хайчилж хэрэглэх боломжтой ноолууран улавч.





### ШИРЭЭНИЙ ГОЁЛЫН БАГЦ

### ХҮҮХДИЙН ГУТАЛ

Анхны алхмаа хийж буй үрсдээ, цэцэрлэгийн насны багачуудад зориулсан 100% ноолууран их биетэй, зөөлөн резинэн ултай, халтирахгүй, өмсөж тайлахад хялбар, урд хэсгээрээ өргөн, хүүхдийн хөлийн анатомид зохицсон тул байгалийн хөдөлгөөний хэв маягт нь саад болж хязгаарлахгүй.



# ДЭЛХИЙН АЛДАРТ ДИЗАЙНЕРТАЙ ХАМТЫН АЖИЛЛАГАА



## GIORGIO SPINA

Дэлхийн загварын ертөнцийн том дөрвөлийн нэг болох Итали улсын алдарт дизайнер Giorgio Spina нь 2022 оны 12-р сараас Говь ХК-ийн ерөнхий дизайнераар томилогдон брэндийн өнгө төрх, загвар дизайн, өмсгөл суултыг илүү сайжруулан дэлхийн тавцанд өрсөлдөхүйц хэмжээнд хүргэхээр ажиллаж байна. Giorgio Spina нь загварын салбарт 20 гаруй жил ажиллахдаа Brunello Cucinelli, Alexander Wang, Moncler, Zegna гэх мэт маш олон алдартай брэндүүд мэргэжлийн ур чадвар, авьяас чадварыг нь үнэлэн бүтээсэн сүлжмэл утсыг өөрсдийн коллекцдоо тусган хамтран ажилладаг билээ.





2024 онд Giorgio Spina дизайнертай дараах коллекцууд дээр хамтран ажиллалаа.

- GOBI & ORGANIC FW 24/25
- CASHMERE REBORN
- RESPONSIBLE CASHMERE
- GOBI & ORGANIC SS25
- GOBI & ORGANIC FW 25/26



# КОЛЛЕКЦУУД

Говь ХК-ийн Дизайн хөгжүүлэлтийн газрын мэргэшсэн чадварлаг хамт олон 2024 онд борлуулалт, ашигт ажиллагаагаа дэмжих, хэрэглэгчдэдээ тогтмол шинэлэг бүтээгдэхүүнээр бэлэг барих зорилгоор сар бүр шинэ коллекц танилцуулахаар төлөвлөж ажилласны дагуу үндсэн 7, капсул 11 коллекц болон шинэ нэр төрлийн 10 бүтээгдэхүүнийг дотоод болон гадаадын зах зээлд хэрэглэгч, үйлчлүүлэгчдэдээ хүргэсэн.



LUNAR NEW YEAR 2024



VALENTINE`S DAY SCARVES



GOBI SS24 “LIGHT BEINGS”



CASHMERE REBORN



TRENDY COATS



WOMEN`S DAY



BAR SHAWL



ORGANIC SS24 “LIGHT BEINGS”



SPORT CASUAL



CASHMERE SHOES



KIDS SS24



MATERNITY &
NEWBORN



NAADAM



ORGANIC FW24/25
“SEE THROUGH”



3D-WHOLEGARMENT



FW24/25 “SOUND”



NEW ACCESSORIES




HOME COLLECTION



# БРЭНДИЙН БҮТЭЦ

**ГОВЬ ХК**

GOBI

GOYO CASHMERE

Орчин үеийн загварын чиг хандлагад нийцүүлэн бүтээлээ урладаг, тод өнгө, загваруудаар эрх чөлөөт байдлыг илэрхийлсэн шинэ залуу үеийн

**GOYO брэнд**

YAMA cashmere by GOBI

Дэлхийн шилдэг дизайнерууд ур ухаанаа шингээн урласан дээд зэргийн чанартай, тансаг зэрэглэлийн

**YAMA брэнд**

GOBI

Бүх насныханд зориулсан сонгодог загварын хувцас, аксессуар болон гэр ахуйн бүтээгдэхүүнээр дэлхийд танигдсан

**GOBI брэнд**

GOBI ORGANIC

Байгалийн үндсэн дөрвөн өнгийн ноолуурыг химийн будаг болон цайруулагч ашиглалгүйгээр урласан

**GOBI ORGANIC брэнд**

GOBI KIDS

Хүүхдийн хөдөлгөөнд саад учруулахгүйгээр дулаахан, таатай, хөнгөн мэдрэмжийг бэлэглэх загварлаг үрсийн

**GOBI KIDS брэнд**



# ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ

БАЙГАЛЬ ОРЧИН

НИЙГЭМ

ЗАСАГЛАЛ

## ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН УДИРДЛАГА

Говь ХК нь бизнесийн үйл ажиллагаанаас үүдэлтэй байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөллөө тогтмол үнэлж, сөрөг үр дагаврыг бууруулах засаглалын тогтолцоогоо бэхжүүлэхэд онцгой анхаарч ажилладаг. Байгууллагад аливаа соёл, тогтолцоог төлөвшүүлэхэд дээд шатны удирдлагын манлайлал чухал үүрэгтэй байдаг. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн зүгээс тогтвортой хөгжлийн үйл ажиллагаанд онцгой ач холбогдол өгч, энэ онд “Тогтвортой хөгжлийн стратегийн бодлого”-ыг хэлэлцэн баталлаа. Энэхүү бодлого нь бидний урт хугацааны бизнесийн үйл ажиллагаанд тогтвортой хөгжлийн зарчмуудыг нэвтрүүлэх суурь болж, шийдвэр гаргалтын явцад байгаль орчин, нийгэм, хүний эрх зэрэг чухал асуудлуудыг харгалзан үзэх, хариуцлагатай үйлдвэрлэл эрхлэх амлалтыг бататгаж байна.
Тогтвортой хөгжлийн стратегийн бодлого дээр үндэслэн:

- Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах чиглэлд
- Хүний эрх, жендерийн чиглэлд
- Нийгмийн хариуцлагын чиглэлд баримтлах тус тусын бодлогын баримт бичгүүдийг ТУЗ-өөс баталж, бодлогын орчныг илүү боловсронгуй болголоо.

Ингэснээр бид бизнесийн үйл ажиллагаагаа хариуцлагатайгаар явуулж, тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд нэг алхам ойртож байна.

## ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН СТРАТЕГИЙН БОДЛОГО

Энэхүү бодлого нь бидний урт хугацааны бизнесийн үйл ажиллагаанд тогтвортой хөгжлийн зарчмуудыг нэвтрүүлэх суурь болж, шийдвэр гаргалтын явцад байгаль орчин, нийгэм, хүний эрх зэрэг чухал асуудлуудыг харгалзан үзэх, хариуцлагатай үйлдвэрлэл эрхлэх амлалтыг бататгаж байна. Түүнчлэн уг бодлогын хамрах хүрээ нь зөвхөн ажилтнуудаар хязгаарлагдахгүй бөгөөд ханган нийлүүлэгчид болон бусад сонирхогч талуудыг хамарч байгаа билээ. Бид энэхүү бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд хариуцлагатай тогтвортой хөгжлийн тогтолцоог бүрдүүлж, хэрэглэгчийн шаардлагыг хангасан чанартай ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэхдээ дараах үндсэн чиглэлүүдийг дэмжиж, оролцогч талуудыг чадавхжуулан хамтран ажиллахаа амлаж байна.

### ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН АМЛАЛТ

**Байгаль орчин**

Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг хүлээн зөвшөөрч, компанийн үйл ажиллагааны экологийн ул мөрийг багасгахад онцгой анхаарч, байгалийн нөөцийн хэрэглээг зөв зохистой ашиглах, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, биологийн олон янз байдлыг хамгаалах арга барилыг хэрэгжүүлэхэд чиглэн ажиллана.

**Нийгмийн хариуцлага**

Хүний эрхийг хүндэтгэсэн, хүртээмжтэй, жендерийн эрх тэгш байдал, оролцоог хангасан ажлын байрыг дэмжиж, нийгэмд эергээр нөлөөлнө.

**Ёс зүйтэй засаглал**

Ил тод, нээлттэй, шударга, хариуцлагатай үйл ажиллагаа явуулж, оролцогч талуудын тэгш оролцоог эрхэмлэн, шударга, ёс зүйтэй шийдвэр гаргах.



# БАЙГАЛЬ ОРЧИН

Говь ХК нь байгаль орчинд ээлтэй, хариуцлагатай үйлдвэрлэлийг эрхэмлэн, уур амьсгалын өөрчлөлт, байгалийн нөөцийн зохистой хэрэглээг бий болгох бодлого баримтлан, түүхий эдийн тогтвортой бэлтгэн нийлүүлэлт, ногоон үйлдвэрлэлийн шийдэл, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг авч, олон улсын стандартуудыг хэрэгжүүлэхийг зорин ажиллаж байна.



# БАЙГАЛЬ ОРЧНЫ ЗОРИЛТ БА ГҮЙЦЭТГЭЛ

Бид 2022 онд батлагдсан тогтвортой хөгжлийн бодлого, зорилгын хүрээнд 2025 онд хүртэл дараах зорилтуудыг дэвшүүлсэн бөгөөд жил бүр зорилтод хүрэх арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэн, гүйцэтгэлийг тогтмол үнэлж ажиллаж байна.

## НОГООН БАЙГУУЛАМЖ

Байгууллагын эзэмшлийн нийт талбайд эзлэх ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэх

Байгууллагын нийт талбайд ногоон байгууламжийн эзлэх хувь




## ХОГ ХАЯГДАЛ

Нийт хог хаягдлыг ангилан бүртгэлжүүлж, хог хаягдлын дахин боловсруулалтын хувийг нэмэгдүүлэх

Нийт хог хаягдалд дахин боловсруулалтын эзлэх хувь




## УС

Байгууллагын үйл ажиллагаанаас гарч буй ахуйн болон үйлдвэрийн бохир усны 10 хүртэлх хувийг дахин цэвэршүүлэх

Дахин цэвэршүүлсэн ус




## ЭРЧИМ ХҮЧ

Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд зарцуулах эрчим хүчний хэрэглээг 15%-аар бууруулах

Нэгж бүтээгдэхүүнд ногдох эрчим хүч /кВт.ц/ш/*




**Нэгж бүтээгдэхүүнд ногдох эрчим хүчний хэрэглээ болон нийт эрчим хүчний зарцуулалтыг тооцохдоо цахилгаан, уур болон дулааны хэрэглээг бүгдийг хамруулан тооцов.*

## СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧ

Үйл ажиллагаандаа сэргээгдэх эрчим хүчийг нэвтрүүлэх

Нийт эрчим хүчний хэрэглээнд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувь




## ХҮЛЭМЖИЙН ХИЙ

Байгууллагын шууд болон шууд бус үйл ажиллагаанаас хамаарах хүлэмжийн хийн ялгарлыг 10% бууруулах

Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэлээс ялгарах хүлэмжийн хий /кгCO2/




2024 онд "Resiliency Consulting Services LLC" компанитай хамтран байгууллагын үйл ажиллагаанаас үүдэлтэй хүлэмжийн хийн ялгарлыг Scope 1, Scope 2, Scope 3 түвшинд нарийвчлан тооцоолсон. Мөн дотооддоо мэдээллийг илүү дэлгэрэнгүй цуглуулснаар тухайн тооцооллыг сайжруулан, 2022, 2023, 2024 оны нийт хүлэмжийн хийн ялгарал ба нэгж бүтээгдэхүүнд ногдох хүлэмжийн хийн ялгарлын тооцооллыг шинэчлэн боловсрууллаа.




**Scope 1. 8.9%**
Шууд ялгаруулалт буюу үйл ажиллагаанд ашиглагдаж буй түлш, агааржуулалтын хий зэргээс ялгарах хүлэмжийн хий

**Scope 2. 88.5%**
Шууд бус ялгаруулалт буюу байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж буй эрчим хүчний хэрэглээнээс үүдэлтэй хүлэмжийн хий

**Scope 3. 2.6%**
Ханган нийлүүлэлтийн сүлжээн дэх хүлэмжийн хийн ялгарал



# УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТ, ХҮЛЭМЖИЙН ХИЙН ЯЛГАРЛЫГ БУУРУУЛАХ БОДЛОГО

2024 оны 4-р улиралд Говь ХК нь уур амьсгалын өөрчлөлт, хүлэмжийн хийн ялгарлын асуудлыг онцгойлон анхаарахаа амлан ТУЗ-ийн түвшинд "Уур амьсгалын өөрчлөлт, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах бодлого"-ыг хэлэлцэн батлав. Энэхүү бодлогынхоо хүрээнд Говь ХК нь бүхий л үйл ажиллагаанаасаа хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, Net Zero түвшинд хүргэх, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах болон дасан зохицох зорилт тавин ажиллахдаа шинжлэх ухаанд суурилсан зорилтуудыг хэрэгжүүлэх, сэргээгдэх эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх, хүлэмжийн хийн шингээлтийг нэмэгдүүлэх үйл ажиллагааг дэмжин, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, түүнд дасах зохицох арга хэмжээг авч, төрөл бүрийн санал санаачилгуудыг дэмжиж, оролцогч талуудыг мэдлэг мэдээллээр хангаж, чадавхжуулан тогтвортой байдлын төлөө тууштай ажиллах болно.



Нийлүүлэлтийн сүлжээн дэх хүлэмжийн хийн хэмжээг тодорхойлох, нүүрстөрөгчийн ул мөрийн иж бүрэн шинжилгээ хийх.



Үйлдвэрлэлд эрчим хүч хэмнэлттэй технологи болон сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг нэвтрүүлэх, тогтвортой мал аж ахуйг бий болгох, энгийн болон технологийн хаягдлыг багасгах.



Нүүрстөрөгчийн хийг шингээх төслүүдэд хөрөнгө оруулах.



Цэвэр үйлдвэрлэлийн технологийг судалж, хэрэгжүүлэх.



Оролцогч талуудад мэдлэг түгээх, чадавхжуулах.



Найдвартай хяналт тайлагналын системийг бий болгож, шаардлагатай тохиолдолд хөндлөнгийн байгууллагаар баталгаажуулах.



Бодлогыг тасралтгүй сайжруулах.



# БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТ

**Байгаль орчны менежментийн тогтолцоо**

Байгаль орчны удирдлагын тогтолцоо ISO 14001:2015 стандартыг 2022 онд баталгаажуулалт хийлгэснээс хойш тасралтгүй сайжруулан 2024 онд олон улсын баталгаажуулалтын байгууллагаар 3 дахь удаагаа магадлан аудитлагдав.

**Үйлдвэрийн хаягдал ус цэвэрлэх байгууламжийг шинэчлэх төсөл**

Говь ХК нь үйлдвэрлэлийн хаягдал усны бохирдлыг бууруулах, дахин ашиглах боломжийг нэмэгдүүлэх, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг багасгах зорилгоор хаягдал ус цэвэрлэх байгууламжаа шинэчлэх төслийг 2024 онд эхлүүлж, томоохон хөрөнгө оруулалтыг хийв.
Энэхүү төслөөр бид одоогийн байгууламжийнхаа хүчин чадлыг нэмэгдүүлж, орчин үеийн дэвшилтэд технологиор тоноглогдсон, бүрэн автомат, хүний хөдөлмөрийг хөнгөвчилсөн, ажилтнуудын эрүүл, аюулгүй ажиллах орчин нөхцөлийг бүрдүүлсэн байхаар төлөвлөсөн юм.
Мөн түүнчлэн цэвэрлэх байгууламж нь Монгол улсын хаягдал усны MNS 6561 стандартад нийцсэн хаягдал ус гаргахаас гадна, цаашид технологийн сайжруулалт хийснээр саарал ус гарган авах боломжид нэг алхам ойртож байгаа юм. Манай үйлдвэрийн хувьд түүхий эдийн анхан шатны боловсруулалтад цэвэр усны нөөцийг ихээр хэрэглэж байгаа нь бидний анхаарах шаардлагатай чухал асуудал бөгөөд тус төслийг бүрэн хэрэгжүүлснээр байгалийн нөөцийн хэрэглээг бууруулах боломжийг бүрдүүлж байна.



**Ногоон байгууламж**

Говь ХК нь Нийслэлийн Байгаль Орчны газартай хамтран "Тэрбум мод" хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зорилгоор нийслэлийн нутаг дэвсгэрт мод тарих ажлыг жил бүр зохион байгуулдаг. Уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт болон агаарын бохирдлын эсрэг хэрэгжүүлэх өндөр ач холбогдолтой, бодит үр дүнтэй арга бол мод тарих юм.
Бид 2024 онд 1,300 ширхэг нарс, хайлаас модыг мэргэжлийн байгууллагатай хамтран тарьсан бол 250 ширхэг хайлаас, гацуур модыг компанийн ажилтнууд гэр бүлийн гишүүдийн хамтаар тарьсан. Түүнчлэн компанийн орчин дахь тоосжилтыг бууруулах, ажлын таатай, эко орчныг бүрдүүлэх зорилгоор нийт 1,200 м² талбайд 3,000 нэг наст цэцэг, 75 ширхэг гацуур, нарс мод тарьж ногоон байгууламж бий болгосноор нийт талбайн 13.1%-ийг ногоон байгууламж эзэлж байна.



**Байгаль орчны хуулийн нийцэл**

Бид Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Байгаль орчны багц хуулиудын нийцлийг жил бүр үнэлэн, хэрэгжилтийг хангуулахад чиглэн ажилладаг бөгөөд 2024 оны байдлаар нийт 16 хууль, 6 журам, 6 стандартуудад нийцэн ажиллаж байна.



**Химийн бодисын менежмент**

- 2024 онд үйлдвэрлэлийн үйл явц дахь химийн бодисын зохистой хэрэглээг хангахаар Геодата ХХК-тай хамтран ашиглаж буй химийн бодисуудад эрсдэлийн үнэлгээ хийлгэж, холбогдох тусгай зөвшөөрлийг авсан.
- Үйлдвэрийн химийн бодисын агуулахад асгаралт, алдагдлыг илрүүлэх мэдрэгч төхөөрөмж суурилуулж, хяналтын тогтолцоог сайжруулсан.
- Химийн бодисын сав, баглаа боодлыг улирал бүр аюултай хог хаягдал устгах тусгай зөвшөөрөлтэй мэргэжлийн байгууллагаар устгуулж, байгаль орчин, хөдөлмөрийн аюулгүй байдлыг ханган ажиллаж байна.

# ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ

Хүн амьдарч, үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явагдаж буй орчинд хог хаягдал тогтмол үүсдэг. Тиймээс хог хаягдлын менежментийг үр дүнтэй хэрэгжүүлж, хаягдлыг эх үүсвэр дээр нь бууруулах, дахин үүсэхээс сэргийлэх, мөн үүссэн хаягдлыг зөв боловсруулах, устгах нь хамгийн чухал юм.

Хог хаягдлын анхан шатны ангилан ялгалт нь цаашдын тээвэрлэлт, дахин боловсруулалтын үр дүнд шууд нөлөөлдөг. Говь ХК-ийн хувьд өдөр бүр дунджаар 1,500 гаруй ажилтан ажилладаг тул хог хаягдлыг зөв ангилан ялгах дадлыг төлөвшүүлэхэд чиглэн ажилтнуудад зориулсан тогтмол сургалт, видео контентуудыг бэлтгэн хүргэж, хог хаягдлыг бууруулах, зөв менежмент хийх мэдлэг, мэдээллийг түгээж байна.

### ХОГ ХАЯГДЛЫН БҮТЭЦ




Энгийн хог хаягдал   Технологийн хаягдал   Аюултай хог хаягдал

### Энгийн хог хаягдал 19%

Энгийн хог хаягдлыг эх үүсвэрээр нь дахивар, цаас, гялгар, бусад гэж ангилдаг бөгөөд үйлдвэр болон оффисын хэмжээнд 48 байршилд 270 ширхэг 4 төрлийн ангилан ялгах хогийн савыг байршуулсан ба ангилалтын төрөл нэмэгдсэнээр ажилтнуудын хогоо зөв ангилан хаях боломж нэмэгдэж байна. 2024 онд энгийн хог хаягдлын 41.4% нь дахин боловсруулах боломжтой хаягдал эзэлж байгаа ба тэдгээрийг дахин боловсруулах мэргэжлийн байгууллагад шилжүүлэв.

### Технологийн хаягдал 78%

Бүтээгдэхүүн үйлдвэрлэх явцад үүссэн технологийн хаягдал нь нийт хог хаягдлын дийлэнх хувийг эзэлж байгаа бөгөөд технологийн хаягдал болох цэвэр очёсыг дахин боловсруулж 2,647.5кг утас буюу 18,132 ширхэг ороолт үйлдвэрлэв. Энэ нь энэ онд үйлдвэрлэсэн нийт бүтээгдэхүүний 1.8%-ийг эзэлж байна.

### Аюултай хаягдал 3%

Бид батарей, химийн бодисын сав болон электрон хог хаягдлыг байгаль орчин болоод хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй байх зорилгоор холбогдох тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллагаар тээвэрлүүлэн, устгуулах арга хэмжээг тогтмол авч хэрэгжүүлж байна



### Нэг удаагийн хэрэглээнээс бүрэн татгалзав

Нэг удаагийн хэрэгслийн байгальд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор:
Бид гадны зочдод зориулан аяга, таваг, стакан зэрэг байнгын хэрэгслүүд болон аяга таваг угаагч, ариутгагч, бусад шаардлагатай бүтээгдэхүүнийг 5 байршилд байршуулав.



# ХАРИУЦЛАГАТАЙ ҮЙЛДВЭРЛЭЛ

Бид түүхэн хөгжлийнхөө явцад олон зуун жилийн түүхтэй ард иргэдийнхээ уламжлалт нүүдэлчин ахуйг, орчин үеийн тоног төхөөрөмж, инновацтай хослуулан бүтээгдэхүүн үйлчилгээгээ хөгжүүлж ирсэн төдийгүй, хэрэглэгчдэдээ чанар, нийцэмжид үнэ, загвар, тогтвортой байдлыг амладаг.



ЧАНАР | НИЙЦЭМЖИТ ҮНЭ | ЗАГВАР | ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

Энэ амлалтынхаа хүрээнд байгаль орчин, нийгэмд ээлтэй, хариуцлагатай коллекцуудынхаа үйлдвэрлэлийн тоо хэмжээг жил бүр нэмэгдүүлсээр байгаа бөгөөд ингэснээр тогтвортой үйлдвэрлэл эрхлэх зорилгодоо хүрэхэд улам ойртож байна.







Бусад бүтээгдэхүүн   Хариуцлагатай коллекц

2024 онд үйлдвэрлэсэн нийт хариуцлагатай коллекцын тоо хэмжээ 2023 онтой харьцуулахад 39%-аар өсөв.

2024 онд үйлдвэрлэсэн нийт бүтээгдэхүүн дэх хариуцлагатай коллекцын эзлэх хувь 46% болж, 2023 оноос 6% өсөв.

### ОРГАНИК КОЛЛЕКЦ

Говь ХК нь байгальд ээлтэй, тогтвортой үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор Органик коллекцыг үйлдвэрлэн, хэрэглэгчдэдээ хүргэдэг билээ. Энэхүү коллекц нь Монгол ноолуурын байгалийн 4 үндсэн өнгийг ямарваа нэг будагч бодис ашиглахгүйгээр, шууд боловсруулж, бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэдгээрээ онцлог бөгөөд ингэснээр цэвэр ус болон химийн бодисын хэрэглээг хамгийн ихээр бууруулж байна.




| | |
|---|---|
| **21.75%** CO2 бууралт | **74.9%** Химийн бодисын зарцуулалт бага |
| **88.75%** Усны хэмнэлт | **2.07%** Эрчим хүчний хэмнэлт |

2024 оны Органик коллекцын үйлдвэрлэлийн тоо хэмжээ 2023 онтой харьцуулахад 79,187 ширхгээр буюу 40%-аар өсөв.

### WHOLEGARMENT 3D КОЛЛЕКЦ

Оёдолгүй ноолууран бүтээгдэхүүн нь уламжлалт сүлжмэл бүтээгдэхүүнээс залгаа оёдолгүйгээрээ ялгаатайгаас гадна үйлдвэрлэлийн явцад өнгө, хээний зохицлоос шалтгаалсан технологийн хаягдал гардаггүйгээрээ онцлог юм.

Wholegarment 3D бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн тоо хэмжээ




Wholegarment 3D коллекцын байгаль орчны эерэг нөлөөлөл

| | |
|---|---|
| 8% CO2 бууралт | 12% Эрчим хүчний хэмнэлт |

2024 оны Wholegarment 3D коллекцын үйлдвэрлэлийн тоо хэмжээ 2023 онтой харьцуулахад 20,598 ширхгээр буюу 14.9%-аар өсөв.

### CASHMERE REBORN КОЛЛЕКЦ

Бид 2023 оноос эхлэн тогтвортой үйлдвэрлэлийн шинэ санаачилгыг танилцуулж Cashmere Reborn коллекцыг худалдаанд гаргасан. Энэхүү коллекц нь бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн явцад үүссэн технологийн хаягдлыг дахин ашиглаж, дахин шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг бөгөөд анхан шатны болон будах үйлдвэрийн боловсруулалт хийгддэггүй тул бусад бүтээгдэхүүнтэй харьцуулахад ус болон химийн бодисын хэрэглээг хамгийн өндөр хувиар бууруулж чаддаг билээ.




| | |
|---|---|
| 8.99% Эрчим хүчний хэмнэлт | 99.78% Химийн бодисын зарцуулалт бага |
| 92.8% Усны хэмнэлт | 25.98% CO2 бууралт |



2024 оны Cashmere Reborn коллекцын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн тоо хэмжээгээ 2023 онтой харьцуулахад 26,768 ширхгээр буюу 6.5 дахин нэмэгдүүлэв.



# НИЙГЭМ

Говь ХК нь Монголын ноос, ноолуурын салбарын анхдагч, хувийн хэвшлийн томоохон ажил олгогч байгууллагын хувьд тогтвортой, эрүүл, аюулгүй ажлын байраар хангах, ажилтнуудынхаа эрх ашгийг хүндэтгэх, өсөж хөгжих боломжоор хангах зэргийг бидний үнэт зүйл хэмээн үзэж удирдлагын түвшинд хэд хэдэн холбогдох бодлогын баримт бичгийг батлав.



# ХҮНИЙ НӨӨЦИЙН СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ

НИЙТ АЖИЛТНЫ ТОО **1,652**

ДУНДАЖ НАС **36**

ЭРЭГТЭЙ **31%**

ЭМЭГТЭЙ **69%**



| | |
|---|---|
| 4% | 18-22 Generation Z |
| 57% | 23-38 Generation Y |
| 36% | 39-54 Generation X |
| 3% | 55-73 Baby Boomers |

ХҮҮХЭД АСРАХ ЧӨЛӨӨТЭЙ АЖИЛТАН **295**

### УДИРДЛАГЫН БАГ

ЭРЭГТЭЙ **38%**

ЭМЭГТЭЙ **62%**




### БАЙРШЛААР

• Улаанбаатар 1,615 • Дархан 3 • Хэнтий 34



### ЧИГ ҮҮРГЭЭР




• Хойд Америк 1 • Европ 12



Монгол улс - 99% Олон улс - 1%

# ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО

**20%**
Хүний нөөцийн эргэц

**0**
Аюул ослын давтамж (ХЭМАБ-ын бодлого)

**0**
Хөдөлмөрийн мөлжлөг, албадсан болон насанд хүрээгүй хүний хөдөлмөр эрхлэлт

Салбартаа өрсөлдөхүйц цалин, урамшуулал

Ажлын байрны таатай орчин, Ажил амьдралын тэнцвэрт байдал өрсөлдөхүйц цалин, урамшуулал

Ажилтнуудын хувийн өсөлт, хөгжил

Хөдөлмөрийн эрүүл, аюулгүй орчин

Ногоон ажлын байр

Ижил тэгш боломж

Тогтвортой нийгмийн хөрөнгө оруулалт

# ХҮНИЙ НӨӨЦИЙН ХАРИУЦЛАГАТАЙ МЕНЕЖМЕНТ




Говь ХК нь ажилтнуудын сайн сайхан байдлыг дэмжих, бүтээлчээр ажиллах орчныг бүрдүүлэх, хүний нөөцийн хариуцлагатай менежментийг хэрэгжүүлэх зорилгоор **Culture at GOBI** буюу байгууллагын соёлын хүрээнд дээрх 5 агуулгын хүрээнд төсөл хөтөлбөрүүдийг үе шаттай хэрэгжүүлэн ажиллаж байна.

2.1 тэрбум ₮+

2024 онд шим тэжээл бүхий эрүүл хоолны зардалд

407,890 ажилтан

Үйлчлүүлсэн ажилтны тоо /давхардсан тоогоор/

### Ажилтны цайны газар

Компанийн хэмжээнд “Ажилтны цайны газар” үйл ажиллагаа явуулж ажилтнуудад шим тэжээлтэй хоолоор үнэ төлбөргүй үйлчилдэг. 2024 оны 4-р сараас эхлэн Кето, Веган хоолны сонголтыг нэмж үйлчилж эхэлсэн.

48.8 сая ₮

Цэцэрлэгийн үйл ажиллагааны зардал

180 хүүхэд

2024 оны хичээлийн жилд хамрагдсан хүүхдүүд

### ГОВЬ-ийн багачууд цэцэрлэг

Ажилтнуудын ажил амьдралын тэнцвэртэй байдлыг хангах, хүүхдүүдийг чанартай боловсрол, хөгжих орчноор хангах зорилгоор 2022 оноос хойш байгууллагын дэргэдэх цэцэрлэг жилийн дөрвөн улирал тасралтгүй үйл ажиллагаагаа явуулж байна. 2024-2025 оны хичээлийн жилд 180 хүүхэд хамрагдсан.



### Цусны донорын өдөрлөг

2024 оны 9-р сард нийгмийн хариуцлагын хүрээнд хүрээнд “Цус сэлбэлтийн үндэсний төв”-тэй хамтран “Цусны донорын өдөрлөг”-ийг 31 дэх жилдээ амжилттай зохион байгуулав. Энэхүү уламжлалт арга хэмжээнд Говь ХК-ийн 67 ажилтан сайн дураараа оролцож, цусаа хандивласнаар нийт 201 хүнд амьдрал бэлэглэх боломж бүрдүүлсэн.



### Уян хатан ажлын цаг

Замын хөдөлгөөний түгжрэлээс урьдчилан сэргийлэх, ажилтнуудын ажил амралтын цагийг тэнцвэржүүлэх, хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор 4 дэх жилдээ ажлын уян хатан цагийн системийг оффисын +500 ажилтнуудад хэрэгжүүлж байна.
Ажилтнуудын ажил амралтын цагийг тэнцвэржүүлэх, хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор сүлжмэлийн үйлдвэрийн нярай болон цэцэрлэгийн насны хүүхдүүдтэй сүлжмэл бүтээгдэхүүний 24 оёдолчныг богиносгосон цагаар ажиллуулж байна.



# ЭРҮҮЛ, АЮУЛГҮЙ АЖЛЫН БАЙР

Аливаа компанийн бүхий л нөөцүүдээс хамгийн үнэт нөөц, баялаг нь ажилтан учир бид ажилтнуудынхаа өсч дэвжих таатай орчныг бүрдүүлэх, ижил тэгш оролцоогоор хангах бодлого баримтлан ажиллаж байна.

Бид ажилтнуудынхаа хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандартыг хангах зорилгоор хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг мэргэжлийн байгууллагаар тогтмол хийлгэдэг. Үнэлгээний хүрээнд ажлын байрны агаарын чанар, гэрэлтүүлэг, дуу чимээ, температур, тоосжилт зэрэг эрүүл мэндэд нөлөөлөх бүхий л хүчин зүйлсийг нарийвчлан судалж, холбогдох стандарт, дүрэм журамд нийцэж буй эсэхийг шалган, үр дүнд нь тулгуурлан ажлын орчны аюулгүй байдлыг улам сайжруулах, хөдөлмөрийн нөхцөлийг тохиромжтой түвшинд байлгах зорилгоор тодорхой арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж байна.

9,569,406

хүн/цаг

### Хугацаа алдсан гэмтэлгүй ажилласан цаг

Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг чанд баримтлан ажилласны үр дүнд 2024 онд 9,569,406 хүн/цаг – ийг хугацаа алдсан гэмтэлгүйгээр ажиллав.



### Урьдчилан сэргийлэх вакцин

Түүхий эдийн онцлогоос хамаарч түүхий ноолууртай шууд харьцаж ажилладаг ажилтнууд хачигт хазуулах эрсдэл өндөр байдаг тул тус эрсдэлд өртөх магадлалтай 40 ажилтныг давхардсан тоогоор хачигт халдвараас урьдчилан сэргийлэх 65 тун вакцинд хамруулсан. Энэхүү арга хэмжээг бид жил бүр түүхий эд татан авч эхлэхээс өмнө буюу 2-3-р сард багтаан тогтмол хийж заншсан.



### Эрүүл мэндийн хугацаат үзлэг

2024 оны 5,6 болон 10-р сарууд хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажилладаг 198 ажилтан, хэвийн нөхцөлд ажилладаг 573 ажилтан, нийт 771 ажилтан Эрүүл мэндийн хугацаат үзлэгт хамрагдав.



### Ундны усны шинжилгээ

Байгууллагын хэмжээнд ундны усны шинжилгээг MNS 9000:2018 стандартад нийцүүлэн 69 цэгт тогтмол хийдэг бөгөөд унд эрүүл ахуйн усны стандартад нийцсэн, цэвэр аюулгүй, нянгийн бохирдолгүй хариу гарав.



### Анхны тусламж үзүүлэгч сургалт

2024 оны 6-р сард ажилтнуудынхаа хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор “Анхны тусламж, эрүүл мэндийн төгс төв”-тэй хамтран “Анхны тусламж үзүүлэгч” сургалтыг зохион байгуулсан ба нийт 8 цагийн сургалтад 52 ажилтан амжилттай хамрагдав.



### Эрүүл мэндийн даатгал

Говь ХК нь ажилтнуудынхаа эрүүл мэндийг хамгаалах, тэдэнд найдвартай даатгалын үйлчилгээ хүргэх зорилгоор 2024 оны 4-р сард МИГ Даатгал компанитай хамтран нэг жилийн хугацаатай гэрээ байгуулж, 630 ажилтныг гэр бүлийн хамт сайн дурын эрүүл мэндийн даатгалд хөнгөлөлттэй нөхцөлөөр хамруулав.

# АЖИЛТНУУДЫН ӨСӨЛТ ХӨГЖИЛ

Манай компани ажилтнуудынхаа мэдлэг ур чадварыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэн мэргэшүүлэх, чадавхжуулах, хөрвөх чадвар бүтээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн ажлын байран дээрх болон танхимын сургалтуудыг гадаад, дотоод эх үүсвэрээс зохион байгуулахаас гадна олон улсын хэмжээнд мэргэшүүлэх шаардлагатай ажилтнуудаа гадаад оронд сургалтад хамруулдаг.

### 2024 ОНЫ СУРГАЛТЫН МЭДЭЭЛЭЛ

**1.34 хүн/цаг**
1 ажилтанд ногдох сургалтын хүн цаг

**2,134 ажилтан**
Сургалтад хамрагдсан ажилтны тоо

**278 сургалт**
Нийт зохиогдсон сургалтын тоо хэмжээ

**190.8 сая ₮**
Сургалтын зардал

| | |
|---|---|
| **ГАДААД ОРНЫ СУРГАЛТ** | · 6 удаагийн сургалт<br>· 14 ажилтан хамрагдсан<br>· Зардал 36.3 сая төгрөг |
| **ГАДНЫН БАЙГУУЛЛАГЫН СУРГАЛТ** | · 68 удаагийн сургалт<br>· 266 ажилтан хамрагдсан<br>· Зардал 125.6 сая төгрөг |
| **ДОТООД СУРГАЛТ** | · 192 удаагийн сургалт<br>· 1,818 ажилтан хамрагдсан<br>· Зардал 0 төгрөг |
| **SCHOLARSHIP ХӨТӨЛБӨРИЙН СУРГАЛТ** | · Бакалавр зэргээр 4 жилийн сургалт<br>· 6 ажилтан хамрагдсан<br>· Зардал 22.0 сая төгрөг |
| **ХЭНТИЙ САЛБАР ҮЙЛДВЭРИЙН СУРГАЛТ** | · Чадамжийн гэрчилгээ олгох сургалт<br>· 12 удаагийн 96 цагийн сургалт<br>· 30 ажилтан хамрагдсан<br>· Зардал 6.9 сая төгрөг |



# ХҮНИЙ ЭРХ, ЖЕНДЕРИЙН БОДЛОГО

Бид 2024 оны 4-р улиралд “Говь ХК-ийн Хүний эрх, Жендерийн бодлого”-ыг Төлөөлөн удирдах зөвлөлийн түвшинд хэлэлцэн батлав. Энэхүү бодлогоороо дамжуулан байгууллагын үйл ажиллагаанаас хүний эрхэд үзүүлж буй сөрөг нөлөөллийг илрүүлэх, түүнээс урьдчилан сэргийлэх, бууруулах, сөрөг нөлөөллөөс үүдэн хүний эрхийн зөрчил гарсан тохиолдолд эрхийг сэргээх механизмыг хэрэгжүүлэх юм. Түүнчлэн уг бодлогын хамрах хүрээ нь зөвхөн байгууллагын ажилтнуудаар хязгаарлагдахгүй бөгөөд ханган нийлүүлэлтийн сүлжээн дэх түүхий эд бэлтгэн нийлүүлэгчид, үйлдвэрлэл, борлуулалт, хэрэглэгч, үйлчлүүлэгч зэрэг бүх оролцогч талуудыг хамарч байгаагаараа онцлог юм. Бид энэхүү бодлогын хэрэгжүүлэх хэд хэдэн зорилтод чиглэсэн арга хэмжээнүүдийг тодорхойлсон.

### ЗОРИЛТОД ЧИГЛЭСЭН АРГА ХЭМЖЭЭ

- Байгууллагын удирдлагын зүгээс хүний эрхийг дээдлэх, олон улсын жишигт нийцүүлэх цогц бодлогыг хэрэгжүүлж, зөв манлайлал, үлгэр дууриалал үзүүлэх.
- Нийт ажилтнууд болон бэлтгэн нийлүүлэгчид, оролцогч талуудад хүний эрх, жендерийн эрх тэгш байдлын үндсэн зарчмуудын талаар сургалтын арга хэмжээг тогтмол зохион байгуулах.
- Байгууллагын үйл ажиллагаа ба ханган нийлүүлэлтийн сүлжээн дэх хүний эрх жендерийн болзошгүй эрсдэлийг тодорхойлох, бууруулах зорилгоор хүний эрхийн магадлан шинжилгээ (ХЭМШ) хийх.
- Хүний эрхийн магадлан шинжилгээний үр дүнд залруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх ба уг чиглэлээр гарч буй хууль тогтоомж, олон улсын шилдэг туршлагыг хэрэгжүүлэх.
- Гомдол барагдуулах системийг найдвартай, хүртээмжтэй байдлаар хэрэгжүүлж, тасралтгүй сайжруулах

# НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН БОДЛОГО

Говь ХК нь нийгмийн хариуцлагын хүрээнд нийгмийн сайн сайхан байдал, амьдрах тавлаг орчин, малчдын амьжиргааг сайжруулахад чиглэсэн санал санаачилгыг дэмжих, нийгэмд эерэг нөлөөлөл үзүүлж, бизнесийн тогтвортой, хүртээмжтэй, хариуцлагатай байдлаар оролцогч талуудаа манлайлагч болж ажиллахаа амлан 2024 оны 4-р улиралд Нийгмийн хариуцлагын бодлогыг Төлөөлөн удирдах зөвлөлөөс батлав.

### ЗОРИЛТОД ЧИГЛЭСЭН АРГА ХЭМЖЭЭ

**Малчдын тогтвортой амьжиргааг дэмжих**

Тогтвортой мал аж ахуй, зохистой бэлчээрийн дадлыг бий болгох замаар малчдын амьжиргааг дээшлүүлэх.

**Малын тавлаг байдлыг хангах**

Мал амьтанд хүнлэг байдлаар хандах буюу түүхий эд бэлтгэх зохистой дадлыг түгээн дэлгэрүүлэх.

**Ажилтнуудын тав тухтай байдлыг хангах**

Бүх ажилтнуудыг эрх тэгш, хүртээмжтэй, нийцэмжит цалин хөлс, өсөн дэвжих боломжтой, аюулгүй ажиллах орчин нөхцөлөөр хангах.

**Олон нийтийг чадавхжуулах**

Малчин өрх, олон нийт, нийгмийн эмзэг бүлэг зэрэг иргэдийн амьжиргааны түвшнийг дээшлүүлэх дадал зуршил, боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх.

**Хэрэглэгчийн мэдлэг, оролцоог нэмэгдүүлэх**

Тогтвортой бүтээгдэхүүний талаар хэрэглэгчдийн мэдлэгийг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүний эдэлгээг уртасгах болон дахин боловсруулахад чиглэсэн хөтөлбөр хэрэгжүүлэх.

**Байгаль орчныг хамгаалах**

Үйлдвэрлэлээс байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага түвшинд байлгахад чиглэсэн арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх.





# НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ТӨСӨЛ

## ТОГТВОРТОЙ НООЛУУР, ГУРВАН ТАЛТ ХАМТАРСАН ТӨСӨЛ





Монгол улсын нийт хүн амын 9.6%, ажиллах хүчний 24.5%-ийг малчин иргэд эзэлдэг. Зонхилох буюу 98.1% нь уламжлалт аргаар, бэлчээрийн мал аж ахуйг, үлдсэн хэсэг нь фермерийн буюу эрчимжсэн мал аж ахуй эрхэлдэг. “Малчдын аж байдлын судалгаагаа” -аар малчин өрхийн нийт орлогын 58%-ийг ямааны ноолуур дангаараа бүрдүүлдэг ажээ.

Сүүлийн жилүүдэд ямааны тоо толгой нэмэгдэж буй нь дэлхий дахинд ихээхэн шүүмжлэл дагуулах сэдэв болсон. Байгаль орчин, цөлжилтийн асуудлыг зөвхөн ямааны тоо толгойтой шууд холбож ойлгох, тоо толгойг бууруулах нь шийдэл гэж үзэж буй нь өөрөө малчдын амьжиргаатай холбоотой нийгмийн бусад асуудлуудыг дагуулах магадлалтай. Тиймээс байгаль орчиндоо ээлтэйгээр, малчин иргэдийнхээ орлогын эх үүсвэрт сөргөөр нөлөөлөхгүйгээр уламжлалт мал аж ахуйн салбараа хөгжүүлэн авч үлдэх нь манай улсын хөгжлийн том сорилт болоод байна.

Говь ХК нь хөнгөн үйлдвэрийн салбарын түүчээлэгчийн хувьд дээрх асуудлын шийдэлд өөрийн хувь нэмрээ оруулах зорилгоор Монгол улсын тогтвортой хөгжлийн зорилтуудад нэгдэж байгууллагынхаа байгаль орчин, нийгэм, засаглалын зорилгын хүрээнд “Тогтвортой ноолуур, гурван талт төсөл” -ийг хэрэгжүүлж буй юм.

Уг төсөл нь Шинжлэх ухаан – Үйлдвэрлэл – Мал аж ахуй эрхлэгчдийн уялдаа холбоог бэхжүүлж, малын эрүүл мэндэд анхаарах, тухайн орон нутгийн онцлогт тохирсон үүлдэр угсааг дэлгэрүүлэх, шинэ залуу малчдыг ямааны ноолуур бэлтгэлийн зөв технологид дадуулах, улмаар түүхий эдийн гарц, чанарыг сайжруулах юм. Нэг малаас гарах түүхий эдийн чанар, гарц сайжирснаар малын ашиг шим нэмэгдэж, тоо толгой багасан улмаар байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахаас гадна мал маллагааны ачааллыг багасгах сайн талтай.

**Голчийн харьцуулсан үзүүлэлт, микрон**




2023 оноос эхлэн малчдын бэлтгэсэн түүхий эдийг шууд худалдан авах арга хэмжээг зохион байгуулж эхэлсэн бөгөөд тус ноолуураар “Responsible Collection” хэмээх коллекцийг тусгайлан үйлдвэрлэж 2024 оны 3-р сард Европын холбооны улсад худалдаалж эхэлсэн. 2024 онд төслийн малчдаас 10.7 тонн ноолуур худалдан авсан нь өмнө оноос 2.8 дахин өсөв.

Энэхүү төсөл нь 2020 оноос эхлэн өдгөө 4 дэх жилдээ амжилттай үргэлжилж байгаа бөгөөд Хөвсгөл аймгийн Их-Уул сум, Баянхонгор аймгийн Жинст сумын 100 гаруй малчид хамрагдаж, чанартай, тогтвортой түүхий эд бэлтгэх шаардлагуудад суралцан, хэрэгжүүлж байна. Бид жил бүр төслийн үйл ажиллагааг дүгнэн, ноолуурын чанарыг тогтмол шинжилж байдаг бөгөөд 2024 оны түүхий эдийн шинжилгээний дүнгээс харвал малчдын бэлтгэж буй ноолуурын хаг, хогт хольцын хэмжээ эрс буурсан бөгөөд ноолуурын голчин хэмжээ 3.4%-аар нарийссан үзүүлэлттэй байна.




## АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНКТАЙ ХАМТАРСАН БЭЛЧЭЭРИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨСӨЛ

“Тогтвортой ноолуур, гурван талт хамтарсан төсөл”-ийн үндсэн үйл ажиллагаанд тулгуурлан Азийн Хөгжлийн Банкны санхүүжилтээр уур амьсгалын өөрчлөлтөд малчдыг бүлгэмээр дасан зохицуулах, бэлчээрийн тогтвортой менежментийг бий болгох туршилтын төслийг 2025-2029 он хүртэл 5 жилийн хугацаатай хэрэгжүүлэхээр төслийн зөвлөх Очир Консалтинг ХХК болон Хөдөө Аж Ахуйн Их Сургуультай хамтран ажиллаж байна.

Цаашид уг төслийн хүрээнд малчид уур амьсгалын өөрчлөлт болоод бэлчээрийн зохистой менежментэд суралцаж, бэлчээрийн олон янзын шийдлүүдийг судлах, бодитойгоор туршиж, боломжит хувилбаруудыг цаашдын мал маллагаандаа хэрэгжүүлэх боломж бүрдэх юм.

## ТОГТВОРТОЙ ХАМТЫН АЖИЛЛАГАА - АДАПТ ТӨСӨЛ



ГОВЬ ХК нь “Уур амьсгалд тэсвэртэй, тогтвортой хөгжлийн шалгуур хангасан мал аж ахуйн бүтээгдэхүүнийг дэмжих, зах зээлтэй холбох” зорилго бүхий Адапт төслийн малчид, хоршоодын төлөөлөлтэй чанар, стандартын шаардлага хангасан түүхий эдийг зах зээлийн үнээр, тогтвортой нийлүүлэх чиглэлээр “Хамтран ажиллах санамж бичиг”-ийг байгууллаа.

АДАПТ төсөл нь Уур амьсгалын Ногоон сангийн санхүүжилтээр хэрэгжиж байгаа бөгөөд НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр (НҮБХХ), БОУАӨЯ, ХХААХҮЯ хамтран Ховд, Завхан, Дорнод, Сүхбаатар аймагт 2021-2028 онд хэрэгжих юм.



## НООЛУУРЫН САЛБАР

Монгол Улсад 2024 онд 22.9 сая тоо толгой ямаан сүрэг тоологдсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.7 сая буюу 7%-аар буурсан үзүүлэлттэй байна.

Манай улс 2024 онд 10.0 мянга орчим тонн ноолуур бэлтгэсэн нь өмнөх оноос 0.5 мянган тонн буюу 5%-аар өссөн үзүүлэлт бөгөөд дэлхийн түүхий ноолуурын 40%-ийг хангаж байна.

2024 онд ноолуурын дундаж үнэ 165.2 мянган төгрөг байсан нь өмнөх оноос 22%-аар өссөн байна. Энэ нь 2024 онд өвөлжилт хүндэрснээс малын тоо толгой буурч, малын гаралтай бүтээгдэхүүний үнэ өссөнтэй холбоотой.




**СҮҮЛИЙН 5 ЖИЛИЙН МОНГОЛ УЛСЫН НООЛУУРЫН САЛБАРЫН ТООН МЭДЭЭЛЭЛ**

**Монгол улсын ямааны тоо толгой /сая/**




*Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо*

**Монгол улсын түүхий ноолуурын бэлтгэл /мянган тн/**




*Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо /тооцооллын аргаар/*

**Түүхий эдийн дундаж үнэ /мянган төгрөг/**




*Эх сурвалж: Монголын ноос ноолуурын холбоо*

**Ноолуурын зах зээл /тэрбум төгрөг/**




*/Түүхий ноолуурын дундаж ханшаар тооцоолов/*



# ЗАСАГЛАЛ

Говь ХК-ийн засаглалын тогтолцоо нь хувьцаа эзэмшигчид, удирдлагууд болон бусад оролцогч талуудын ашиг сонирхлын тэнцвэрийг хангаж, компанийн зорилт, үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тодорхойлох, хэрэгжүүлэх, хянахад чиглэсэн бүтэц, зохицуулалтын нийлбэр юм.



# ЗАСАГЛАЛЫН БҮТЭЦ, ҮЙЛ АЖИЛЛАГАА

Говь ХК-ийн засаглалын тогтолцоо нь хувьцаа эзэмшигчид, удирдлагууд болон бусад оролцогч талуудын ашиг сонирхлын тэнцвэрийг хангаж, компанийн зорилт, үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тодорхойлох, хэрэгжүүлэх, хянахад чиглэсэн бүтэц, зохицуулалтын нийлбэр юм.

Бид олон нийтэд нээлттэй хувьцаат компанийн хувьд Компанийн тухай хууль, Монголын компанийн засаглалын кодекс, олон улсын сайн засаглалын туршлагаас суралцан засаглалын тогтолцоогоо тасралтгүй сайжруулан, холбогдох хууль дүрэм журмуудын хэрэгжилтийг хангаж, улсдаа компанийн засаглалаар тэргүүлсэн үлгэр жишээ компани болохыг зорин ажилладаг.




Хувьцаа эзэмшигчдийн хурлаас Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)-ийг томилдог бөгөөд ТУЗ нь хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчдынхаа эрх ашгийг хангах, хөрөнгийн өгөөж үр ашгийг нэмэгдүүлэх, компанийн гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавин, оновчтой чиглүүлгээр хангаж ажиллахыг зорьдог.

ТУЗ-ийн дэргэд Нэр дэвшүүлэх хороо, Цалин урамшууллын хороо, Эрсдэл аудитын хороо гэсэн 3 хороо үйл ажиллагаа явуулан тус бүрийн чиг үүргийнхээ дагуу бодлогыг хэрэгжүүлэн компанийн Менежмент багийнхны үйл ажиллагаанд хяналт тавин дүгнэлт өгч, үр дүнгээ ТУЗ-д тайлагнан ажилладаг.

Эрсдэл аудитын хорооны харьяанд Дотоод аудитын хэлтсийг ажиллуулан компанийн хэмжээнд хараат бусаар дотоод хяналтыг хэрэгжүүлдэг.

ТУЗ-ийн харьяанд ТУЗ-ийн ажлын алба ажилладаг ба ТУЗ-ийн үйл ажиллагаа болон компанийн засаглалын дотоод зохион байгуулалтыг хариуцдаг.



# ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО




Говь ХК нь урт хугацааны хөрөнгө оруулалт, санхүүгийн тогтвортой байдал, бизнесийн тасралтгүй байдлыг хангахад шаардлагатай итгэлцэл, ил тод байдал, хариуцлагын орчныг бүрдүүлж, бүхий л оролцогч талын эрх ашгийн тэнцвэртэй байдлыг хангасан шударга, ёс зүйтэй засаглалын тогтолцоог бүрдүүлэх бодлогыг баримтлан ажиллаж байна.

## ЗАСАГЛАЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТУУД

1. Оролцогч талуудын эрх ашгийг хангах
2. ТУЗ-ийн зохистой бүтэц зохион байгуулалтыг бүрдүүлэх
3. Тайлагнал мэдээллийн ил тод байдлыг хангах
4. Шударга ёс зүйтэй үйл ажиллагаа явуулах
5. Хяналтын тогтолцоог бүрдүүлэх
6. Компанийн соёлыг төлөвшүүлэх
7. Цалин урамшууллын зохистой системийг бүрдүүлэх
8. Тогтвортой хөгжлийн үйл ажиллагааг хөгжүүлэх
9. Компанийн засаглалыг сайжруулах

## ЗАСАГЛАЛЫН ЗАРЧИМУУД

- Ил тод байдлыг хангах
- Бүх оролцогч талын эрх ашгийн тэнцвэртэй байдлыг хангах
- Хууль, дүрэм журмыг мөрдөх
- Шударга, ёс зүйтэй байх
- Хяналт, хариуцлагын тогтолцоог бүрдүүлэх
- Байгууллагын соёлыг төлөвшүүлэх
- Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх
- Тасралтгүй сайжруулах

Бид 2024 онд компанийн сайн засаглалыг бэхжүүлэн сайжруулах зорилтын хүрээнд дараах ажлуудыг хийсэн.

## БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН БҮРДЛИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛГООР ТУЗ-ӨӨС БАТАЛСАН БОДЛОГО, ЖУРМУУД

### НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛСАН

- Цалин урамшууллын бодлого
- Комплайнсын бодлого
- Шүгэл үлээх тогтолцооны үйл ажиллагааны журам
- ТУЗ-ийн өөрийн үнэлгээний асуулга

### ШИНЭЭР БАТАЛСАН

- ТУЗ-ийн гишүүдийн цалин, хангамж, урамшууллын зарчим
- Хувьцааг худалдан авах шаардах эрхийг хэрэгжүүлэх журам
- Тогтвортой хөгжлийн стратегийн бодлого
- Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах бодлого
- Хүний эрх, жендерийн бодлого
- Нийгмийн хариуцлагын бодлого

## ЗАСАГЛАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛГООР ХИЙГДСЭН АЖЛУУД

- Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийн тайланг 2 удаа хийн Санхүүгийн зохицуулах хороогоор хянан баталгаажуулалт хийлгэсэн бөгөөд үнэлгээгээр Монголын нээлттэй хувьцаат компаниудаа тэргүүлсэн үзүүлэлттэй байв.
- Хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагч нарынхаа оролцоог хангах, компанийн үйл ажиллагаатай биечлэн танилцуулах, тэдний санал хүсэлтийг үйл ажиллагаандаа тусгах зорилгоор 2024 онд шинэ коллекцитой танилцах арга хэмжээ болон үйлдвэртэй танилцах аяллыг тус бүр 2 удаа зохион байгуулсан.
- Мөн үйлдвэртэй танилцах аяллын үед компанийн удирдлага болон ТУЗ-ийн хараат бус гишүүн хувьцаа эзэмшигчдийг хүлээн авч уулзан нээлттэй хэлэлцүүлэг хийсэн.
- ТУЗ-ийн хараат бус гишүүний сонгон шалгаруулалтыг анх удаа олон нийтэд нээлттэй зарлах байдлаар зохион байгуулсан.
- Шинээр ТУЗ-ийн бүрэлдэхүүнд орсон гишүүдэд компанийн үйл ажиллагаа, засаглалын тогтолцооны талаар чиглүүлэх сургалт орсон.
- Мэдээллийн хүртээмжтэй, ил тод байдлыг сайжруулах, гадаад хөрөнгө оруулагчдыг тухай бүр мэдээллээр хангах үүднээс компанийн албан ёсны мэдээ, мэдэгдэл, улирал ба жилийн тайлангууд болон ТУЗ-ийн тогтоолуудыг англи ба монгол хэл дээр давхар хүргэн ажиллалаа.
- ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэл, аудитын хорооны чиг үүрэгт комплайнсын хяналтын чиг үүргийг нэмж оруулан 2 удаагийн ээлжит хурлаар үйл ажиллагаа нь танилцан, чиг удирдлагаар хангаж ажилласан.
- 2024 оныг хүртэл бодлогын баримт бичгийн бүрдлийг сайжруулах дээр анхаарч шинээр олон бодлого журмуудыг батласан бол энэ оноос эхлэн эдгээр баримт бичгүүдийн хэрэгжилтийг сайжруулах зорилгоор нийцлийн үнэлгээг хийсэн. Тус үнэлгээг Дотоод аудитын хэлтэс хөндлөнгөөс дахин үнэлж давхар хяналтыг хийх бөгөөд 2025 оны 1-р улирлыг дуустал үргэлжлэх төлөвлөгөөтэй байна.



# ОРОЛЦОГЧ ТАЛУУДТАЙ ХАМТЫН АЖИЛЛАГАА

### ОРОЛЦОГЧ ТАЛУУДТАЙ ХАМТРАН АЖИЛЛАХ УДИРДЛАГЫН ЗОРИЛГО

- Үйлдвэр, үйл ажиллагааны ойролцоох орших суугч иргэд, бэлтгэн нийлүүлэгчид болон малчид, хэрэглэгч, төр захиргааны байгууллага, судалгаа шинжилгээний байгууллага, төрийн бус байгууллага, хөрөнгө оруулагчид, банк санхүүгийн байгууллага, иргэний нийгмийн байгууллагуудтай харилцан итгэлцэл, нээлттэй ил тод байдал, нэгдмэл сонирхолд үндэслэсэн тогтвортой харилцаа бий болгоно.
- Бэлтгэн нийлүүлэгч, малчдын чадавхыг бэхжүүлж, уламжлалд суурилсан байгальд ээлтэй, хүний эрхийг дээдэлсэн ахуй соёлын мэдлэгийг бий болгон, хамтын ажиллагааг идэвхтэй хөгжүүлнэ.

### УДИРДЛАГЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗАРЧИМ

Говь ХК нь бүхий л үйл ажиллагаа, төслөөс бүх талуудын оролцоог ижил түвшинд чухалчлан, үйл ажиллагааны ил тод байдлыг эрхэмлэн олон талт ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрч, нээлттэй бөгөөд харилцан хүндэтгэлтэйгээр санал бодлоо солилцон нийгэм, хүрээлэн буй орчин, оролцогч талуудад болон хийсэн үйлдэл, үр дүндээ хариуцлагатай хандаж, тогтвортой хөгжлийн зорилгод тэмүүлж ажиллана.

## ОРОЛЦОГЧ ТАЛУУДТАЙ ХАРИЛЦАХ, ХАМТРАН АЖИЛЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ /2023-2025 ОН/

| Д/д | Оролцогч талууд | Зорилго | Харилцаа, хамтын ажиллагаа | Давтамж |
|---|---|---|---|---|
| 1 | Үйлдвэрийн үйл ажиллагааны ойр орчим орших суугч иргэд, байгууллагын ажилтнууд | Үйл ажиллагааны тухай мэдээлэл хүргэх, санал гомдол хүлээн авч оролцогч талуудын итгэлцлийг бүрдүүлэх | Харьяалах хорооны удирдлагын ордонд Говь ХК-ийн Мэдээллийн самбар байршуулж, дараах мэдээллийг түгээх:<br>• Үйл ажиллагааны ерөнхий мэдээлэл<br>• Нийгмийн эрүүл мэнд, аюулгүй байдлын журам танилцуулах<br>• Санал, гомдол хүлээж авах, барагдуулах механизмыг танилцуулах | Улирал, хагас жил |
| 2 | Бэлтгэн нийлүүлэгчид (малчин, хоршоо, компани) | Түүхий эдийн чанарын шаардлагаас гадна, хүний эрх, байгаль орчин хамгаалах тухай мэдлэг олгож бүтээгдэхүүний хүн ба байгаль орчинд ээлтэй, органик нэр хүндийг баталгаажуулах | • Говь ХК-ийн үйл ажиллагаатай танилцах аялал зохион байгуулах<br>• Хүний эрх, байгаль орчин хамгаалах чиглэлээр сургалт сурталчилгаа зохион байгуулах<br>• Санал, гомдол хүлээж авах, барагдуулах механизмыг танилцуулах | Хагас жил, жилээр |
| 3 | Гэрээт гүйцэтгэгчид, тэдний ажилтнууд | Зохистой хөдөлмөр эрхлэлтийн ойлголтыг төлөвшүүлж, хүний эрхийг хүндэтгэхэд хамтын чармайлт гаргах | • Гэрээт, гүйцэтгэгчийн менежментийн төлөвлөгөөг хэлэлцэж, баталгаажуулах, зохистой хөдөлмөр эрхлэлт ба байгаль орчны шаардлагуудыг гэрээнд оруулах, мөрдүүлэх<br>• Санал, гомдол хүлээж авах, барагдуулах механизмыг танилцуулах | Тухай бүр |
| 4 | Үйлчлүүлэгчид, хэрэглэгчид | Зохистой хэрэглээг сурталчлан таниулах, итгэлцлийг бүрдүүлэх | • Нээлттэй хаалганы өдөр зохион байгуулах<br>• Дэлгүүрүүдэд үйлчлүүлэгчийн мэдээллийн самбар ажиллуулах<br>• Санал, гомдол хүлээж авах, барагдуулах механизмыг танилцуулах | Жилээр |
| 5 | Эмзэг бүлэг | Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, бусад нийгмийн эмзэг бүлэгт нийгэмших зан үйлд дэмжлэг болох | • Нийгмийн нөлөөллийн ажлууд зохион байгуулах<br>• Тусгай зориулалтын сургууль, цэцэрлэгтэй хамтарч ажиллах<br>• Брэндингийн мэдээлэлд Брайль үсэг ашиглах боломж эрэлхийлэх | Тухай бүр |

Үйлдвэр, үйл ажиллагааны ойролцоох оршин суугч иргэд, бэлтгэн нийлүүлэгчид болон малчид, хэрэглэгч, төр захиргааны байгууллага, судалгаа шинжилгээний байгууллага, төрийн бус байгууллага, хөрөнгө оруулагчид, банк санхүүгийн байгууллага, иргэний нийгмийн байгууллагуудтай харилцан итгэлцэл, нээлттэй ил тод байдал, нэгдмэл сонирхолд үндэслэсэн тогтвортой харилцаа бий болгох зорилгоор боловсруулсан дээрх төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулан ажиллав.

### 1. Үйлдвэрийн үйл ажиллагааны ойр орчим оршин суугч иргэд, байгууллагын ажилтнууд




Говь ХК нь Хан-Уул дүүргийн 3-р хороонд байрладаг тул хорооны байранд байгууллагын мэдээллийг хүргэх мэдээллийн самбар тогтоов. Хан-Уул дүүргийн 3-р хорооны иргэдэд мэдээлэл хүргэх сургалт зохион байгуулав.

### 2. Бэлтгэн нийлүүлэгчид (малчин, хоршоо, компани)



2024 оны 3-р сарын 7-ны өдөр түүхий эд бэлтгэн нийлүүлэгчдийн төлөөлөл болсон нийт 20 хоршоодын удирдлагуудыг хүлээн авч уулзав. Тус арга хэмжээний хүрээнд Говь ХК-ийн Гүйцэтгэх захирал болон удирдлагууд, ХААИС-ийн эрдэмтэн багш нар хамтран ноолуурын салбарт тавигдаж буй олон улсын шаардлага, тогтвортой түүхий эд, ноолуур бэлтгэлийн зөв дадлын талаар илтгэл тавьж, татвар тайлагналтай холбоотой хэлэлцүүлэг өрнүүлэн, үйлдвэртэй танилцах аяллыг амжилттай зохион байгуулав.

Мөн манай компани 2024 онд түүхий эд худалдах, худалдан авах гэрээг шинэчилж, илүү тогтвортой байдал руу төвлөрч байна. Гэрээнд байгаль орчин, нийгэм, засаглалын шаардлагыг оруулж малчид болон хоршоотой гэрээ байгуулан ажиллав.

### 3. Гэрээт гүйцэтгэгч, ханган нийлүүлэгчийн удирдлагын журам



Говь ХК-ийн бизнесийн үйл ажиллагаанд оролцож буй гэрээт туслан гүйцэтгэгчид, ханган нийлүүлэгчдэд учирч болзошгүй аюул, эрсдэлийг илрүүлэх, түүнд хяналт тавих тогтолцоог тайлбарлан таниулах зорилгоор "Гэрээт гүйцэтгэгч, ханган нийлүүлэгчийн удирдлагын журам"-ыг 2023 онд батлагсан. Тус журмын хүрээнд гэрээт гүйцэтгэгч, ханган нийлүүлэгчид байгаль орчин, нийгэм, хөдөлмөрийн эрүүл мэнд аюулгүй байдлын чиглэлээр шаардлагуудыг тавин ажиллаж байна.

### 4. Үйлчлүүлэгчид, хэрэглэгчид



Бид хэрэглэгч, үйлчлүүлэгчдэд зориулан үйлдвэртэй танилцах аяллыг нээлттэйгээр зохион байгуулж эхэлсэн бөгөөд 2024 онд нийт 179 удаагийн үйлдвэртэй танилцах аялалд 2,234 зочин хамрагдав.

### 5. Эмзэг бүлэг

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор 2024 оноос эхлэн Монголын Хараагүйчүүдийн Үндэсний төвийн дэргэдэх Бэст массаж төвтэй хамтран ажилчдадаа толгой, хүзүү, мөрний бариа заслын үйлчилгээг үзүүлж эхэлсэн. Говь эмнэлгийн байранд 7 хоног бүрийн Мягмар гаригт хуваарийн дагуу ажилтнуудыг хамруулж байна.



## ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧИДТАЙ ХАРИЛЦАХ ХӨТӨЛБӨР

Говь ХК-ийн Засаглалын бодлогын хүрээнд дэвшүүлсэн Оролцогч талуудын эрх ашгийг хангах зорилтыг биелүүлэх, компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийг хангах, хөрөнгө оруулагчдад компанийн талаарх үнэн зөв мэдээ мэдээллийг тогтмол хүргэх, тэдний оролцоог сайжруулах зорилгоор ТУЗ-өөс "Хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөр"-ийг баталсан. ТУЗ-ийн ажлын алба нь тус хөтөлбөрийн хэрэгжилтийг хариуцдаг ба 2024 онд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллалаа. Үүнд:

- Компанийн санхүү, үйл ажиллагааны тайланг улирал бүр хүргэхээс гадна хөрөнгө оруулалтын шийдвэрт нөлөө үзүүлэхүйц мэдээ мэдээллийг тухай бүр холбогдох журмын дагуу бэлтгэн Монголын хөрөнгийн бирж болон компанийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд хүргэсэн.
- Гадаад хөрөнгө оруулагч нарт зориулан олон нийтэд хүргэх тайлан, мэдээ мэдээлэл болон ТУЗ-ийн тогтоол, дүрэм журмыг англи хэл дээр давхар бэлтгэн хүргэсэн.
- Хөрөнгө оруулагч болон оролцогч талуудад мэдээлэл хүргэх, санал хүсэлт, гомдлыг хүлээн авах үндсэн суваг болох компанийн цахим хуудасны (info.gobi.mn) агуулгыг тогтмол шинэчлэн, сайжруулалт хийсэн.
- Хувьцаа эзэмшигч нараас ирсэн санал хүсэлт, өргөдөл гомдлыг утсаар, и-мэйлээр, веб хуудсаар, биечлэн гэх мэт боломжит бүх сувгаар хүлээн авч бүртгэн, тухай бүр холбогдох удирдлагуудад мэдээлэл хүргэн шийдвэрлүүлж хувьцаа эзэмшигч нартай эргээд холбоо барьж үр дүнг мэдэгдэн, мэдээллээр ханган ажилласан.

### Хувьцаа эзэмшигч нарын үйлдвэртэй танилцах аялал

Хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагч нарынхаа оролцоог хангах, компанийн үйл ажиллагаатай биечлэн танилцуулах, тэдний санал хүсэлтийг үйл ажиллагаандаа тусгах зорилгоор 2024 онд дараах арга хэмжээг зохион байгуулсан. Үүнд:

- 2024 оны 3-р сарын 20-ны өдөр шинэ коллекцтой танилцах арга хэмжээг 2 удаа
- 2024 оны 4-р сарын 12, 9-р сарын 13-ны өдрүүдэд үйлдвэртэй танилцах аялал 2 удаа

Мөн 9-р сарын үйлдвэртэй танилцах аяллын үед компанийн удирдлага болон ТУЗ-ийн хараат бус гишүүн хувьцаа эзэмшигчдийг хүлээн авч уулзан нээлттэй хэлэлцүүлэг хийсэн.






# КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКСИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ

Говь ХК-ийн "Компанийн засаглалын кодекс"-ийн хэрэгжилтийг 2024 оны 6-р сарын 30 болон 12-р сарын 31-ний өдрийн байдлаар ТУЗ-ийн ажлын алба үнэлсэн бөгөөд үнэлгээний үр дүнг Санхүүгийн зохицуулах хороо хянан баталгаажуулсан болно.

| № | Гарчиг | Авбал зохих оноо | 2023.12.31 | | 2024.06.30 | | 2024.12.31 | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | СЗХ-ны хяналтын оноо | Хувь | СЗХ-ны хяналтын оноо | Хувь | СЗХ-ны хяналтын оноо | Хувь |
| 1 | ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт | 12 | 11 | 91.7% | 11 | 91.7% | 12 | 100.0% |
| 2 | ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг | 10 | 9 | 90.0% | 10 | 100.0% | 10 | 100.0% |
| 3 | Тайлагнал, мэдээллийн ил тод, байдал | 6 | 6 | 100.0% | 6 | 100.0% | 6 | 100.0% |
| 4 | Аудит, хяналтын тогтолцоо | 6 | 6 | 100.0% | 6 | 100.0% | 6 | 100.0% |
| 5 | Эрсдэлийн удирдлага | 8 | 8 | 100.0% | 8 | 100.0% | 8 | 100.0% |
| 6 | Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал | 6 | 6 | 100.0% | 6 | 100.0% | 6 | 100.0% |
| 7 | Оролцогч талуудын эрх ашиг | 8 | 8 | 100.0% | 8 | 100.0% | 8 | 100.0% |
| 8 | Компанийн соёл | 6 | 6 | 100.0% | 6 | 100.0% | 6 | 100.0% |
| 9 | Хувьцаа эзэмшигчдийн эрх | 10 | 10 | 100.0% | 10 | 100.0% | 9 | 90.0% |
| | Нэгдсэн дүн | 72 | 70 | 97.2% | 71 | 98.6% | 71 | 98.6% |

Үнэлгээний нэгдсэн дүнгээс харахад Говь ХК-ийн "Компанийн засаглалын кодекс"-ийн хэрэгжилтийн үнэлгээ нь 2023 оны эцсээр 97.2% буюу дунд засаглалтай байсан бол 2024 онд хагас жил болон жилийн эцсийн байдлаар 2 удаа дахин үнэлж, Санхүүгийн зохицуулах хорооны зүгээс хянан баталгаажуулалт хийсний үр дүнд 98.6% болж 1.4% өссөн буюу засаглал хэвийн, эрсдэлгүй гэж үнэлэгдсэн байна. **/Монгол улс дахь нээлттэй хувьцаат компаниуд дотроо эхний байранд үнэлэгдэв./**

Засаглалын үнэлгээний дэлгэрэнгүй тайлантай МХБ болон компанийн цахим хуудаснаас танилцах боломжтой.



# ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД




НИЙТ ХУВЬЦААНЫ ТОО

**780,112,500**

НИЙТ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТОО

**25,151**

*/2024.12.31-ний байдлаар/*

## НӨЛӨӨ БҮХИЙ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД

| Хувьцаа эзэмшигчийн нэр | 2023.12.31 | | 2024.12.31 | |
|---|---|---|---|---|
| | Хувьцааны тоо ширхэг | Эзэмшлийн хувь | Хувьцааны тоо ширхэг | Эзэмшлийн хувь |
| Таван Богд Холдингс ХХК | 400,140,072 | 51.29% | **681,267,736** | **87.33%** |
| Хиде Интер ХХК | 265,238,300 | 34.00% | - | - |

*Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч: Компанийн гаргасан саналын эрхтэй нийт хувьцааны 5 болон түүнээс дээш хувийг дангаараа, эсхүл холбогдох этгээдийн хамт эзэмшиж байгаа болон тэдгээрийн саналын эрхийг хууль болон гэрээнд заасны дагуу хэрэгжүүлж байгаа иргэн, хуулийн этгээдийг хэлнэ.*

**Нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн бүтцэд орсон гол өөрчлөлт**

2024 оны 3-р сард нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн бүтцэд томоохон өөрчлөлт орж Таван Богд Холдингс ХХК нь Говь ХК-ийн 87.33%-ийг эзэмшдэг болсон.

Үүнтэй холбоотойгоор Компанийн тухай хууль (КТХ)-ийн 53.2-д заасны дагуу "Таван Богд Холдингс" ХХК-ийн хувьцааны эзэмшил 75 хувийг давсан тул Говь ХК-ийн бусад хувьцаа эзэмшигчид хувьцааг эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах эрхийг КТХ-ийн 53 болон 54-р зүйлд заасны дагуу хуулийн хугацаанд хэрэгжүүлэх үүрэг Говь ХК-д үүссэн тул манай компани хуульд заасан үүргээ хэрэгжүүлэн, бусад хувьцаа эзэмшигчдийн эрхийг эдлүүлж, тэдний эрх ашгийг хангах зорилгоор "Бусад хувьцаа эзэмшигчдийн Хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах эрхийг хэрэгжүүлэх" шийдвэрийг гаргаж нэгж хувьцааг 268.26 төгрөгөөр эргүүлэн худалдаж авсан.

Тус шийдвэртэй холбоотой хувьцаа эргүүлэн худалдан авахыг компаниас шаардах эрх хэрэгжүүлэх хүсэлт гаргасан хувьцаа эзэмшигчдийн хүсэлтийг 2024 оны 4-р сарын 24-ний өдрөөс 2024 оны 6-р сарын 5-ны өдрийг дуустал цаасан болон цахим хэлбэрээр хүлээн авсан.

Дээрх хугацаанд нийт 96 хувьцаа эзэмшигчээс 3,427,017 ширхэг хувьцааг худалдах хүсэлт хүлээн авсан бөгөөд төлбөрийг 2024 оны 06-р сарын 12-ны өдөр хувьцаа эзэмшигчдийн үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн дансанд нь байршуулсан болно. Шаардах эрхийг хуулийн дагуу хэрэгжүүлсэн тухай тайланг бэлтгэн 2024 оны 6-р сарын 13-ны өдөр СЗХ, МХБ-д хүргэсэн.

# НЭГДМЭЛ СОНИРХОЛТОЙ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН МЭДЭЭЛЭЛ

| Д/д | Компанийн нэрс | Д/д | Компанийн нэрс |
|---|---|---|---|
| 1 | Таван Богд Холдингс ХХК | 21 | Таван Богд Билдинг Саплай ХХК |
| 2 | Таван Богд Интернэйшнл ХХК | 22 | Таван Богд Тэтгэврийн Хуримтлал ХХК |
| 3 | Таван Богд Дистрибьюшн ХХК | 23 | Таван Богд Моторс ХХК |
| 4 | Таван Богд ХХК | 24 | Гэрлүг Виста Сервис ХХК |
| 5 | Эйрлинк Монголиа ХХК | 25 | Таван Богд Нура ХХК |
| 6 | Улаанбаатар Гурил ХХК | 26 | Ти Би Эм Өү ХХК |
| 7 | Жуулчин ХХК | 27 | Таван Богд Автомотив ХХК |
| 8 | Жуулчин Дюти Фрий ХК | 28 | Таван Богд Дилер ХХК |
| 9 | Файв Старс Ин Хархорин ХХК | 29 | Жуулчин Фүүдс ХХК |
| 10 | Хаан Палас ХХК | 30 | Горхийн Чулуу ХХК |
| 11 | Сэргэлэн Резорт ХХК | 31 | Говийн Од Групп ХХК |
| 12 | Таван Богд Фүүдс ХХК | 32 | Таванбогд Констракшн Машинери ХХК |
| 13 | Таван Богд Фүүдс Пицца ХХК | 33 | Таван Богд Ассет Менежмент ХХК |
| 14 | Улаанбаатар Принт ХХК | 34 | Juulchin World Gmbh /ХБНГУ/ |
| 15 | Таван Богд Фууд Сервис ХХК | 35 | Саппортсервисес Монголиа ХХК |
| 16 | Таван Богд Проперти ХХК | 36 | Хаан Банк ХК |
| 17 | Таван Богд Хаус ХХК | 37 | Тэмүүжин цогцолбор ХХК |
| 18 | Таван Богд Резиденс ХХК | 38 | Жуулчин Туризм Корпорэйшн ХХК |
| 19 | Таван Богд Финанс ББСБ ХХК | 39 | Ар И Ди Эженси ХХК |
| 20 | Таван Богд Капитал ҮЦК ХХК | 40 | Вайт Маркетинг Эйженси ХХК |

## ЭЦСИЙН ӨМЧЛӨГЧИЙН МЭДЭЭЛЭЛ

| Д/д | Овог, нэр | Иргэний харьяалал | Эзэмшлийн хувь | |
|---|---|---|---|---|
| | | | Хувь хүн | Нэгдмэл сонирхолтой хуулийн этгээд |
| 1 | Цагаач БААТАРСАЙХАН | Монгол | 0.006% | Таван Богд Холдингс ХХК 87.33%<br>Таван Богд ХХК 0.40%<br>Таван Богд Капитал ҮЦК ХХК 0.04% |



# ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

Говь ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн эрхээ хэрэгжүүлэх гол хэлбэр нь Хувьцаа эзэмшигчдийн хурал бөгөөд Хувьцаа эзэмшигчдийн хурал нь компанийн эрх барих дээд удирдлага юм.

## 2024 ОНЫ ЭЭЛЖИТ ХУРАЛ

Говь ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2024 оны 4-р сарын 29-ний өдрийн 10:00 цагт ХААН театрт амжилттай зохион байгуулагдав.

**Хурлын ирц**

Хуралд урьдчилан санал өгөх арга хэлбэрээр нийт 12,462,706 (1.60%) саналын эрхтэй 629 хувьцаа эзэмшигч, хурлын өдөр биечлэн оролцох арга хэлбэрээр 678,761,381 (87.01%) саналын эрхтэй 74 хувьцаа эзэмшигч буюу нийт 691,224,087 саналын эрхтэй 703 хувьцаа эзэмшигч оролцсоноор хурлын ирц 88.61% болж бүрдэн хурал хүчин төгөлдөр явагдав.

**Хурлаар танилцуулсан асуудал**

1. Говь ХК-ийн 2023 оны үйл ажиллагаа болон санхүү үр дүнгийн тайлан
2. 2023 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг тараахгүй тухай ТУЗ-ийн тогтоол
3. ТУЗ-өөс компанийн 2023 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаар гаргасан дүгнэлт
4. ТУЗ-ийн 2023 оны ажлын тайлан
5. ТУЗ-ийн гишүүдийн цалингийн хэмжээг шинэчлэх төсөл
6. ТУЗ-ийн 2024 оны цалингийн төсөв
7. ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийн танилцуулга

**Хурлаас гарсан шийдвэр**

Хувьцаа эзэмшигчид дээрх асуудлуудтай холбогдох тайлан илтгэлүүдийг сонсож, асуулт хариулт болон санал шүүмжлэлээ хэлэлцсэний эцэст саналын хуудсаар саналаа өгсөн бөгөөд Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас дараах шийдвэрийг гаргав.

1. ТУЗ-өөс "Говь ХК-ийн гүйцэтгэх удирдлагын баг 2023 онд төлөвлөгдсөн зорилтоо биелүүлэхийн тулд өөрсдийн нөөц боломжоо бүрэн дүүрэн ашиглан ажилласан" гэсэн дүгнэлт өгснийг 99.99%-ийн саналаар батлав.
2. ТУЗ-ийн гишүүдийн цалингийн хэмжээг шинэчлэх саналыг 99.99%-ийн саналаар батлав.
3. ТУЗ-ийн 2024 оны цалингийн төсвийг 99.99%-ийн саналаар батлав.
4. ТУЗ-ийн гишүүдийг 9 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр 3 жилийн хугацаатай сонгон томилов.

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ЗАРДАЛ

*/мянган төгрөг/*

| Зардлын төрөл | 2023 | 2024 | Өөрчлөлт % |
|---|---|---|---|
| Хувьцаа эзэмшигчдийн хурлын зардал | 19,448 | 23,861 | 23% |

# ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

## ТУЗ-ИЙН БҮРЭЛДЭХҮҮН

## ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮД



**Д.ГЭРЭЛМАА**

ТУЗ-ийн дарга,
Эрсдэл, аудитын хорооны гишүүн,
Нэр дэвшүүлэх хорооны гишүүн

**МЭРГЭЖИЛ**
Эдийн засагч

**БОЛОВСРОЛ**
1982-1988
ЗХУ, Москва хотын Цахилгаан Холбооны Дээд Сургууль, Холбооны инженер эдийн засагч, бакалавр
2000-2003
МУ-ын ЗГ-ийн хэрэгжүүлэгч агентлаг “Удирдлагын академи”, удирдахуйн ухааны доктор

**ХӨДӨЛМӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА**
1988-1992
Радио Телевизийн Техникийн Төв, эдийн засагч
1992-1994
Эдийн Засгийн Хөгжлийн Коллеж, Бизнес удирдлагын тэнхим, Багш
1994-2003
Эдийн Засгийн Хөгжлийн Коллеж, Бизнес удирдлагын тэнхим, Тэнхимийн эрхлэгч
2003-2006
Монгол Улсаас НҮБ-д суух Байнгын төлөөлөгчийн газар, Швейцарийн Холбооны улс дахь ЭСЯ, Нягтлан бодогч
2006-2009
СЭЗИС, Сургалт Эрдэм Шинжилгээ эрхэлсэн дэд захирал
2009-2015
СЭЗИС, Сургалт эрхэлсэн дэд захирал
2015 оноос
СЭЗИС, Бизнес удирдлагын тэнхимийн профессор
2022 оноос
СЭЗИС, Ахисан Түвшний сургуулийн профессор
2013 оноос
Говь ХК-ийн ТУЗ-ийн гишүүн

**ГОВЬ ХК-ИЙН ХУВЬЦААНЫ ЭЗЭМШИЛ**
Хувьцаа эзэмшдэггүй.



**Д.ХҮРЭЛБААТАР**

Нэр дэвшүүлэх хорооны дарга,
Цалин, урамшууллын хорооны дарга

**МЭРГЭЖИЛ**
Нягтлан бодогч, Эдийн засагч, Санхүүч

**БОЛОВСРОЛ**
1979-1981
Худалдааны Техникум, Нягтлан бодогч, бакалавр
1985-1989
ОХУ-ын Байгалийн Улсын Их сургууль (Иркутск хотын УАААДС), Эдийн засагч, санхүүч магистр

**ХӨДӨЛМӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА**
1981-1984
Улсын банк, Улсын байцаагч аудитор
1990-2005
Худалдаа Хөгжлийн Банк, Харилцагчийн үйлчилгээний газрын захирал
2005-2007
Монгол шуудан банк, Дэд захирал
2008-2016
Говь ХК, ТУЗ-ийн гишүүн
2007-2020
Худалдаа Хөгжлийн Банк, Гүйцэтгэх захирлын орлогч
2020-2022
Худалдаа Хөгжлийн Банк, ТУЗ-ийн ажлын албаны дарга
2022 оноос
Говь ХК-ийн ТУЗ-ийн гишүүн

**ГОВЬ ХК-ИЙН ХУВЬЦААНЫ ЭЗЭМШИЛ**
4,800 ширхэг (0.0006%)





**А.ЖАРГАЛМАА**

Эрсдэл, аудитын хорооны дарга

**МЭРГЭЖИЛ**
Нягтлан бодогч

**БОЛОВСРОЛ**
2008-2012
Oxford Brookes Их Сургууль, Нягтлан бодох бүртгэл, бакалавр
2010-2012
ACCA Мэргэшлийн түвшний шалгалтууд, (Association of Chartered Certified Accountants)
2012-2015
Санхүү Эдийн Засгийн Их сургууль, Бизнесийн удирдлага, магистр
2013-2015
Хандонг Глобал Их Сургууль, Глобал менежмент, MBA

**ХӨДӨЛМӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА**
2012-2017
Багш, Санхүү Эдийн Засгийн их сургууль
2013-2014
Итезмон ХХК, Нягтлан бодогч
2014-2014
Иаруди Консалтинг ХХК, Зөвлөх
2016-2018
Бурый мэдвэдь ХХК, Нягтлан бодогч
2015-оноос
Дүнгээ ХХК, Нягтлан бодогч
2017 оноос
GAPE (Global Academy for Professional Education), ACCA ахлах багш, хөтөлбөрийн удирдагч
2019 оноос
Говь ХК-ийн ТУЗ-ийн гишүүн

**ГОВЬ ХК-ИЙН ХУВЬЦААНЫ ЭЗЭМШИЛ**
Хувьцаа эзэмшдэггүй.



**Б.ЦЭЭНЯМ**

Цалин, урамшууллын хорооны гишүүн

**МЭРГЭЖИЛ**
Маркетингийн менежмент

**БОЛОВСРОЛ**
2014-2018
Санхүү Эдийн Засгийн Их Сургууль, Маркетингийн менежмент, бакалавр
2022-2023
АНУ, Lindenwood Их Сургууль, Бизнесийн удирдлага, магистр

**ХӨДӨЛМӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА**
2018-2021
Таван Богд Холдингс ХХК, Маркетингийн газар, Судалгааны менежер
2023-2025
АНУ, Anand Resource компани, Ерөнхий менежер
2025 оны 3-р сараас
Таван Богд Холдингс ХХК, Дотоод аудит хариуцсан дэд захирал
2024 оноос
Говь ХК-ийн ТУЗ-ийн гишүүн

**ГОВЬ ХК-ИЙН ХУВЬЦААНЫ ЭЗЭМШИЛ**
Хувьцаа эзэмшдэггүй.

# ТУЗ-ИЙН ЕРДИЙН ГИШҮҮД



Ц.БААТАРСАЙХАН

Нэр дэвшүүлэх хорооны гишүүн

**МЭРГЭЖИЛ**
Инженер

**БОЛОВСРОЛ**
1984-1988
Монгол улс, Политехникийн Их Сургууль, Холбооны инженер, бакалавр
1989-1993
Япон улс, Токио хотын Цахилгаан Холбоо, Электроникийн Их Сургууль, Электроникийн инженер, бакалавр

**ХӨДӨЛМӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА**
1993-1997
Япон Монголын хамтарсан Алтай ХХК, Гүйцэтгэх захирал
1997 оноос
Таван Богд Группийн Ерөнхийлөгч, Таван Богд Холдингс ХХК-ийн Ерөнхий захирал,
2001-2003
МИАТ компани, Дэд ерөнхийлөгч
2008-2024
Говь ХК, Гүйцэтгэх захирал
2009 оноос
Хаан Банк ХК, ТУЗ-ийн гишүүн
2007 оноос
Говь ХК-ийн ТУЗ-ийн гишүүн

**ГОВЬ ХК-ИЙН ХУВЬЦААНЫ ЭЗЭМШИЛ**
Хувь хүн: 50,000 ширхэг (0.006%)
Нэгдмэл сонирхолтой хуулийн этгээд:
Таван Богд Холдингс ХХК 681,267,736 ширхэг (87.33%)
Таван Богд ХХК 3,140,239 ширхэг (0.40%)
Таван Богд Капитал ҮЦК ХХК 278,030 ширхэг (0.04%)



Д.ХУЛАН

Цалин, урамшууллын хорооны гишүүн

**МЭРГЭЖИЛ**
Олон улсын банк санхүү

**БОЛОВСРОЛ**
1985-1990
Орос улс, Москвагийн Санхүүгийн Дээд Сургууль, Олон улсын банк санхүү, бакалавр

**ХӨДӨЛМӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА**
1990-1992
Монгол Улсын Сангийн Яам, Эдийн засгийн гадаад харилцааны хэлтэс, Эдийн засагч
1993-1997
Говь ХК, Токио дахь салбар, Төлөөлөгч, худалдааны менежер
1997-2000
Таван Богд Холдингс ХХК, Дэд захирал
2000-2002
Худалдаа Хөгжлийн Банк, Дэд захирал
2003-2021
Таван Богд Групп, Тэргүүн дэд ерөнхийлөгч
2003-2021
Хаан Банк ХК, ТУЗ-ийн гишүүн
2009 оноос
Люксембург улсын Монгол дахь өргөмжит консул
2021 оноос
Хаан Банк ХК, ТУЗ-ийн дэд дарга
2021 оноос
Таван Богд Групп, ТУЗ-ийн дарга
2007 оноос
Говь ХК-ийн ТУЗ-ийн гишүүн

**ГОВЬ ХК-ИЙН ХУВЬЦААНЫ ЭЗЭМШИЛ**
Хувь хүн: 12,973,022 ширхэг (1.66%)
Нэгдмэл сонирхолтой хуулийн этгээд:
Таван Богд Холдингс ХХК 681,267,736 ширхэг (87.33%)
Таван Богд ХХК 3,140,239 ширхэг (0.40%)
Таван Богд Капитал ҮЦК ХХК 278,030 ширхэг (0.04%)





Б.АМАРСАЙХАН

Гүйцэтгэх захирал

**МЭРГЭЖИЛ**
Бизнесийн удирдлага ба энтрепренершип

**БОЛОВСРОЛ**
2016 - 2019
Их Британи улс, Westminister Их Сургууль, Бизнесийн удирдлага ба энтрепренершип, бакалавр

**ХӨДӨЛМӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА**
2019-2023
Говь Кашмер Европ ХХК, Гүйцэтгэх захирал
2022 оноос
Говь Кашмер Их Британи ХХК, Гүйцэтгэх захирал
2022-2024
Говь ХК, Стратеги, өсөлт хөгжил хариуцсан захирал
2022 оноос
Таван Богд Холдингс ХХК, Стратеги, бизнес хөгжил хариуцсан захирал
2023 оноос
Говь Кашмер Казахстан ХХК, Говь Кашмер Америк ХХК, Говь Кашмер Өвөр Монгол ХХК, Гүйцэтгэх захирал
2024 оноос
Говь ХК, Гоёо ХХК, Гүйцэтгэх захирал, Говь Австрали салбарын захирал
2023 оноос
Говь ХК-ийн ТУЗ-ийн гишүүн

**ГОВЬ ХК-ИЙН ХУВЬЦААНЫ ЭЗЭМШИЛ**
Хувь хүн: 1,000 ширхэг (0.0001%)
Нэгдмэл сонирхолтой хуулийн этгээд:
Таван Богд Холдингс ХХК 681,267,736 ширхэг (87.33%)
Таван Богд ХХК 3,140,239 ширхэг (0.40%)
Таван Богд Капитал ҮЦК ХХК 278,030 ширхэг (0.04%)



Ц.ОРГИЛБОЛД

Тэргүүн дэд захирал

**МЭРГЭЖИЛ**
Олон улсын харилцаа

**БОЛОВСРОЛ**
2011-2014
Япон улс, Temple Их Сургууль, Олон улсын харилцаа, бакалавр

**ХӨДӨЛМӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА**
2014
Эдийн засгийн хөгжлийн яам, Чөлөөт бүс хариуцсан мэргэжилтэн
2016
Таван Богд Холдингс ХХК, Бизнес хөгжлийн менежер
2016-2017
Жуулчин Дюти Фрий ХК, Гүйцэтгэх захирал
2017-2019
Гоёо ХХК, Гүйцэтгэх захирал
2019-2021
Говь ХК, Үйл ажиллагаа хариуцсан дэд захирал
2021-2022
Саппорт Сервисес Монголиа ХХК, Дэд захирал
2022-2023
Говь ХК, Тэргүүн дэд захирал /Дизайн, үйлдвэрлэл, дэмжих/
2023 оноос
Говь ХК, Тэргүүн дэд захирал /Гадаад, экспортын борлуулалт/, Говь Кашмер Европ ХХК, Гүйцэтгэх захирал
2023 оноос
Говь ХК-ийн ТУЗ-ийн гишүүн

**ГОВЬ ХК-ИЙН ХУВЬЦААНЫ ЭЗЭМШИЛ**
Хувь хүн: Хувьцаа эзэмшдэггүй.
Нэгдмэл сонирхолтой хуулийн этгээд:
Таван Богд Холдингс ХХК 681,267,736 ширхэг (87.33%)
Таван Богд ХХК 3,140,239 ширхэг (0.40%)
Таван Богд Капитал ҮЦК ХХК 278,030 ширхэг (0.04%)



**Н.МӨНХБАТ**

Эрсдэл, аудитын хорооны гишүүн

**МЭРГЭЖИЛ**
Санхүүгийн удирдлага

**БОЛОВСРОЛ**
2003-2007
ШУТИС, Электроникийн инженер, бакалавр
2011-2013
Англи улс, University of Gloucestershire, Бизнесийн удирдлагын магистр
2013-2015
Англи улс, Kaplan Financial Institute, CFA Level 2 тэнцсэн

**ХӨДӨЛМӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА**
2007-2011
Баз Тек ХХК, Ерөнхий менежер
2015-2018
Ард Санхүүгийн Нэгдэл ХК, Хөрөнгө оруулалтын менежер
2018-2018
Говь ХК, Санхүү төлөвлөлтийн хэлтсийн дарга
2018-2019
Таван Богд Холдингс ХХК, Санхүү төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга
2019-2021
Шунхлай ХХК, Бизнес төлөвлөлтийн газрын захирал
2021 оноос
Таван Богд Холдингс ХХК, Санхүү удирдлага хариуцсан захирал
2024 оноос
Говь ХК-ийн ТУЗ-ийн гишүүн

**ГОВЬ ХК-ИЙН ХУВЬЦААНЫ ЭЗЭМШИЛ**
Хувь хүн: 1,630 ширхэг (0.00%)
Нэгдмэл сонирхолтой хуулийн этгээд:
Таван Богд Холдингс ХХК 681,267,736 ширхэг (87.33%)
Таван Богд ХХК 3,140,239 ширхэг (0.40%)
Таван Богд Капитал ҮЦК ХХК 278,030 ширхэг (0.04%)

## ТУЗ-ИЙН БҮРЭЛДЭХҮҮНД ОРСОН ӨӨРЧЛӨЛТ

- 2024 оны Хувьцаа эзэмшигчдийн хурлаар ТУЗ-ийн гишүүдийг 3 жилийн хугацаатай сонгон томилсон ба Н.Мөнхбат, Э.Пүрэвлхам гишүүд ТУЗ-ийн ердийн гишүүнээр шинээр сонгогдсон.
- 2024 оны 8-р сард ТУЗ-ийн ердийн гишүүн Э.Пүрэвлхам өөрийн хүсэлтээр чөлөөлөгдөх хүсэлтээ ирүүлснийг хүлээн авч, хараат бус гишүүний сонгон шалгаруулалтыг нээлттэй зарлах байдлаар зохион байгуулж, ТУЗ-ийн 2024 оны 9-р сарын 10-ны шийдвэрээр Э.Пүрэвлхам гишүүнийг чөлөөлж, 2025 оны Хувьцаа эзэмшигчдийн хурал хүртэл ТУЗ-ийн хараат бус гишүүнээр Б.Цээнямыг түр томилсон.

## ТУЗ-ИЙН ГИШҮҮДИЙГ СОНГОХ, ТОМИЛОХ

Говь ХК нь компанийн дүрэмдээ заасны дагуу ТУЗ-ийн гишүүдийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар санал хураах кумулятив аргаар сонгон 3 жилийн хугац аатай томилдог.
ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны зүгээс ТУЗ-ийн гишүүдийн идэвх оролцоо, ажлын тайлан, гүйцэтгэлтэй танилцан, компанийн урт хугацааны стратеги төлөвлөлт, бизнесийн чиг хандлагатай уялдуулан ТУЗ-ийн гишүүдийг улиран нэр дэвшүүлэх, эсхүл бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах эсэх шийдвэрийг хэлэлцэн гаргадаг.
Говь ХК-ийн "ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах, нэр дэвшүүлэх журам"-ын дагуу Нэр дэвшүүлэх хорооны зүгээс ТУЗ-ийн гишүүдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах шаардлагатай гэж шийдвэрлэсэн тохиолдолд ердийн болон хараат бус гишүүдийн тоо, шинээр нэр дэвшүүлэх хараат бус гишүүдийн хэрэгцээ, мэргэжил, ур чадварын нэмэлт шалгуурыг тодорхойлон, сонгон шалгаруулалтыг зохион байгуулдаг. Хараат бус гишүүдийн сонгон шалгаруулалтыг нээлттэй байдлаар, эсвэл өмнөх сонгон шалгаруулалтад оролцсон нэр дэвшигчдээс сонгон шалгаруулах гэсэн арга хэлбэрээс сонгон явуулдаг. Улмаар нэр дэвшигчдэд үнэлгээ хийн, хэлэлцэн, дүгнэлт гаргасны үндсэн дээр нэр дэвшигчдийн жагсаалтыг батлан гаргадаг.
Удаан хугацаагаар үүргээ хэрэгжүүлэх боломжгүй болсон, чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан, эсхүл нас барсан ТУЗ-ийн гишүүнийг орлох этгээдийг Хувьцаа эзэмшигчдийн хурлаар сонгох хүртэл ТУЗ-ийн шийдвэрээр түр томилж, хувьцаа эзэмшигчдийн дараагийн ээлжит хурлаар оруулж батлуулдаг. Түр томилогдсон гишүүн нь хараат бус гишүүнд тавигдах шаардлагыг хангасан байх ба ТУЗ-ийн гишүүний бүх эрх, үүргийг эдэлнэ.



## ТУЗ-ИЙН ГИШҮҮДИЙН ЦАЛИН, УРАМШУУЛАЛ

ТУЗ-ийн гишүүдийн цалингийн хэмжээг ТУЗ-ийн дэргэдэх Цалин, урамшууллын хорооноос тодорхойлон санал боловсруулж Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэдэг.

Говь ХК-ийн ТУЗ-ийн гишүүдийн цалин сар бүр олгох тогтмол цалин болон хурлын оролцоонд үндэслэсэн цалин гэсэн бүтэцтэй байдаг. 2024 оны 4-р сарын Хувьцаа эзэмшигчдийн хурлаар ТУЗ-ийн гишүүдийн цалингийн хэмжээг дараах байдлаар тогтоосон.

**ТОГТМОЛ ЦАЛИН**

- Ердийн гишүүний үндсэн цалин **1,400,000₮**
- Хараат бус гишүүний үндсэн цалин **2,800,000₮**
- ТУЗ-ийн даргын албан тушаалын нэмэгдэл **1,000,000₮**
- ТУЗ-ийн дэргэдэх хороодын дарга нарын албан тушаалын нэмэгдэл **400,000₮**

**ОРОЛЦООНД ҮНДЭСЛЭСЭН НЭМЭЛТ ЦАЛИН**

ТУЗ-ийн хурал,
Хувьцаа эзэмшигчдийн хурал,
ТУЗ-ийн дэргэдэх хороодын
хуралд оролцсон оролцоо тутамд
**650,000₮**

## ЦАЛИН, УРАМШУУЛЛЫН ЗАРЧИМ

Цалин, урамшууллын хорооны 2024 оны эхний хурлаар ТУЗ-ийн гишүүдийн цалин, хангамж, урамшууллын зарчмыг дараах байдлаар тодорхойлсон.

- ТУЗ-ийн гишүүд нь компанийн санхүү, үр дүнгээс хамаарсан аливаа урамшуулал авахгүй.
- ТУЗ-ийн хараат бус гишүүдийн оролцоог нэмэгдүүлэх, хариуцлагыг үнэлэх зорилгоор хараат бус гишүүдийн үндсэн цалинг ердийн гишүүдийнхээс өндөр байлгана.
- Компанийн Менежмент багт ажилладаг ТУЗ-ийн ердийн гишүүд нь ТУЗ-ийн гишүүний хувьд аливаа хангамжийг давхар авахгүй.

## 2024 ОНЫ ЦАЛИН, УРАМШУУЛАЛ

| ТУЗ-ийн цалин урамшуулал | 2023 он Гүйцэтгэл | 2024 он | | Өөрчлөлт % | |
|---|---|---|---|---|---|
| | | Төсөв* | Гүйцэтгэл | 2023Г/2024Г | 2024Т/2024Г |
| Тогтмол цалин | 161,200 | 211,200 | 213,533 | 32% | 1% |
| Оролцооны цалин | 37,200 | 50,700 | 44,200 | 19% | -13% |
| НДШ | 25,485 | 30,119 | 27,371 | 7% | -9% |
| Дүн | 223,885 | 292,019 | 285,104 | 27% | -2% |

**2024 оны 4-р сарын Хувьцаа эзэмшигчдийн хурлаар ТУЗ-ийн 2024 оны цалингийн төсвийг баталсан.*

# ТУЗ-ИЙН 2024 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН

## ХУРЛЫН МЭДЭЭЛЭЛ

| Хурал | Ээлжит хурал | Ээлжит бус хурал | Цахим санал хураалт | Хэлэлцсэн асуудал | Шийдвэр | Санал зөвлөмж | Үүрэг даалгавар | Баталсан тогтоол |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| ТУЗ-ийн хурал | 5 | 5 | 7 | 55 | 46 | 18 | 20 | 41 |
| Эрсдэл, аудитын хорооны хурал | 3 | 1 | 3 | 19 | 9 | 7 | 12 | 4 |
| Нэр дэвшүүлэх хорооны хурал | 2 | 1 | 6 | 26 | 16 | 10 | 13 | 5 |
| Цалин, урамшууллын хорооны хурал | 2 | - | - | 14 | 8 | 6 | 5 | 1 |
| **Нийт** | **12** | **7** | **16** | **114** | **79** | **41** | **50** | **51** |

Говь ХК-ийн ТУЗ болон ТУЗ-ийн дэргэдэх хороод нь 2024 онд нийт 12 ээлжит хурал, 7 ээлжит бус хурал, 16 цахим санал хураалт зохион байгуулж гишүүд идэвх санаачилгатай ажиллан нийт 114 асуудлыг хэлэлцэн, 79 шийдвэр гаргаж, 51 тогтоол баталсан бөгөөд чиг үүргийнхээ хүрээнд удирдлагуудад 41 санал зөвлөмж, 50 үүрэг даалгавруудыг өгч, хэрэгжилт дээр нь хяналт тавьж анхаарч ажиллав. ТУЗ-ийн шийдвэрийн биелэлт 100%, удирдлагуудад өгсөн үүрэг даалгаврын биелэлт 95% хэрэгжилттэй байв.

## ХУРЛЫН ИРЦ

| № | ТУЗ-ийн гишүүний нэр | ТУЗ-ийн хорооны харьяалал | ТУЗ-ийн хурлын ирц | ТУЗ-ийн хорооны хурлын ирц |
|---|---|---|---|---|
| 1 | Д.Гэрэлмаа | Эрсдэл, аудитын хорооны гишүүн, Нэр дэвшүүлэх хорооны гишүүн | 100% | 100% |
| 2 | Д.Хүрэлбаатар | Нэр дэвшүүлэх хорооны дарга, Цалин, урамшууллын хорооны дарга | 100% | 100% |
| 3 | А.Жаргалмаа | Эрсдэл, аудитын хорооны дарга, Цалин, урамшууллын хорооны гишүүн /2024 оны 10-р сар хүртэл/ | 100% | 100% |
| 4 | Б.Цээням | Цалин, урамшууллын хорооны гишүүн | 100% | 100% |
| 5 | Ц.Баатарсайхан | Нэр дэвшүүлэх хорооны гишүүн | 100% | 100% |
| 6 | Д.Хулан | Цалин, урамшууллын хорооны гишүүн Эрсдэл, аудитын хорооны гишүүн /2024 оны 5-р сар хүртэл/ | 100% | 100% |
| 7 | Н.Мөнхбат | Эрсдэл, аудитын хорооны гишүүн | 94% | 100% |
| 8 | Б.Амарсайхан | Цалин, урамшууллын хорооны гишүүн /2024 оны 5-р сар хүртэл/ | 100% | 100% |
| 9 | Ц.Оргилболд | Нэр дэвшүүлэх хорооны гишүүн /2024 оны 5-р сар хүртэл/ | 100% | 100% |

**Хурлын давтамж**

Ээлжит хурал: ТУЗ-ийн хурал 2 сард нэг удаа буюу жилд 6 удаа (үүний нэг нь ТУЗ-ийн хараат бус гишүүдийн хурал), Эрсдэл, аудитын хорооны хурал улиралд нэг удаа буюу жилд 4 удаа, Нэр дэвшүүлэх хорооны хурал хагас жилд нэг удаа буюу жилд 2 удаа, Цалин, урамшууллын хорооны хурал хагас жилд нэг удаа буюу жилд 2 удаа хуралддаг.

Ээлжит бус хурал: ТУЗ болон хороодын ээлжит бус хурлыг ТУЗ-ийн дарга, гишүүд, компанийн Гүйцэтгэх захирал болон Менежмент багийн гишүүдийн санаачилга, шаардлагаар хэдийд ч хуралдуулж болно.



## 2024 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН

Говь ХК-ийн ТУЗ нь 2024 онд 5 ээлжит хурал, 5 ээлжит бус хурал, 7 цахим санал хураалт зохион байгуулж 55 асуудлыг хэлэлцэн, 46 шийдвэр гаргаж, 41 тогтоол баталсан бөгөөд чиг үүргийнхээ хүрээнд удирдлагуудад 18 санал зөвлөмж, 20 үүрэг даалгаврыг өгч, хэрэгжилт дээр нь хяналт тавьж чиглүүлэн ажиллав.

2024 онд ТУЗ-ийн зүгээс компанийн санхүү, үйл ажиллагаанд хяналт тавих, чиглүүлэх чиг үүргийн хүрээнд оны эхний хурал дээр компанийн бизнес төлөвлөгөөг баталж сар бүр санхүү, үр дүнгийн тайлангаар дамжуулан төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавьж ажилласан.
Энэ онд компанийн удирдлагын түвшинд томоохон өөрчлөлт орсон үйл явдал тохиолдсон нь 2008 оноос хойш Говь ХК-ийн Гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан Ц.Баатарсайхан нь өөрийн хүсэлтээр үүрэгт ажлаас чөлөөлөгдөх хүсэлтийг ТУЗ-д гаргасан. Улмаар ТУЗ-ийн зүгээс дараагийн Гүйцэтгэх захирлаар томилох хүнийг хэлэлцээд Говь ХК-ийн ХБНГУ дахь охин компанийн удирдлага, Стратеги, өсөлт хөгжил хариуцсан захирлын албан тушаалыг хашиж компанийн бүхий л түвшний үйл ажиллагаа руу нарийн орж ажиллаж байгаа тул ур чадвар болон туршлагыг нь үнэлж Б.Амарсайханыг 3-р сараас эхлэн томилов.

Шинээр томилогдсон Гүйцэтгэх захирал эрч хүчтэй, шинэ үеийн төлөөлөл болсон чадварлаг удирдлагын хувьд ГОВЬ брэндийг дэлхийн зах зээлд шинээр таниулах зорилгоор rebranding хийж, бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт, дижитал шилжилт, эмх цэгц болон мэдээ мэдээллийн урсгалын сайжруулалт зэрэг ажлуудыг хэрэгжүүлэн компанид олон дэвшилтийг авч ирж байгаа бөгөөд ТУЗ-ийн зүгээс Гүйцэтгэх захирлын үйл ажиллагаатай тухай бүр танилцан, чиг удирдлагаар ханган ажиллалаа.

Говь ХК нь 2024 онд нийт компанийн хэмжээнд системийн шинэчлэлтийн ажлыг өргөжүүлэн SAP S/4 HANA ERP системийг үйл ажиллагаандаа бүрэн нэвтрүүлэх, MES (Manufacturing Execution System) болон Conveyor Belt (Дамжлагын систем)-ийг нэвтрүүлэх зэрэг томоохон ажлуудыг хэрэгжүүлж байгаатай холбоотой ТУЗ-ийн зүгээс 1 удаагийн цахим хурал, 2 удаагийн биет хурлаар дамжуулан Мэдээлэл технологийн газрын тайлантай танилцаж, хяналт тавин, чиглүүлж ажилласан.

Компанийн засаглалын дотоод бодлогын баримт бичгүүдийг батлах чиг үүргийн хүрээнд 8-р сард Шүгэл үлээх тогтолцооны үйл ажиллагааны журам, 10-р сард Комплайнсын бодлогыг тус тус шинэчлэн баталсан.

Мөн БОНЗ-ын асуудлуудад нухацтай анхаарч, хяналт удирдлагаа хэрэгжүүлэн БОНЗ-ын үйл ажиллагааны тайлантай 3 удаагийн ээлжит хурлаар дамжуулан танилцаж, ТУЗ-өөс баталсан Тогтвортой хөгжлийн үүрэг амлалтынхаа хэрэгжилтэд хяналт тавин, удирдлагын багийг амжилттай чиглүүлэн ажиллалаа. Энэ онд хэрэгжүүлсэн чухал ажлуудын нэг бол Тогтвортой хөгжлийн цогц бодлогыг боловсруулж эхлэн, зөвлөх компанитай хамтран ТУЗ болон Менежмент багийн түвшинд шат дараалсан сургалт, уулзалтуудыг зохион байгуулж 10-р сарын ТУЗ-ийн хурал дээр Тогтвортой хөгжлийн стратегийн бодлого, Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах бодлого, Хүний эрх, жендерийн бодлого, Нийгмийн хариуцлагын бодлогуудыг шинээр тодорхойлон баталсан.

Бид дээрх бодлогуудынхаа нийцлийг хангах, компанийн үйл ажиллагааны үе шат тус бүрт тусган хэрэгжүүлж тогтвортой хөгжлийн үйл ажиллагаагаа үнэлж дүгнэн, тасралтгүй сайжруулалтын арга хэмжээг авч ажиллах зорилгоор олон улсын чиг хандлага болон засаглалын сайн туршлагуудаас суралцан ажиллаж байна.

ТУЗ-ийн нэгэн чухал үүрэг бол хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хангах, тэдний эрх ашиг зөрчигдөхөөс сэргийлэх явдал бөгөөд 2024 оны 3-р сард нөлөө бүхий хувьцаа эзэмшигч Таван Богд Холдингс ХХК нь хувьцааны эзэмшлээ нэмэгдүүлсэнтэй холбоотой Компанийн тухай хуулийн дагуу жижиг хувьцаа эзэмшигчид өөрсдийн эзэмшлийн хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг Говь ХК-аас шаардах эрх үүссэнийг хуулийн дагуу амжилттай хэрэгжүүлсэн.

# ТУЗ-ИЙН БОЛОН ТУЗ-ИЙН ГИШҮҮНИЙ ҮНЭЛГЭЭ

Говь ХК нь ТУЗ-ийн үйл ажиллагаагаа тогтмол сайжруулах зорилгоор 2015 оноос хойш жил бүр ТУЗ-ийн өөрийн үнэлгээг хийж байна. Мөн түүнээс гадна ТУЗ-ийн гишүүний өөрийн үнэлгээг 2018 оноос эхлэн хийж заншсан. Эдгээр үнэлгээний асуулгуудыг Нэр дэвшүүлэх хорооноос боловсруулан баталдаг бөгөөд 2024 онд СЗХ-оос боловсруулсан ТУЗ-ийн болон ТУЗ-ийн гишүүний үнэлгээний загварт суурилан, өмнөх хувилбарын асуултуудаасаа тусган, компанийн засаглалын олон улсын сайн туршлага, зарчмыг харгалзан шинэчлэн боловсруулсан.

Бид жил бүр ТУЗ-ийн болон ТУЗ-ийн гишүүний өөрийн үнэлгээг хийснээр ТУЗ-ийн үйл ажиллагаагаа дүгнэн, давуу тал болон эрсдэлтэй, сайжруулах шаардлагатай зүйлсээ тодорхойлон цаашдын төлөвлөгөөг боловсруулж, улмаар тасралтгүй сайжруулалтыг хийн ажиллаж байна.

## ТУЗ-ИЙН 2024 ОНЫ ҮНЭЛГЭЭ

2024 онд шинэчлэн боловсруулсан ТУЗ-ийн үнэлгээний асуулга нь нийт 10 бүлгийн хүрээнд 90 асуулт, нөхөж бичих 1 чөлөөт асуултаас бүрддэг.

ТУЗ-ИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН /2023-2024 он/

(2 өөр асуулга тул агуулгын хувьд харьцуулах боломжтой үзүүлэлтүүдийг харьцуулав)




2024 оны үнэлгээг агуулгаар нь авч үзвэл 10 бүлгээс 8 бүлгийг нь 2023 оны үнэлгээний дундажтай харьцуулан харах боломжтой байна. Үнэлгээний үр дүнгийн хувьд 2023 онд дундаж 94% байсан бол 2024 онд 93%-аар үнэлэгдсэн.

2024 оны үнэлгээний үр дүнгээс харахад ТУЗ-ийн дэргэдэх хороод болон ТУЗ-ийн ажлын алба бүлгүүдийн үнэлгээ буурсан байгаа нь өмнөх асуулгаар 3 хороог ерөнхийд нь үнэлдэг байсан бол одоо хороо тус бүрийн чиг үүргийг илүү задалж нарийвчлан үнэлдэг болсонтой холбоотой гэж үзэж байна. Мөн 2024 оны хувьд ТУЗ-ийн бүтэц бүрэлдэхүүн бүлэг 9%-ийн өсөлттэйгөөр үнэлэгдсэн нь хамгийн өндөр өсөлт болсон байна.

# ТУЗ-ИЙН ГИШҮҮНИЙ 2024 ОНЫ ҮНЭЛГЭЭ

2024 онд шинэчилсэн ТУЗ-ийн гишүүний үнэлгээ нь ТУЗ-ийн гишүүний үүрэг, оролцоотой холбоотой 29 асуулт, ТУЗ-ийн үйл ажиллагаа болон компанийн үйл ажиллагаатай холбоотой өөрийн санаачилж хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнтэй холбоотой нөхөж бичих 1 чөлөөт асуултаас бүрддэг.

ТУЗ-ийн гишүүний үнэлгээний дундаж /2023-2024 он/




ТУЗ-ийн гишүүд өөрсдийгөө жил бүр үнэлснээр өөрийн давуу болон сул талыг олж харах, цаашид анхаарч ажиллах үйл ажиллагааны чиглэлээ тодорхойлж дүгнэхээс гадна Нэр дэвшүүлэх хорооны зүгээс ТУЗ-ийн гишүүдийнхээ үйл ажиллагааг дүгнэх нэгэн үзүүлэлт болдог.
2024 оны хувьд ТУЗ-ийн гишүүдийн шинэчилсэн өөрийн үнэлгээний дундаж 92% болж өмнөх оноос 3% өссөн үр дүнтэй байна.

## ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮНИЙ ОРОЛЦОО

Говь ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүд нь оны эхэнд тухайн жилд анхаарч ажиллах чиглэлээ тодорхойлдог бөгөөд оны эцэст компанийн болон ТУЗ-ийн үйл ажиллагаатай холбоотой өөрийн санаачилж хэрэгжүүлсэн ажлын үр дүнгээ дүгнэн хэлэлцдэг. Бид ТУЗ-ийн хараат бус гишүүдийнхээ оролцоог нэмэгдүүлэх зорилгоор 2022 оноос эхлэн хараат бус гишүүдийн хурлыг жилд 1 удаа тогтмол зохион байгуулж байгаа ба 2024 оны хурлыг 2025 оны 1-р сард зохион байгуулж, үйлдвэрт шинээр нэвтрүүлсэн систем, дамжлагуудтай нарийн танилцаж, компанийн үйл ажиллагаатай холбоотой асуудлыг хараат бусаар хэлэлцэн, үйл ажиллагаанд саналаа тусган ажилласан.

# ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООДЫН ТАЙЛАН

## НЭР ДЭВШҮҮЛЭХ ХОРОО

**Зорилго**

ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны зорилго нь ТУЗ-ийг Эрх бүхий албан тушаалтнууд буюу ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх захирал, бусад Менежмент багийн удирдлагуудын залгамж халааны тогтвортой байдлыг хангах, тэдгээрийн ажил үүргийн тодорхойлолт, гэрээний нөхцөлийг тодорхойлох, ажлын гүйцэтгэл, үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгч хяналт тавин, чиг удирдлагаар хангах гэсэн үндсэн чиглэлээр чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь туслахад оршино. Мөн тус хороо нь ЭБАТ-уудтай холбоотой шүгэл үлээх системээр ирүүлсэн мэдээллийг шийдвэрлэх чиг үүргийг хэрэгжүүлдэг.

**Бүрэлдэхүүн**

| Бүрэлдэхүүн | ТУЗ-ийн гишүүний хэлбэр | ТУЗ-ийн гишүүний нэр |
|---|---|---|
| Хорооны дарга | Хараат бус гишүүн | Д.Хүрэлбаатар |
| Гишүүд | Хараат бус гишүүн | Д.Гэрэлмаа |
| | Ердийн гишүүн | Ц.Баатарсайхан |

**Хорооны бүрэлдэхүүнд орсон өөрчлөлт:**

2024 оноос эхлэн хороодын гишүүний бүрэлдэхүүнийг томилохдоо компанийн Менежмент багт ажилладаггүй ТУЗ-ийн гишүүдийг томилох зарчмыг баримталж эхэлсэн тул ТУЗ-ийн 2024 оны 5-р сарын 21-ны №24 тоот тогтоолоор тус хорооны гишүүн Ц.Оргилболдын оронд ТУЗ-ийн ердийн гишүүн Ц.Баатарсайханыг томилов.

### 2024 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН

Нэр дэвшүүлэх хороо нь 2024 онд 2 ээлжит хурал, 1 ээлжит бус хурал, 6 цахим санал хураалт зохион байгуулж, 26 асуудлыг хэлэлцэн, 16 шийдвэр гаргав. Хорооны чиг үүргийнхээ хүрээнд 10 төрлийн санал зөвлөмж, 13 үүрэг даалгаврыг холбогдох албан тушаалтнуудад өгч, хяналт тавьж ажилласан бөгөөд 5 тогтоол батлав. Тус хорооны шийдвэрийн биелэлт 100%, удирдлагуудад өгсөн үүрэг даалгаврын биелэлт 100% хэрэгжилттэй байв.

- Компанийн ЭБАТ-уудын залгамж халааны тогтвортой байдлыг хангах чиг үүргийн хүрээнд дараах ажлыг хэрэгжүүлсэн. Үүнд:
  - Гүйцэтгэх захирал чөлөөлөгдөх хүсэлт өгсөнтэй холбоотой хүсэлтийг хүлээн авч, шинээр томилох Гүйцэтгэх захирал дээр санал боловсруулан 2024 оны 2-р сарын 28-ны ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн томилсон.
  - Нөлөө бүхий хувьцаа эзэмшигчээс албан бичгээр ирүүлсэн "ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигчид санал оруулах тухай" хүсэлтийг хүлээн авч "ТУЗ-ийн гишүүнийг нэр дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам"-ын дагуу ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийн нэрсийг тодорхойлон баталж, 4-р сарын хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар ТУЗ-ийн гишүүдийг 3 жилийн хугацаатай сонгон томилов.
  - ТУЗ-ийн ердийн гишүүнээс 8-р сард чөлөөлөгдөх хүсэлт ирүүлснийг хүлээн авч, хуулийн дагуу 2025 оны Хувьцаа эзэмшигчдийн хурал хүртэл хараат бус гишүүнийг түр томилохоор шийдвэрлэсэн. Улмаар ТУЗ-ийн хараат бус гишүүний сонгон шалгаруулалтыг нээлттэй зарлах байдлаар зохион байгуулж, 2024 оны 9-р сарын 10-ны ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн томилсон.

- ЭБАТ-удын ажил үүргийн тодорхойлолт, гэрээний нөхцөлийг тодорхойлон хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргийн хүрээнд дараах ажлыг хэрэгжүүлсэн. Үүнд:
  - Шинээр томилогдсон Гүйцэтгэх захирлын эрх, үүргийн хэмжээг хэлэлцэн, Менежментийн гэрээний нөхцөлийг шинэчлэн ТУЗ-ийн хурлаар гэрээний загварыг батлуулж, Гүйцэтгэх захиралтай гэрээг байгуулсан.
  - Хагас жилийн хорооны хурал дээр Менежмент багийн удирдлагуудын ажил үүргийн чиглэл, гэрээний нөхцөл, хэрэгжилтийн талаар танилцаж Хүний нөөц хариуцсан захирлыг чиг удирдлагаар хангаж ажилласан.
  - ТУЗ-ийн гишүүдийн хууль, дүрэм журмын дагуу хэрэгжүүлэх эрх үүргийн матрицыг хэлэлцэж, цаашид тогтмол сайжруулан, хэрэгжилтийг хангаж ажиллахаар шийдвэрлэв.



- ЭБАТ-уудын ажлын гүйцэтгэл, үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгч хяналт тавин, удирдлагаар хангах чиг үүргийн хүрээнд дараах ажлыг хэрэгжүүлсэн. Үүнд:
  - Оны эхний хурлаар Менежмент багийн удирдлагуудын 2023 оны ажлын тайлантай танилцаж, тус тайланд Гүйцэтгэх захирлаас өгсөн дүгнэлттэй танилцан үйл ажиллагаа сайжруулах зөвлөмжийг өгөв. Менежмент багийнхны жилийн тайлан болон гүйцэтгэлд үндэслэн хамт олноо манлайлан удирдаж, амжилттай ажилласан хоёр удирдлагыг ТУЗ-ийн нэрэмжит шагналд нэр дэвшүүлэн, ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн шагнав.
  - Хагас жилийн хурлаар Гүйцэтгэх захирлын ажлын тайлантай танилцаж, хяналт удирдлагын үүргээ хэрэгжүүлэв. Мөн Гүйцэтгэх захирлын жилийн эцсийн үр дүнг дүгнэх зорилгоор тайлангийн загварыг боловсруулсан бөгөөд 2025 оны 1-р сарын хурлаар ажлын үр дүнтэй танилцана.
  - Тус хурлаар компанийн "Шүгэл үлээх тогтолцооны үйл ажиллагааны журам"-ыг шинэчлэх төслийг хэлэлцэн, 2024 оны 8-р сарын 9-ний ТУЗ-ийн хурлаар батлуулсан. Энэхүү журмын хэрэгжилтийг хангаж, компанийн шүгэл үлээх системээр ЭБАТ-уудтай холбоотой ирсэн мэдээллийг тухай бүр шийдвэрлэн холбогдох удирдлагуудад санал зөвлөмж, хугацаатай үүрэг даалгавруудыг өгч хэрэгжилтэд хяналт тавин ажилласан.
  - 2024 онд ТУЗ-ийн өөрийн үнэлгээ болон ТУЗ-ийн гишүүний өөрийн үнэлгээний асуулгыг шинэчлэн үнэлгээг хийсэн.

### ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНУУДЫН ЗАЛГАМЖ ХАЛААНЫ БОДЛОГО

**Эрх бүхий албан тушаалтан (ЭБАТ):** Компанийн дүрмээр тодорхойлсны дагуу ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх захирал, дэд захирлууд, газрын захирлууд, хуулийн зөвлөх, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга зэрэг компанийн албан ёсны шийдвэрийг гаргахад болон гэрээ, хэлцэл хийхэд шууд болон шууд бусаар оролцдог удирдах албан тушаалтнуудыг хэлнэ.




**Залгамж халааны бодлого**

- Нэр дэвшүүлэх хороо болон Хүний нөөцийн газар нь компанийн дотоод болон гадаад зах зээлийн өөрчлөлт, бизнесийн урт хугацааны стратеги төлөвлөгөө, өсөлт хөгжилтэй уялдуулан ЭБАТ-уудад тавигдах шаардлага, мэдлэг мэргэжил, ур чадварын шалгуурыг оновчтой тодорхойлно.

- Нэр дэвшүүлэх хороо болон Хүний нөөцийн газар нь ЭБАТ-уудыг сонгон шалгаруулахад баримтлах зарчим, шалгуур үзүүлэлт, залгамж халаа бэлтгэх төлөвлөгөө болон ур чадварыг хөгжүүлэх төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж, тасралтгүй сайжруулалт хийнэ.

- Компанийн зүгээс ЭБАТ-уудыг тогтвор суурьшилтай сэтгэл ханамжтай ажиллах нөхцөл, ажлын байран дээр өсөж дэвших боломжоор хангана.

- ТУЗ нь энэхүү бодлогын хэрэгжилтийг хангах замаар удирдах албан тушаалтны орон тоо гэнэт буюу төлөвлөгдөөгүй байдлаар өөрчлөгдсөнөөс үүдэн хувьцаа эзэмшигч болон бусад оролцогч талуудын эрх ашиг хохирох эрсдэлтэй нөхцөл үүсгэхгүйн тулд ЭБАТ-уудын залгамжлагч хүний нөөцийн бэлэн байдлыг тогтмол бүрдүүлж, компанийн үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хадгалах зохистой тогтолцоог бүрдүүлнэ.

# ЦАЛИН, УРАМШУУЛЛЫН ХОРОО

**Зорилго**

ТУЗ-ийн дэргэдэх Цалин, урамшууллын хорооны зорилго нь ТУЗ-ийг Эрх бүхий албан тушаалтнууд буюу ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх захирал, бусад Менежмент багийн удирдлагуудыг цалин, урамшууллын талаар баримтлах бодлогыг тодорхойлох, Компанийн хэмжээнд баримтлах Цалин, урамшууллын бодлого, төлөвлөгөө, хөтөлбөрүүдийг тодорхойлох, хэрэгжилтэд хяналт тавих чиглэлээр чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь туслахад оршино.

| Бүрэлдэхүүн | ТУЗ-ийн гишүүний хэлбэр | ТУЗ-ийн гишүүний нэр |
|---|---|---|
| Хорооны дарга | Хараат бус гишүүн | Д.Хүрэлбаатар |
| Гишүүд | Хараат бус гишүүн | Б.Цэээням |
| | Ердийн гишүүн | Д.Хулан |

**Хорооны бүрэлдэхүүнд орсон өөрчлөлт:**

2024 оноос эхлэн хороодын гишүүний бүрэлдэхүүнийг томилохдоо компанийн Менежмент багт ажилладаггүй ТУЗ-ийн гишүүдийг томилох зарчмыг баримталж эхэлсэн тул ТУЗ-ийн 2024 оны 5-р сарын 21-ны №24 тоот тогтоолоор тус хорооны гишүүн Б.Амарсайханы оронд ТУЗ-ийн ердийн гишүүн Э.Пүрэвлхамыг томилов.
Мөн 9-р сард ТУЗ-ийн гишүүдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт орсонтой холбоотой ТУЗ-ийн 2024 оны 10-р сарын 30-ны №34 тоот тогтоолоор тус хорооны гишүүн А.Жаргалмаа, Э.Пүрэвлхам нарын оронд ТУЗ-ийн хараат бус гишүүн Б.Цэээням, ТУЗ-ийн ердийн гишүүн Д.Хулан нарыг томилов.

## 2024 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН

Цалин урамшууллын хороо нь 2024 онд 2 ээлжит хурал зохион байгуулж, 14 асуудлыг хэлэлцэн, 8 шийдвэр гаргав. Хорооны чиг үүргийнхээ хүрээнд 6 төрлийн санал зөвлөмж, 5 үүрэг даалгаврыг холбогдох албан тушаалтнуудад өгч, хяналт тавьж ажилласан бөгөөд 1 тогтоол батлав. Тус хорооны шийдвэрийн биелэлт 100%, удирдлагуудад өгсөн үүрэг даалгаврын биелэлт 100% хэрэгжилттэй байв.

- ЭБАТ-уудын цалин, урамшууллын бодлогыг тодорхойлон, хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргийн хүрээнд дараах ажлыг хэрэгжүүлсэн. Үүнд:
    - Оны эхний хурлаар ТУЗ-ийн гишүүдийн цалин, хангамж, урамшууллын зарчмыг хэлэлцэн батлав. Ингэснээр Менежмент багт ажилладаг ТУЗ-ийн ердийн гишүүд, бусад ердийн гишүүд болон хараат бус гишүүдийн цалин, хангамж, урамшууллыг тогтооход баримтлах тодорхой зарчимтай болсон.
    - ТУЗ-ийн хараат бус гишүүдийн оролцоог нэмэгдүүлэх, хариуцлагыг үнэлэх зорилгоор хараат бус гишүүдийн цалингийн хэмжээг шинэчлэх санал боловсруулж 2024 оны 4-р сарын хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар батлуулахаас гадна 2024 оны ТУЗ-ийн цалингийн төсвийг нээлттэй хэлэлцэн батлуулсан.
    - ЭБАТ-уудын цалин урамшууллын гүйцэтгэлтэй хагас жил тутам танилцаж ажилласан бөгөөд хагас жилийн хурлаар ЭБАТ-уудын урамшууллын зарчимтай танилцахаас гадна Гүйцэтгэх захирлын цалингийн хэмжээг хэлэлцэн шинэчлэн тогтоосон.
- Компанийн хэмжээнд баримтлах цалин, урамшууллын бодлого, төлөвлөгөө, хөтөлбөрүүдийг тодорхойлон, хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргийнхээ хүрээнд дараах ажлыг хэрэгжүүлсэн. Үүнд:
    - Оны эхний хурлаар компанийн Цалин урамшууллын бодлогыг шинэчлэх төслийг хэлэлцэн 2024 оны 1-р сарын 26-ны ТУЗ-ийн хурлаар батлуулав.
    - Мөн тус хурлаар компанийн 2023 оны цалин урамшууллын гүйцэтгэлд хяналт тавьж, 2024 оны төсвийг хэлэлцэн бизнес төлөвлөгөөнд тусган ТУЗ-өөр батлуулсан.
    - Байгууллагын соёлын судалгаа, ажилтнуудын сэтгэл ханамжийн судалгааны үр дүн, түүнийг сайжруулах чиглэлээр хийгдсэн ажлуудтай танилцаж удирдлагыг чиг удирдлагаар хангасан.



## ЦАЛИН, УРАМШУУЛЛЫН БОДЛОГО

**Говь ХК-ийн цалин, урамшууллын бодлого**

Компанийн дотоод, гадаад зах зээлийн өөрчлөлт, бизнесийн урт хугацааны стратеги төлөвлөгөө, өсөлт хөгжил, санхүүгийн үр ашиг болон ажилтнуудын ажлын үр дүн, бүтээмжтэй уялдсан цалин, урамшууллын зохистой бөгөөд үр дүнтэй тогтолцоотой байна.

**Цалин, урамшууллын тогтолцоо**




### ЦАЛИН, УРАМШУУЛЛЫН ЗОРИЛТ

- Ажиллах орчныг тасралтгүй сайжруулан, ажилтнууд үр чадвараа хөгжүүлэх, сурч хөгжих, хөдөлмөрөө шударгаар үнэлүүлэх, тогтвортой, сэтгэл ханамжтай, аз жаргалтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх замаар компанийн соёлын судалгааны дундаж үзүүлэлтийг жил бүр зөв зохистой түвшинд нэмэгдүүлнэ.
- Хөдөлмөрийн бүтээмж, дундаж цалингийн өсөлтийн зохистой харьцааг инфляцын түвшин болон бодит цалингийн өсөлттэй уялдуулна.
- Компанийн цалин, урамшууллын зардлыг компанийн үр ашигтай жил бүр уялдуулан төлөвлөнө.

### ЦАЛИН, УРАМШУУЛЛЫН ЗАРЧИМ

- Бизнесийн үйл ажиллагаа, стратеги зорилттой уялдуулах,
- Зах зээлд өрсөлдөхүйц байх,
- Ижил тэгш байх,
- Инфляцын түвшин болон бодит цалингийн өсөлтийг уялдуулах,
- Шударга, ил тод байх,
- Шинийг эрэлхийлэн, тасралтгүй сайжруулах.

## ЭРСДЭЛ, АУДИТЫН ХОРОО

**Зорилго**

ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэл, аудитын хорооны зорилго нь компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагааны хяналтын тогтолцооны үр дүнтэй байдалд хяналт тавих, чиглүүлэх, дотоод хяналт, комплайнс болон эрсдэлийн удирдлагын тогтолцооны үр дүнтэй байдалд хяналт тавих, чиглүүлэх, хараат бус аудитын байгууллагатай харилцан, хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх боломжоор хангах гэсэн үндсэн 3 чиг үүргийг хэрэгжүүлж ТУЗ-ийг эрсдэлийн удирдлага болон компанийн үйл ажиллагаа дахь хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

| Бүрэлдэхүүн | ТУЗ-ийн гишүүний хэлбэр | ТУЗ-ийн гишүүний нэр |
|---|---|---|
| Хорооны дарга | Хараат бус гишүүн | А.Жаргалмаа |
| Гишүүд | Хараат бус гишүүн | Д.Гэрэлмаа |
| | Ердийн гишүүн | Н.Мөнхбат |

**Хорооны бүрэлдэхүүнд орсон өөрчлөлт:**

2024 оны Хувьцаа эзэмшигчдийн хурлаар ТУЗ-ийн гишүүдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт орсонтой холбоотой ТУЗ-ийн 2024.05.21-ны №24 тоот тогтоолоор тус хорооны гишүүн Д.Хулангийн оронд ТУЗ-ийн ердийн гишүүн Н.Мөнхбатыг томилов.

### 2024 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН

Эрсдэл, аудитын хороо нь 2024 онд 3 ээлжит хурал, 1 ээлжит бус хурал, 3 цахим санал хураалт зохион байгуулж, 19 асуудлыг хэлэлцэн, 9 шийдвэр гаргав. Хорооны чиг үүргийнхээ хүрээнд 7 төрлийн санал зөвлөмж, 12 үүрэг даалгаврыг холбогдох албан тушаалтнуудад өгч, хяналт тавьж ажилласан бөгөөд 4 тогтоол батлав. Тус хорооны шийдвэрийн биелэлт 100%, удирдлагуудад өгсөн үүрэг даалгаврын биелэлт 83% хэрэгжилттэй байв.

- Компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагааны хяналтын тогтолцоог сайжруулах чиг үүргийн хүрээнд дараах ажлыг хэрэгжүүлсэн. Үүнд:
  - Компанийн улирал болон хагас жилийн санхүүгийн тайлангуудтай танилцан дүгнэж, олон нийтэд мэдээлэх үйл ажиллагаанд хяналт тавьсан.
  - Улирал бүрийн хурлаар дамжуулан сонирхлын зөрчилтэй болон холбоотой талуудтай хийгдсэн гүйлгээний гүйцэтгэлтэй танилцан ТУЗ-ийн 2024 оны 1-р сарын 26-ны хурлаар батлсан холбоотой талуудтай хийх гүйлгээний төсвийн хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан.

- Компанийн дотоод хяналт, комплайнс, эрсдэлийн удирдлагын тогтолцоог сайжруулах чиг үүргийн хүрээнд дараах ажлыг хэрэгжүүлсэн. Үүнд:
  - Дотоод аудитын хэлтсийн ажлын тайлантай улирал бүр танилцаж компанийн хэмжээнд хийгдсэн дотоод аудитын ажлын үр дүнтэй танилцан дотоод хяналтын чиг үүргээ хэрэгжүүлсэн.
  - Говь ХК нь 2024 оноос Нийцлийн газартай болсон бөгөөд тус газрын тайлантай хагас жил тутам танилцаж үйл ажиллагаар төлөвшүүлэх, үр дүнтэй байдлыг хангахад чиг удирдамжаар хангаж ажилласан. Мөн 3-р улирлын хурал дээр Комплайнсын бодлогыг шинэчлэх төслийг хэлэлцэн 2024 оны 10-р сарын 30-ны ТУЗ-ийн хурлаар батлуулсан.
  - Хагас жилийн хурлаар эрсдэлийн удирдлагын багийн ажлын тайлан, эрсдэлийн үнэлгээ болон мониторингийн үр дүнтэй танилцаж удирдамжаар хангаж ажилласан. Мөн “Бизнесийн тасралтгүй үйл ажиллагааны журам”-ын хэрэгжилтийг хангах зорилгоор боловсруулж буй Бизнесийн тасралтгүй үйл ажиллагааны төлөвлөгөөний явцтай танилцан санал зөвлөмжийг өгсөн.

- Хараат бус аудитын байгууллагатай харилцах, хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх боломжоор хангах чиг үүргийн хүрээнд дараах ажлыг хэрэгжүүлсэн. Үүнд:
  - Оны эхний хурал дээр 2023 хараат бус аудиторын дүгнэлт зөвлөмжтэй танилцаж, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан.
  - 2023 оны тусдаа буюу охин компаниуд ороогүй санхүүгийн тайланд хөндлөнгийн аудит хийх байгууллагын сонгон шалгаруулалттай танилцан санал өгч 2024 оны 4-р сарын 19-ний ТУЗ-ийн хурлаар сонгов.
  - 2024 оны хөндлөнгийн аудиторын сонгон шалгаруулалтад хорооны гишүүдийн зүгээс хараат бус байдлын шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлгээг хийж, үнийн саналтай танилцан санал өгч 2024 оны 9-р сарын 10-ны ТУЗ-ийн хурлаар сонгов.
  - 11-р сард ээлжит бус хурлаар 2024 оны хөндлөнгийн аудитын төлөвлөгөөтэй танилцан, бэлтгэл ажлыг хангахтай холбоотой зөвлөмж үүрэг даалгаврыг холбогдох удирдлагуудад өгсөн.



# ДОТООД ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО

Манай компани дотоод хяналтын тогтолцоондоо “Хамгаалалтын гурван шугам” загварын дагуу зохион байгуулалтыг хийж, үйл ажиллагаагаа сайжруулан ажиллаж байна. Энэ загвар нь шат шатны удирдлагууд өдөр тутмын төлөвлөх, гүйцэтгэх, тайлагнах, хянах, зохицуулах үндсэн чиг үүргүүдээ хэрэгжүүлэн ажиллахад ач холбогдолтой байдаг.




*Хамгаалалтын I шугам:*
*Компанийн үндсэн үйл ажиллагааг явуулж буй нэгжүүд Гүйцэтгэх удирдлагаас өгсөн чиг үүргийн дагуу өдөр тутмын хяналтыг хэрэгжүүлж, тайлагнадаг.*

*Хамгаалалтын II шугам:*
*Компанийн үндсэн үйл ажиллагааг дэмжиж ажилладаг нэгжүүд Гүйцэтгэх удирдлагаас өгсөн чиг үүргийн дагуу өдөр тутмын хяналтыг давхар хэрэгжүүлж, тайлагнадаг.*

*Хамгаалалтын III шугам:*
*Гүйцэтгэх удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтын тогтолцоо нь хэрэгжиж байгаа эсэх, оновчтой байгаа эсэх дээр баталгаажуулалтыг хийж, үндсэн чиг үүргийн хувьд Эрсдэл, аудитын хороонд, захиргааны хувьд Гүйцэтгэх удирдлагад тайлагнадаг.*

### ДОТООД ХЯНАЛТЫН БОДЛОГО

Манай компанийн дотоод хяналтын бодлого нь компанийн үйл ажиллагааг үр дүнтэй эрхлэн явуулахтай холбоотой дараах харилцааг зохицуулах, нягтлан шалгах, хяналт тавих зорилготой. Үүнд:

- Компанийн үйл ажиллагааг хууль тогтоомж, тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм журмын дагуу үр ашигтайгаар удирдан явуулах,
- Компанийн эд хөрөнгийг хамгаалах, найдвартай байдлыг хангах,
- Ашиглан, залилангийн үйлдэл болон алдаанаас урьдчилан сэргийлэх, илрүүлэх, засах,
- Нягтлан бодох бүртгэлийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангах,
- Үйл ажиллагааны болон санхүүгийн мэдээллийг цаг тухайд нь үнэн зөв, бодитоор бэлтгэн гаргах,
- Эрсдэлийг тогтмол хянах, удирдах.

Говь ХК нь дотоод хяналтыг Бүх ажилтан, Нэгжийн удирдлага, Гүйцэтгэх удирдлагын баг, Дотоод аудитын хэлтэс, ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэл, аудитын хороо, ТУЗ, Хөндлөнгийн аудит гэсэн шатлалтайгаар хэрэгжүүлдэг ба ТУЗ-ийн зүгээс Эрсдэл, аудитын хороогоор дамжуулан компанийн дотоод хяналтын үйл ажиллагаанд хяналт тавьдаг.

### ДОТООД АУДИТЫН ХЭЛТЭС

Дотоод аудитын зорилго нь компанийн засаглалын үйл явц, эрсдэлийн удирдлагын үр нөлөөтэй байдал, дотоод хяналтын үр ашигт байдалд үнэлгээ хийх тэдгээрийн байнгын сайжруулалтад дэмжлэг үзүүлэх замаар байгууллагын үнэ цэнийг хамгаалах, нэмэгдүүлэхэд оршино. Үйл ажиллагаандаа Олон улсын дотоод аудиторуудын институтийн батлан гаргасан ёс зүйн дүрэм, үндсэн зарчмууд болон дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандартуудыг мөрдлөг болгон ажиллаж байна.

#### БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Дотоод аудитын үйл ажиллагаа нь ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэл, аудитын хорооны харьяанд Дотоод аудитын хэлтэс гэсэн бүтэцтэйгээр үндсэн чиг үүргээ хэрэгжүүлж байна. Эрсдэл, аудитын хороо нь Дотоод аудитын дүрэм, стратеги зорилт, эрсдэлд суурилсан аудитын төлөвлөгөө, нөөцийн төсвийг батлах, хэлтсийн даргыг томилж цалин урамшууллыг тогтоохоос гадна аудитын төлөвлөгөөний гүйцэтгэл, үйл ажиллагаанд хяналт тавьж, Дотоод аудитын бие даасан, хараат бус байдлыг баталгаажуулдаг.

#### ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХАМРАХ ХҮРЭЭ

Компанийн зорилго, зорилтуудаа хүрэхийн тулд шийдвэр гаргалт, бодлого тодорхойлолт, бизнесийн болон дэмжих ажиллагааны процессууд, комплайнс болон тайлагналын үйл ажиллагааг хамруулан хуваарилагдсан үүрэг хариуцлагыг биелүүлж, чанартай гүйцэтгэл гаргаж байгаа эсэхийг баталгаажуулдаг.

### 2024 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН

- Баталгаажуулах ажлаар нийт 86 анхаарах асуудлыг дэвшүүлэн үүсэж болох эрсдэл, шалтгааныг тодорхойлон, шийдвэрлэх санал, зөвлөмжөөр хангаж ажилласан.
- Мониторингийн ажлаар 9 багц бүхий 66 зөвлөмжийн хэрэгжилтийг эргэн дүгнэсэн. Илэрсэн асуудлуудыг шийдвэрлэх, эрсдэлийг бууруулах, үр дүнг сайжруулах талаар хэрэгжилтийн хувийг нэмэгдүүлэхийг чухалчилсан.
- Зөвлөх үйлчилгээг гүйцэтгэх удирдлагаас санал авч хэлэлцэн гүйцэтгэдэг бөгөөд шаардлагатай санал зөвлөмжийг хүргүүлж, хамтран ажилласан.
- Компанийн засаглал, дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын тогтолцоо нь үр дүнтэй хэрэгжиж байгаа эсэхэд үнэлж, компанийн үнэ цэнийг нэмэгдүүлэх, тасралтгүй сайжруулах талаар зөвлөмж, дэмжлэгийг өгсөн.
- Дотоод аудитын чанарын баталгаажуулалтын дотоод үнэлгээг өөрсдөө хийж, дотоод аудитын үйл ажиллагаанд анхаарах асуудлуудыг тодорхойлон сайжруулалтыг хийсээр ажиллаж байна.



## ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

#### ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН БОДЛОГО

Говь ХК нь эрсдэлийн удирдлагын бодлогынхоо хүрээнд компанийн ерөнхий үзэл баримтлал, чиглэлд нийцтэй эрсдэлийн удирдлагын тогтолцоог бүрдүүлж, оролцогч талуудын ажиллах үндсэн зарчим, эрх үүрэг, хариуцлагыг тодорхойлон, эрсдэлийн удирдлагыг амжилттай хэрэгжүүлж, үр дүнд нь мониторинг хийж, тасралтгүй сайжруулан ажиллаж байна.

Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлснээр бизнесийн эрсдэлийн орчныг тасралтгүй хянах, сайжруулах боломжийг бий болгож, ажилтнуудын эрсдэлийн талаарх ойлголт, мэдлэгийг сайжруулан, удирдлагын түвшинд стратегийн оновчтой шийдвэр гаргах, бизнесийн зорилго, зорилтыг дэмжихэд болон бизнест тулгарах алдагдал, хохирлоос урьдчилан сэргийлэхэд тусалдаг.

#### ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ЗАРЧИМ

- Үнэт зүйлийг бий болгох ба хамгаалах,
- Засаглалын зохистой бүтцийг хэрэгжүүлэх,
- Байгууллагын үйл явцын салшгүй хэсэг байх,
- Шийдвэр гаргалтын нэг хэсэг байх,
- Ил тод ба оролцоог хангасан байх,
- Эрсдэлийн соёлыг төлөвшүүлэх,
- Тасралтгүй сайжруулах.
- Стандарт шаардлагыг хангах, чанарын хяналтыг сайжруулах олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн бэлэн бүтээгдэхүүний лабораторийг тасралтгүй хөгжүүлэх.

### ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ЗАСАГЛАЛ



Говь ХК-ийн эрсдэлийн удирдлагын тогтолцоо нь засаглал, хэрэгжүүлэлт гэсэн үндсэн хоёр түвшин бүхий “Гурван давхар хамгаалалтын шугам”-аар зохицуулагддаг.
Эрсдэлийн засаглалын үүрэг хариуцлага болон нэгдсэн хяналтыг хэрэгжүүлэх нь ТУЗ-ийн үндсэн зорилгуудын нэг юм. Иймд компанид эрсдэлийн удирдлагын тогтолцоог бүрдүүлэгч нь ТУЗ, түүний дэргэдэх Эрсдэл, аудитын хороо байна.

Компанид эрсдэлийн удирдлагын бодлогыг хэрэгжүүлэгч нь эрсдэлийн удирдлагын баг байх бөгөөд Гүйцэтгэх захирал багийн бүрэлдэхүүнийг томилно. Эрсдэлийн менежер нь эрсдэлийн удирдлагын багийн гишүүн байх бөгөөд нэгжийн удирдлагууд нь эрсдэлийг хариуцагч байна гэж тус бодлогод заасан байдаг. Манай компанийн эрсдэлийн удирдлагын багийг компанийн удирдах албан тушаалтнууд бүрдүүлж байгаа бөгөөд Гүйцэтгэх захирал ахлан ажиллаж, эрсдэлийн удирдлагын бодлогын хүрээнд эрсдэл хүлээн зөвшөөрөх хэм хэмжээний дагуу улирал бүр хянах байдлаар эрсдэлийг удирдан үр дүнгээ Эрсдэл, аудитын хороонд тайлагнадаг.

## БИЗНЕСИЙН ТАСРАЛТГҮЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Говь ХК нь ирээдүйд үүсэж болох онцгой нөхцөл байдлаас үүдэн компанийн үйл ажиллагаа тасалдах эрсдэлээс урьдчилан сэргийлэх, онцгой нөхцөл байдал үүссэн тохиолдолд үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хадгалах, нөхөн сэргээх арга хэмжээг тодорхой байлгах зорилгоор бизнесийн тасралтгүй үйл ажиллагааны бодлогыг хэрэгжүүлдэг.
Тус бодлогын хүрээнд Гүйцэтгэх удирдлагаас компанийн үйл ажиллагаанд учирч болох давагдашгүй хүчин зүйл, цар тахлын үед авах шаардлагатай арга хэмжээг боловсронгуй болгон, хор уршгийг арилгах, сэргээн босгох ажиллагааг түргэн шуурхай зохион байгуулах, нөөцийн бэлэн байдлыг хангаж, үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хадгалахад чиглэсэн журмыг боловсруулсан.

Энэхүү журмынхаа хэрэгжилтийг хангах зорилгоор голлох эрсдэлүүдэд авч хэрэгжүүлэх бизнесийн тасралтгүй үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж байгаа ба 2024 онд Эрсдэл, аудитын хорооны зүгээс 2 удаагийн ээлжит хурал дээр тус төлөвлөгөөний боловсруулах явцтай танилцаж санал зөвлөмжийг өгсөн.

## 2024 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН

### Эрсдэлийн удирдлагын баг

Эрсдэлийн удирдлагын шинэчилсэн журмын дагуу эрсдэлийн үнэлгээ болон эрсдэлийн мониторингийг жилд 2 удаа хийж, үр дүнг Эрсдэл, аудитын хороонд тайлагнан ажиллаа. Эрсдэлийн удирдлагын багийн бүрэлдэхүүний хувьд байгууллагын бүтэц зохион байгуулалтын өөрчлөлтийн дагуу тухай бүр томилгоог шинэчлэн батлуулав.

### Эрсдэлийн удирдлагын тогтолцооны хэрэгжилт

Байгууллагын эрсдэлийн удирдлагын календарийн дагуу нийт газар, үйлдвэр, нэгжүүд учирч болзошгүй эрсдэлүүдээ тодорхойлох, үнэлэх, удирдах, хяналт мониторинг хийх, тайлагнах буюу тогтолцооны үе шатуудыг бүрэн хэрэгжүүлж, эрсдэлээс үүсэх үр нөлөөг хамгийн бага түвшинд байлгахаар удирдан ажилласаар байна.

### Эрсдэлийн соёлыг түгээн дэлгэрүүлэх

Сургалт хөгжлийн төлөвлөгөөний дагуу 2024 онд эрсдэлийн удирдлагын мэдлэг ойлголт, аргазүйн сургалтыг зохион байгуулж Эрсдэлийн удирдлагын баг болон нийт эрсдэл хариуцагч нэгжийн удирдлагуудыг хамруулав. Сургалтын агуулгад ISO31000:2018 Эрсдэлийн удирдлага, ISO22301:2019 Бизнесийн тасралтгүй үйл ажиллагааны менежмент, процессын удирдлага зэрэг багтав.

Байгууллагын эрсдэлийн удирдлагын шинэчилсэн календарийн дагуу эрсдэлийн удирдлагын тогтолцооны үе шат бүрийг үр дүнтэй гүйцэтгэхэд дэмжлэг болох үүднээс эрсдэл хариуцагч нарт Эрсдэлийн удирдлагын багаас тухай бүр тухайн газар, үйлдвэр, нэгжийн эрсдэл бүр дээр газар дээр болон зайнаас ойлголт болон аргазүйн зөвлөгөөг өгч, хэрхэн удирдах амжилттайгаар хамтран ажиллалаа.



### Гэнэтийн эрсдэлийн үнэлгээ

2024 оны 2-р сарын 14-ний өдөр цас, зудын улмаас улсын хэмжээнд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдал зарласан бөгөөд 2024 оны 2-р сарын 19-ний өдрийн байдлаар улсын хэмжээнд 667,841 толгой мал хорогдсон нь Говь ХК-ийн хувьд бүтээгдэхүүний түүхий эд татан авалтад сөргөөр нөлөөлөхүйц нөхцөл байдал үүссэн учир гэнэтийн эрсдэлийн үнэлгээг хийж, хариу арга хэмжээний төлөвлөлт боловсруулан эрсдэл хариуцагч нарт илгээв.
Амьтны эрхийг хамгаалах байгууллагаас (PETA) Монголын ноос ноолуурын үйлдвэрүүдийн нэрийг цохон ямаа самнах үйл ажиллагааг шүүмжилсэн нийтлэл гарсантай холбогдуулж байгууллагад учирч болох эрсдэлийг үнэлж, эрсдэл удирдагч нарт заавар, зөвлөмж хүргэв.

## ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ТАЙЛАН

2024 оны хагас жилийн байдлаар удирдах арга хэмжээ авах шаардлагатай 555 эрсдэл байсан бөгөөд дундаж оноо 4 буюу ДУНД түвшинд байв. Тайлант хугацааны туршид бид эрсдэлийн дундаж оноог оны эцэс гэхэд БАГА түвшинд хүргэх зорилттой ажилласан билээ.

| | | | Үр нөлөө | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Маш бага | Бага | Дунд | Их | Маш их |
| | | | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| Магадлал | Маш их | 5 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| | Их | 4 | 1 | 7 | 0 | 1 | 0 |
| | Дунд | 3 | 55 | 9 | 17 | 1 | 2 |
| | Бага | 2 | 140 | 46 | 19 | 9 | 10 |
| | Маш бага | 1 | 131 | 71 | 28 | 1 | 7 |

| Эрсдэлийн түвшин | Тоо | Эзлэх % |
|---|---|---|
| Маш их | 0 | 0.0% |
| Их | 4 | 0.9% |
| Дунд | 126 | 22.5% |
| Бага | 294 | 53.0% |
| Маш бага | 131 | 23.6% |
| **Нийт** | **555** | **100.0%** |

Эрсдэлийн дундаж түвшин




Эрсдэл удирдах хариу арга хэмжээний төлөвлөлт боловсруулан хэрэгжүүлж, үүн дээр хоёрдугаар хагас жилийн эрсдэлийн үнэлгээгээр шинэ эрсдэлүүд тодорхойлогдон нэмэгдэж нийт 566 эрсдэл бүртгэлтэй байснаас 6 эрсдэл хаагдаж, нийт эрсдэлийн оноо 3 буюу БАГА түвшинд байна.

# КОМПЛАЙНСЫН УДИРДЛАГА

Говь ХК нь бизнесийн үйл ажиллагаагаа хууль дээдлэх, шударга байх, хариуцлагатай байх, ил тод нээлттэй байх, ёс зүйтэй байх зарчмыг баримтлан явуулдаг бөгөөд тогтвортой хөгжлийн бодлого, зорилтод ёс зүйн нийцлийг тодотгон тусгаж, энэ хүрээнд авч буй арга хэмжээг комплайнсын удирдлагаар зохицуулдаг. Комплайнсын удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэх нь ажилтан, харилцагч болон дотоод гадаад хөрөнгө оруулагчдын итгэл үнэмшлийг бэхжүүлж, учирч болохуйц эрсдэлээс урьдчилан сэргийлэх ач холбогдолтой.

Бид 2022 оны 8 сард Ёс зүйн кодоо шинэчлэн баталсан билээ. Манай компанийн "Ёс зүйн код" дараах зарчмуудыг агуулдаг:




## 2024 ОНЫ ОНЦЛОХ АЖЛУУД

- Комплайнсын бодлого шинэчлэн батлагдав.
- "Шүгэл үлээх тогтолцооны үйл ажиллагааны журам", "Ёс зүйн кодын хэрэгжилтийг зохицуулах журам"-ууд шинэчлэгдэв.
- "Ажлын байрны ёс зүй"-н сургалт, "Шүгэл үлээх систем"-ийн үйл ажиллагааны тайлан мэдээ танилцуулагдаж ил тод, хүртээмжтэй байдлыг хангаж ажиллав.
- Ёс хорооны гишүүдийг чадавхжуулах, комплайнсын ойлголт мэдлэг өгөх, удирдлагын ёс зүйн манлайллыг дээшлүүлэх зорилгоор мэргэжлийн байгууллагын зөвлөх үйлчилгээ болон сургалт авав.
- Баримт бичгийн хэрэгжилтийг үнэлэх, үйл ажиллагааг сайжруулж бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор "Бодлого журмын нийцэл"-ийн ажлыг эхлүүлэв.



# КОМПЛАЙНСЫН БОДЛОГО

**Зорилго**

- Комплайнсын шаардлага болон үүрэг, амлалтыг чанд мөрдөн, байгууллагын үнэт зүйл, ёс зүйн хэм хэмжээг хариуцлагатай зан үйл болгон төлөвшүүлж, комплайнсын эрсдэлийг удирдан, ёс зүйтэйгээр үйл ажиллагаа явуулахад тус бодлогын зорилго оршино.
- Байгууллага нь зарим чиг үүргээ гуравдагч этгээдээр гүйцэтгүүлэх тохиолдолд гуравдагч этгээд нь тус бодлогын холбогдох шаардлагыг хангасан байна.

**Хамрах хүрээ**

- Олон нийтэд нээлттэй байх бөгөөд Говь ХК-ийн нийт ажилтнууд, охин компанийн ажилтнууд, гэрээт компани, ханган нийлүүлэгч болон хөлсөөр ажиллах гэрээгээр ажиллаж буй ажилтнуудыг хамруулна.

**Зарчим**



# ШҮГЭЛ ҮЛЭЭХ СИСТЕМ

ГОВЬ ХК 2022 онд байгууллагын үйл ажиллагааны ёс зүйн доголдлыг эрт үед нь илрүүлэх гарч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, засаж сайжруулах, ажилтны байгууллагадаа итгэх итгэлийг бэхжүүлэх зорилгоор “Шүгэл үлээх удирдлагын тогтолцоо”-г нэвтрүүлж, шүгэл үлээх систем болон бусад эх сурвалжийг ашиглалтад оруулсан.

**Шүгэл үлээх боломжтой эх сурвалжууд**

| Шүгэл үлээх систем | Утсаар | Бусад |
|---|---|---|
| info.gobi.mn/whistleblowing | 70139977-6 | Ярилцлагын хуудас, албан бичиг |

Дээрх эх сурвалжаар ирсэн мэдээллийн төрөл, зэрэглэл, хамрах хүрээ зэргээс шалтгаалан журмын дагуу Төлөөлөн удирдах зөвлөл, Нэр дэвшүүлэх хороо, Комплайнсын газар, Ёс зүйн хороо шууд хүлээн авч аливаа ёс зүйн зөрчлийг илрүүлэх, шийдвэрлэх, урьдчилан сэргийлэх, сайжруулах, шударга тогтолцоог ханган ажиллахаар зохицуулагдсан.

2024 онд “Шүгэл үлээх систем”-д нийт 49 шүглийн мэдээлэл ирсэн байна. Үүнд:

| Шүгэл үлээх системээр | Утсаар | Бусад |
|---|---|---|
| 70% | 20% | 10% |

**Зөрчил мэдээлэл шийдвэрлэсэн байдлаар**




**Шүгэл үлээх системийн сургалт**

| ГАДААД СУРГАЛТ | ДОТООД СУРГАЛТ |
|---|---|
| Ёс зүйн хорооны гишүүд, Комплайнсын газар болон бусад газар нэгж, дунд түвшний удирдлагууд | Үйлдвэр удирдлагын газрын 5 үйлдвэр болон Хэнтий салбар нэгжийн ажилтнууд |
| **Сургалтын тоо 10** | **Сургалтын тоо 6** |
| Сургалтад хамрагдсан ажилтнуудын тоо | Сургалтад хамрагдсан ажилтнуудын тоо |
| **268** | **766** |

**Шүгэл үлээх системийн сайжруулалт**




Шүгэл үлээгчийн мэдээллийн нууцлалыг хадгалах суурь зарчмыг алдагдуулахгүйгээр нэг удаагийн олгогдсон кодоор чат бичих, нэмэлт мэдээлэл авах, шүгэл үлээгч, мэдээлэл хүлээн авагчийн харилцаар эргэх холбоотой болгон сайжруулалт хийгдэв.

# ЧАНАРЫН УДИРДЛАГА

Говь ХК нь түүхий эдийг малчдын гараас хүлээн авахаас эцсийн бэлэн бүтээгдэхүүн хүртэлх бүхий л шат дамжлагад 230 үзүүлэлтээр чанарын шалгалтыг хийж, технологийн горимыг чанд мөрдөн, бүтээгдэхүүнээ үндэсний болон олон улсын стандартын шаардлагын дагуу үйлдвэрлэж, баталгаажуулан дотоод, гадаад, онлайн сувгаар хэрэглэгчдэд хүргэдэг.
Бид хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэхээр үйлдвэрлэлийн шат дамжлага бүрдээ чанарын удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэн, үндэсний 85 MNS стандарт, компанийн 18 бодлого, 6 дүрэм, 152 журам, технологийн горим, 47 ажлын заавар, зааварчилгаа, 14 гарын авлагыг мөрдөж, чанарын хяналт шалгалтыг 100% хийж, чанарын удирдлагын тогтолцооны стандартын шаардлагыг бүхийл үйл ажиллагаандаа хэрэгжүүлж тасралтгүй сайжруулан ажиллаж байна.

## ЧАНАРЫН БОДЛОГО

Бид хэрэглэгч, харилцагчдынхаа өнөөгийн болон ирээдүйн хэрэгцээ шаардлагад нийцсэн чанартай, загварлаг бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ.

## ЧАНАРЫН ЗОРИЛТУУД

- Үйлдвэрлэлийн техник технологийг тасралтгүй сайжруулж, бэлэн бүтээгдэхүүний чанарыг 95%-д хүргэх
- Хэрэглэгчийн сэтгэл ханамжийг эрхэмлэж, тасралтгүй дээшлүүлэхийг
- Бүтээгдэхүүний чанартай холбоотой хэрэглэгчийн гомдлын үзүүлэлтийг нийт борлуулалтын тоо ширхгийн 0.5%-аас ихгүй байлгаж, сэтгэл ханамжийг нэмэгдүүлнэ.
- Стандарт шаардлагыг хангах, чанарын хяналтыг сайжруулах олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн бэлэн бүтээгдэхүүний лабораторийг тасралтгүй хөгжүүлэх.


ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВ

ИТГЭМЖЛЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

Дугаар TL 01

ISO/IEC 17025:2017 (MNS ISO/IEC 17025:2018)

"Говь" ХК-ийн Дотоод хяналтын лабораторийг

Олгосон огноо: 2024.02.14

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

APAC

0000621

Говь ХК нь 1998 оноос одоог хүртэлх итгэмжилсэн лабораторийн чанарын хяналтыг удирдлага болгон ажиллаж байна. 2024 онд MNS ISO/IEC 17025:2018 "Сорилтын болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхид тавих ерөнхий шаардлага хангасан Итгэмжилсэн лабораторийн гэрчилээг 2 жилийн хугацаатайгаар сунгасан.
Мөн лабораторийн итгэмжлэлийн хүрээнд ILAC. APAC лого ашиглах нэмэлт гэрээ байгуулсан. Олон талт харилцан хүлээн зөвшөөрөх тухай хэлэлцээр буюу ILAC-ийн хэлэлцээрт 140 гаруй итгэмжлэлийн байгууллага нэгдсэн бөгөөд хэлэлцээрийн хүрээнд итгэмдэгдсэн лабораториуд олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдөж, тэдний боловсруулсан үр дүн бүхий экспортын бараа бүтээгдэхүүнийг хилийн чанадад шууд хүлээн авах нөхцөл бүрдэж байна.

Бид дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн Монгол ноолууран бүтээгдэхүүнийг хэрэглэгчдэдээ хүргэхийн тулд Монгол Улсын тэдийгүй олон улсын стандартын шаардлагыг хангаж, удирдлагын тогтолцоогоо тасралтгүй сайжруулж байна.

- 2021.06 — "Органик бүтээгдэхүүн" гэрчилгээ



- 2021.07 — OEKO-TEX® утасны гэрчилгээ
- 2021.12 — "Цэвэр ноолуур боловсруулах зохистой дадал" тохирлын гэрчилгээ
- 2022.08 — ISO 14001:2015 стандарт
- 2022.08 — ISO 45001:2018 стандарт
- 2022.12 — "MNS 6926:2021 "Текстилийн тогтвортой үйлдвэрлэл" тохирлын гэрчилгээ"
- 2023.05 — "Монголын хаан ширхэгт" тохирлын гэрчилгээ
- 2023.06 — ISO 9001:2015 стандарт
- 2024.02 — OEKO-TEX® бэлэн бүтээгдэхүүний гэрчилгээ

# ГОВЬ ГРУППИЙН БҮТЭЦ







## КОМПАНИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТАД ГАРСАН ГОЛ ӨӨРЧЛӨЛТҮҮД

- Нийцлийн газар шинээр бий болсон. Тус газрын харьяанд Хуулийн хэлтэс, Тогтвортой хөгжлийн хэлтэс, Чанар стандарт баталгаажуулалтын хэлтэс, Хөдөлмөрийн эрүүл мэнд аюулгүй байдлын хэлтсүүдийг нэгтгэхээс гадна Дотоод хяналтын албыг шинээр байгуулсан.
- Мерчендайзингийн газар шинээр бий болсон. Тус газрын харьяанд дотоод болон гадаад мерчендайзингийн хэлтсүүдийг нэгтгэсэн.

ГАЗАР - 12
ХЭЛТЭС - 44
ҮЙЛДВЭР - 5

# МЕНЕЖМЕНТ БАГИЙН УДИРДЛАГУУД

| № | Албан тушаал | Овог нэр | Говь ХК-д ажилласан хугацаа | Говь ХК-ийн хувьцаа эзэмшил |
|---|---|---|---|---|
| 1 | Гүйцэтгэх захирал | Б.Амарсайхан | 5 жил | 1,000 ширхэг (0.0001%) Нэгдмэл сонирхолтой хуулийн этгээд: 87.33% |
| 2 | Тэргүүн дэд захирал /Гадаад, экспорт борлуулалт/ | Ц.Оргилболд | 5 жил | Хувьцаа эзэмшдэггүй. Нэгдмэл сонирхолтой хуулийн этгээд: 87.33% |
| 3 | Тэргүүн дэд захирал /Дотоод борлуулалт/ | Б.Ариунаа | 12 жил | 1,000 ширхэг (0.0001%) |
| 4 | Дизайн, үйлдвэрлэл хариуцсан дэд захирал | Б.Болормаа | 18 жил | 1,000 ширхэг (0.0001%) |
| 5 | Гадаад борлуулалт хариуцсан дэд захирал | О.Мишээл | 8 жил | 1,000 ширхэг (0.0001%) |
| 6 | Үйлдвэр удирдлага хариуцсан захирал | М.Болортуяа | 9 жил | 800 ширхэг (0.0001%) |
| 7 | Санхүү бүртгэл хариуцсан захирал | Д.Содгэрэл | 14 жил | 800 ширхэг (0.0001%) |
| 8 | Санхүү удирдлага хариуцсан захирал | Г.Баярбат | 6 сар | Хувьцаа эзэмшдэггүй. |
| 9 | Хүний нөөц хариуцсан захирал | Т.Ичинхорлоо | 4 сар | Хувьцаа эзэмшдэггүй |
| 10 | Экспортын борлуулалт хариуцсан захирал | Г.Анударь | 10 жил | 800 ширхэг (0.0001%) |
| 11 | Дизайн хөгжүүлэлт хариуцсан захирал | А.Учрал | 10 жил | 800 ширхэг (0.0001%) |
| 12 | Мерчиндайзинг хариуцсан захирал | О.Цэнгэл | 9 жил | 800 ширхэг (0.0001%) |
| 13 | Мэдээлэл технологи хариуцсан захирал | Б.Эрдэнэ | 1.5 жил | Хувьцаа эзэмшдэггүй. |
| 14 | Нийцэл хариуцсан захирал | Б.Чингүүн | 9 сар | Хувьцаа эзэмшдэггүй. |
| 15 | Хуулийн хэлтсийн дарга | Ц.Цасчихэр | 11 жил | 1,000 ширхэг (0.0001%) |
| 16 | Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга | М.Сэлэнгэ | 8 жил | 500 ширхэг (0.0000%) |
| 17 | Дотоод аудитын хэлтсийн дарга | Н.Сайнзул | 10 жил | 800 ширхэг (0.0001%) |



# МЕНЕЖМЕНТ БАГИЙН УДИРДЛАГУУДЫН ЦАЛИН, УРАМШУУЛАЛ

## ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ЦАЛИН, УРАМШУУЛАЛ

Компанийн гүйцэтгэх удирдлагыг Гүйцэтгэх захирал хэрэгжүүлдэг. Гүйцэтгэх захирлын цалин, урамшуулал нь компанийн санхүү, үйл ажиллагааны үр дүн болон ажлын гүйцэтгэл, ур чадварын үнэлгээтэй уялдсан байх бөгөөд цалин, урамшууллын хэмжээ, түүнийг олгох зарчмыг ТУЗ-ийн дэргэдэх Цалин, урамшууллын хороо тогтоодог.
Гүйцэтгэх захирлын эрх үүрэг, хариуцлагыг тодорхойлсон Менежментийн гэрээний нөхцөлийг ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороо боловсруулан, гэрээний агуулгыг ТУЗ-ийн хурлаар баталдаг бөгөөд ТУЗ-өөс 2024 оны 3-р сард шинээр томилогдсон Гүйцэтгэх захиралтай Менежментийн гэрээг байгуулсан.

## МЕНЕЖМЕНТ БАГИЙН БУСАД УДИРДЛАГУУДЫН ЦАЛИН, УРАМШУУЛАЛ

Гүйцэтгэх захирлаас бусад Менежмент багийн удирдлагуудын цалин, урамшуулал, түүнийг олгох шалгуур үзүүлэлтийг Цалин, урамшууллын бодлогын хүрээнд нь Гүйцэтгэх захирал тогтоодог. Харин ТУЗ-ийн дэргэдэх нэгжүүд болох ТУЗ-ийн нарийн бичгийн дарга болон Дотоод аудитын хэлтсийн даргын цалинг ТУЗ-ийн дэргэдэх хороодын саналыг үндэслэн ТУЗ тогтоодог.
Менежмент багийн удирдлагууд нь ТУЗ-ийн гишүүний үүргийг давхар гүйцэтгэж байгаа тохиолдолд ТУЗ-ийн гишүүний цалинг авах ба хангамж, урамшууллыг давхар авахгүй байх зарчмыг Цалин урамшууллын хороо тогтоосон.

## ЦАЛИНГИЙН БҮТЭЦ

| Үзүүлэлт | Ээлэх жин |
|---|---|
| **Үндсэн цалин** | Албан тушаалын чиг үүргээс хамаарна. |
| **Гүйцэтгэлээс хамаарсан нэмэгдэл цалин /KPI/**<br>· Компанийн борлуулалт, ашгаас хамаарсан үзүүлэлт<br>· Тухайн ажилтны төлөвлөгөөт ажлын гүйцэтгэлийн үзүүлэлт<br>· Хариуцсан газар нэгжийн хүний нөөцийн эргэцийн үзүүлэлт | |

## УРАМШУУЛЛЫН ЗАРЧИМ

Говь ХК-д мөрдөгдөж буй Цалин урамшууллын бодлого, Үр дүнгийн урамшуулал олгох журмын дагуу компанийн санхүү үр дүнгийн гүйцэтгэлээс хамааран тухайн жилийн бизнес төлөвлөгөөний борлуулалтын гүйцэтгэл, цэвэр ашгийн гүйцэтгэлийн тодорхой шалгуурыг хангасан үед урамшууллыг олгодог.

### ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН АЖЛЫН ҮР ДҮНГ ДҮГНЭХ ҮЗҮҮЛЭЛТ

| Шалгуур үзүүлэлт | Эзлэх жин | Зорилт | Хэмжигдэхүүн | Эзлэх жин |
|---|---|---|---|---|
| Жилийн бизнес төлөвлөгөөний биелэлт | 85% | Үр ашгийг нэмэгдүүлэх | Компанийн үр ашгийг нэмэгдүүлэхтэй холбоотой төлөвлөгөөний биелэлтээр хэмжинэ. Үүнд:<br>Борлуулалтын орлогыг нэмэгдүүлэх,<br>Ашгийг нэмэгдүүлэх,<br>Үйл ажиллагааны зардлыг бууруулах, зохистой зарцуулах,<br>Эргэлтийн хөрөнгийн үр ашгийг нэмэгдүүлэх, бараа материалын эргэцийг сайжруулах гэх мэт... | 50% |
| | | Үйл ажиллагаа, процессыг сайжруулах | Компанийн үйл ажиллагаа, процессыг сайжруулахтай холбоотой төлөвлөгөөний биелэлтээр хэмжинэ. Үүнд:<br>Үйлдвэрлэлийн жигд үйл ажиллагаар хангах, төлөвлөгөөг биелүүлэх,<br>Бүтээгдэхүүний чанарын үзүүлэлтийг өсгөх,<br>Үйл ажиллагааны процессыг сайжруулах, бүтээмжийг нэмэгдүүлэх,<br>Эрсдэлийн удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэх,<br>Менежментийн тогтолцооны стандартыг хангах,<br>Тогтвортой хөгжлийн үйл ажиллагаар хөгжүүлэх,<br>Хөдөлмөрийн эрүүл мэнд аюулгүй байдлыг хангах<br>Байгууллагын соёлыг сайжруулах,<br>Ажлын байрны таатай орчныг бүрдүүлэх<br>Ур чадвартай ажилтнуудыг бүрдүүлж, чадавхжуулах<br>Хүний нөөцийг тогтворжуулах, эргэцийг бууруулах гэх мэт... | 50% |
| Ур чадварын үнэлгээний үр дүн | 15% | Удирдлагын манлайлах ур чадварыг нэмэгдүүлэх | Ур чадварын үнэлгээний үр дүнгээр хэмжинэ. | 100% |

Менежмент багийн удирдлагуудын хувьд ажлын байрны чиг үүрэгтэй уялдан ажлын үр дүнг дүгнэх үзүүлэлтийн зорилтыг хэмжих хэмжигдэхүүн болон эзлэх жин өөр өөр байдаг.

### 2024 ОНЫ ЦАЛИН, УРАМШУУЛАЛ

*/мянган төгрөг/*

| Менежмент багийн цалин, урамшуулал | 2023 он | 2024 он | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Цалин | 1,811,628 | 2,079,731 | 14.8% |
| Урамшуулал | 56,000 | 114,214 | 104.0% |
| НДШ | 251,889 | 274,787 | 9.1% |
| **Дүн** | 2,119,517 | 2,468,732 | 16.5% |



# КОМПАНИЙН ХУВЬЦААНЫ АРИЛЖААНЫ МЭДЭЭЛЭЛ

Говь ХК-ийн зах зээлийн үнэлгээ 2024.12.31-ний хаалтын ханшаар 201,269,025,000 төгрөг байна. Жилийн арилжааны мэдээллийг графикаар үзүүлэв.




## 52 ДОЛОО ХОНОГИЙН ХУВЬЦААНЫ АРИЛЖААНЫ ХАНШ

| Үзүүлэлт | 2023 он | 2024 он | Өөрчлөлт % |
|---|---|---|---|
| ГАРГАСАН ХУВЬЦААНЫ ТОО /ширхэг/ | 780,112,500 | 780,112,500 | - |
| ХУВЬЦААНЫ ҮНЭ /төгрөг/ | | | |
| Хаалтын үнэ | 273.59 | 258.00 | -5.7% |
| Хамгийн их үнэ | 350.00 | 283.98 | -18.9% |
| Хамгийн бага үнэ | 240.69 | 245.06 | 1.8% |
| Дундаж үнэ | 263.90 | 261.24 | -1.0% |
| АРИЛЖААЛАГДСАН ТОО /ширхэг/ | | | |
| Хамгийн их /өдөрт/ | 7,500,000 | 257,495,975 | 3333.3% |
| Хамгийн бага /өдөрт/ | 179 | 322 | 79.9% |
| Дундаж /өдөрт/ | 62,704 | 1,078,172 | 1619.5% |
| Нийт | 15,676,081 | 269,543,096 | 1619.5% |
| АРИЛЖААНЫ ҮНИЙН ДҮН /төгрөг/ | | | |
| Хамгийн их /өдөрт/ | 2,625,000,000 | 65,661,782,758 | 2401.4% |
| Хамгийн бага /өдөрт/ | 52,805 | 85,264 | 61.5% |
| Дундаж /өдөрт/ | 18,985,172 | 275,011,411 | 1348.6% |
| Нийт | 4,746,292,927 | 68,752,852,703 | 1348.6% |
| ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ /төгрөг/ | 213,430,978,875 | 201,269,025,000 | -5.7% |

# НОГДОЛ АШИГ

Манай компани нь дотоодын зах зээлд байр сууриа хадгалах, улмаар зах зээлд эзлэх хувиа өсгөх, гадаад болон онлайн худалдааны зах зээлээ тэлэхийн тулд техник, технологио шинэчлэх, бүтээгдэхүүний чанарыг сайжруулах, үйл ажиллагаагаа өргөжүүлэхээр чармайн ажиллахын зэрэгцээ хувьцаа эзэмшигчдийнхээ хөрөнгө оруулалтын өгөөжийг тасралтгүй өсгөж, ногдол ашиг тогтмол тараах бодлогыг баримталдаг.
"Ногдол ашгийн журам"-ын 2-р бүлэгт ногдол ашгийн бодлогыг дараах байдлаар тодорхойлсон байдаг.

## НОГДОЛ АШГИЙН БОДЛОГО

2.1. Компанийн ногдол ашгийн бодлого нь Компанийн үйл ажиллагаа болон стратегийн бодлоготой уялдсан байна.
2.2. Компани хувьцаа эзэмшигчдийн оруулсан хөрөнгийг зүй зохистой захиран зарцуулж, ногдол ашгийн хэмжээг зохистой түвшинд байлгах бодлоготой ажиллана.
2.3. Компани нь Компанийн тухай хуулийн 47-р зүйл, Компанийн дүрмийн 8.12-д заасан ногдол ашиг хуваарилах нөхцөл хангагдсан тохиолдолд ногдол ашиг хуваарилна.
2.4. Нэгж хувьцаанд хуваарилах ногдол ашгийн хэмжээг тухайн санхүүгийн жилийн татварын дараах цэвэр ашгийн хэмжээ, Компанийн богино болон дунд хугацааны стратегийн төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын хэрэгцээ шаардлага зэргийг үндэслэн ТУЗ тогтооно.
2.5. Тухайн санхүүгийн жилд олсон цэвэр ашиг нь өмнөх жилийнхээс буураагүй тохиолдолд ногдол ашгийн хэмжээг бууруулахгүй байх бодлого баримтална.
2.6. Ногдол ашгийг мөнгөн хэлбэрээр олгоно.
2.7. Ногдол ашиг хуваарилсны дараа үлдэх ашгаас нийгэм, соёлын арга хэмжээ, үйлдвэр хөгжүүлэх сан байгуулж болно. Санг байгуулах асуудлыг ТУЗ шийдвэрлэнэ.

## НОГДОЛ АШГИЙН МЭДЭЭЛЭЛ

| Ногдол ашиг зарласан он | Хувьцааны тоо (ширхэг) | Нэгж хувьцаанд зарласан ногдол ашиг (төгрөг) | Нийт зарласан ногдол ашгийн дүн (төгрөг) | Ногдол ашиг тараалт |
|---|---|---|---|---|
| 1997 | 7,801,125 | 153.80 | 1,199,813,025 | 2007 он хүртэлх ногдол ашгийг Говь ХК-ийн албан ёсны веб хуудсаар дамжуулан ирүүлсэн ногдол ашгийн хүсэлтийн дагуу шилжүүлж байна. |
| 1998 | 7,801,125 | 150.00 | 1,170,168,750 | |
| 1999 | 7,801,125 | 166.00 | 1,294,986,750 | |
| 2000 | 7,801,125 | 100.00 | 780,112,500 | |
| 2001 | 7,801,125 | 20.16 | 157,270,680 | |
| 2002-2004 | 7,801,125 | - | - | |
| 2005 | 7,801,125 | 60.00 | 468,067,500 | |
| 2006 | 7,801,125 | 60.00 | 468,067,500 | |
| 2007-2009 | 7,801,125 | - | - | Санхүүгийн үр дүнгээс шалтгаалан ногдол ашиг хуваарилаагүй. |
| 2010 | 7,801,125 | 100.00 | 780,112,500 | 2010-2018 он хүртэлх ногдол ашгийг хувьцаа эзэмшигчдийн харилцдаг үнэт цаасны компаниуд руу 100% тараасан. |
| 2011 | 7,801,125 | 100.00 | 780,112,500 | |
| 2012 | 7,801,125 | 125.00 | 975,140,625 | |
| 2013 | 7,801,125 | 130.00 | 1,014,146,250 | |
| 2014 | 7,801,125 | 140.00 | 1,092,157,500 | |
| 2015 | 7,801,125 | 140.00 | 1,092,157,500 | |
| 2016 | 7,801,125 | 200.00 | 1,560,225,000 | |
| 2017 | 7,801,125 | 220.00 | 1,716,247,500 | |
| 2018 | 780,112,500 | 6.80 | 5,304,765,000 | |
| 2019-2024 | 780,112,500 | - | - | Санхүүгийн үр дүнгээс шалтгаалан ногдол ашиг хуваарилаагүй. |

**2024 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг хуваарилахгүй тухай**

Говь ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 2-р сарын 7-ны өдрийн №3 тоот тогтоолын дагуу 2024 оны санхүүгийн үр дүн нь компанийн ногдол ашгийн бодлогын 2.3-т заасан ногдол ашиг олгох нөхцөлийг хангаагүй буюу санхүүгийн зохистой харьцааг хангахгүй байгаа тул ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн.





# ГОВЬ ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2024 оны 12-р сарын 31

## ХАРААТ БУС АУДИТОР

Говь ХК-ийн Эрсдэл аудитын хороо нь хараат бус аудиторт тавигдах хараат бус байдлын болон мэргэшил, ажлын туршлага, бусад шалгуур үзүүлэлтийг тогтоож, уг шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа байдалд дүгнэлт хийн хараат бус аудиторын эрх, үүрэг, хариуцлага, аудиторт төлөх хөлсний хэмжээ, бусад гэрээний нөхцөлийн талаар санал боловсруулан ТУЗ-өөр шийдвэрлүүлэн батлуулдаг. Мөн хараат бус аудитын үйл ажиллагаанд нь хяналт тавихаас гадна удирдлагад өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийн биелэлтэд хяналт тавьж чиглүүлэн ажилладаг.

Говь ХК-ийн 2024 оны 12-р сарын 31-нээрх санхүүгийн тайланд Кэй Пи Эм Жи Аудит ХХК хөндлөнгийн аудит хийсэн. Гэрээний дүн 85,860 ам.доллар буюу 290,261,750 төгрөг.
Кэй Пи Эм Жи Аудит ХХК нь олон улсын 4 том аудитын компанийн нэг бөгөөд 2013 онд Санхүүгийн зохицуулах хороонд Үнэт цаасны зах зээлд үйлчилгээ үзүүлэх Аудитын компаниар бүртгэгдсэн.

ГОВЬ ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД

# НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН БОЛОН ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

## АГУУЛГА


**ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ** ........ 117
**ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН МЭДЭГДЭЛ** ........ 118
**ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН** ........ 119
**НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**
- Нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан ........ 124
- Нэгтгэсэн иж бүрэн орлогын тайлан ........ 125
- Нэгтгэсэн өмчийн өөрчлөлтийн тайлан ........ 126
- Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан ........ 127
- Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулгууд ........ 128


2024 ОНЫ 12-Р САРЫН 31



## ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

| | |
|---|---|
| **Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга** | Ц. Баатарсайхан (2025 оны 2 дугаар сараас) |
| **Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүд** | Ц. Баатарсайхан<br>Д. Хулан<br>Б. Амарсайхан<br>Ц. Оргилболд<br>Н. Мөнхбат |
| **Хараат бус Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүд** | А. Жаргалмаа<br>Д. Гэрэлмаа<br>Д. Хүрэлбаатар<br>Б. Цээням |
| **Нарийн бичгийн дарга** | М. Сэлэнгэ |
| **Харилцагч банкууд** | Хаан Банк<br>Голомт Банк<br>Хас Банк<br>Худалдаа Хөгжлийн Банк<br>Ариг Банк<br>Америкийн Банк Корпораци<br>Дойче Банк Эй Жи<br>Хятадын Бүтээн Байгуулалтын Банк Корпораци |
| **Албан хаяг** | Говь үйлдвэрийн байр, үйлдвэрийн гудамж,<br>Хан-Уул дүүрэг, 3 дугаар хороо,<br>Улаанбаатар-17062, Монгол улс |
| **Хараат бус аудитор** | КЭЙ ПИ ЭМ ЖИ АУДИТ ХХК<br>Монгол улс, Улаанбаатар хот 14240,<br>Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо<br>Энхтайваны өргөн чөлөө 17,<br>Блю Скай Тауэр, 602 тоот |

## Гүйцэтгэх Удирдлагын Мэдэгдэл

Говь ХК-ийн удирдлага нь нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэх, тайлагнах үүрэгтэй.

Говь ХК болон түүний охин компаниуд (цаашид хамтад нь "Групп" гэх)-ын нэгтгэсэн санхүүгийн тайлан нь СТОУС-ын Стандартуудын дагуу бэлтгэгдсэн. Группийн удирдлага нь энэхүү нэгтгэсэн санхүүгийн тайлан нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв илэрхийлсэн гэдгийг баталгаажуулах үүрэгтэй.

Группийн удирдлага нь Группийн санхүүгийн байдлыг үндэслэлтэй, үнэн зөв илэрхийлж чадах, санхүүгийн тайлангууд нь тодруулга 2-оос 4-т дурдсан шаардлагуудад нийцсэн гэдгийг баталгаажуулах боломжийг хангах зөв зохистой нягтлан бодох бүртгэлийг хөтөлж байгаа гэдгийг баталгаажуулах үүрэгтэй.

Мөн удирдлага нь Группийн эд хөрөнгийг хадгалан хамгаалах, аливаа залилан ашиглан, зүй бус үйлдлээс сэргийлэх, ийм үйлдэл гарвал илрүүлэхэд шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх ерөнхий үүрэгтэй.

Группийн удирдлага нь нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тохиромжтой бодлогыг сонгож, тууштайгаар хэрэглэж, үндэслэлтэй, нягт нямбай тооцоолол, үнэлэмж хийж, бүх холбогдох нягтлан бодох бүртгэлийн стандартыг мөрдсөн гэж үзэж байна.

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн нэгтгэсэн санхүүгийн тайланг удирдлага шийдвэрийн дагуу зөвшөөрч батлав.

Б. Амарсайхан
Гүйцэтгэх Захирал

Д. Содгэрэл
Бүртгэл Хариуцсан Захирал

Улаанбаатар хот,
Монгол Улс

Огноо: 2025 оны 3 дугаар сарын 21-ний өдөр

KPMG

**Кэй Пи Эм Жи Аудит ХХК**
Монгол Улс, Улаанбаатар-14240,
Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо,
Энхтайваны өргөн чөлөө 17,
Блю Скай Тауэр, 602 тоот

Утас : +976 7011 8101
Факс: +976 7011 8102
www.kpmg.com/mn

## Хараат Бус Аудиторын Тайлан

Говь Хувьцаат Компанийн Хувьцаа Эзэмшигчид болон Төлөөлөн Удирдах Зөвлөлд:

**Дүгнэлт**

Бид Говь ХК (цаашид "Толгой Компани" гэх) болон түүний охин компаниуд (цаашид хамтад нь "Групп" гэх)-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн нэгтгэсэн ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, нэгтгэсэн өмчийн өөрчлөлтийн тайлан, нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогууд ба бусад тайлбар мэдээллүүдийг агуулсан тодруулгуудаас бүрдсэн нэгтгэсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр, энэхүү нэгтгэсэн санхүүгийн тайлан нь Группийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн нэгтгэсэн санхүүгийн гүйцэтгэл болон нэгтгэсэн мөнгөн гүйлгээг Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөлөөс баталсан СТОУС Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартууд (цаашид "СТОУС Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартууд" гэх)-ын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн Үндэслэл**

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (цаашид "АОУС" гэх)-ын дагуу хийж гүйцэтгэсэн. Уг стандартын дагуу хүлээх үүрэг хариуцлагыг энэхүү тайлангийн *Нэгтгэсэн Санхүүгийн Тайлангийн Аудитад Хүлээх Аудиторын Үүрэг Хариуцлага* хэсэгт харуулсан. Бид Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөлийн Мэргэжлийн Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Дүрэм (Хараат Бус Байдлын Олон Улсын Стандарт үүнд хамаарна) (цаашид "НБЁЗОУСЗ-ийн Ёс зүйн Дүрэм" гэх) болон нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой Монгол Улс дахь ёс зүйн зохих шаардлагуудын дагуу Группээс хараат бус байж, НБЁЗОУСЗ-ийн Ёс Зүйн Дүрэм болон эдгээр ёс зүйн шаардлагуудад нийцүүлэн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь дүгнэлт өгөхөд хангалттай бөгөөд зохих үндэслэл болно гэдэгт бид итгэж байна.

**Аудитын Гол Онцлох Зүйлс**

Аудитын гол онцлох зүйлс гэдэг нь бидний мэргэжлийн үнэлэмжээр тайлант жилийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал ач холбогдол бүхий зүйлс юм. Бид нэгтгэсэн санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр аудитын гол онцлох зүйлсийг бүхэлд нь авч үзсэн ба дүгнэлт гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн тусдаа дүгнэлт гаргаагүй болно.

Кэй Пи Эм Жи Аудит ХХК нь Монгол Улсын хязгаарлагдмал хариуцлагатай компани бөгөөд баталгаагаар хязгаарлагдсан Англи Улсын хувийн компани болох KPMG International Limited-д харьяалагдах бие даасан гишүүн байгууллагуудын нэгтгэсэн KPMG олон улсын байгууллагын гишүүн юм. Бүх эрх хуулиар хамгаалагдсан.

KPMG

**Аудитын Гол Онцлох Зүйлс, Үргэлжлэл**

***Борлуулалтын орлого хүлээн зөвшөөрөлт***

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн Тодруулга 24.1, мөн Тодруулга 2.12-т тусгагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын тодруулгуудыг харна уу.

| Гол онцлох зүйлс | Тэдгээрийг шийдвэрлэсэн аудитын арга хэмжээ |
|---|---|
| Аудитын Олон Улсын Стандартад борлуулалтын орлого хүлээн зөвшөөрөлттэй холбоотой залилангийн эрсдэл аливаа байгууллагад зайлшгүй байдаг гэж үздэг. Бид бөөний борлуулалтын орлого бодитоор үүссэн эсэхэд уг эрсдэлийг авч үзсэн ба уг эрсдэлийг удирдлагад үүсч буй төлөвлөсөн санхүүгийн үр дүнд хүрэх шахалт эсвэл удирдлага нь бөөний борлуулалтын дүнг гүйвүүлан ашиглаж шагнал урамшуулалд хүртэх эрсдэл байж болзошгүй гэж тодорхойлсон.<br><br>Дээрх зүйлстэй холбоотойгоор бид бөөний борлуулалтын орлого хүлээн зөвшөөрөлтийг нэгтгэсэн санхүүгийн тайлангийн гол онцлох зүйл гэж авч үзсэн. | Борлуулалтын орлогын хувьд гүйцэтгэсэн аудитын горимууд:<br><br>- Бид удирдлагын зүгээс борлуулалт болон борлуулалтын орлого хүлээн зөвшөөрөх үйл явцад хэрэгжүүлж буй хяналтууд, тэр дундаа борлуулалтын орлого хүлээн зөвшөөрөлтийн оршин байх, үнэн зөв байх болон цаг хугацаанд нь бүртгэх зэрэг хяналтуудыг шалгасан.<br><br>- Бид Группийн хэрэгжүүлсэн борлуулалтын орлого хүлээн зөвшөөрөх бодлогыг удирдлагатай ярилцлага хийх, борлуулалтын орлогыг хүлээн зөвшөөрч буй цаг хугацааг холбогдох стандартын шаардлагад нийцэж буй эсэхийг борлуулалтын гэрээнүүдээс түүвэр байдлаар сонгон ажил гүйлгээний хүргэлтийн нөхцөлүүдийг ойлгох үүднээс нягтлан шалгасан.<br><br>- Борлуулалтын орлогыг зохих санхүүгийн жилд борлуулалтын гэрээний нөхцөлийн дагуу хүлээн зөвшөөрсөн эсэхийг шалгах үүднээс жилийн дуусгавар болох хугацааны үед хийгдсэн борлуулалтын ажил гүйлгээнүүдээс түүврээр сонгон авч бараа материалын зарлагыг илэрхийлэх баримтууд, борлуулсан бараа материалын хүргэлтийг худалдан авагч талаас хүлээн зөвшөөрсөн холбогдох баримт бичгүүдтэй тулган шалгасан.<br><br>- Бид Групп болон түүний худалдан авагч нарын хооронд хийгдсэн борлуулалтын ажил гүйлгээнд тулган баталгаажуулалт хийх гэх мэт аудитын горимтуудыг хэрэгжүүлсэн.<br><br>- Бид тайлант жилийн дараа үед хийгдсэн борлуулалтын буцаалтууд болон худалдан авагч нь бодитой байсан эсэхийг шалгасан.<br><br>- Бид орлого хүлээн зөвшөөрөх ердийн үйл явцаас гадуур борлуулалтын орлогын журналын бичилтүүд хийгдсэн эсэхийг шалгасан. |

KPMG

**Бусад Мэдээлэл**

Удирдлага нь бусад мэдээллийн хувьд үүрэг, хариуцлага хүлээх юм. Бусад мэдээлэл гэдэгт жилийн тайланд орсон мэдээллийг хамруулж ойлгох ба нэгтгэсэн санхүүгийн тайлан болон манай аудиторын тайлан үүнд хамаарахгүй болно.

Нэгтгэсэн санхүүгийн тайлан дахь бидний дүгнэлт нь бусад мэдээллийг хамрахгүй бөгөөд үүнд бид ямар нэгэн баталгаажуулалт илэрхийлэхгүй юм.

Бусад мэдээлэлтэй уншиж танилцан, уг мэдээлэл нь нэгтгэсэн санхүүгийн тайлан эсвэл аудитын явцад олж авсан бидний ойлголттой материаллаг хэмжээгээр нийцэхгүй эсвэл материаллагаар буруу илэрхийлэгдсэн зүйлс байгаа эсэхийг шалгах нь нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой бидний хүлээх үүрэг, хариуцлага юм. Хийж гүйцэтгэсэн ажлын хүрээнд бусад мэдээлэлд аливаа материаллаг буруу илэрхийлэл байна гэж үзвэл бид энэ талаар тайлагнах үүрэгтэй. Бусад мэдээлэлтэй холбоотойгоор бидэнд тайлагнах зүйлс байгаагүй.

**Удирдлага болон Засаглах Эрх Мэдэл Бүхий Этгээдүүдийн Нэгтгэсэн Санхүүгийн Тайланд Хүлээх Үүрэг Хариуцлага**

Нэгтгэсэн санхүүгийн тайланг СТОУС Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартуудын дагуу бэлтгэж, үнэн зөв толилуулах нь удирдлагын үүрэг хариуцлага юм. Алдаа, зальт ажиллагааны улмаас материаллагаар буруу илэрхийлэгдээгүй нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх үүрэг хариуцлагыг мөн удирдлага хүлээнэ.

Нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлагын зүгээс Группийн тасралтгүй үйл ажиллагаа эрхлэх чадамжийг үнэлэн, шаардлагатай гэж үзвэл тасралтгүй үйл ажиллагаатай холбоотой асуудлуудыг нэгтгэсэн санхүүгийн тайланд тодруулж, Группийг татан буулгах юм уу үйл ажиллагааг нь зогсоох эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй үйл ажиллагааны зарчимд суурилан нэгтгэсэн санхүүгийн тайлангаа бэлтгэх үүргийг Группийн удирдлага хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь Группийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хүлээнэ.

KPMG

**Нэгтгэсэн Санхүүгийн Тайлангийн Аудитад Хүлээх Аудиторын Үүрэг Хариуцлага**

Нэгтгэсэн санхүүгийн тайлан нь залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй нотолгоог олж авах, бидний дүгнэлтийг агуулж буй аудиторын тайланг танилцуулах нь бидний зорилго юм. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний баталгаажуулалт хэдий ч АОУС-ын дагуу гүйцэтгэсэн аудит нь бүхий л материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлнэ гэсэн баталгаа биш юм. Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдааны улмаас үүсч болох ба дангаараа эсвэл нийтдээ уг нэгтгэсэн санхүүгийн тайланд үндэслэн гаргах мэдээлэл хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөхөөр хүлээгдэж байвал материаллаг гэж үзнэ.

АОУС-ын дагуу аудит хийх үед мэргэжлийн үнэлэмж гаргах, мэргэжлийн ул итгэх үзлээр хандахыг аудитын ажлын явцад шаарддаг. Бид мөн:

- Нэгтгэсэн санхүүгийн тайланд залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирохуйц аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж, өөрсдийн дүгнэлтийн үндэслэл болохуйц хангалттай, зохистой аудитын нотолгоог олж авдаг. Залилан нь хуйвалдаан, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг орхигдуулах зэрэг явдлуудыг агуулсан байдаг тул залилангаас үүсэх материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдааны улмаас үүсэх буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэлээс харьцангуй их байдаг.

- Группийн дотоод хяналтын үр ашигтай байдалд дүгнэлт өгөх зорилгоор бус харин тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горимыг боловсруулахын тулд аудитын ажилтай холбоотой дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.

- Удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын зохистой байдал, нягтлан бодох бүртгэлийн тооцооллын үндэслэл болон холбогдох тодруулгуудыг үнэлдэг.

- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, мөн бид олж авсан нотолгоондоо тулгуурлан Группийн тасралтгүй үйл ажиллагаагаа эрхлэх чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал оршин байгаа эсэхийг тодорхойлдог. Материаллаг тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл бид аудиторын тайланд нэгтгэсэн санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарал хандуулах эсвэл энэхүү тодруулга нь хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Бид дүгнэлтээ аудиторын тайлан гаргах өдөр хүртэлх олж авсан аудитын нотолгоонд үндэслэн гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал, эсвэл нөхцөл байдал нь Группийг тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах боломжгүй болгоход хүргэж болно.

- Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц болон агуулгыг тодруулгуудын хамт үнэлж, нэгтгэсэн санхүүгийн тайлан нь холбогдох ажил гүйлгээнүүд болон үйл явдлуудыг үнэн зөв илэрхийлсэн эсэхийг үнэлдэг.

- Нэгтгэсэн санхүүгийн тайланд дүгнэлт өгөх зорилгоор Групп дэх компаниудын санхүүгийн мэдээлэл болон бизнесийн үйл ажиллагааны талаар аудитын хангалттай бөгөөд зохистой нотолгоог олж авдаг. Бид Группийн аудитыг гүйцэтгэх, хянах, удирдах үүрэгтэй. Бид зөвхөн өөрсдийн аудитын дүгнэлтэнд хариуцлага хүлээнэ.



KPMG

**Нэгтгэсэн Санхүүгийн Тайлангийн Аудитад Хүлээх Аудиторын Үүрэг Хариуцлага, Үргэлжлэл**

Бид бусад асуудлуудын дундаас аудитын ажлын төлөвлөсөн цар хүрээ, хугацаа болон аудитын явцад тодорхойлсон дотоод хяналтын аливаа мэдэгдэхүйц доголдлыг багтаагаад аудитын илэрсэн томоохон асуудлуудаар засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдтэй харилцдаг.

Мөн бид засаглах эрх бүхий этгээдүүдэд хараат бус байдлын талаарх холбогдох ёс зүйн шаардлагыг биелүүлсэн талаарх мэдэгдлийг хийдэг бөгөөд шаардлагатай үед бидний хараат бус байдалд нөлөөлж болохуйц бүхий л харилцаа болон бусад асуудлууд, хараат бус байдлын эрсдэлийг бууруулсан эсвэл түүний эсрэг авсан хамгаалалтын хариу үйлдлүүдийн талаарх мэдэгдлийг хийдэг.

Засаглах эрх бүхий этгээдүүдтэй харилцсан асуудлуудаас бид тайлант жилийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн өндөр ач холбогдолтой гэж үзсэн зүйлсийг аудитын гол онцлох зүйлс хэмээн тодотгосон болно. Бид аудитын гол онцлох зүйлсийг хууль тогтоомжоор нийтэд ил болгохыг хориглоогүй үед эсвэл маш ховор тохиолдолд тайланд тодруулахгүй байх нь тодруулснаас илүүтэйгээр олон нийтийн эрх ашигт нийцнэ гэж үзсэнээс уг онцлох зүйлсийг тайланд оруулахгүй хэмээн шийдвэр гаргаснаас бусад тохиолдолд эдгээр зүйлсийг тайландаа оруулдаг.

Энэхүү хараат бус аудиторын тайлангийн аудитын гэрээт ажлын партнер нь Гун Пён Шиг, аудитын компанийн Ерөнхий Захирал нь Г. Соёлмаа нар болно.

КЭЙ ПИ ЭМ ЖИ АУДИТ ХХК
KPMG AUDIT LLC

Кэй Пи Эм Жи Аудит ХХК

Кэй Пи Эм Жи Аудит ХХК
Монгол Улс, Улаанбаатар хот
2025 оны 3 дугаар сарын 21-ний өдөр

| Баталгаажуулсан: | Баталсан: |
| --- | --- |
| Г. Соёлмаа | Гун Пён Шиг |
| *Ерөнхий Захирал* | *Партнер* |

> Энэхүү тайлан нь аудитын тайлангийн өдөр буюу 2025 оны 3 дугаар сарын 21-ний өдрөөр хүчин төгөлдөр үйлчилнэ. Аудитын тайлангийн өдөр болон энэхүү тайланг хэрэглэх хугацааны хооронд тохиолдож болох аливаа тайлагналын үеийн дараах үйл явдал, нөхцөл байдал нь уг нэгтгэсэн санхүүгийн тайлан болон тодруулгад материаллаг нөлөө үзүүлж болох юм. Тиймээс аудитын тайланг хэрэглэгчид нь уг тайлагналын үеийн дараах үйл явдал, нөхцөл байдлын нөлөөллийг дээрх аудитын тайланд тусгаагүйг анхаарна уу. Энэхүү тайлан нь зөвхөн Группийн хувьцаа эзэмшигчдэд зориулагдсан болно. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө үүрэг, хариуцлага хүлээхгүй болно.

**ГОВЬ ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД**
**2024 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨРХ**
**НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**
**(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

| | Тодруулга | 2024.12.31 | 2023.12.31 (Дахин тайлагнасан*) | 2023.01.01 (Дахин тайлагнасан*) |
|---|---|---|---|---|
| **Хөрөнгө** | | | | |
| *Эргэлтийн хөрөнгө* | | | | |
| Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө | 5 | 4,326,046 | 9,491,111 | 9,034,919 |
| Урьдчилгаа төлбөр | 7 | 3,512,304 | 3,173,680 | 2,318,495 |
| Дансны болон бусад авлага | 6 | 9,404,878 | 8,030,908 | 3,318,986 |
| Бараа материал | 8 | 122,708,175 | 142,521,277 | 128,791,463 |
| Буцаах эрхтэй бараагаарх хөрөнгө | | - | - | 17,227 |
| | | **139,951,403** | **163,216,976** | **143,481,090** |
| *Эргэлтийн бус хөрөнгө* | | | | |
| Үндсэн хөрөнгө | 9 | 146,412,229 | 111,731,120 | 119,914,402 |
| Ашиглах эрхтэй түрээсийн хөрөнгө | 10 | 2,780,438 | 2,109,746 | 731,724 |
| Хойшлогдсон татварын хөрөнгө | 23.3 | 5,661,214 | 9,276,559 | 14,879,483 |
| Бусад эргэлтийн бус хөрөнгүүд | 12 | 11,472,217 | 7,930,958 | 1,587,295 |
| | | **166,326,098** | **131,048,383** | **137,112,904** |
| **Нийт хөрөнгө** | | **306,277,501** | **294,265,359** | **280,593,994** |
| **Өр төлбөр ба эзэмшигчдийн өмч** | | | | |
| *Богино хугацаат өр төлбөр* | | | | |
| Дансны болон бусад өглөг | 13 | 37,867,812 | 38,880,126 | 20,969,192 |
| Гэрээний өр төлбөр | 13.1 | 2,129,778 | 1,672,424 | 1,983,898 |
| Буцаах эрхтэй барааны өр төлбөр | | - | - | 26,503 |
| Богино хугацаат түрээсийн өглөг | 14 | 1,103,295 | 964,376 | 777,988 |
| Орлогын албан татварын өглөг | 23.2 | 381,026 | 1,801,506 | 3,683,126 |
| Богино хугацаат зээл | 15 | 211,265,887 | 232,559,514 | 129,853,617 |
| | | **252,747,798** | **275,877,946** | **157,294,324** |
| *Урт хугацаат өр төлбөр* | | | | |
| Урт хугацаат түрээсийн өглөг | 14 | 1,922,734 | 1,321,948 | 112,069 |
| Урт хугацаат зээл | 15 | 36,210,000 | 9,830,059 | 95,686,234 |
| Бусад урт хугацаат өглөг | 16 | - | 17,036,260 | 30,984,941 |
| Хойшлогдсон татварын өглөг | 23.3 | 13,939,844 | 7,883,775 | 8,206,834 |
| | | **52,072,578** | **36,072,042** | **134,990,078** |
| **Нийт өр төлбөр** | | **304,820,376** | **311,949,988** | **292,284,402** |
| **Эздийн өмч** | | | | |
| Хувьцаат капитал | 17 | 780,113 | 780,113 | 780,113 |
| Дахин үнэлгээний нөөц | 20 | 43,777,386 | 20,514,269 | 21,507,631 |
| Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц | 22 | (12,119,789) | (10,662,273) | (11,436,010) |
| Хуримтлагдсан алдагдал | | (30,980,585) | (28,316,738) | (22,542,142) |
| **Нийт эздийн өмч** | | **1,457,125** | **(17,684,629)** | **(11,690,408)** |
| **Нийт өр төлбөр ба эздийн өмч** | | **306,277,501** | **294,265,359** | **280,593,994** |

**Тодруулга 2.2.2 болон Тодруулга 21-г харна уу.*

*Хавсаргасан тодруулгууд нь энэхүү нэгтгэсэн санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.*



**ГОВЬ ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД**
**2024 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН**
**НЭГТГЭСЭН АШИГ, АЛДАГДАЛ БОЛОН БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН**
**(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

| | Тодруулга | 2024 | 2023 |
|---|---|---|---|
| Борлуулалтын орлого | 24.1 | 247,026,317 | 255,650,516 |
| Борлуулсан бүтээгдэхүүний өртөг | 24.2 | (138,552,341) | (131,011,345) |
| **Нийт ашиг** | | **108,473,976** | **124,639,171** |
| Бусад орлого | 26.1 | 3,649,691 | 6,525,518 |
| Борлуулалт ба түгээлтийн зардал | 24.4 | (53,217,129) | (73,593,361) |
| Ерөнхий ба удирдлагын зардал | 24.5 | (24,908,151) | (19,733,240) |
| Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын буцаалт | 30.1 | - | 9,266 |
| Бусад зардал | 26.2 | (6,919,419) | (6,980) |
| **Үйл ажиллагааны ашиг** | | **27,078,968** | **37,840,374** |
| Санхүүгийн орлого | 25 | 4,465,583 | 229,734 |
| Санхүүгийн зардал | 27 | (33,118,100) | (38,046,985) |
| **Татварын өмнөх ашиг (алдагдал)** | | **(1,573,549)** | **23,123** |
| Орлогын албан татварын зардал | 23 | (2,083,660) | (6,791,081) |
| **Тайлант жилийн цэвэр алдагдал** | | **(3,657,209)** | **(6,767,958)** |
| **Бусад дэлгэрэнгүй орлого:** | | | |
| **Ашиг, алдагдал руу дараа үед дахин ангилагдах боломжгүй бусад дэлгэрэнгүй орлого:** | | | |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нөлөө | 20 | 32,341,972 | - |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний татварын нөлөө | 20 | (8,085,493) | - |
| **Ашиг, алдагдал руу дараа үед дахин ангилагдах боломжтой бусад дэлгэрэнгүй орлого:** | | | |
| Гадаад дахь охин компаниудын цэвэр хөрөнгийн гадаад валютын ханшийн хөрвүүлэлтийн зөрүү | 22 | (1,457,516) | 773,737 |
| **Тайлант жилийн бусад дэлгэрэнгүй орлого** | | **22,798,963** | **773,737** |
| **Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй орлого (алдагдал)** | | **19,141,754** | **(5,994,221)** |
| **Нэгж хувьцаанд ногдох алдагдал (төгрөгөөр)** | 19 | **(5)** | **(9)** |

*Хавсаргасан тодруулгууд нь энэхүү нэгтгэсэн санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.*

**ГОВЬ ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД**
**2024 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН**
**НЭГТГЭСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**
**(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

| | Тодруулга | Хувьцаат капитал | Дахин үнэлгээний нөөц | Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц | Хуримтлагдсан алдагдал | Нийт |
|---|---|---|---|---|---|---|
| **2023 оны 01 сарын 01-ний үлдэгдэл** | | **780,113** | **44,568,540** | **(11,436,010)** | **(28,084,878)** | **5,827,765** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө (Тодруулга 2.2.2 болон Тодруулга 21-г харна уу) | 21 | - | (23,060,909) | - | 5,542,736 | (17,518,173) |
| **2023 оны 01 сарын 01-ний дахин тайлагнасан үлдэгдэл** | | **780,113** | **21,507,631** | **(11,436,010)** | **(22,542,142)** | **(11,690,408)** |
| *Нийт дэлгэрэнгүй орлого:* | | | | | | |
| Тайлант жилийн цэвэр алдагдал | | - | - | - | (6,767,958) | (6,767,958) |
| Бусад дэлгэрэнгүй орлого | 22 | - | - | 773,737 | - | 773,737 |
| *Эздийн өмчтэй холбоотой өөрчлөлт:* | | | | | | |
| Хуримтлагдсан ашиг уруу шилжүүлсэн | 20 | - | (993,362) | - | 993,362 | - |
| **2023 оны 12 сарын 31-ний үлдэгдэл** | | **780,113** | **20,514,269** | **(10,662,273)** | **(28,316,738)** | **(17,684,629)** |
| **2024 оны 01 сарын 01-ний үлдэгдэл** | | **780,113** | **20,514,269** | **(10,662,273)** | **(28,316,738)** | **(17,684,629)** |
| *Нийт дэлгэрэнгүй орлого:* | | | | | | |
| Тайлант жилийн цэвэр алдагдал | | - | - | - | (3,657,209) | (3,657,209) |
| Бусад дэлгэрэнгүй орлого | 20, 22 | - | 24,256,479 | (1,457,516) | - | 22,798,963 |
| *Эздийн өмчтэй холбоотой өөрчлөлт:* | | | | | | |
| Хуримтлагдсан ашиг уруу шилжүүлсэн | 20 | - | (993,362) | - | 993,362 | - |
| **2024 оны 12 сарын 31-ний үлдэгдэл** | | **780,113** | **43,777,386** | **(12,119,789)** | **(30,980,585)** | **1,457,125** |

*Хавсаргасан тодруулгууд нь энэхүү нэгтгэсэн санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.*

3

**ГОВЬ ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД**
**2024 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН**
**НЭГТГЭСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**
**(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

| | Тодруулга | 2024 | 2023 |
|---|---|---|---|
| **Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | | |
| **Тайлант жилийн цэвэр алдагдал** | | (3,657,209) | (6,767,958) |
| Тохируулгууд: | | | |
| Эргэлтийн бус хөрөнгийн элэгдэл ба хорогдлын зардал | 24.3 | 14,554,268 | 12,643,029 |
| Орлогын албан татварын зардал | 23 | 2,083,660 | 6,791,081 |
| Хүүгийн зардал | 15.2 | 28,966,791 | 30,257,198 |
| Хүүгийн орлого | 25 | (21,032) | (229,734) |
| Хөнгөлөлттэй зээлийн дискаунтын нөлөө | 27 | 3,000,620 | 4,418,776 |
| Гадаад валютын ханшийн зөрүүний гарз | | 1,103,637 | 1,176,462 |
| Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын буцаалт | 30.1 | - | (9,266) |
| Бараа материалын хасагдуулгын зардал (буцаалт), цэвэр | 8 | 197,117 | (166,906) |
| Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз | 26.2 | 60,004 | 6,980 |
| | | **46,287,856** | **48,119,662** |
| Өөрчлөлт: | | | |
| Дансны болон бусад авлага | | (6,518,867) | (3,548,120) |
| Урьдчилгаа төлбөр | | 1,358,657 | (6,148,480) |
| Бараа материал | | 19,615,985 | (13,562,908) |
| Буцаах эрхтэй бараагаарх хөрөнгө | | - | 17,227 |
| Дансны ба бусад өглөг | | (5,048,402) | (11,962,418) |
| Буцаах эрхтэй барааны өр төлбөр | | - | (26,503) |
| Гэрээний өр төлбөр | | 457,354 | (311,474) |
| | | **56,152,583** | **12,576,986** |
| Төлсөн орлогын албан татвар | 23.2 | (1,918,219) | (3,392,836) |
| Төлсөн хүү | 15.2 | (24,506,337) | (27,329,645) |
| **Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ** | | **29,728,027** | **(18,145,495)** |
| **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | | |
| Хүлээн авсан хүү | 25 | 21,032 | 229,734 |
| Үндсэн хөрөнгө борлуулснаас орж ирсэн мөнгө | | 25,055 | 1,359,228 |
| Үндсэн хөрөнгийн худалдан авалт | 9 | (15,206,659) | (4,642,753) |
| Биет бус хөрөнгийн худалдан авалт | 12.1 | (5,889,178) | (1,249,934) |
| **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ** | | **(21,049,750)** | **(4,303,725)** |
| **Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | | |
| Авсан зээл (холбоотой талыг оролцуулаад) | 15.2 | 1,248,559,876 | 1,153,263,480 |
| Гаргасан бонд | 15.2 | 10,982,346 | - |
| Төлсөн зээл (холбоотой талын зээлийг оролцуулаад) | 15.2 | (1,270,804,301) | (1,130,151,838) |
| Холбогдох талуудад өгсөн урьдчилгаа | 28.3 | - | (18,950,000) |
| Холбоотой этгээдэд олгосон урьдчилгаа төлбөр | 28.3 | - | 18,950,000 |
| Төлсөн түрээсийн төлбөр | 15.2 | (1,098,962) | (965,391) |
| Төлсөн ногдол ашиг | 18 | (355) | (280) |
| **Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ** | | **(12,361,396)** | **22,145,971** |
| **Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр бууралт** | | **(3,683,119)** | **(303,249)** |
| Гадаад дахь охин компанийн гадаад валютын ханшийн хөрвүүлэлтийн зөрүү | | (1,457,516) | 773,737 |
| Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн үлдэгдэл дэх ханшийн зөрүүний нөлөөлөл | | (24,430) | (14,296) |
| **Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 5 | **9,491,111** | **9,034,919** |
| **Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 5 | **4,326,046** | **9,491,111** |

*Хавсаргасан тодруулгууд нь энэхүү нэгтгэсэн санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.*

4

**ГОВЬ ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД**
**2024 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД**
**(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

## 1. Үндсэн үйл ажиллагаа ба зохион байгуулалт

Говь ХК (цаашид “Компани” гэх) нь 1981 онд Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан. Компанийн 87.33%-ийг Монгол Улсад бүртгэлтэй Таван Богд Холдингс ХХК эзэмшдэг бөгөөд үлдсэн 12.67%-ийг бусад жижиг хувьцаа эзэмшигчид эзэмшдэг. 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Говь ХК нь нийт 25,151 хувьцаа эзэмшигчтэй байсан.

Компани нь Монгол улс, Улаанбаатар хот-17062, Хан-Уул дүүрэг, 3 дугаар хороо, Говь Хувьцаат Компанийн байранд байрлах бөгөөд Компани болон охин компаниуд (цаашид “Групп” гэж нэрлэх) нь үндсэн үйл ажиллагаагаа Монгол, БНХАУ, АНУ, Герман, Их Британи зэрэг улсад эрхлэн явуулдаг.

Компани нь Улсын Бүртгэлийн Ерөнхий Газарт бүртгүүлж, улсын бүртгэлийн 2076357 тоот регистрийн дугаартай гэрчилгээ авсан болно.

Групп нь сүлжмэл, оёмол, нэхмэл бүтээгдэхүүн зэрэг бэлэн болон хагас боловсруулсан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалт, хуурай хими цэвэрлэгээний үйлчилгээ зэрэг үндсэн үйл ажиллагааг эрхэлдэг. Группийн үйл ажиллагааны орлогын талаар тодруулга 24.1-д тодруулсан болно. Группийн охин компаниудын үйл ажиллагааны талаарх мэдээллийг тодруулга 11-т тодруулсан.

Нэгтгэсэн санхүүгийн тайланг 2025 оны 3 дугаар сарын 21-ний өдрөөр Группийн удирдлага батлан гаргасан.

## 2. Нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогын хураангуй

### 2.1 Тайлагналын нийцэл

Нэгтгэсэн санхүүгийн тайланг Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөлөөс (НББОУСЗ) гаргасан СТОУС Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартуудын дагуу бэлтгэж, толилуулсан.

### 2.2 Нэгтгэсэн санхүүгийн тайлан бэлтгэсэн суурь

Нэгтгэсэн санхүүгийн тайланг зарим үндсэн хөрөнгөөс бусад зүйлсийн хувьд түүхэн өртөгт үндэслэн бэлтгэсэн. Нягтлан бодох бүртгэлийн бодлогод тусгаснаар зарим үндсэн хөрөнгийг дахин үнэлсэн үнэ буюу бодит үнэ цэнээр бүртгэсэн. Түүхэн өртөг нь хөрөнгийг худалдан авах үед төлсөн эсвэл солилцсон зүйлийн бодит үнэ цэнэ байдаг.

Нэгтгэсэн санхүүгийн тайлан дахь дүнгүүдийг тодруулгад өөрөөр заасноос бусад тохиолдолд мянгачилан, Группийн бүртгэлийн валют болох Монгол Улсын мөнгөн тэмдэгт болох төгрөгөөр толилуулсан.

#### 2.2.1 Тасралтгүй байх зарчим

Группийн 2024 оны нийт борлуулалтын орлого 247 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 3%-аар буурсан. Аялал жуулчлал сэргэсэнтэй холбоотойгоор дотоодын зах зээлийн борлуулалт 16.4 тэрбум (11%) төгрөгөөр өсч 163.4 тэрбум төгрөг болсон. Группийн нийт цэвэр борлуулалт 2023 онтой харьцуулахад буурсан ч, цэвэр алдагдал 46%-аар буурсан үзүүлэлттэй байна. 2025 онд дотоодын болон глобал зах зээлийн борлуулалт нэмэгдэж, цэвэр алдагдал 2024 оныхоос буурах төлөвтэй байна. 2024 онд Монгол Улс нийт 809 мянган жуулчин хүлээн авсан ба үүнээс 120 мянган жуулчин нь Группийн Улаанбаатар хот дах дэлгүүрүүдээс худалдан авалт хийсэн нь дотоодын зах зээл өндөр гүйцэтгэлтэй гарахад нөлөөлсөн. 2025 оны 1 дүгээр сарын байдлаар Монгол Улсад зорчих жуулчдын тоо өмнөх 2024 оны мөн үетэй харьцуулахад 19%-аар өссөн, цаашид энэ өсөлт хадгалагдах хандлагатай байгаа тул Дотоодын зах зээлийн жуулчдын борлуулалт өснө гэж төсөөлж байна.

2030 он гэхэд Монгол Улс нь 2 сая жуулчин хүлээн авахаар зорьж байгаа тул үүнийг даган Дотоодын борлуулалт тасралтгүй өснө гэсэн хүлээлттэй байна. Глобал зах зээлийн хувьд сүүлийн жилүүдэд гадаад зах зээлүүдэд брендээ таниулах ажлуудыг идэвхтэй хийсэн ба Macy's, Nordstrom, Otto зэрэг дижитал борлуулалтын сувгуудыг нэмж, нэмэлтээр олон улсын нэр хүндтэй маркетингийн компанитай хамтарч ажиллаж буйтай холбоотойгоор борлуулалт 2025 онд нэмэгдэнэ гэсэн хүлээлттэй байна.



**ГОВЬ ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД**
**2024 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД**
**(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

## 2. Нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогын хураангуй (үргэлжлэл)

### 2.2 Нэгтгэсэн санхүүгийн тайлан бэлтгэсэн суурь (үргэлжлэл)

#### 2.2.1 Тасралтгүй байх зарчим (үргэлжлэл)

Мөн 2024 онд үйлдвэрлэлийн бүтээмжийг сайжруулах хүрээнд хөрөнгө оруулалт хийсэн нь үйлдвэрлэлийн зардлыг хэмнэж, бүтээгдэхүүний өртгийг бууруулснаар нийт ашгийн түвшин нэмэгдэнэ. Мөн нийт ашгийн түвшин багатай гадаад бөөний борлуулалтын нийт борлуулалтанд эзлэх хувийг бууруулснаар ашигт ажиллагаа сайжирна гэсэн хүлээлттэй байна.

Үйл ажиллагааны зардлын хувьд Групп бараа материалын менежментэд түлхүү анхаарч оновчтой төлөвлөлтийг хийснээр үйлдвэрлэлийн нэмэгдэл зардал болон санхүүжилтийн зардлыг бууруулах нөхцөл бүрдэнэ. Групп компанийн энэхүү стратеги нь урт хугацааны тогтвортой өсөлтийг хангах зөв стратеги гэж үзэж байна.

2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр Говь ХК нь дээд шатны хянагч этгээд болох Таван Богд Холдингс ХХК-аас Говь ХК-ийг тасралтгүй үйл ажиллагаа явуулах боломжийг бүрдүүлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлсээр байх болно гэсэн албан бичгийг хүлээн авсан. Тус албан бичигт Говь ХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн тайлан тайлагнасан өдрөөс хойш 12-оос доошгүй сарын хугацаанд хүлээсэн үүргээ биелүүлж санхүүгийн дэмжлэг үзүүлнэ хэмээн тусгагдсан. Мөн Таван Богд Холдингс ХХК өөрийн харьяа аж ахуй нэгжүүд нь Говь ХК-аас төлөх төлбөрийг нэхэмжлэхгүй, эргүүлэн татахгүй, буцаан төлөхийг шаардахгүй гэдгийг баталж, Говь ХК-д бий болж болзошгүй бэлэн мөнгөний дутагдлыг нөхөхөд тусалж цаашид санхүүжилт олгох болно гэдгээ мэдэгдсэн.

Групп нь тасралтгүй байдлын зарчимд үндэслэн нэгтгэсэн санхүүгийн тайлангуудыг бэлтгэсэн бөгөөд удирдлагын зүгээс үүнийг зохистой гэж үзсэн.

#### 2.2.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт

Өмнө нь газрыг нь дахин үнэлгээний өдрөөрх бодит үнэ цэнээс дараа үеийн хуримтлагдсан үнэ цэнийн бууралтыг хассан дахин үнэлсэн дүнгээр толилуулж байсан. Группийн удирдлага энэ ангиллын үндсэн хөрөнгө дээр өртгийн загвар ашиглан санхүүгийн тайлан бэлтгэх нь Таван Богд Холдингс Группийн түвшинд нэг ижил нягтлан бодох бүртгэлийн бодлого ашиглах ба үүгээр Группийн санхүүгийн байдал болон санхүүгийн гүйцэтгэлийг илүү найдвартай болон хамааралтай мэдээллээр хангана гэж үзэж байна. Үүний дагуу Групп 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн энэ ангиллын үндсэн хөрөнгийн нягтлан бодох бүртгэлийн бодлогоо өөрчилж эдгээр хөрөнгүүдийг өртгөөр нь хэмжиж бүртгэсэн ба энэ нь өртгөөс хуримтлагдсан үнэ цэнийн бууралтыг хассан дүн байна (Тодруулга 2.6-г харна уу).

Түүнчлэн Групп нь дахин үнэлэгдсэн үндсэн хөрөнгийн дахин үнэлгээнд хамаарах элэгдлээр хэрэгжсэн хэсгийг дахин үнэлгээний нөөцөөс хуримтлагдсан ашиг уруу тусгах нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийг хийсэн. Дахин үнэлэгдсэн хөрөнгийг худалдах эсвэл ашиглалтаас хасах үед дахин үнэлгээний нөөцөд үлдсэн нэмэгдлийг хуримтлагдсан ашиг руу шууд шилжүүлнэ. Группийн удирдлага энэ бодлогын өөрчлөлтийг ашиглан санхүүгийн тайлан бэлтгэх нь Таван Богд Холдингс Группийн түвшинд нэг ижил нягтлан бодох бүртгэлийн бодлого ашиглах ба үүгээр Группийн санхүүгийн байдал болон санхүүгийн гүйцэтгэлийг илүү найдвартай болон хамааралтай мэдээллээр хангана гэж үзэж байна. Үүний дагуу Групп 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогодоо өөрчлөлт оруулсан. (Тодруулга 2.6-г харна уу).

Дээрх нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийг буцаан мөрдөх явцад харьцуулсан мэдээллийг дахин тайлагнасан. 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөрх байдлаарх мэдээллийг багтаасан гурван үеийн санхүүгийн байдлын тайланг агуулсан дээрх дахин тайлагналын тоон нөлөөллийн хураангуйг Тодруулга 21-с харна уу.

### 2.3 Нэгтгэлийн суурь

Нэгтгэсэн санхүүгийн тайлан нь Компанийн болон түүний хяналтад байдаг охин компаниудын санхүүгийн тайлангаас бүрддэг. Компани дараах тохиолдолд хяналтыг бий болгодог:

**2. Нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогын хураангуй (үргэлжлэл)**

**2.3 Нэгтгэлийн суурь (үргэлжлэл)**

- Санхүүжигчийг удирдах чадвар;
- Санхүүжигчээс өөрийн оролцооны дагуу хувьсах өгөөж хүртэх эсвэл эрхээ шилжүүлэх; болон
- Санхүүжигчийн өгөөжид нөлөөлөх эрх мэдлийг ашиглах чадвар

Дээр дурдсан гурван шалгуурын аль нэгийг өөрчлөх нөхцөл болзол үүссэн тохиолдолд Групп нь санхүүжигчид тогтоосон хяналтаа алдсан эсэх талаар дахин үнэлнэ.

Санхүүжигчид нөлөө үзүүлэх саналын эрхийн олонхийг эзэмшдэггүй хэдий ч Компанийн эзэмшиж буй саналын эрх нь санхүүжигчийн холбогдох үйл ажиллагаанд нөлөө үзүүлэх бодит чадвартай байвал санхүүжигчид үзүүлэх нөлөө байна гэж үздэг.

Компанийн эзэмшиж буй саналын эрх нь санхүүжигчийн холбогдох үйл ажиллагаанд нөлөө үзүүлэх хүч байгаа эсэхийг дараах хүчин зүйлүүдээр үнэлдэг.

- Компанийн саналын эрхийн хэмжээ болон бусад хувьцаа эзэмшигчдийн саналын эрхийн тархалт болон сарнилт
- Компани болон бусад хувьцаа эзэмшигчдийн саналын эрхээ хэрэгжүүлэх чадвар
- Бусад гэрээгээр тохирсон саналын эрх
- Компанийн саналын эрх нь одоогийн холбогдох үйл ажиллагаанд нөлөөлж чадах бусад хүчин зүйлүүд

Компани охин компанийг хяналтдаа оруулсан өдрөөс эхлэн нэгтгэсэн санхүүгийн тайланд уг охин компанийг нэгтгэх ба охин компани дахь хяналтаа алдсан өдрөөс эхлэн нэгтгэхээ зогсоодог. Тусгайлан, охин компанийн тайлант жилийн орлого, зардлыг нэгтгэсэн санхүүгийн тайланд тусгахдаа тухайн охин компани дахь хяналтыг олж авсан өдрөөс тухайн охин компани дахь хяналтаа алдсан өдөр тасалбар болгон тайлант жилийн орлого, зардлыг ашиг алдагдал болон бусад нэгтгэсэн дэлгэрэнгүй орлогын тайланд нэгтгэдэг.

Охин компанийн ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогыг Группийн эзэд болон хяналтын эрхгүй хувь оролцоонд ногдох хэсэг гэж ангилан харуулдаг. Охин компанийн нийт дэлгэрэнгүй орлогыг Группийн эзэд болон хяналтын эрхгүй хувь оролцоонд хуваарилах бөгөөд үүнийг хяналтын эрхгүй хувь оролцоо хасах үлдэгдэлтэй болох байсан ч хэрэгжүүлнэ.  Хэрэв шаардлагатай бол, Группийн нягтлан бодох бүртгэлийн бодлоготой нийцүүлэхийн тулд охин компанийн санхүүгийн тайланд тохируулга хийдэг.

Толгой болон охин компаниудын хооронд гарсан орлого, зардал, мөнгөн гүйлгээ болон хөрөнгө, өр төлбөр, өмчийн дансдын үлдэгдлийг нэгтгэсэн санхүүгийн тайланд бүрэн устгадаг.

**2.3.1. Группийн охин компани дахь эзэмшлийн хувийн өөрчлөлт**

Охин компани дахь Группийн эзэмшлийн хувийн өөрчлөлтийг охин компани дахь хяналтын багцаа алдаагүй л бол эзэмшигчийн өмчийн ажил гүйлгээ байдлаар бүртгэнэ. Охин компани дахь Группийн хувь эзэмшил болон хяналтын эрхгүй хувь оролцооны дансны үнийг эзэмшлийн хувьд гарсан өөрчлөлтөөр залруулдаг. Хяналтын эрхгүй хувь оролцоон дахь өөрчлөлт ба төлсөн эсвэл хүлээн авсан зүйлийн бодит үнэ цэнийн хоорондох аливаа зөрүүг өмчид шууд хүлээн зөвшөөрч, Группийн эзэмшигчдэд хуваарилдаг.

Групп нь охин компани дахь хяналтын багцаа алдсан үед олз, гарзыг (i) хүлээн авсан зүйлсийн бодит үнэ цэнэ ба үлдсэн эзэмшлийн хувийн бодит үнэ цэнийн нийлбэр (ii) охин компанийн хөрөнгө (гүүдвиллийг оролцуулаад) ба өр төлбөрийн дансны үнэ ба хяналтын эрхгүй хувь оролцооны зөрүүгээр тодорхойлно.

Бусад дэлгэрэнгүй орлогын тайланд охин компанитай холбоотой бүртгэсэн өмнөх бүх дүнг тэдгээр хөрөнгийн данснаас хасалт байдлаар бүртгэнэ (холбогдох СТОУС-д заасны дагуу ашиг алдагдал руу ангилж тайлагнах эсвэл хуримтлагдсан ашиг руу шилжүүлнэ). Өмнөх охин компанид үлдсэн аливаа хөрөнгө оруулалтын хяналтаа алдсан өдрөөрх бодит үнэ цэнийг СТОУС 9 *Санхүүгийн хэрэглүүр: Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт*–ийн дагуу анхдагч хүлээн зөвшөөрөлтийн бодит үнэ цэнээр эсвэл хэрэв тохиромжтой бол хараат эсвэл хамтарсан хяналттай аж ахуйн нэгжид оруулсан хөрөнгө оруулалтын анхдагч хүлээн зөвшөөрөлтийн өртгөөр тооцно.



ГОВЬ ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
2024 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)

**2. Нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогын хураангуй (үргэлжлэл)**

**2.4 Бараа материал**

Бараа материалыг жигнэсэн дундаж өртгийн аргаар хэмжсэн худалдан авалт ба/эсвэл үйлдвэрлэлийн өртөг, цэвэр боломжит үнэ цэнийн аль багаар хэмжинэ. Худалдан авах зардал нь тайлант хугацаан дахь худалдан авалтын холбогдох нэмэлт зардлыг агуулдаг. Үйлдвэрлэлийн зардал нь шууд хамааралтай зардлууд ба бүтээгдэхүүнтэй холбоотойгоор гарсан шууд бус зардлын зарим хэсгийг багтаана.

Цэвэр боломжит үнэ цэнэ нь тооцоолсон борлуулахаар тооцсон үнээс түүнийг иж бүрдэл болгохоор тооцсон зардал ба борлуулахад шаардагдах тооцсон зардлыг хассан дүнг хэлнэ. Бараа материалын хүлээгдэж буй хэрэглээ болон цэвэр боломжит үнэ цэнийг харгалзан бараа материал, бүтээгдэхүүний хувьд хасагдуулга нөөцийг шаардлагатай үед тодорхойлно.

**2.5 Урьдчилгаа төлбөр**

Урьдчилгаа төлбөр нь мөнгөн хэлбэрээр төлөгдсөн боловч зардал нь хараахан гараагүй төлбөр эсвэл хүлээн аваагүй бараа материалын төлбөрөөс бүрдэнэ. Урьдчилгаа төлбөрийг анх хөрөнгөөр бүртгэх ба төлөгдсөн мөнгөн дүнгээр нь хэмжинэ. Уг төлбөрийг тухайн зардал нь гарсан тохиолдолд эсвэл хугацаа дуусах үед ашиг, алдагдал руу болон бараа материалыг хүлээн авсан тохиолдолд холбогдох хөрөнгөнд ангилдаг.

Урьдчилгаа төлбөртэй холбоотой бүтээгдэхүүний өртөг эсвэл үйлчилгээ нь нэг жилийн дотор зарлагадах бол урьдчилгаа төлбөрийг нэгтгэсэн санхүүгийн байдлын тайланд эргэлтийн хөрөнгөөр ангилна. Бусад тохиолдолд эргэлтийн бус хөрөнгөөр ангилна. Тайлант жилийн эцэст Групп урьдчилгаа төлбөрийн дансны үнэд хяналт тавьж, үнэ цэнийн бууралт гарсан эсэхийг тодорхойлдог.

**2.6 Үндсэн хөрөнгө**

Группийн эзэмшиж буй газрын эрхийг анх өртгөөр нь Группийн үндсэн хөрөнгө гэж хүлээн зөвшөөрнө. Групп нь газар эзэмших эрхийг олж эзэмшсэн өдрөөс эхлэн холбогдох газрын төлбөрийг улсад тушаадаг бөгөөд энэхүү төлбөрийн хэмжээ харьцангуй бага хэмжээтэй юм. Газрын эрхийг элэгдүүлдэггүй бөгөөд өртгөөр хэмжинэ. Дуусаагүй барилгыг нэгтгэсэн санхүүгийн байдлын тайланл хөрөнгийн өртгөөс хуримтлагдсан элэгдэл болон хуримтлагдсан үнэ цэнийн бууралтыг хассан дүнгээр тайлагнана.

Үндсэн хөрөнгийг анх өртгөөр нь бүртгэнэ. Үндсэн хөрөнгийн өртөг дараах зардлуудаас бүрдэнэ. Үүнд:

- Хөнгөлөлт урамшууллын дараах худалдан авсан үнэ, гаалийн татвар болон худалдан авалттай холбоотой буцаан олгогдохгүй татвар;
- Удирдлагын зорилгоор үйл ажиллагаа явуулахад бэлэн болгож түүнийг байршуулах болон шаардлагатай нөхцөлийг хангахтай холбоотой гарсан аливаа шууд зардлууд.

Худалдаж авсан программ хангамж нь холбогдох тоног төхөөрөмжийн үйл ажиллагаатай салшгүй холбоотой бол тухайн тоног төхөөрөмжийн нэг хэсэг байдлаар капиталжуулна.

Үндсэн хөрөнгийн өртөгт мэргэжлийн үйлчилгээний төлбөр, бэлтгэл шаардагдах хөрөнгийн хувьд тодруулга  2.16-д тусгасан бодлогын дагуу капиталжуулсан зээлийн хүүгийн зардлыг багтаадаг. Үндсэн хөрөнгийг ашиглахад бэлэн болгож суурилуулах үед тохирох үндсэн хөрөнгийн төрөлд нь ангилан бүртгэнэ.

Тайлант үеийн эцэст барилгаас бусад үндсэн хөрөнгийг өртгөөс нь хуримтлагдсан элэгдэл болон хуримтлагдсан үнэ цэнэ бууралтыг хассан дүнгээр хэмжсэн.

**2. Нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогын хураангуй (үргэлжлэл)**

**2.6 Үндсэн хөрөнгө (үргэлжлэл)**

Дахин үнэлсэн дүнгээр илэрхийлэгдсэн барилгыг нэгтгэсэн санхүүгийн байдлын тайланд тэдгээрийн дахин үнэлсэн дүнгээр тайлагнах ба мэргэжлийн хүлээн зөвшөөрөгдсөн үнэлгээчний зах зээлийн бодит нотолгоонд үндэслэн дахин үнэлсэн өдрийн үндсэн хөрөнгийн бодит үнэ цэнээс хуримтлагдсан элэгдэл болон хуримтлагдсан үнэ цэнэ бууралтыг хассан дүнгээр тайлагнадаг. Дансны үнэ ба бодит үнэ цэнийн хооронд материаллаг зөрүү гаргахгүй байх үүднээс тайлагналын үеийн эцэс бүрт хөрөнгийн бодит үнэ цэнийг тодорхойлдог.

Хэрэв дахин үнэлгээний үр дүнд хөрөнгийн дансны үнэ өссөн байвал энэ өсөлтийг тухайн хөрөнгийн дахин үнэлгээний бууралтыг буцааж өмнөх ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрсөн хэмжээгээр ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө. Бусад бүх тохиолдолд үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлтийг бусад дэлгэрэнгүй орлогын тайланд тусгаж, өмчийн хэсэгт хуримтлуулан бүртгэнэ.

Дахин үнэлгээний үр дүнд хөрөнгийн дансны үнэ буурсан байвал тухайн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлээс давсан бууралтыг зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэнэ.

Дахин үнэлгээ хийсэн өдрөөрх хуримтлагдсан элэгдлийг тухайн хөрөнгийн нийт дансны үнэтэй цэвэрлэдэг бөгөөд дансны цэвэр дүн нь хөрөнгийн дахин үнэлэгдсэн дүнгээр дахин илэрхийлэгддэг.

Групп нь дахин үнэлэгдсэн үндсэн хөрөнгийн дахин үнэлгээнд хамаарах элэгдлээр хэрэгжсэн хэсгийг дахин үнэлгээний нөөцөөс хуримтлагдсан ашиг уруу тусгадаг. Дахин үнэлсэн хөрөнгийг худалдах эсвэл ашиглалтаас хасах үед дахин үнэлгээний санд үлдсэн нэмэгдлийг хуримтлагдсан ашиг руу шууд шилжүүлнэ. Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлээс хуримтлагдсан ашиг руу шилжүүлсэн дүн нь хөрөнгийг дахин үнэлсэн дансны үнээс тооцоолсон элэгдэл болон хөрөнгийн анхны өртгөөс тооцоолсон элэгдлийн зөрүүгээр тооцоологдоно.

Үндсэн хөрөнгөтэй холбоотой гарсан дараа үеийн зардал нь тухайн хөрөнгийн анх тооцсон бүтээмжийн түвшинг нэмэгдүүлэх замаар Группд эдийн засгийн ирээдүйн өгөөжийг авчрах магадлалтай үед өртгөөр үндсэн хөрөнгийн дансны үнийг нэмэгдүүлдэг.

Бусад бүх худалдан авалтын дараа гарсан зардлуудыг гарсан тайлант үед нь зардлаар бүртгэнэ. Газар болон дуусаагүй барилгаас бусад үндсэн хөрөнгийн өртөг эсвэл дахин үнэлсэн дүнгээс тэдгээрийн үлдэгдэл өртгийг хассан дүнг шулуун шугамын аргаар, ашиглалтын жилд нь элэгдүүлдэг.

Үндсэн хөрөнгийн ашиглалтын жил:

| | |
|---|---|
| Барилга байгууламж | 10 – 40 жил |
| Тоног төхөөрөмж | 10 жил |
| Тавилга, эд хогшил | 2 - 10 жил |
| Тээрийн хэрэгсэл | 10 жил |
| Түрээсийн сайжруулалт | 2 - 5 жил |

Тооцоолсон ашиглалтын жил, үлдэх өртөг болон элэгдлийг тооцох аргыг тайлан гаргах өдрөөр хянаж үздэг ба тооцооллыг өөрчлөх шаардлагатай байвал нөлөөллийг нь ирэх жилүүдэд залруулдаг.

Үндсэн хөрөнгийг ашиглалтаас хасах үед болон тухайн хөрөнгийг үргэлжлүүлэн ашигласнаар ямар нэгэн эдийн засгийн үр өгөөж олохгүй гэж үзвэл бүртгэлээс хасдаг. Үндсэн хөрөнгийн зүйлийг ашиглалтаас хассан, зарж борлуулснаас үүсэх ашиг алдагдлыг худалдан борлуулсан үнэ ба хөрөнгийн дансны үнэ хоёрын зөрүүгээр тодорхойлох ба тухайн жилийн ашиг, алдагдалд тусгана.

**2.7 Биет бус хөрөнгө**

Ашиглагдах жил нь тодорхой, тусад нь худалдан авсан биет бус хөрөнгийг өртгөөс нь хуримтлагдсан элэгдэл ба үнэ цэнийн бууралтын алдагдлыг хассан дүнгээр хэмжинэ.





ГОВЬ ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
2024 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)

**2. Нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогын хураангуй (үргэлжлэл)**

**2.7 Биет бус хөрөнгө (үргэлжлэл)**

Биет бус хөрөнгийн хорогдлыг шулуун шугамын аргаар, биет бус хөрөнгийн ашиглалтын жилээр тооцоолон хүлээн зөвшөөрдөг. Тооцоолсон ашиглалтын жил болон хорогдол бодох аргыг тайлан гаргах өдрөөр хянаж үздэг ба тооцооллыг өөрчлөх шаардлагатай байвал нөлөөллийг нь ирэх жилүүдэд залруулдаг.

Ашиглагдах жил нь тодорхойгүй, тусад нь худалдан авсан биет бус хөрөнгийг өртгөөс нь үнэ цэнийн бууралтын алдагдлыг хассан дүнгээр хэмжсэн.

Биет бус хөрөнгийн ашиглалтын жил нь 2-оос 10 жил.

Биет бус хөрөнгийг ашиглалтаас хасах үед болон тухайн хөрөнгийг үргэлжлүүлэн ашигласнаар ямар нэгэн эдийн засгийн үр өгөөж олохгүй гэж үзвэл бүртгэлээс хасдаг. Биет бус хөрөнгийн зүйлийг ашиглалтаас хассан, зарж борлуулснаас үүсэх ашиг, алдагдлыг худалдан борлуулсан үнэ ба хөрөнгийн дансны үнэ хоёрын зөрүүгээр тодорхойлох ба тухайн жилийн ашиг, алдагдалд тусгана.

**2.8 Үндсэн хөрөнгө, ашиглах эрхтэй хөрөнгө болон биет бус хөрөнгийн үнэ цэнийн бууралт**

Тайлант үеийн эцэст бүрд Групп нь үндсэн хөрөнгө, ашиглах эрхтэй хөрөнгө ба биет бус хөрөнгийн дансны үнэд үнэ цэнэ бууралтын шинж тэмдэг илэрсэн эсэхийг тодорхойлох шалгуур хийдэг. Хэрэв ийм шинж тэмдэг илэрсэн бол үнэ цэнэ бууралтын гарз (ийм гарз гарсан бол)-ыг тогтоохын тулд тухайн хөрөнгийн нөхөгдөх боломжтой үнийг тодорхойлно.

Хөрөнгийн нөхөгдөх боломжтой үнийг тухайн хөрөнгийн хувьд тооцоолох боломжгүй бол Групп нь уг хөрөнгийн харьяалагдах "мөнгөн орлого үүсгэгч нэгж"-ийн нөхөгдөх боломжтой үнийг тооцоолно. "Мөнгөн орлого үүсгэгч нэгж"-д хуваарилах боломжийн бөгөөд тууштай суурь үзүүлэлтийг тодорхойлж чадвал аж ахуйн зориулалттай хөрөнгийг тодорхой "мөнгөн орлого үүсгэгч нэгж"-д хуваарилах ба ийм боломжгүй бол хамгийн боломжийн бөгөөд тууштай ашиглах боломжтой суурь үзүүлэлтийг ашиглан хамгийн жижиг "мөнгөн орлого үүсгэгч нэгж"-д хамааруулан шалгадаг.

Хөрөнгийн эсвэл "мөнгөн орлого үүсгэгч нэгж"-ийн нөхөгдөх боломжтой үнэ гэдэг нь хөрөнгийг ашигласнаар олж болох өгөөж ба хөрөнгийн бодит үнэ цэнээс борлуулах өртөг зардлыг хассан цэвэр дүн хоёрын аль ихээр нь тогтоогдоно. Ашигласнаар олж болох өгөөжийг үнэлэхдээ одоогийн мөнгөний үнэ цэнийн зах зээлийн үнэлэмж болон хөрөнгийн тусгайлсан эрсдэлийг тусгасан татварын өмнөх дискаунтын хувиар дискаунтлан тооцсон ирээдүйн мөнгөн гүйлгээний өнөөгийн үнэ цэнийг ашигладаг. Үнэ цэнэ бууралтын шалгуурын зорилгоор дангаар нь шалгах боломжгүй хөрөнгийг бусад хөрөнгө эсвэл бүлэг хөрөнгөөс ("мөнгөн орлого үүсгэгч нэгж") хамааралгүйгээр дангаараа мөнгөн орлого бий болгох чадвартай хамгийн жижиг хөрөнгийн бүлэгт хамааруулан шалгадаг.

Нэгж хөрөнгө эсвэл түүний харьяалагдах "мөнгөн орлого үүсгэгч нэгж"-ийн дансны үнэ нь нөхөгдөх боломжтой тооцоолсон үнээс их байвал үнэ цэнэ бууралтын гарзыг бүртгэж, ашиг, алдагдалаар тусгана. "Мөнгөн орлого үүсгэгч нэгж"-ийн хувьд тодорхойлсон үнэ цэнэ бууралтын гарзыг бүртгэхдээ эхлээд тухайн нэгжид хуваарилагдсан гүүдвилийн дансны үнийг бууруулах ба үлдсэн алдагдлын дүнгээр тухайн нэгж (бүлэг нэгж)-д багтсан бусад хөрөнгийн дансны үнийг хувь тэнцүүлэн бууруулна.

Өмнөх жилүүдэд бүртгэсэн үнэ цэнэ бууралтын алдагдал буурсан эсвэл алдагдал үгүй болсон эсэхийг илрүүлэхийн тулд үнэ цэнэ бууралтын алдагдлыг тайлангийн өдрөөр дахин хянана. Нөхөгдөх боломжтой дүнг тодорхойлоход ашигласан тооцоолол өөрчлөгдсөн бол үнэ цэнийн бууралтын алдагдлыг буцаана, үүнд гүүдвиллийн үнэ цэнийн бууралтын алдагдал хамаарахгүй. Үнэ цэнийн бууралт бүртгээгүй байсан бол байх байсан элэгдэл, хорогдлыг хассан хөрөнгийн дансны үнийг бууруулахгүй байхаар бодож үнэ цэнийн бууралтын алдагдлыг буцаана.

## 2. Нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогын хураангуй (үргэлжлэл)

### 2.9 Санхүүгийн хэрэгслүүд

Санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөрүүдийг Групп тухайн хэрэглүүртэй холбоотой гэрээт тал болох үед нь хүлээн зөвшөөрдөг.

Санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрийг анх бодит үнэ цэнээр нь бүртгэх ба үүнд гэрээт харилцагчидаас үүссэн дансны авлагыг СТОУС 15-ын дагуу анх бүртгэнэ. Санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөр (ашиг, алдагдалаарх бодит үнэ цэнээр бүртгэдэг санхүүгийн хөрөнгө ба өрийн хэрэгсэлээс бусад)-ийг гаргах эсвэл худалдан авахтай шууд холбоотой гарсан зардалыг анх бүртгэлд тусгахдаа санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнэ дээр нэмж эсвэл өр төлбөрийн бодит үнэ цэнээс хасч бүртгэнэ.

Ашиг, алдагдалаарх бодит үнэ цэнээр бүртгэдэг санхүүгийн хөрөнгө ба өрийн хэрэгслийг гаргах эсвэл худалдан авахтай шууд холбоотой гарсан зардлыг тухайн жилийн ашиг, алдагдлаар бүртгэнэ.

### 2.10 Санхүүгийн хөрөнгө

Ердийн журмаар худалдах, худалдан авах санхүүгийн хөрөнгийг бодит гүйлгээ гарсан өдрөөр нягтлан бодох бүртгэлд тусгах эсвэл бүртгэлээс хасдаг.

Ердийн журмаар худалдах, худалдан авах гэдэг нь тогтоосон хугацааны дотор эсвэл тухайн зах зээл дээр тогтсон дүрэм журмаар хөрөнгийг шилжүүлэх нөхцөлөөр санхүүгийн хөрөнгийг худалдах, худалдан авахыг хэлнэ.

Санхүүгийн хөрөнгийг ангиллаас нь хамааран анх бүртгэсний дараа хорогдуулсан өртгөөр эсвэл бодит үнэ цэнээр нь хэмждэг.

#### 2.10.1 Санхүүгийн хөрөнгийн ангилал

Дараах нөхцөлүүдийг хангасан өрийн хэрэгслүүд нь дараа үеүдэд хорогдуулсан өртгөөр хэмжигдэнэ:

- Мөнгөн урсгалыг цуглуулахын тулд санхүүгийн хөрөнгийг эзэмших зорилготой бизнесийн загвараар эзэмшдэг; болон
- Зөвхөн үндсэн төлбөрийн төлөлт ба гэрээний нөхцөлөөр тодорхой заасан өдрөөрх төлөгдөөгүй үндсэн төлбөрийг үлдэгдэлд тооцсон хүүгийн төлбөрөөс бүрдэх төлбөрүүдийн мөнгөн урсгалыг тогтоосон хугацаанд хуваарийн дагуу хүлээн авах нөхцөлтэй байх.

Дараах нөхцөлүүдийг хангасан өрийн хэрэгслүүдийг бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр хэмжинэ (БДОБҮЦ):

- Мөнгөн урсгалыг цуглуулахын тулд эсвэл арилжаалах зорилгоор санхүүгийн хөрөнгийг эзэмших зорилго бүхий бизнесийн загвараар эзэмшдэг; болон
- Зөвхөн үндсэн төлбөрийн төлөлт ба гэрээний нөхцөлөөр тодорхой заасан өдрөөрх төлөгдөөгүй үндсэн төлбөрийг үлдэгдэлд тооцсон хүүгийн төлбөрөөс бүрдэх төлбөрүүдийн мөнгөн урсгалыг тогтоосон хугацаанд хувиарийн дагуу хүлээн авах нөхцөлтэй байх

Бусад санхүүгийн хөрөнгийг дараа үед ашиг, алдагдалаарх бодит үнэ цэнэ (ААБҮЦ)-ээр хэмжинэ.

Дээр дурдсанаас үл хамааран, Групп санхүүгийн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөх үед дараах ангиллыг сонгон бүртгэж болно:

- Групп тодорхой шалгуурuудыг хангасан тохиолдолд буцаах сонголтгүйгээр өмчийн хэрэглүүр дэх хөрөнгө оруулалтыг дараа үеүдэд хэмжихдээ бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогоор тусгаж болно; болон
- Групп өрийн хэрэглүүрээрх хөрөнгө оруулалтыг хорогдуулсан өртөг эсвэл БДОБҮЦ-ээр бүртгэх зарчмыг сонгосон байсан нягтлан бодох бүртгэлийн нийцгүй байдлыг арилгана гэж үзэж байвал буцаах сонголтгүйгээр ААБҮЦ-ээр тусгаж болно.





## 2. Нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогын хураангуй (үргэлжлэл)

### 2.10 Санхүүгийн хөрөнгө (үргэлжлэл)

#### 2.10.1 Санхүүгийн хөрөнгийн ангилал (үргэлжлэл)

Группийн санхүүгийн хөрөнгө нь хорогдуулсан өртгөөрх санхүүгийн хөрөнгөөс бүрдэж байна.

*Хорогдуулсан өртөг болон үр ашигт хүүгийн арга*

Үр ашигт хүүгийн арга гэдэг нь санхүүгийн өрийн хорогдуулсан өртгийг тооцоолон, хүүгийн орлогыг хугацааны туршид хуваарилах арга юм.

Худалдаж авсан эсвэл бий болгосон үнэ цэнийн бууралт бүхий зээл ба авлагын санхүүгийн хөрөнгөөс бусад (анхлан хүлээн зөвшөөрөхдөө үнэ цэнэ нь буурсан хөрөнгө) санхүүгийн хөрөнгийн хувьд үр ашигт хүүгийн хувь нь ирээдүйд төлөхөөр тооцоолсон бүх мөнгөн төлбөр (үр ашигт хүүгийн хувьд нөлөөлөх бүхий л төлбөр хураамж, ажил гүйлгээний зардал, хөнгөлөлт урамшууллыг багтаасан)-ийг санхүүгийн өрийн гэрээний хугацааны эцэс гэхэд анх бүртгэсэн цэвэр дансны үнэтэй тэнцүү байхаар үнэ цэнийн бууралтын нөөцийг хасахын өмнөх төлбөрийг өрийн хугацаа эсвэл шаардлагатай тохиолдолд түүнээс богино хугацаанд хуваарилахад хэрэглэдэг хүүгийн хувь юм.

Санхүүгийн хөрөнгийн хорогдуулсан өртөг гэдэг нь санхүүгийн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөх үед хэмжсэн дүнгээс үндсэн төлбөрийн эргэн төлөлтийг хасч, анхны дүн ба дуусгавар болох үеийн дүнгийн хооронд үүссэн аливаа зөрүүг үр ашигт хүүний арга ашиглан тооцсон хорогдуулгыг нэмж аливаа алдагдлын нөөцийг тохируулсан дүнгээр тодорхойлогдоно.

Санхүүгийн хөрөнгийн дансны үнэ нь аливаа алдагдлын нөөцөөр тохируулаагүй дүн байна.

Хүүгийн орлогыг анх үр ашигт хүүгийн түвшин ашиглан хорогдуулсан өртгөөр болон БДОБҮЦ-ээр хэмжигдэх бүх өрийн хэрэгслүүдийн хувьд бүртгэдэг. Зээлийн үнэ цэнийн бууралттай санхүүгийн хөрөнгүүдийн хувьд хүүгийн орлогыг тухайн санхүүгийн хөрөнгийн нийт дансны үнэд үр ашигт хүүгийн түвшинг ашиглах замаар тооцоолно.

Дараа тайлант үед зээлийн үнэ цэнийн бууралтад орсон санхүүгийн хөрөнгийн хувьд тухайн хөрөнгийн хорогдуулсан өртөгт үр ашигт хүүгийн түвшин ашиглах замаар тодорхойлно. Санхүүгийн хөрөнгийн зээлийн эрсдэл дараа тайлант үед сайжирч санхүүгийн хөрөнгө нь зээлийн үнэ цэнийн бууралтгүй болсон ч гэсэн тооцооллыг нийт сууриар буцаахгүй.

Хүүгийн орлогыг тайлант үеийн ашиг, алдагдлаар тайлагнадаг ба "санхүүгийн ба бусад орлогын хүүгийн орлого" хэсэгт ангилна.

#### 2.10.2 Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт

Групп хорогдуулсан өртгөөр хэмжигдсэн санхүүгийн хөрөнгөд хүлээгдэж буй алдагдлыг хүлээн зөвшөөрөн бүртгэдэг.  Тухайн санхүүгийн хэрэгслийг хүлээгдэж буй алдагдлын дүн анх хүлээн зөвшөөрч бүртгэснээс хойш эрсдэлийн өөрчлөлтийг үнэлж тайлант хугацаа болгонд шинэчилнэ.

Групп дансны авлагад нийт хугацааны туршид хүлээгдэж буй алдагдлыг тооцоолон бүртгэдэг. СТОУС 9-ийн дагуу үнэ цэнийн бууралттай авлагаас бусад дансны авлагын үлдэгдэл нь 400 сая төгрөгөөс давсан бөгөөд даатгагдаагүй авлагыг тусгайлан үнэлж, үлдсэн авлагын дүнг хугацаа хэтэрсэн хоногт үндэслэн багцын аргаар тооцсон.

Эдгээр санхүүгийн хөрөнгийн хүлээгдэж буй алдагдлыг тооцоолохдоо алдагдлын түүхэн мэдээллийг зээлдэгчдэд тусгайлан тодорхойлсон хүчин зүйлс, үндсэн үйл ажиллагаа явуулж буй зах зээлийн нөхцөл байдал, одоогийн болон ирээдүйг таамаглаж буй мэдээллийг тайлагналын өдрөөр харгалзан тохируулсан матрицыг ашиглан тооцоолж болох бөгөөд уг тооцоололд тохиромжтой гэж үзвэл мөн мөнгөний цаг хугацааны үнэ цэнийг харгалзан үзэж болно. Нийт хугацааны туршид хүлээгдэж буй алдагдал нь санхүүгийн хэрэгслийн хүлээгдэж буй нийт хугацааны туршид гарах бүхий л боломжит дефолт үйл явдлаас үүсэх алдагдлыг илэрхийлнэ.

**2. Нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогын хураангуй (үргэлжлэл)**

**2.10 Санхүүгийн хөрөнгө (үргэлжлэл)**

**2.10.2 Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт (үргэлжлэл)**

*(i) Зээлийн эрсдэлийн мэдэгдэхүйц өсөлт*

Санхүүгийн хэрэгслийн зээлийн эрсдэл нь анх бүртгэлд тусгаснаас хойш мэдэгдэхүйц хэмжээгээр өссөн эсэхийг үнэлэхдээ Групп анх бүртгэлд тусгасан өдрийн санхүүгийн хэрэгслээс үүссэн эрсдэлийг, тайлант өдрөөрх эрсдэлийн дүнтэй харьцуулдаг. Энэхүү үнэлгээг хийхдээ Групп үндэслэлтэй бөгөөд дэмжигдэхүйц тоон болон чанарын мэдээллийн аль алиныг нь харгалзан үзэх ба эдгээр нь түүхэн туршлага болон өндөр хүчин чармайлт, өртөг шаардахааргүйгээр олж авах боломжтой ирээдүйг таамаглаж буй мэдээллүүд байна.

Ирээдүйг таамаглаж буй мэдээлэл нь Группийн зээлдэгчийн үйл ажиллагаа эрхэлдэг салбарын ирээдүйн хэтийн төлөвийг агуулсан, эдийн засгийн шинжээчийн тайлангаас авсан мэдээлэл болон санхүүгийн шинжээч, засгийн газрын байгууллага, холбогдох судалгааны байгууллага, бусад ижил төстэй байгууллагаас гаргасан мэдээллүүд болон Группийн үндсэн үйл ажиллагаатай холбоотой эдийн засгийн бодит болон урьдчилан таамагласан янз бүрийн гадаад эх сурвалжийн мэдээллүүдийг авч үздэг.

Зээлийн эрсдэл нь анх хүлээн зөвшөөрснөөс хойш мэдэгдэхүйц хэмжээгээр өссөн эсэхийг үнэлэхдээ дараах мэдээллийг харгалзан үзнэ:

- Санхүүгийн хэрэгслийн гадаад (хэрэв байгаа бол) эсвэл дотоод зээлийн үнэлгээний бодит эсвэл хүлээгдэж буй мэдэгдэхүйц бууралт;
- Тухайн санхүүгийн хэрэгслийн гадаад зах зээлийн эрсдэлийн үзүүлэлтүүдийн бууралт. Үүнд: ижил төстэй хэрэглүүрийн өгөөжийн түвшин ихээхэн ялгаатай байх, зээл ба авлагын эрсдэлийг солилцох гэрээний үнэ эсвэл шаардагдах цаг хугацаа болон үргэлжлэх байдлын улмаас санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнэ нь хорогдуулсан өртгөөсөө бага байх зэрэг юм;
- Одоо байгаа эсвэл урьдчилан таамагласан бизнест нөлөөлж болохуйц сөрөг өөрчлөлт, зээлдэгчийн өрийг эргэн төлөх чадварыг бууруулж болзошгүй нөлөөлөх санхүүгийн эсвэл эдийн засгийн нөхцөл байдлууд;
- Зээлдэгчийн үйл ажиллагааны бодит эсвэл хүлээгдэж буй үр дүнгийн мэдэгдэхүйц бууралт;
- Зээлдэгчийн бусад санхүүгийн хэрэгслүүдийн зээлийн эрсдэлийн мэдэгдэхүйц өсөлт;
- Зээлдэгчийн хууль эрх зүй, эдийн засаг, технологийн орчинд гарч буй бодит буюу хүлээгдэж буй томоохон сөрөг өөрчлөлтүүд нь төлбөрийн үүргээ биелүүлэх чадварыг мэдэгдэхүйцээр бууруулах.

Дээрх үнэлгээний үр дүнгээс үл хамааран Групп анх бүртгэлд тусгаснаас хойш гэрээний төлбөр 30 хоногоос дээш хугацаагаар хэтэрсэн үед санхүүгийн хөрөнгийн зээлийн эрсдэл мэдэгдэхүйц хэмжээгээр нэмэгдсэн гэж үзнэ. Хэрвээ зээлийн эрсдэл мэдэгдэхүйцээр нэмэгдээгүйг илтгэх үндэслэлтэй бөгөөд дэмжигдэхүйц нотолгоо байгаа тохиолдолд эрсдэлийг мэдэгдэхүйцээр нэмэгдсэн гэж үзэхгүй байж болно.

Хэрэв санхүүгийн хэрэгсэл нь тайлант өдрөөр эрсдэлийн түвшин бага гэж тодорхойлогдсон бол дээр дурдсанаас үл хамааран Групп санхүүгийн хэрэгслийн зээл ба авлагын эрсдэл анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш мэдэгдэхүйц өсөлт гараагүй гэж үздэг. Санхүүгийн хэрэгсэл нь дараах нөхцөлд эрсдэл бага гэж тодорхойлогдоно:

- Санхүүгийн хэрэгсэл нь  эргэн төлөгдөхгүй байх эрсдэл багатай,
- Зээлдэгч ойрын хугацаанд гэрээний мөнгөн урсгалын үүргийг биелүүлэх бүрэн чадавхтай, мөн
- Урт хугацаанд эдийн засгийн болон бизнесийн нөхцөл байдалд гарах сөрөг өөрчлөлт нь зээлдэгч гэрээний мөнгөн урсгалын үүргээ биелүүлэх чадварыг бууруулж болзошгүй боловч энэ нь заавал бууруулна гэж тооцохгүй байж болно.







**2. Нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогын хураангуй (үргэлжлэл)**

**2.10 Санхүүгийн хөрөнгө (үргэлжлэл)**

**2.10.2 Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт (үргэлжлэл)**

*(i) Зээлийн эрсдэлийн мэдэгдэхүйц өсөлт (үргэлжлэл)*

Хэрэв Группийн санхүүжилтийн хөрөнгө нь дэлхийн түвшинд танигдсан зээлийн үнэлгээний тодорхойлолттой нийцсэн эсвэл хөндлөнгийн үнэлгээний мэдээллийн олдоц хомс тохиолдолд, дотооддоо “хэвийн” гэж үнэлсэн санхүүгийн хөрөнгийг эрсдэл багатай гэж үзнэ. “Хэвийн” гэсэн үнэлгээ нь оролцогч тал санхүүгийн хувьд өндөр чадавхтай бөгөөд өнгөрсөн хугацаанд хугацаа хэтэрсэн төлөгдөөгүй үүрэг үүсээгүй байхыг хэлнэ.

Групп зээлийн эрсдэлд мэдэгдэхүйц өсөлт гарсан эсэхийг тодорхойлоход ашигласан шалгуурууд нь зээл ба авлагын төлөгдөх хугацаа хэтрэхээс өмнө эрсдэлийн мэдэгдэхүйц өсөлтийг тодорхойлох үр ашигтай үзүүлэлтүүд гэдгийг тогтмол хянадаг ба шаардлагатай тохиолдолд өөрчилдөг.

*(ii) Дефолтын тодорхойлолт*

Групп дотоод удирдлагын зорилгоор түүхэн туршлагад үндэслэн зээлийн эрсдэлийн дараах шалгууруудын аль нэгийг нь хангасан санхүүгийн хөрөнгүүд нь нөхөгдөх боломжгүй болсон үед үүнийг дефолт үйл явдал гэж үздэг.

- Зээлдэгч гэрээнд заасан санхүүгийн харьцаа үзүүлэлтүүдийг зөрчсөн тохиолдолд;
- Зээлдэгчийн талаар дотооддоо боловсруулсан эсвэл гадаад эх сурвалжаас авсан мэдээлэл нь зээлдэгч бусад зээлдүүлэгчдэд болон Группд зээл ба авлагаа бүрэн эргүүлэн төлөх магадлал багатайг илэрхийлж  буй тохиолдолд (Группийн эзэмшиж буй барьцаа хөрөнгийг харгалзан үзэхгүй).

Дээрх шалгуураас үл хамааран Группийн санхүүгийн хөрөнгийн төлбөр төлөх хугацаа 90 хоногоос дээш хугацаагаар хэтэрсэн бол дефолт үйл явдал гэж үзнэ. Хэрвээ гэрээнд заасан үүргээ биелүүлэхэд нэмэлт хугацаа хэрэгтэй болсныг батлах үндэслэлтэй бөгөөд дэмжигдэхүйц мэдээлэл байгаа бол дээрх тодорхойлолтод хамаарахгүй байж болно.

*(iii) Үнэ цэнийн бууралттай санхүүгийн хөрөнгүүд*

Нэг болон түүнээс дээш үйл явдал тухайн санхүүгийн хөрөнгөөс хүлээн авахаар тооцоолсон ирээдүйн мөнгөн урсгалд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй тохиолдолд тухайн санхүүгийн хөрөнгийг үнэ цэнийн бууралттай гэж үзнэ. Дараах тодорхойлолтууд нь санхүүгийн хөрөнгийн үнэ цэнэ буурсан илэрхий нотолгоо болох юм:

- Үнэт цаас гаргагч эсвэл зээлдэгч талд томоохон хэмжээний санхүүгийн хүндрэл үүссэн;
- Гэрээний үүргээ биелүүлэхгүй байх, тухайлбал эргэн төлөлтийг  төлбөрийн хугацааг хэтрүүлэх эсвэл төлөх чадамжгүй болох (дээр дурдсан (ii)- ийг харна уу);
- Зээлдэгчийн санхүүжүүлэгч нь зээлдэгчийн санхүүгийн хүндрэлтэй байдлаас үүссэн эдийн засгийн болон гэрээний шалтгааны улмаас зээлдэгчидтэй тохирсон үүрэг амлалтаа хэрэгжүүлэх боломжгүй болох;
- Зээлдэгч нь дампуурлаа зарлах эсвэл санхүүгийн хувьд дахин бүтцийн өөрчлөлт хийх магадлалтай болсон;
- Санхүүгийн хүндрэлээс болж тухайн санхүүгийн хөрөнгийн идэвхтэй зах зээл байхгүй болох.

*(iv) Бүртгэлээс хасах*

Групп санхүүгийн хөрөнгийг зээлдэгч нь томоохон санхүүгийн хүндрэлд орсон ба зээлдэгчийн татан буугдах эсвэл дампуурах үйл явц эхэлсэн, авлага төлөгдөх хугацаа 1 жилээс дээш хугацаагаар хэтэрсэн зэрэг үйл явдлын аль нэг нь бий болсон үед буюу авлагын эргэн төлөлт хийгдэх бодит боломж байхгүй болсон үед бүртгэлээс хасна.  Бүртгэлээс хасагдсан санхүүгийн хөрөнгөд Группийн бодлогын дагуу авлага цуглуулах үйл явц хийгдэж, хуулийн дагуу шаардлагатай арга хэмжээг авч болно. Бүртгэлээс хасагдсан авлага нь эргэн төлөгдсөн тохиолдолд тайлант жилийн ашиг, алдагдлын тайланд тусгана.

**2. Нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогын хураангуй (үргэлжлэл)**

**2.10 Санхүүгийн хөрөнгө (үргэлжлэл)**

**2.10.2 Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт (үргэлжлэл)**

*(v) Хүлээгдэж буй зээлийн алдагдлыг хүлээн зөвшөөрөх, хэмжих*

Хүлээгдэж буй зээлийн алдагдал нь төлбөр төлөгдөхгүй байх магадлал (тухайлбал төлбөрийн чадваргүй болсон үе дэх алдагдлын далайц), алдагдал үүсэх магадлал болон эрсдэлд өртөх боломжтой зээл ба авлагын дүнгийн үржвэр юм. Төлбөр төлөгдөхгүй байх магадлал болон алдагдал үүсэх магадлалын үнэлгээ нь ирээдүйг таамаглаж буй мэдээллээр залруулагдсанг дээр өгүүлсэнчлэн ирээдүйг таамаглаж буй мэдээллээр залруулагдсан түүхэн мэдээлэлд үндэслэдэг.

Тайлагналын өдрийн байдлаар дансны үнээрээ толилуулагдсан эрсдэлтэй санхүүгийн хөрөнгийг Группийн зээлдэгчийн ирээдүйд шаардагдах санхүүжилтийн хэмжээ болон ирээдүйг таамаглаж буй мэдээллүүд ашиглан тодорхойлно.

Тайлангийн өдрөөрх эрсдэлд өртөх магадлалтай тухайн санхүүгийн хөрөнгийн дансны үнээрээ илэрхийлэгдсэн.

Санхүүгийн хөрөнгийн хувьд хүлээгдэж буй зээлийн алдагдал нь гэрээний дагуу Группийн хүлээн авах эрх бүхий нийт мөнгөн урсгал болон Группийн хүлээн авахаар тооцоолсон бүх мөнгөн гүйлгээг үр ашигт хүүгийн аргаар дискаунтчилсан дүнгийн зөрүүгээр тооцоологддог.

Хэрэв өмнөх тайлант үед санхүүгийн хэрэгслийн алдагдлын нөөц сан нь нийт хугацаанд хүлээгдэж буй зээл ба авлагын алдагдлаар хэмжигдсэн хэдий ч тайлант жилийн эцэст нийт хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдлын шалгуурыг хангаагүй бол Групп хялбарчилсан аргачлал ашигласан хөрөнгөөс бусад санхүүгийн хөрөнгийн хувьд тайлант жилийн эцсээрх 12 сарын хүлээгдэж буй зээл ба авлагын алдагдлыг тооцоолдог.

Групп санхүүгийн бүх хэрэгслийн үнэ цэнийн өсөлт бууралтыг тухайн холбогдох дансаар дамжуулан залруулж бүртгэнэ.

**2.10.3 Санхүүгийн хөрөнгийг данснаас хасах**

Групп нь зөвхөн санхүүгийн хөрөнгийн мөнгөн урсгалыг хүлээн авах эрх дуусгавар болсон эсвэл санхүүгийн хөрөнгийн мөнгөн урсгалыг хүлээн авах эрх ба хөрөнгийг эзэмшихтэй холбоотой бүх эрсдэл болон өгөөжийг бусдад шилжүүлсэн үед санхүүгийн хөрөнгийг данснаас хасна.

Хорогдуулсан өртгөөрх санхүүгийн хөрөнгийг данснаас хасахдаа тухайн хөрөнгийн дансны үнэ ба хүлээн авсан дүн болон авлагын нийлбэрийн зөрүүг ашиг, алдагдлын тайланд хүлээн зөвшөөрнө.

**2.11 Санхүүгийн өр төлбөр ба өмч**

**2.11.1 Өр төлбөр эсвэл өмчөөр ангилах**

Гэрээний зохицуулалтын агуулга болон санхүүгийн өр төлбөр болон өмчийн хэрэгслийн тодорхойлолтын дагуу өр болон өмчийн хэрэгслийг санхүүгийн өр төлбөр эсвэл өмч гэж ангилдаг.

**2.11.2 Өмчийн хэрэгсэл**

Группийн бүх хөрөнгөөс өр төлбөрийг хассаны дараа үлдэх хэсгээс хувь хүртэх нөхцөл бүхий аливаа гэрээг өмчийн хэрэгсэл гэдэг. Группээс гаргаж байгаа өмчийн хэрэгслийг хүлээн авсан мөнгөнөөс санхүүгийн хэрэгслийг гаргахтай холбоотой шууд зардлыг хассан дүнгээр хэмжиж бүртгэдэг.

*(i) Энгийн хувьцаа*

Энгийн хувьцааг эздийн өмчийн хэсэгт ангилж, бүртгэдэг. Энгийн хувьцаа нэмж гаргахтай холбоотой нэмэгдэл зардлыг татварын аливаа нөлөөллийн дараах цэвэр дүнгээр нь эздийн өмчийн бууралтаар хүлээн зөвшөөрдөг.



ГОВЬ ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
2024 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)

**2. Нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогын хураангуй (үргэлжлэл)**

**2.11 Санхүүгийн өр төлбөр ба өмч (үргэлжлэл)**

**2.11.2 Өмчийн хэрэгсэл (үргэлжлэл)**

*(ii) Хувьцаат капиталыг буцаан худалдан авах (халаасны хувьцаа)*

Хувьцаат капиталыг буцаан худалдан авсан үед аливаа татварын нөлөөллийн дараах худалдан авахтай холбоотой гарсан шууд зардлыг багтаасан дүнгээр эздийн өмчийн бууралт гэж бүртгэдэг.

Буцаан худалдан авсан хувьцааг халаасны хувьцаа гэж нэрлэх бөгөөд өмчийн өөрчлөлтийн тайланд халаасны хувьцаа гэж тайлагнадаг. Халаасны хувьцааг дахин борлуулсан эсвэл дахин эргэлтэнд гаргасан үед хүлээн авсан дүнг өмчийн өсөлтөөр бүртгэдэг бөгөөд тухайн ажил гүйлгээтэй холбогдон гарсан өсөлт, бууралтыг нэмж төлөгдсөн капитал гэж толилуулдаг.

*(iii) Хуримтлагдсан ашиг (алдагдал)*

Хуримтлагдсан ашиг (алдагдал) нь Толгой компанийн өмчийн эздэд ногдох ашиг, алдагдлаас зарласан ногдол ашгийг хассан дүн болно. Стандартад шилжилтийн шаардлагын дагуу нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтөөс үүссэн нөлөөллийг хуримтлагдсан ашиг (алдагдал)-д бүртгэдэг.

*(iv) Группийн эздийн оруулсан хөрөнгө оруулалт*

Хувьцаа эзэмшигчдийн зүгээс мөнгө болон бусад мөнгөн бус хөрөнгөөр сайн дурын үндсэн дээр (жишээлбэл, ямар нэгэн санхүүгийн үүрэг хүлээлгэхгүйгээр) оруулсан хөрөнгө оруулалт нь тухайн хөрөнгийн бодит үнэ цэнээр эздийн өмчид шууд бүртгэгддэг.

*(v) Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц*

Хөрвүүлэлтийн нөөц нь гадаад үйл ажиллагааны санхүүгийн тайлангийн хөрвүүлэлтээс үүссэн гадаад валютын ханшийн зөрүү болон Толгой компанийн гадаад охин компанид оруулсан цэвэр хөрөнгө оруулалтыг хейджинг хийсэн өр төлбөрийн хөрвүүлэлтээс үүссэн гадаад валютын ханшийн зөрүүнээс бүрдэнэ.

**2.11.3 Санхүүгийн өр төлбөр**

Бүх санхүүгийн өр төлбөрийг анх бүртгэсний дараа үр ашигт хүүгийн аргыг ашиглан хорогдуулсан өртгөөр бүртгэдэг. Группийн санхүүгийн өр төлбөр нь үр ашигт хүүгийн аргыг ашиглан хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн хэрэгслүүдээс бүрддэг.

2.11.3.1 Хорогдуулсан өртгөөрх санхүүгийн өр төлбөр

Үр ашигт хүүгийн арга гэдэг нь санхүүгийн өр төлбөрийн хорогдуулсан өртгийг тооцож, холбогдох хугацааны туршид хүүгийн зардлыг хуваарилах арга юм. Үр ашигт хүүгийн хувь нь ирээдүйд төлөхөөр тооцоолсон бүх мөнгөн төлбөр (үр ашигт хүүгийн хувьд нөлөөлөх бүхий л төлбөр хураамж, ажил гүйлгээний зардал, хөнгөлөлт урамшууллыг багтаасан)-ийг санхүүгийн өр төлбөрийн хугацааны туршид эсвэл шаардлагатай тохиолдолд түүнээс богино хугацаанд хорогдуулахад хэрэглэдэг хүүгийн хувь юм.

2.12.3.2 Санхүүгийн өр төлбөрийг данснаас хасах

Групп нь санхүүгийн өр төлбөрийг зөвхөн гэрээний үүрэг биелэгдсэн, цуцлагдсан эсвэл гэрээний хугацаа дууссан тохиолдолд данснаас хасна. Данснаас хасч буй санхүүгийн өр төлбөрийн дансны үнэ ба төлсөн дүн болон өглөгийн нийлбэрийн зөрүүг ашиг, алдагдлын тайланд хүлээн зөвшөөрнө.

**2. Нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогын хураангуй (үргэлжлэл)**

**2.12 Орлого хүлээн зөвшөөрөлт**

СТОУС 15-ын дагуу Групп нь гэрээнд заасан гүйцэтгэлийн үүрэг хангагдсан буюу бүтээгдэхүүн, үйлчилгээний хяналтыг худалдан авагч талд шилжүүлсэн тохиолдолд орлогыг хүлээн зөвшөөрнө.

Гүйцэтгэлийн үүрэг гэдэг нь өөр хоорондоо ялгаатай бүтээгдэхүүн, үйлчилгээг (бараа үйлчилгээний багц) нийлүүлэх үүргийг хэлнэ.

Дараах шалгууруудын аль нэг нь хангагдсан тохиолдолд Групп холбогдох гүйцэтгэлийн үүргийг тодорхой хугацааны туршид биелэгдэх гүйцэтгэлийн үүрэг гэж үзэж тэрхүү хугацааны туршид орлогоо хэсэгчлэн хүлээн зөвшөөрнө. Үүнд:

- Групп гүйцэтгэлийн үүргээ биелүүлсэн цаг хугацаатай зэрэгцэн, уг ажлын гүйцэтгэлээр дамжуулан худалдан авагч үр өгөөж хүртэх;
- Группийн гүйцэтгэлийн үүргийн биелэлт нь ямар нэг хөрөнгийг бий болгодог эсвэл хөрөнгийн үнэ цэнийг нэмэгдүүлдэг бөгөөд уг хөрөнгө бий болсон эсвэл үнэ цэнэ нь нэмэгдэх бүрд худалдан авагч хяналтыг өөртөө авах;
- Группийн гүйцэтгэлийн үүргийн биелэлтээр дамжин бий болж буй хөрөнгийг Групп ашиглаж үр өгөөж хүртэх боломжгүй хэдий ч гүйцэтгэлийн үүрэг хангагдах бүрд төлбөр хүлээн авах эрхтэй байх.

Бусад тохиолдолд, худалдан авагч нь өөр хоорондоо ялгаатай бүтээгдэхүүн эсвэл үйлчилгээний хяналтыг авах үед тодорхой нэг хугацаанд хангагдах гүйцэтгэлийн үүрэг гэж үзэж орлогыг хүлээн зөвшөөрнө.

Орлогыг худалдан авагчтай байгуулсан гэрээний дагуу Группийн хүлээн авах эрхтэй гэж үзэж буй төлбөрийн дүнд үндэслэн хэмжинэ. Групп нь гэрээнд заасан гүйцэтгэлийн үүрэг хангагдсан буюу тусгайлан бүтээгдэхүүн, үйлчилгээний хяналтыг худалдан авагч талд шилжүүлсэн тохиолдолд орлогыг хүлээн зөвшөөрнө.

Гэрээний хөрөнгө нь хөрөнгийг худалдан авагчид шилжүүлсэн боловч бүтээгдэхүүн эсвэл үйлчилгээтэй холбоотой төлбөрийг Групп хүлээн авах эрх үүсээгүй үед бий болох хөрөнгө юм. Уг гэрээний хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг СТОУС 9-ийн дагуу хэмжинэ. Авлага нь тодорхой хугацааны дотор төлөгдөх, цаг хугацаанаас өөр хүчин зүйлээс хамааралгүй, төлбөр хүлээн авах эрх юм.

Гэрээний өр төлбөр нь худалдан авагчаас төлбөр хүлээн авсан боловч худалдан авагчид барааг шилжүүлэх эсвэл үйлчилгээ үзүүлэх (төлөх ёстой төлбөрийн хэмжээ) Группийн үүргийг илэрхийлнэ.

Нэг гэрээтэй холбоотой гэрээний хөрөнгө ба гэрээний өр төлбөрийг цэвэр дүнгээр нь тайлагнана.

Группийн орлого нь дараах үндсэн эх үүсвэрээс бүрддэг:

а) Барааны борлуулалт;
б) Үйлчилгээний орлого;
в) Бусад орлого.



ГОВЬ ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
2024 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)

**2. Нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогын хураангуй (үргэлжлэл)**

**2.12.1 Барааны борлуулалт**

Групп нэхмэл, оёмол болон сүлжмэл ноолууран бүтээгдэхүүнийг жижиглэнгийн болон бөөний худалдан авагч, онлайн платформоор борлуулдаг.

Бөөний худалдан авагчид хийсэн борлуулалтыг тухайн бүтээгдэхүүний хяналтыг худалдан авагчид шилжүүлсэн үед бүртгэдэг. Хяналт шилжсэн гэдэг нь бүтээгдэхүүнийг бөөний худалдан авагчид хүргэсэн, бөөний худалдан авагч нь тухайн бүтээгдэхүүний борлуулалтын суваг болон бүтээгдэхүүний үнэтэй холбоотой шийдвэр гаргах эрх худалдан авагчид бүрэн шилжсэнийг хэлнэ. Бөөний худалдан авагчтай байгуулсан гэрээнд заасан тодорхой цэгт барааг хүргүүлсэн, бараатай холбоотой бүхий л эрсдэл бөөний худалдан авагчид шилжсэн, худалдан авагч гэрээнд заасан барааг хүлээн авснаа зөвшөөрсөн зэрэг барааны өмчлөл ба эрсдэлтэй холбоотой бүх нөхцөл биелсэн үед барааг худалдан авагчид хүргэсэн гэж үзнэ.

Барааг худалдан авагчид хүргэсэн тухайн цаг үед буюу төлбөрийг хүлээн авах нь тодорхой бөгөөд төлбөрийг хүлээн авах нь зөвхөн цаг хугацааны асуудал болсон үед авлагыг бүртгэнэ.

Жижиглэн худалдааны борлуулалтын орлогыг барааны хяналтыг шилжүүлсэн үед буюу худалдан авагч дэлгүүрт барааг худалдан авсан үед бүртгэнэ. Худалдан авагч барааг худалдан авмагц гүйлгээний төлбөрийг нэхэмжилдэг.

Группийн бодлогын дагуу жижиглэнгийн худалдан авагчид худалдан авсан бараагаа 24 цагийн дотор, бөөний худалдан авагчид гэрээгээр тохирсон хязгаарт багтаан буцаах эрхтэй. Тиймээс гэрээний өр төлбөр (буцаагдах боломжит өр төлбөр) болон буцаах эрхтэй бараагаарх хөрөнгө (эргэлтийн хөрөнгөөр тайлагнагдсан)-ийг буцаагдах боломжит дүнд үндэслэн бүртгэнэ. Групп буцаагдах боломжит дүнг түүхэн мэдээлэл болон хуримтлуулсан туршлага дээрээ үндэслэн тооцоолдог.

Хувьсах төлбөртэй холбогдсон тодорхойгүй хүчин зүйлс нь хожим тодорхой болоход хүлээн зөвшөөрөгдсөн орлогын дүнд материаллаг нөлөөгүй бол хувьсах төлбөрийн тооцоолсон дүнг ажил гүйлгээний үнэд оруулан тооцно.

**2.12.2 Үйлчилгээний орлого**

Үйлчилгээний орлого нь холбоотой талууд болон бусад харилцагчдад үзүүлсэн хуурай цэвэрлэгээ болон оёдлын үйлчилгээтэй холбоотой.

Групп гүйцэтгэлийн үүргээ биелүүлэх үед уг гүйцэтгэлээр дамжуулан харилцагч үр өгөөж хүртэлх болон хяналтыг нэгэн зэрэг шилжүүлэн авснаар борлуулалтын орлогыг үйлчилгээ үзүүлж буй хугацааны туршид хүлээн зөвшөөрнө.

Гүйцэтгэлийн үүргийн ахиц дэвшлийг гарцын аргаар хэмжих бөгөөд тодорхой өдөр хүртэл харилцагчид шилжүүлсэн бараа, үйлчилгээний бодит үнэ цэнийг Группийн гэрээний дагуу шилжүүлэхээр амласан үлдсэн бараа, үйлчилгээнд ногдох дүнгээр орлого хүлээн зөвшөөрнө.

**2. Нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогын хураангуй (үргэлжлэл)**

**2.12 Орлого хүлээн зөвшөөрөлт (үргэлжлэл)**

**2.12.3 Бусад орлого**

Бусад орлого нь түүхий эд материал болон хагас боловсруулсан бүтээгдэхүүнийг дотоодын харилцагчдад борлуулсантай холбоотой.

Бүтээгдэхүүнийг Группийн агуулахаас илгээж, бүтээгдэхүүний хяналтыг харилцагч авах үед бусад орлогыг хүлээн зөвшөөрдөг. Борлуулалтын нэхэмжлэхийн дагуу тодорхой нэг хугацаанд орлого хүлээн зөвшөөрдөг. Орлогыг Группийн харилцагчтай байгуулсан гэрээгээр авах эрхтэй хүлээгдэж буй төлбөрийг үндэслэн хэмжинэ.

Групп нь гүйцэтгэлийн үүргээ биелүүлж, тухайлбал бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний хяналтыг харилцагчид шилжүүлж, ялангуяа бараа харилцагчийн тодорхой байршилд (хүргэлт) хүргэгдсэн үед бусад орлогыг хүлээн зөвшөөрнө.

**2.12.4 Буцаах эрхтэй бараагаарх хөрөнгө болон өр төлбөр**

*Буцаах эрхтэй бараагаарх хөрөнгө*

Буцаах эрхтэй бараагаарх хөрөнгө нь харилцагчаас буцаагдаж ирэхээр хүлээгдэж буй барааг хүлээн авах Группийн эрхийг илэрхийлнэ. Хөрөнгийг барааны өмнөх дансны үнээс буцаагдаж ирэх барааны боломжит үнийн бууралтыг багтаасан барааг буцаах үед гарах хүлээгдэж буй зардлыг хасч хэмжинэ. Групп буцаагдахаар хүлээгдэж буй барааны хөрөнгийн хэмжилтэд орох аливаа өөрчлөлт болон үнэ цэнийн аливаа нэмэлт бууралтыг байгаа эсэхийг үнэлж шинэчилдэг. Буцаалтын дүнг тооцоолохын тулд Групп хүлээгдэж буй үнэ цэнийн аргыг ашиглан багцын түвшин дэх буцаалтын тоо хэмжээг өөрийн хуримтлагдсан түүхэн туршлагад үндэслэн тодорхойлдог. Өмнөх жилүүдэд тогтмол хэмжээний барааны буцаалт хийгдэж байсан тул мэдэгдэхүйц хэмжээний орлогын буцаалт бүртгэгдэх магадлал бага байна гэж үздэг.

*Буцаах эрхтэй барааны өр төлбөр*

Буцаах эрхтэй барааны өр төлбөр нь харилцагчаас хүлээн авсан нийт төлбөр (эсвэл авлага) эсвэл төлбөрийн зарим хэсгийг буцаан олгох үүрэг хариуцлага бөгөөд Групп харилцагчид буцаан олгоно гэж хүлээгдэж буй тооцоолсон дүнгээр хэмжигдэнэ. Групп тайлант үе бүрийн эцэст буцаах эрхтэй барааны өр төлбөр (ба гүйлгээний үнийн харгалзах өөрчлөлт)-ийн тооцооллыг шинэчилдэг.

**2.13 Түрээс**

**2.13.1 Түрээсийн тодорхойлолт**

Хэрвээ тодорхой төлбөртэйгээ тогтсон хугацааны туршид, тодорхой хөрөнгийг ашиглаж, хянах эрх үүссэн бол тухайн гэрээг түрээсийн гэрээ эсвэл уг гэрээнд түрээсийн зүйл агуулагдсан байна гэж үзнэ.

СТОУС 16-г анх хэрэгжүүлэх үед эсвэл дараа нь бизнес нэгдэлтэй холбоотойгоор үүссэн болон өөрчилсөн гэрээнүүдийг Групп СТОУС 16-д тодорхойлсны дагуу гэрээ нь түрээсийн гэрээ эсвэл түрээсийн зүйл агуулагдсан эсэхийг гэрээг өөрчилсөн өдөр эсвэл худалдан авалтын өдрийн аль тохиромжтой өдрөөр үнэлнэ. Гэрээний нөхцөл дараа нь өөрчлөгдөөгүй бол дахин үнэлэх шаардлагагүй.





**ГОВЬ ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД**
**2024 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД**
**(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

**2. Нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогын хураангуй (үргэлжлэл)**

**2.13 Түрээс (үргэлжлэл)**

**2.13.2 Түрээслэгч - Групп**

*Гэрээний зүйл тус бүрийн төлбөрийн хуваарилалт*

Групп нь түрээсийн зүйл ба нэмэлтээр нэг эсвэл түүнээс дээш түрээс эсвэл түрээсийн бус зүйл агуулсан гэрээний хувьд түрээсийн зүйлийн гэрээ нэг бүрийн төлбөрийг түрээсийн ба түрээсийн бус зүйлсийн нэг бүрийн үнийн нийлбэр дээр суурилан хуваарилна.

*Богино хугацаат түрээс ба бага үнэтэй хөрөнгийн түрээс*

Групп нь гэрээний хугацаа нь 12 сар ба түүнээс бага хугацаанд түрээслэх худалдан авах нөхцөлгүй дэлгүүр болон агуулахуудын түрээсийг богино хугацаат түрээсээр хүлээн зөвшөөрнө. Бага үнэтэй богино хугацаат түрээсийн төлбөр ба бага үнэтэй хөрөнгийн түрээсийг мөн адил хүлээн зөвшөөрнө. хөрөнгийг түрээсийг шулуун шугамын арга эсвэл бусад системчлэгдсэн аргууд дээр суурилан түрээсийн хугацаанд зардлаар хүлээн зөвшөөрнө.

*Ашиглах эрхтэй түрээсийн хөрөнгө*

Ашиглах эрхтэй түрээсийн хөрөнгийн өртөгт дараах зүйлс багтана:

- Түрээсийн өр төлбөрийн анх тооцсон дүн;
- Түрээс эхэлснээс эсвэл эхлэхээс өмнө төлсөн түрээсийн төлбөрөөс түрээснээс авсан урамшууллыг хассан дүн;
- Группээс гарсан анхдагч шууд зардлууд; болон
- Түрээсийн шаардсан нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор тодорхой хөрөнгийг буулгах, нүүлгэх, хөрөнгө байрлах газрыг сэргээх эсвэл тухайн хөрөнгийг сэргээхэд Группээс гарсан зардлын тооцоолсон дүн.

Ашиглах эрхтэй түрээсийн хөрөнгийг өртгөөс нь үнэ цэнийн бууралт болон хуримтлагдсан элэгдлийг хассан дүнгээр хэмждэг ба түрээсийн өр төлбөрт хийгдсэн аливаа өөрчлөлтөөр залруулдаг.

Групп нь түрээсийн гэрээ дуусгавар болох үед тодорхой түрээсийн хөрөнгийн өмчлөлийг шилжүүлэн авах бол ашиглах эрхтэй түрээсийн хөрөнгийг түрээс эхэлсэн өдрөөс эхлэн ашиглагдах хугацаа дуусгавар болох хүртэл элэгдүүлнэ. Өөрөөр заагаагүй бол, ашиглах эрхтэй түрээсийн хөрөнгийн тооцоолсон ашиглагдах хугацаа ба түрээсийн хугацааны аль багаар нь шулуун шугамын аргаар элэгдүүлнэ.

Групп нь хөрөнгө оруулалтын зориулалттай хөрөнгө болон бараа материалын тодорхойлолтод нийцээгүй ашиглах эрхтэй түрээсийн хөрөнгийг нэгтгэсэн санхүүгийн байдлын тайланд тусдаа мөрөөр толилуулна.

*Буцаан авах түрээсийн барьцаа*

Төлөгдсөн буцаан авах түрээсийн барьцааг СТОУС 9 Санхүүгийн хэрэглүүрийн дагуу бодит үнэ цэнээр нь анх хүлээн зөвшөөрнө. Анх хүлээн зөвшөөрсөн бодит үнэ цэнийн залруулга нь нэмэлт түрээсийн төлбөр байх ба ашиглах эрхтэй түрээсийн хөрөнгийн өртөгт оруулан бүртгэнэ.

*Түрээсийн өр төлбөр*

Групп нь түрээс эхэлсэн өдрөөр төлөгдөөгүй байсан түрээсийн төлбөрийн өнөөгийн үнэ цэнээр түрээсийн өр төлбөрийг хүлээн зөвшөөрнө. Түрээсийн өр төлбөрийн өнөөгийн үнэ цэнийг тооцоход Групп нь түрээсийн хүүгийн түвшин тодорхойлох боломжгүй үед түрээс эхлэх өдрөөр түрээсийн гэрээний нуугдмал хүү мэдэгдэхгүй бол өсөн нэмэгдэх хүүг ашиглана.

**2. Нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогын хураангуй (үргэлжлэл)**

**2.13 Түрээс (үргэлжлэл)**

**2.13.2 Түрээслэгч – Групп (үргэлжлэл)**

Түрээсийн төлбөрт дараах зүйлс багтана:

- Тогтмол төлбөрүүдээс (бодит тогтмол төлбөрүүд) түрээсийн урамшууллыг хассан дүн;
- Гэрээ эхлэх өдрөөр үнийн индекс эсвэл ханшийг ашиглан тодорхойлогдсон үнийн индекс эсвэл ханшнаас хамааралтай хувьсах түрээсийн төлбөрүүд;
- Үлдэх өртгийн баталгаагаар Группээс төлөгдөх боломжтой төлбөрийн дүн;
- Худалдан авах нөхцөлтэй үед худалдан авалтын боломжит үнэ;
- Түрээсийн гэрээнд Групп нь түрээсийн хугацааг цуцлах эрхтэй үед түрээсийн гэрээг цуцлахад үүсэх торгууль.

Хувьсах төлбөртэй түрээсийн төлбөрийг гэрээ хэрэгжиж эхэлсэн өдрөөрх түрээсийн зах зээлийн үнээр анх хүлээн зөвшөөрнө. Үнийн индекс эсвэл ханшнаас хамааралгүй хувьсах түрээсийн төлбөрийг түрээсийн өр төлбөр ба ашиглах эрхтэй түрээсийн хөрөнгийн дүнд оруулахгүй ба түрээсийн төлбөр гарсан тохиолдолд эсвэл нөхцөлд зардлаар хүлээн зөвшөөрнө.

Гэрээ хэрэгжиж эхэлснээс хойш түрээсийн өр төлбөрийг хүүний өсөлт ба түрээсийн төлбөрийн дүнгээр тохируулна.

Дараах тохиолдолд Групп нь түрээсийн өр төлбөрийг (ашиглах эрхтэй түрээсийн хөрөнгөтэй холбоотой залруулгын хамт бүртгэж) дахин хэмжинэ:

- Түрээсийн хугацаа өөрчлөгдсөн эсвэл худалдан авах нөхцөлтэй гэрээтэй үед дахин үнэлгээ хийсэн өдрөөрх хорогдуулалтын түвшинг ашиглан хорогдуулсан түрээсийн төлбөрөөр хэмжигдэх түрээсийн өр төлбөрийг дахин үнэлж өөрчлөлт орсон;
- Анх ашигласан хоргдуулалтын түвшинг ашиглан хорогдуулсан түрээсийн төлбөрөөр хэмжигдэх түрээсийн өр төлбөрийг тодорхойлох үед гарсан баталгаат үлдэх өртөгт нөлөөлсөн түрээсийн зах зээлийн боломжит төлбөрийн түрээсийн зах зээлийн түвшин өөрчлөгдсөнөөр түрээсийн төлбөр өөрчлөгдсөн.

Түрээсийн өр төлбөрийг санхүүгийн байдлын тайланд тусад нь толилуулж, холбогдох тодруулгыг мөн тусад нь харуулна.

*Түрээсийн гэрээний өөрчлөлт*

Групп нь дараах тохиолдолд түрээсийн өөрчлөлтийг тусдаа түрээсээр бүртгэнэ:

- Өөрчлөлт нь нэмэлтээр нэг болон түүнээс дээш тодорхой хөрөнгө ашиглах эрх үүсгэж, түрээсийн зүйлийг нэмэгдүүлсэн; ба
- Түрээсийн үзүүлэлтүүд нь түрээсийн гэрээ тус бүр дээр тусгайлан заасан нөхцөл үүссэн үед түрээсийн зүйлийг нэмэгдүүлэхэд хэмжигдэхүйц нэг бүрийн үнээр өссөн.

Групп нь тусдаа түрээсээр бүртгэгдэхгүй түрээсийн өөрчлөлтийн хувьд өөрчлөгдсөн түрээсийн гэрээний хугацааг харгалзан өөрчлөлт орсон өдрөөрх шинэчлэгдсэн хорогдуулалтын түвшинг ашиглан шинэчлэгдсэн түрээсийн төлбөрийг хорогдуулан түрээсийн өр төлбөрийг хүлээн зөвшөөрнө.

Групп нь түрээсийн өр төлбөр шинэчлэгдсэн тохиолдолд ашиглах эрхтэй түрээсийн хөрөнгийн дүнг тохируулж бүртгэнэ. Өөрчлөгдсөн түрээсийн гэрээнд түрээсийн зүйл ба нэмэлтээр нэг эсвэл түүнээс дээш түрээс эсвэл түрээсийн бус зүйл агуулсан гэрээний хувьд түрээсийн зүйлийн гэрээ нэг бүрийн төлбөрийг түрээсийн зүйлийн холбогдох нэг бүрийн үнэ ба түрээсийн бус зүйлийн нэг бүрийн үнийн нийлбэр дээр суурилан хуваарилна.





**2. Нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогын хураангуй (үргэлжлэл)**

**2.13 Түрээс (үргэлжлэл)**

**2.13.3 Түрээслүүлэгч - Групп**

Түрээсийн гэрээгээр эрсдэл өгөөжийг түрээслэгчид шилжүүлж байгаа бол түрээсийг санхүүгийн түрээсээр ангилна. Дээрхээс бусад бүх түрээс нь үйл ажиллагааны түрээсээр ангилагдана.

Үйл ажиллагааны түрээсийн төлбөрийг түрээсийн хугацаанд шулуун шугамын аргаар бүртгэдэг. Үйл ажиллагааны түрээсийн дор үүсэх түрээсийн үүрэг хариуцлагыг уг үүрэг үүсэх хугацааны турш зардлаар бүртгэдэг. Үйл ажиллагааны түрээсийн үед түрээсийн урамшуулал хүлээн авсан үед уг урамшууллыг өр төлбөрөөр бүртгэнэ. Урамшууллын нийт ашгийг түрээсийн зардлаас хасч шулуун шугамын аргаар бүртгэнэ.

**2.14 Гадаад валютын ажил гүйлгээ**

Группийн бие даасан компани бүрийн хувьд санхүүгийн тайланг бэлтгэхдээ компанийн тайлагналын валютаас бусад валютыг (гадаад валют) ажил гүйлгээ гарсан өдрийн ханшаар хөрвүүлэн бүртгэсэн.

Төгрөгөөс бусад мөнгөн тэмдэгт нь гадаад валют гэж тооцогддог ба гадаад валютаар хийгдсэн гүйлгээнүүд нь тухайн гүйлгээний өдрийн зах зээлийн ханшаар төгрөг рүү хөрвүүлэгддэг.

Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн хөрөнгө болон өр төлбөр нь тухайн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлангийн өдрийн ханшаар төгрөг рүү хөрвүүлэгддэг. Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгө хөрөнгө болон өр төлбөрүүдийн гүйлгээ хийгдсэн өдрөөс хойших ханшийн өөрчлөлтөөс үүсэн гарах өөрчлөлтийг гарсан цаг хугацаанд нь ашиг, алдагдлаар бүртгэнэ.

Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн бус зүйлсийн хөрөнгө ба өр төлбөр нь тухайн гүйлгээний өдрийн зах зээлийн ханшаар хөрвүүлэгддэг.

Нэгтгэсэн санхүүгийн тайлан бэлтгэхтэй холбоотойгоор, Группийн гадаад үйл ажиллагааны хөрөнгө болон өр төлбөрийг тайлант хугацаа бүрийн эцсийн өдрийн ханшаар Төгрөг рүү хөрвүүлсэн. Тайлант хугацааны турш дахь орлого болон зардлын зүйлсийг хөрвүүлэхдээ ажил гүйлгээ үүссэн өдрийн ханшийг ашигласан.

Ханшийн зөрүүнээс үүссэн зөрүүг бусад дэлгэрэнгүй орлогын тайланд тусган эздийн өмчийн хэсэгт хуримтлуулан бүртгэнэ.

**2.15 Зардал хүлээн зөвшөөрөлт**

Зардлыг нэгтгэсэн дэлгэрэнгүй орлогын тайланд зардлын чиг үүргийн аргыг ашиглан тайлагнадаг. Борлуулсан бүтээгдэхүүний өртөгт борлуулсан барааны бүтээгдэхүүнтэй шууд холбоотой зардлууд багтдаг. Группийн үйл ажиллагааны зардалд ерөнхий ба удирдлагын, борлуулалт ба маркетингийн болон бусад бизнесийн үйл ажиллагааны зардлууд ордог.

**2.16 Зээлийн өртөг**

Шалгуурт нийцсэн хөрөнгийн олж бэлтгэх, барьж байгуулах ба үйлдвэрлэхэд шууд холбоотой хүүгийн зардлыг тэдгээр хөрөнгийн өртөгт оруулж бүртгэдэг. Шалгуурт нийцсэн хөрөнгө гэдэг нь түүнийг зориулалтаар нь ашиглах эсвэл борлуулахад бэлэн болгоход их хэмжээний хугацаа зарцуулдаг хөрөнгийг хэлэх ба уг хөрөнгийг ашиглах ба борлуулахад бэлэн болгох хүртэлх хугацаанд хүүгийн зардлыг хөрөнгийн өртөгт оруулдаг.

Зориулалт нь тодорхой зээлийг холбогдох хөрөнгийг зориулалтын дагуу ашиглаж эхлэх хүртэл эсвэл борлуулахад бэлэн болсон нь тодорхой болсон үед зээлийг ерөнхий зээлийн капиталжуулалтын түвшинг тооцох зорилгоор зээлийн ерөнхий санд байлгадаг. Тодорхой зээлийг түр хугацаагаар хөрөнгө оруулалт хийх зорилгоор олж авсан хөрөнгө оруулалтын орлого нь шаардлага хангасан хөрөнгөнд зарцуулагдах хүртэл хүлээгдэж байна.

**2. Нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогын хураангуй (үргэлжлэл)**

**2.16 Зээлийн өртөг (үргэлжлэл)**

Зээлийн хүүгийн зардлаас хасч хөрөнгийн зориулалт нь тодорхой зээлээрх түр хөрөнгө оруулалтаас олсон хөрөнгө оруулалтын орлогын зарцуулалтыг зээлийн өртгөөс хасч капиталжуулан хөрөнгийн өртөгт бүртгэнэ. Бусад бүх зээлийн хүүг тэдгээрийг гарсан жилийн ашиг, алдагдлын тайланд тусгана.

**2.17 Ажилчдын тэтгэмж**

*Ажилчдын богино хугацаат тэтгэмж*

Холбогдох үйлчилгээ үзүүлсэн үед ажилчдын богино хугацаат тэтгэмжийг зардлаар бүртгэдэг. Групп нь ажилчдынхаа үзүүлсэн үйлчилгээний үр дүнд ийнхүү төлөхөөр хуулиар хүлээсэн эсвэл үүсмэл үүрэг хүлээсэн бөгөөд холбогдох өрийн дүнг найдвартайгаар тооцоолох боломжтой бол өрийн санг бүртгэдэг.

*Улсад төлөх тэтгэвэр, тэтгэмжийн төлөвлөгөө*

Ажилчдын тэтгэвэр, тэтгэмж нь Монгол Улсын Нийгмийн Даатгалын Санд төвлөрүүлэх хуулиар тогтоосон нийгмийн даатгалын шимтгэлээс бүрдэнэ. Тодорхой шимтгэлийн дүн бүхий тэтгэвэр, тэтгэмжийн хөтөлбөрт төвлөрүүлэх шимтгэлийг түүнийг төлөх үүрэг хүлээсэн тайлант үеийн зардлаар бүртгэдэг.

**2.18 Нөөц**

Групп нь өнгөрсөн үйл явдлын улмаас хуулиар үүрэг хүлээсэн эсвэл үүсмэл үүрэг хариуцлага хүлээсэн бөгөөд энэхүү үүргийг барагдуулахад эдийн засгийн өгөөжийг зарцуулах өндөр магадлалтай бөгөөд үүрэг хариуцлагыг бодитоор хэмжих боломжтой бол нөөцийг нэгтгэсэн санхүүгийн байдлын тайланд хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

Бүртгэлд тусгагдсан нөөцийн дүн нь үүссэн өрийг төлж барагдуулахад шаардагдах мөнгөн дүнгийн хэмжээг тайлант жилийн эцсийн байдлаар тухайн өртэй холбоотой нөхцөл байдал, эрсдэлийг харгалзан тооцоолсон удирдлагын хийж чадах хамгийн сайн тооцоололд үндэслэдэг. Одоогийн үүссэн өрийг барагдуулахад хэрэгтэй тооцоолж буй мөнгөн гүйлгээнд үндэслэн нөөцийг хэмждэг ба түүний дансны дүн нь тэдгээр мөнгөн гүйлгээний өнөөгийн үнэ цэнээр тодорхойлогддог.

Нөөцийг барагдуулахад шаардлагатай эдийн засгийн өгөөжийг бүгдийг нь эсвэл заримыг нь гуравдагч тал нөхөн төлөх магадлалтай ба хэрэв нөхөн төлөх нь тодорхой болсон бөгөөд нөхөн төлбөрийн хэмжээг найдвартай хэмжих боломжтой үед түүнийг авлага хэмээн бүртгэнэ.

Нөөцийг тайлант хугацаа бүрийн эцэст дахин хянах ба тайлант хугацааны эцэст хамгийн сайн тооцооллыг тусгаж залруулдаг. Эдийн засгийн өгөөжийг шилжүүлж өр төлбөрийг барагдуулах шаардлагагүй болсон үед нөөцийг буцаана.

**2.19 Болзошгүй өр төлбөр ба хөрөнгө**

Аж ахуйн нэгжийн бүрэн хяналтаас гадуурх нэг болон түүнээс дээш ирээдүйн үйл явдал тохиолдох, эс тохиолдохоос хамаарч үүсэх эсэх нь тодорхойлогддог тул болзошгүй өр ба болзошгүй хөрөнгийг бүртгэдэггүй. Эдийн засгийн өгөөжийг агуулсан нөөцийн гадагш урсгал гарах магадлал маш бага биш л бол бүх тохиолдолд болзошгүй өр төлбөрийг нэгтгэсэн санхүүгийн тайланд нэмж тодруулна.





ГОВЬ ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
2024 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)

**2. Нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогын хураангуй (үргэлжлэл)**

**2.20 Санхүүгийн орлого болон санхүүгийн зардал**

Санхүүгийн орлогод оруулсан хөрөнгийн хүүгийн орлого орно. Хүүгийн орлогыг үр ашигтай хүүгийн аргыг ашиглан ашиг, алдагдалд хуримтлуулах хэлбэрээр хүлээн зөвшөөрдөг.

Санхүүгийн зардалд зээлийн хүүгийн зардал орно. Шаардлага хангасан хөрөнгийг худалдан авах, барих, үйлдвэрлэхтэй шууд холбоотой зээлийн зардлыг тухайн хөрөнгийн өртгийн нэг хэсэг болгон капиталжуулна. Зээлийн бусад бүх зардлыг үр ашигтай хүүгийн аргыг ашиглан ашиг, алдагдалд бүртгэнэ.

**2.21 Нэгж хувьцааны ашиг**

Групп энгийн хувьцааны хувьд нэгж хувьцаанд ногдох суурь ашгийг тооцоолдог. Группийн энгийн хувьцаа эзэмшигчдэд хамаарах цэвэр ашиг, алдагдлыг тайлант хугацааны туршид эргэлтэнд байсан энгийн хувьцааны жинлэсэн дундаж тоонд хуваах замаар нэгж хувьцаанд ногдох суурь ашгийг тооцоолдог.

Хэрэв эргэлтэнд байгаа боломжит болон энгийн хувьцааны тоо нь капиталжуулалт, олгосон бонус эсвэл хувьцаа хувааснаас өссөн, эсвэл хувьцаа хуваалтыг буцааснаас буурсан тохиолдлуудад нэгж хувьцаанд ногдох суурь болон бууруулсан ашиг нь толилуулагдсан бүх тайлант хугацааны туршид буцаан үйлчлэх зарчмаар толилуулагддаг.

**2.22 Холбоотой тал**

Групп болон Группийн толгой компани болон түүнтэй холбоотой этгээдүүдийн хооронд нөөц, ажил үйлчилгээ эсвэл үүрэг хариуцлага шилжүүлэхдээ төлбөр нэхэмжилсэн эсэхээс үл хамааран тэдгээрийн хооронд хийгдсэн ажил гүйлгээг холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээ гэнэ. Аливаа хувь хүн эсвэл түүний гэр бүлийн ойр дотны гишүүнийг дараах тохиолдолд Групптэй холбоотой гэж үзнэ:

- Группийг шууд эсвэл хамтран хянадаг;
- Группийн үйл ажиллагаанд мэдэгдэхүйц нөлөө үзүүлдэг;
- Группийн болон Группийн толгой компанийн удирдах ажилтан.

Хэрэв дараах нөхцөлийн аль нэг нь хангагдаж байвал тухайн аж ахуйн нэгжийг Групптэй холбоотой гэж үзнэ:

- Тухайн аж ахуйн нэгж болон Групп нь нэг бүлэг аж ахуйн нэгжийн бүрэлдэхүүнд багтаж байвал өөрөөр хэлбэл, толгой компани, охин компани болон нэг толгой компанид багтдаг охин компаниуд бүгд бусадтайгаа холбоотой гэсэн үг юм.
- Нэг аж ахуйн нэгж нь нөгөө аж ахуйн нэгжийн хараат эсвэл хамтарсан үйлдвэр бол эсвэл нөгөө аж ахуйн нэгжийг багтаасан бүлгийн нэг аж ахуйн нэгжийнх нь хараат эсвэл хамтарсан үйлдвэр бол;
- Хоёр компани хоёулаа нэг гуравдагч этгээдийн хамтарсан хөрөнгө оруулалттай компани бол;
- Нэг аж ахуйн нэгж нь гуравдагч аж ахуйн нэгжийн хамтарсан үйлдвэр ба харин нөгөө аж ахуйн нэгж нь уг гуравдагч аж ахуйн нэгжийн хараат компани бол;
- Тухайн аж ахуйн нэгж нь Групп эсвэл Групптэй холбоотой аж ахуйн нэгжийн аль нэгнийх нь ажилчдын тэтгэвэр тэтгэмжид зориулсан ажил эрхлэлтийн дараах тэтгэмжийн төлөвлөгөө байгаа бол
- Тухайн аж ахуйн нэгж нь дээр дурдсан холбоотой талаар тодорхойлогдсон хувь хүний шууд эсвэл хамтарсан хяналтад дор байх;
- Группийг шууд эсвэл хамтран хянадаг этгээд нь тухайн аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд их хэмжээний нөлөөтэй байх, тухайн аж ахуйн нэгжийн, эсвэл түүний толгой компанийн удирдах ажилтан.

**2. Нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогын хураангуй (үргэлжлэл)**

**2.23 Татвар**

Орлогын татварын зардал нь тухайн жилд төлөхөөр тооцсон татвар ба хойшлогдсон татварын нийлбэрээс бүрдэнэ.

**2.23.1 Тухайн жилийн орлогын албан татвар**

Тухайн жилийн татварын өглөг нь тухайн жилийн татвар ногдуулах орлогод суурилсан байна. Татвар ногдуулах орлого нь Группийн санхүүгийн тайлангаар тодорхойлсон ашгаас зөрүүтэй байдаг нь санхүүгийн тайланд тусгагдсан орлого, зарлагын зүйлсийн татвар ногдох, татвар ногдох орлогоос хасагдах хугацаа нь татварын тайлангийн зорилгоор өөр тайлант хугацаанд үүсдэг эсвэл эдгээр нь огт татвар ногдохгүй эсвэл татвар ногдох орлогоос хасагдахгүй байдагтай холбоотой. Группийн тухайн жилийн татварын өрийг тайлангийн өдрөөр хүчин төгөлдөр эсвэл хүчин төгөлдөр болох нь тодорхой татварын хувь хэмжээгээр тооцож, тодорхойлно.

**2.23.2 Хойшлогдсон татвар**

Хойшлогдсон татварыг нэгтгэсэн санхүүгийн тайлан дахь хөрөнгө, өр төлбөрийн дансны үнэ болон татвар ногдуулах орлогыг тооцоход хэрэглэсэн тэдгээрийн татварын суурь хоёрын хоорондын түр зөрүүнд тооцдог. Ерөнхийдөө бүх татвар ногдох түр зөрүүгээр хойшлогдсон татварын өрийг бүртгэдэг. Хойшлогдсон татварын хөрөнгийг бараг бүх хасагдах түр зөрүүнд тооцдог боловч ирээдүйд тэдгээр хасагдах түр зөрүүг шингээхэд хүрэлцэхүйц татвар ногдуулах ашигтай байх өндөр магадлалтай эсэхийг харгалздаг. Эдгээр хойшлогдсон татварын хөрөнгө ба өр төлбөрийг гүүдвилл болон татварын ногдуулах орлого ба санхүүгийн ашгийн аль алинд нь нөлөөлдөггүй ажил гүйлгээ (бизнесийн нэгдлээс бусад)-ний үед бусад хөрөнгө ба өр төлбөрийг анх бүртгэхэд үүссэн түр зөрүүгээр бүртгэдэггүй.

Групп түр зөрүүг өөрчлөх хугацаанд хяналт тавих боломжтой байх, мөн түр зөрүү нь ойрын ирээдүйн тайлант үед өөрчлөгдөхгүй гэсэн магадлалтай байхаас бусад тохиолдолд охин, салбар болон хараат компани дахь хөрөнгө оруулалт болон хамтарсан компани дахь хувь оролцоотой холбоотой татвар ногдох бүх түр зөрүүний хувьд хойшлогдсон татварын өр төлбөрийг хүлээн зөвшөөрөх ёстой. Түр зөрүүг ойрын ирээдүйн тайлант үед өөрчлөх магадлалтай бөгөөд татвар ногдох ашиг нь түр зөрүүгийн эсрэг ашиглагдахуйц үед охин эсвэл хараат компанид оруулсан хөрөнгө оруулалтаас үүсэх бүхий л татвар ногдох орлогоос хасагдах түр зөрүүг Групп хойшлогдсон татварын хөрөнгөөр хүлээн зөвшөөрдөг.

Хойшлогдсон татварын хөрөнгийн дансны үнийг тайлант хугацааны эцэст дахин хянаж үздэг ба хойшлогдсон татварын хөрөнгийн бүх эсвэл зарим өгөөжийг хүртэх хангалттай хэмжээний татвар ногдох ашиг олох магадлал үгүй болох үед хойшлогдсон татварын хөрөнгийн дансны үнийг бууруулдаг.

Тайлант үеийн эцсээр хүчин төгөлдөр болсон, эсвэл хүчин төгөлдөр мөрдөж байгаа татварын хувь хэмжээ (татварын хууль)-нд үндэслэн хөрөнгө нь хэрэгжих буюу өр төлбөрийг төлөх тайлант үед мөрдөгдөхөөр хүлээгдэж буй татварын хувь хэмжээгээр хойшлогдсон татварын хөрөнгө болон өр төлбөрийг хэмждэг. Тайлант үеийн эцэст Групп нь хойшлогдсон татварын өр төлбөр болон хойшлогдсон татварын хөрөнгийн дансны үнийг нөхөх буюу барагдуулах арга хэлбэрээс үүсэж байгаа татварын үр нөлөөг хойшлогдсон татварын өр төлбөр болон хойшлогдсон татварын хөрөнгийн хэмжилтэнд тусгадаг.

Тайлант үеийн татварын өр төлбөрийг тайлант үеийн татварын хөрөнгөөр суутган тооцох хууль ёсны хүчин төгөлдөр эрхтэй, орлогын татвараар тооцоо хийдэг ижил татварын албатай харьцдаг ба тайлант үеийн татварын өр төлбөр болон хөрөнгийг цэвэр сууриар барагдуулахаар төлөвлөсөн тохиолдолд хойшлогдсон татварын өр төлбөр болон хөрөнгийг цэвэр дүнгээр тооцдог.

Нэгтгэсэн санхүүгийн тайланг стандартын дагуу бэлтгэх нь тайлангийн өдрийн тайлагнасан хөрөнгө, өр төлбөрийн дүн болон тайлант хугацааны орлого, зардлын тайлагнасан дүнгүүдэд нөлөөлөхүйц дүгнэлт, тооцоолол, таамаглал хийхийг удирдлагаас шаарддаг. Эдгээр тооцоог хийхдээ тодорхой бус байдлын улмаас ирээдүйн тайлант үеийн бодит үр дүнг эдгээр тооцооллоос зөрүүтэй дүн дээр үндэслэн гаргаж болно.



ГОВЬ ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
2024 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)

**2. Нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогын хураангуй (үргэлжлэл)**

**2.23 Татвар (үргэлжлэл)**

**2.23.2 Хойшлогдсон татвар (үргэлжлэл)**

Тооцоолол болон үндсэн таамаглалыг байнга хянаж байдаг. Нягтлан бодох бүртгэлийн тооцоололд хийсэн засварыг тооцооллыг засварласан тайлант үе болон цаашид нөлөөлсөн аливаа хугацаанд хүлээн зөвшөөрнө.

**2.23.3 Тухайн жилийн болон хойшлогдсон татвар**

Тайлант хугацааны болон хойшлогдсон татварыг бусад дэлгэрэнгүй орлогод эсвэл шууд өмчид хүлээн зөвшөөрсөн зүйлд хамаарахаас бусад тохиолдолд ашиг, алдагдалд бүртгэнэ. Энэ тохиолдолд тайлант хугацааны болон хойшлогдсон татварыг бусад дэлгэрэнгүй орлогод эсвэл шууд өмчид тус тус бүртгэнэ. Бизнесийн нэгдлийн анхдагч бүртгэлээс одоогийн татвар эсвэл хойшлогдсон татвар үүссэн тохиолдолд татварын үр нөлөөг бизнесийн нэгдлийн нягтлан бодох бүртгэлд оруулна.

**2.24 Сегментийн мэдээлэл**

Үйл ажиллагааны сегмент нь Группийн эрхэлж буй бизнесийн үйл ажиллагаатай холбоотойгоор орлого олж, зардал гаргадаг Группийн нэг бүрэлдэхүүн хэсэг юм. Үүнд, бусад бүрэлдэхүүн хэсгүүдтэй хийсэн ажил гүйлгээтэй холбоотой орлого болон зардал орно. Группийн гол үйл ажиллагааны шийдвэр гаргагчид сегментүүдийн гүйцэтгэлийг үнэлэх болон нөөцийг хэрхэн хуваарилах шийдвэр гаргахын тулд сегментүүдийн үйл ажиллагааны үр дүнг байнга хянаж байдаг бөгөөд сегмент бүрийн санхүүгийн мэдээллийг гаргадаг.

**2.25 Засгийн газрын буцалтгүй тусламж**

Засгийн газрын буцалтгүй тусламж гэдэг нь Группийн үйл ажиллагаатай холбоотой өнгөрсөн болон ирээдүйн тодорхой нөхцөлүүдийг хангасан нөхцөлд засгийн газрын байгууллагаас Групп руу нөөцийг шилжүүлэх явдал юм (тухайлбал, засгийн газрын татаас). Групп зардлаас чөлөөлөх хэлбэрээр авсан тусламжийг засгийн газрын буцалтгүй тусламжаар хүлээн хүлээн зөвшөөрсөн. Тухайлбал, Засгийн газрын татаасаар бага хүүтэй авсан зээлийг засгийн газрын буцалтгүй тусламжаар бүртгэсэн. Групп буцалтгүй тусламжаар нөхөхөөр төлөвлөж буй зардлыг зардал болгон хүлээн зөвшөөрдөг тул ийм тусламжийг системчилсэн байдлаар ашиг, алдагдалд бүртгэдэг.

Зах зээлийн хүүгээс доогуур хүүтэй зээлийг СТОУС 9-ийн дагуу анх хүлээн зөвшөөрч, дараа нь хэмждэг. СТОУС 9 нь зах зээлийн ханшаас доогуур хүүтэй зээлийг бодит үнэ цэнээр хэмжихийг шаарддаг. Өөрөөр хэлбэл, зах зээлтэй холбоотой хүүгээр хямдруулсан ирээдүйн хүлээгдэж буй мөнгөн гүйлгээний өнөөгийн үнэ цэнээр бүртгэхийг шаарддаг. Засгийн газрын буцалтгүй тусламжийг анх хүлээн зөвшөөрөх үеийн зээлийн бодит үнэ цэнэ ба хүлээн авсан дүнгийн зөрүүгээр хэмжигдэх ба буцалтгүй тусламжийн шинж чанараас хамааран бүртгэнэ.

**3. Нягтлан бодох бүртгэлийн үнэлэмж ба тодорхой бус байдал дахь таамаглал, тооцооллын үндсэн эх сурвалж**

Нэгтгэсэн санхүүгийн тайланг СТОУС Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартуудад нийцүүлэн бэлтгэх үйл явц нь таамаглал тооцоолол, үнэлэмж хэрэглэхийг удирдлагаас шаарддаг ба энэхүү таамаглал, тооцоолол, үнэлэмж нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын хэрэгжилт, нэгтгэсэн санхүүгийн тайлангийн өдрөөр тайлагнагдсан хөрөнгө, өр төлбөрийн дүн, болзошгүй хөрөнгө, өр төлбөрийн тодруулга болон тайлант үед хүлээн зөвшөөрөгдсөн орлого, зардлын дүнд тус тус нөлөөлдөг. Ирээдүйд гарах бодит үр дүн нь эдгээр тооцооллоос зөрүүтэй байж болно.

Тооцоолол, түүнийг хийхэд хэрэглэсэн таамаглал, төсөөллийг байнга хянадаг. Нягтлан бодох бүртгэлийн тооцоололд хийсэн өөрчлөлтийг өөрчлөлт хийгдсэн тайлант үе болон ирээдүйн тайлант үеүдэд тус тус тусгадаг.

**3.1 Нягтлан бодох бүртгэлийн үнэлэмж**

**3.1.1 Газрын эрхийн ашиглалтын жил ба элэгдэл**

Групп нь Монгол Улсад орших газрыг 15-аас 60 жилээр түрээсэлдэг.

Монгол Улсын Газрын тухай хууль нь Монгол Улсын аж ахуйн нэгжүүдэд газрын эрх эзэмших эрх зүйн үндсийг тогтоосон.

Групп газрыг гэрээний дагуу олж эзэмшсэн төлбөрөөр нь анх бүртгэлд тусгадаг. Групп өнгөрсөн жилүүдэд газар эзэмших эрхийн хугацааг маш бага хэмжээний жил тутмын төлбөр төлж амжилттай сунгуулсан. Группийн удирдлага газар эзэмших эрхийн хугацааг бага хэмжээний төлбөр төлж, цаашид тодорхойгүй хугацаагаар эзэмшинэ гэдэгт итгэлтэй байна. Газрыг өртгөөс хуримтлагдсан үнэ цэнийн бууралтыг хассан дүнгээр хэмждэг.

**3.1.2 Монгол Улсын татварын систем**

Зах зээлийн эдийн засагт шилжих шилжилттэй холбоотойгоор Монголын Засгийн Газар бизнес болон эдийн засгийн бүтцэд өөрчлөлт шинэчлэлтийг хийсээр байна. Үүний үр дүнд бизнесийн үйл ажиллагаанд нөлөө үзүүлэх хууль журмууд ч мөн өөрчлөгдсөөр байна.

Өөр өөр эрх бүхий байгууллагууд татварын хуулийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийж төлбөр торгууль тавих хуулиар тогтоосон эрхтэй байдаг. Групп татварын хууль тогтоомжийн ойлголт дээрээ үндэслэн бүх татваруудыг үнэн зөв тодорхойлсон гэж итгэж байгаа боловч дээр дурдсан хүчин зүйлүүдээс үндэслэн Группд татварын эрсдэл байсаар байна.

**3.1.3 Хувьсах дүнг тооцоолох болон хязгаарлалтыг үнэлэх аргыг тодорхойлох нь**

Бараа бүтээгдэхүүн борлуулах зарим гэрээнүүдэд буцаах нөхцөл бүхий хувьсах хүчин зүйлийг агуулсан байдаг. Групп нь буцаан олгоно гэж буй таамаглаж буй дүнг тооцоход тохирох аргад үндэслэн хүлээгдэж буй үнэ цэнийн арга болон хамгийн боломжит дүнгийн аргыг ашиглан тооцоолдог.

Групп нь адил төстэй олон тооны хэрэглэгчийн гэрээнүүдийн хувьд буцаагдах эрх бүхий бараануудын хувьсах төлбөрийг тооцоолоход хүлээгдэж буй үнэ цэнийн арга нь тохиромжтой арга гэж үзсэн.

Гүйлгээний үнэ дэх хувьсах хэмжигдэхүүнийг оруулахын өмнө Групп нь хувьсах төлбөрийн дүн хязгаарлагдаж байгаа эсэхийг авч үздэг. Групп нь хувьсах зардлын тооцооллыг Группийн түүхэн туршлага, бизнесийн таамаглал, одоогийн эдийн засгийн нөхцөл байдалд тулгуурлан хязгаарлаагүй болохыг тогтоосон. Үүнээс гадна хувьсах төлбөрийн тодорхойгүй байдлыг богино хугацаанд шийдвэрлэдэг.

2024 онд борлуулалтын орлого нь 11,360,745 мянган төгрөгийн буцаалт, хөнгөлөлтийг хассаны дараа 247,026,317 мянган төгрөг (2023 онд борлуулалтын орлого нь 17,310,811 мянган төгрөгийн буцаалтыг хассаны дараа 255,650,516 мянган төгрөг) байсан.







**3. Нягтлан бодох бүртгэлийн үнэлэмж ба тодорхой бус байдал дахь таамаглал, тооцооллын үндсэн эх сурвалж (үргэлжлэл)**

**3.2 Тодорхой бус байдал дахь таамаглал, тооцооллын үндсэн эх сурвалж**

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн их хэмжээний дүн бүхий үзүүлэлтүүдэд дараах таамаглал төсөөллийг ашиглан, нэгтгэсэн санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрсөн.

**3.2.1 Алдагдлын нөөц сангийн тооцоолол**

Групп дансны авлагын хүлээгдэж буй алдагдлыг тооцоолохдоо харилцагч тус бүрийн бие даасан нөхцөл байдлын үнэлгээ, эдийн засгийн нөхцөл байдал болон салбарын нөхцөл байдал зэрэгт тулгуурлан тооцоолсон.

Энэ тохиолдолд удирдлагын үнэлгээ нь харилцагч талын нөхцөл байдал, харилцаа холбоо, түүний талаарх тодорхой байгаа зах зээлийн мэдээлэл болон зээлийн талаарх мэдээ тайлан зэрэг дээр үндэслэн хийгддэг. Групп нь цуглуулагдахаар хүлээгдэж буй дүнг илэрхийлэх үүднээс хасагдуулгыг удирдлагын үнэлгээний дагуу тооцоолдог. Энэхүү тусгайлсан хасагдуулгын тооцоолсон дүнд нөлөөлөхүйц аливаа өөрчлөлт гарвал түүнийг дахин тооцон үзэж тохируулдаг.

Үнэлгээ болон тооцоолол хийсэн аргачлалаас хамааран бүртгэсэн зардлын дүн болон хугацааны хувьд нөөц сангууд ялгаатай байж болно. Найдваргүй авлагын нөөц сан өсвөл үйл ажиллагааны зардал өсөх ба эргэлтийн хөрөнгө буурах нөлөөтэй.

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх Группийн дансны ба бусад авлагын дансны үнэ нь 9,404,878 мянган төгрөг, авлагын нөөц сангийн үлдэгдэл 1,761,809 мянган төгрөг (2023 онд: дансны ба бусад авлагын дансны үнэ нь 8,030,908 мянган төгрөг, авлагын нөөц сангийн үлдэгдэл 1,761,809 мянган төгрөг) байсан.

**3.2.2 Удаан гүйлгээтэй бараа материалын хасагдуулгын нөөц**

Группийн удирдлага удаан гүйлгээтэй, зарагддаггүй болон эвдэрч гэмтсэн бараа материалыг тодорхой хугацаагаар хянадаг ба үнэлэмж болон тооцооллыг ашигладаг. Тооцоолол болон холбогдох төсөөллүүд нь түүхэн туршлага дээр үндэслэдэг ба бодит үр дүн нь тооцооллоос зөрүүтэй байж болно.

Группийн нягтлан бодох бүртгэлийн бодлого нь бараа материалыг үйлдвэрлэж дуусгаснаас хойш борлуулаагүй бол хугацаа, насжилт болон бараа материалын зэрэглэлээс хамаарч ангилалын дагуу хасагдуулга байгуулна.

Удирдлага дээрх бараа материалын үнэлгээг тодорхойлоход хэрэглэсэн төсөөлөл болон үнэлэмж зохистой буюу тохиромжтой гэдэгт итгэж байна.

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх бараа материалын дансны үнэ нь 122,708,175 мянган төгрөг, бараа материалын хасагдуулгын үлдэгдэл нь 2,387,704 мянган төгрөг (2023 онд бараа материалын дансны үнэ нь 142,521,277 мянган төгрөг, бараа материалын хасагдуулгын үлдэгдэл нь 2,190,587 мянган төгрөг) байсан.

**3.2.3 Бараа материалын цэвэр боломжит үнэ цэнийг тооцоолох**

Цэвэр боломжит үнэ цэнэ гэж бизнесийн хэвийн үйл ажиллагааны явцад бараа материалыг худалдан борлуулахаар тооцоолж буй үнээс түүнийг борлуулахад шаардагдах тооцсон зардлыг хассан дүн юм. Гэмтэлтэй, хоцрогдсон болон удаан хугацаанд хөдөлгөөнд ороогүй бараа материал байгаа эсэхийг удирдлагын зүгээс тогтмол хянадаг.

Групп өөрийн тооцооллыг үнэн зөв, бодитой гэж үзэж байгаа боловч аливаа бодит нөхцөл байдал эсвэл нөлөө бүхий хүчин зүйлсээс шалтгаалан тооцоололд өөрчлөлт орсон тохиолдолд ашиг, алдагдал болон өмчид материаллагаар нөлөө үүсч болзошгүй.

**3. Нягтлан бодох бүртгэлийн үнэлэмж ба тодорхой бус байдал дахь таамаглал, тооцооллын үндсэн эх сурвалж (үргэлжлэл)**

**3.2.4 Үндсэн хөрөнгийн ашиглалтын жил**

Тодруулга 2.6-д тайлбарласнаар, Групп үндсэн хөрөнгийн ашиглалтын жилийн тооцооллыг нэгтгэсэн санхүүгийн тайлангийн өдрөөр хянадаг ба тооцооллыг өөрчлөх шаардлагатай бол залруулдаг. Тайлант жилийн эцэст үндсэн хөрөнгийн ашиглалтын жилийн тооцоололд өөрчлөлт гараагүй. Үндсэн хөрөнгийн ашиглалтын жилийг тооцоолоход үнэлэмж ашигладаг ба уг тооцоолол нь тайлант жилийн цэвэр ашигт нөлөө үзүүлэх боломжтой. Удирдлага дээрх тооцоолсон үндсэн хөрөнгийн ашиглалтын жил уг хөрөнгийн бодитой эдийн засгийн ашиглах жил гэдэгт итгэж байна.

**3.2.5 Барилга бодит үнэ цэнийн хэмжилт**

Барилга нь санхүүгийн тайлагналын зорилгоор бодит үнэ цэнээр хэмжигдсэн. Групп хөрөнгийн бодит үнэ цэнийг тооцоолохдоо ажиглаж болох зах зээлийн үнийн мэдээллийг ашигладаг. Идэвхтэй зах зээлийн үнэ цэнийн мэдээлэл (1-р түвшин) тодорхойгүй бол Групп хараат бус мэргэжлийн үнэлгээчнээр хөрөнгийн үнэлгээг тооцоолуулдаг. Эдгээр тооцооллоос хамаарч барилгын үнэлгээ өөрчлөгдөх боломжтой.

Барилгын бодит үнэ цэнийг тооцоолоход ашигласан мэдээлэл болон үнэлгээний аргачлалын талаар тодруулга 9.2-г харна уу.

**3.2.6 Хойшлогдсон орлогын албан татвар**

Групп нь аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг тооцоолохдоо Монгол Улсын хуулиар тогтоосон татварын хувь хэмжээ, татвараас хасагдахгүй зардлууд, татварын хуульд орсон өөрчлөлтүүд болон удирдлагын хүлээж буй ирээдүйн үр дүн зэргийг харгалзаж үздэг. Хойшлогдсон орлогын албан татварыг түр зөрүүн дээр суурилан тооцоолдог ба энэ нь санхүүгийн тайланд тайлагнасан орлого, зардал болон татварын хуулийн дагуу тодорхойлсон татвар ногдох орлого, зардлын хоорондох зөрүү юм. Эдгээр түр зөрүүнээс үүссэн татварын нөлөөллийг нэгтгэсэн санхүүгийн тайланд хойшлогдсон татварын хөрөнгө эсвэл өр төлбөрөөр тусгадаг.

Группийн удирдлага нь хойшлогдсон татварын хөрөнгө хэрэгжихгүй гэж үзэж байгаа тохиолдолд хойшлогдсон татварын хөрөнгийг хүлээн зөвшөөрдөггүй. Бодит үр дүн нь энэ таамаглалаас зөрүүтэй байх тохиолдолд ирээдүйн тайлант үеүдэд уг таамаглалын залруулга хийх ба тайлант жилийн санхүүгийн байдал болон орлогод материаллаг нөлөө үзүүлэхүйц өөрчлөлтийг хүлээн зөвшөөрч хойшлогдсон татварын хөрөнгөөр бүртгэх шаардлага тулгарч болно.

Групп 2024 болон 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдлын тайланд нийт 5,661,214 мянган төгрөг болон 9,276,559 мянган төгрөгийн хойшлогдсон татварын хөрөнгө хүлээн зөвшөөрсөн.

Групп 2024 болон 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдлын тайланд нийт 13,939,844 мянган төгрөг болон 7,883,775 мянган төгрөгийн хойшлогдсон татварын өр төлбөр хүлээн зөвшөөрсөн. Тодруулга 2.23 болон 23.3-г харна уу.



ГОВЬ ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
2024 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)

**4. 2024 онд хэрэгжиж эхэлсэн нягтлан бодох бүртгэлийн шинэ стандартууд, нэмэлт өөрчлөлтүүд болон цаашид тавигдах шаардлагууд**

**4.1 СТОУС Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартуудад орсон тайлант жилд заавал хэрэгжиж эхэлсэн шинэ стандартууд болон нэмэлт өөрчлөлтүүд**

Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (“НББОУСЗ”)-өөс гаргасан 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр болон тухайн өдрөөс хойш хэрэгжиж эхэлсэн СТОУС Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартуудад орсон шинэ стандартууд болон нэмэлт өөрчлөлтүүдийг Групп тайлант жилд хэрэгжүүлсэн.

| Хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн огноо | Нягтлан бодох бүртгэлийн шинэ стандартууд болон нэмэлт өөрчлөлтүүд |
|---|---|
| 2024 оны 01 сарын 01 | • Шалгуур үзүүлэлт бүхий эргэлтийн бус өр төлбөр – НББОУС 1-ийн нэмэлт өөрчлөлтүүд<br>• Эргэлтийн ба эргэлтийн бус өр төлбөрийн ангилал – НББОУС 1-ийн нэмэлт өөрчлөлтүүд<br>• Борлуулаад буцаан түрээслэх ажил гүйлгээний түрээсийн өр төлбөр – СТОУС 16-ийн нэмэлт өөрчлөлтүүд<br>• Бэлтгэн нийлүүлэгчийн санхүүжилтийн тохиролцоо – НББОУС 7 болон СТОУС 7-ийн нэмэлт өөрчлөлтүүд |

Шалгуур үзүүлэлт бүхий эргэлтийн бус өр төлбөр – НББОУС 1-ийн нэмэлт өөрчлөлтүүдөөс бусдаар тайлант жилд хэрэгжүүлсэн СТОУС Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартуудад орсон шинэ стандартууд болон нэмэлт өөрчлөлтүүд нь тайлант жилийн Группийн санхүүгийн байдал болон гүйцэтгэл, тэдгээр санхүүгийн тайлангийн тодруулгуудад материаллаг нөлөө үзүүлээгүй болно. Шалгуур үзүүлэлт бүхий эргэлтийн бус өр төлбөрийн нөлөөг Тодруулга 15-аас харна уу.

**4.2 Батлагдсан боловч хэрэгжиж эхлээгүй СТОУС Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартуудад орсон шинэ стандартууд болон нэмэлт өөрчлөлтүүд**

Нягтлан бодох бүртгэлийн хэд хэдэн шинэ стандартууд нь 2024 оны 01 дүгээр сарын 01-ээс хойших тайлант жилүүдэд хэрэгжиж эхлэх бөгөөд мөрдөгдөж эхлэх хугацаанаас нь өмнө хэрэгжүүлэхийг зөвшөөрсөн. Гэхдээ Групп санхүүгийн тайланг бэлтгэхдээ дараах шинэ эсвэл нэмэлт өөрчлөлт орсон стандартуудыг хэрэгжүүлж эхлээгүй байна.

| Хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэх огноо | Нягтлан бодох бүртгэлийн шинэ стандартууд болон нэмэлт өөрчлөлтүүд |
|---|---|
| 2025 оны 01 сарын 01 | • Арилжаалагдах боломж бага – НББОУС 21-ийн нэмэлт өөрчлөлтүүд |
| 2026 оны 01 сарын 01 | • Санхүүгийн хэрэглүүрийн ангилал ба хэмжилт – СТОУС 9 болон СТОУС 7-ийн нэмэлт өөрчлөлтүүд<br>• СТОУС Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартуудын жил бүрийн сайжруулалт – 11-р хэвлэл |
| 2027 оны 01 сарын 01 | • СТОУС 18 Санхүүгийн тайлангийн толилуулга ба тодруулга<br>• СТОУС 19 Олон нийтийн үүрэг хариуцлага хүлээгээгүй охин компаниуд: Тодруулга |
| Сонголттойгоор мөрдөх боломжтой / мөрдөх хугацааг тодорхойгүйгээр хойшлуулсан | • Хөрөнгө оруулагч болон түүний хараат эсвэл хамтарсан компани хоорондын борлуулалт болон хувь оруулсан хөрөнгө – СТОУС 10 болон НББОУС 28-ын нэмэлт өөрчлөлтүүд |

Групп СТОУС 18 *Санхүүгийн тайлангийн толилуулга ба тодруулга* стандартаас бусдаар дээрх шинэ стандартууд болон нэмэлт өөрчлөлтүүд нь Группийн нэгтгэсэн санхүүгийн тайланд материаллаг нөлөө үзүүлэхгүй гэсэн хүлээлттэй байна.

**4. 2024 онд хэрэгжиж эхэлсэн нягтлан бодох бүртгэлийн шинэ стандартууд, нэмэлт өөрчлөлтүүд болон цаашид тавигдах шаардлагууд (үргэлжлэл)**

**4.2 Батлагдсан боловч хэрэгжиж эхлээгүй СТОУС Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартуудад орсон шинэ стандартууд болон нэмэлт өөрчлөлтүүд (үргэлжлэл)**

**СТОУС 18 Санхүүгийн Тайлангийн Толилуулга ба Тодруулга**

2027 оны 01 дүгээр сарын 01-ээс эхлэх болон түүнээс хойших тайлант жилүүдэд СТОУС 18 нь НББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга стандартыг орлоно. Шинэ стандартаар дараах үндсэн шинэ шаардлагуудыг танилцуулсан.

- Компаниуд бүх орлого, зардлыг ашиг, алдагдлын тайланд үйл ажиллагаа, хөрөнгө оруулалт, санхүүжилт, зогсоосон үйл ажиллагаа болон орлогын татвар гэсэн таван үндсэн төрөлд ангилах шаардлагатай. Компаниуд мөн шинээр тодорхойлсон үйл ажиллагааны ашгийн дүнг толилуулах шаардлагатай болсон. Компанийн цэвэр ашгийн дүн өөрчлөгдөхгүй.
- Удирдлагын тодорхойлсон гүйцэтгэлийн хэмжүүр (“УТГХ”) нь санхүүгийн тайланд тусдаа тодруулгаар толилуулагдана.
- Санхүүгийн тайланд мэдээллийг хэрхэн бүлэглэх талаар дэлгэрэнгүй удирдамж гарсан.

Түүнээс гадна, үйл ажиллагааны мөнгөн гүйлгээг шууд бус аргаар толилуулж байгаа тохиолдолд компаниуд мөнгөн гүйлгээний тайланг үйл ажиллагааны ашгийн дүнгээс эхлэх шаардлагатай.

Групп шинэ стандартын, ялангуяа Группийн ашиг, алдагдлын тайлан, мөнгөн гүйлгээний тайлангийн бүтэц болон УТГХ-ээр шаардсан нэмэлт тодруулгын нөлөөг үнэлэх шатандаа явж байна. Мөн Групп санхүүгийн тайлангийн мэдээллийг хэрхэн цаашид бүлэглэх, тэр дундаа одоогоор 'бусад' гэж тэмдэглэсэн зүйлсүүдэд үзүүлэх нөлөөллийг үнэлж байна.







**5. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө**

| | 2024 | 2023 |
|---|---|---|
| Касс дахь бэлэн мөнгө | 42,827 | 31,550 |
| Банк дахь харилцах данс | 4,283,219 | 9,459,561 |
| | **4,326,046** | **9,491,111** |

Групп мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийг зээлийн эрсдэл багатай гэж үнэлсэн.

**6. Дансны ба бусад авлага**

| | 2024 | 2023 |
|---|---|---|
| Дансны авлага | 7,743,698 | 7,553,053 |
| Үнэ цэнийн бууралтын сан | (1,640,363) | (1,640,363) |
| | **6,103,335** | **5,912,690** |
| Холбоотой талаас авах авлага (Тодруулга 28.2) | 70,162 | 129,632 |
| Бусад авлага (Тодруулга 6.2) | 3,352,827 | 2,110,032 |
| Үнэ цэнийн бууралтын сан | (121,446) | (121,446) |
| | **9,404,878** | **8,030,908** |

**6.1 Дансны авлага**

Группийн зээлийн борлуулалтын урьдчилан батлагдсан зээлийн хязгаарт багтаан төлөгдөх дундаж хугацаа 30-90 хоног байна. Аливаа шинэ харилцагчийг хүлээн зөвшөөрөхөөс өмнө Группийн удирдлага харилцагчийн зээлийн эрсдэлийн чанарыг үнэлэн зээлийн хязгаарыг харилцагч тус бүрийн хувьд тодорхойлдог.

Групп дансны авлагын хүлээгдэж буй алдагдлыг тооцоолохдоо харилцагч тус бүрийн бие даасан нөхцөл байдлын үнэлгээ, эдийн засгийн нөхцөл байдал болон салбарын нөхцөл байдал зэрэгт тулгуурлан тооцоолсон.

Эдгээр тохиолдолд тухайн харилцагчдын авлагын үлдэгдэл, хамтын ажиллагааны түүх болон зах зээлийн мэдэгдэж буй хүчин зүйлс дээр үндэслэсэн эсрэг талын одоогийн санхүүгийн байдал, боломжит хамгийн сайн баримт, нөхцөлийг үнэлэн дүгнэлт хийсэн. Групп нь харилцагч бүрд хүлээгдэж буй эргэн төлөгдөх дүнг бууруулсантай холбоотойгоор тусгайлан нөөцийг бүртгэсэн. Энэхүү тусгайлсан хасагдуулгын тооцоолсон дүнд нөлөөлөхүйц аливаа өөрчлөлт гарвал түүнийг дахин тооцон үзэж тохируулдаг.

Групп нь харилцагч санхүүгийн хүнд байдалд орсон тухай мэдээлэл хүлээн авсан, авлагын эргэн төлөгдөх бодитой төлөв байхгүй үед, өөрөөр хэлбэл, эдгээр тохиолдолын аль нэг нь үүссэн буюу хариуцагч татан буугдсан, дампуурлын үе шатанд орсон, эсвэл борлуулалтын авлага нь арваас дээш жилийн насжилттай болсон тохиолдолд борлуулалтын авлагын данснаас хасдаг. Хууль сахиулах байгууллагын шийдвэрээр данснаас хассан авлага байхгүй.

Группийн түүхэн зээлийн алдагдал нь харилцагчийн сегмент бүрийн хувьд эрс ялгаатай хэв шинжийг харуулдаггүй тул өнгөрсөн үеийн төлөв байдалд суурилсан алдагдлын санг Группийн харилцагчийн сегментээр ялгаж харуулаагүй болно.

**6.2 Бусад авлага**

| | 2024 | 2023 |
|---|---|---|
| НӨАТ авлага | 1,236,901 | 1,272,263 |
| Ажилчдаас авах авлага | 1,085,306 | 432,179 |
| Бусад | 1,030,620 | 405,590 |
| | **3,352,827** | **2,110,032** |

**ГОВЬ ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД**
**2024 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН**
**НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД**
**(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

## 7. Урьдчилгаа төлбөр

| | 2024 | 2023 |
|---|---|---|
| Бэлтгэн нийлүүлэгчдэд төлсөн урьдчилгаа | 2,114,485 | 1,288,446 |
| Урьдчилж төлсөн зардал | 1,397,819 | 1,885,234 |
| | **3,512,304** | **3,173,680** |

## 8. Бараа материал

| | 2024 | 2023 |
|---|---|---|
| Түүхий эд материал | 31,346,563 | 35,591,584 |
| Дуусаагүй үйлдвэрлэл | 11,993,582 | 20,703,068 |
| Бэлэн бүтээгдэхүүн | 69,897,920 | 74,816,715 |
| Хангамжийн материал | 11,843,122 | 13,207,219 |
| Замд яваа бараа | 14,692 | 393,278 |
| | **125,095,879** | **144,711,864** |
| Бараа материалын үнэ цэнийн бууралтын хасалдуулга | (2,387,704) | (2,190,587) |
| | **122,708,175** | **142,521,277** |

Түүхий эд материалд түүхий ноолуур, самнасан ноолуур, ноолууран утас, даавуу болон драп багтсан. 2024 онд бараа материалаас борлуулсан бүтээгдэхүүний өртөг 132.4 тэрбум төгрөг (2023 онд 121.4 тэрбум төгрөг) бүртгэсэн.

*Бараа материалын үнэ цэнийн бууралтын хасагдуулгын хөдөлгөөн*:

| | 2024 | 2023 |
|---|---|---|
| Эхний үлдэгдэл | 2,190,587 | 2,357,493 |
| Тайлант жилд байгуулсан үнэ цэнийн бууралтын хасагдуулга (Тодруулга 24.5) | 362,506 | 594,422 |
| Үнэ цэнийн бууралтын буцаалт (Тодруулга 24.5) | (165,389) | (761,328) |
| Эцсийн үлдэгдэл | **2,387,704** | **2,190,587** |

2024 онд нийт 157.0 тэрбум төгрөг (2023 онд 138 тэрбум төгрөг)-ийн бараа материалыг банкны зээлд барьцаалсан (Тодруулга 15.1).



**ГОВЬ ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД**
**2024 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН**
**НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД**
**(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

## 9. Үндсэн хөрөнгө

| | Газар (Дахин тайлагнасан) | Барилга (Дахин тайлагнасан) | Тоног төхөөрөмж (Дахин тайлагнасан) | Тавилга, эд хогшил | Тээврийн хэрэгсэл | Дуусаагүй барилга | Түрээсийн сайжруулалт | Нийт |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| ***Өртөг эсвэл дахин үнэлэгдсэн дүн:*** | | | | | | | | |
| **2023 оны 01 дүгээр сарын 01** | **464,442** | **75,129,464** | **113,474,665** | **6,194,637** | **2,178,921** | **18,371** | **622,574** | **198,083,074** |
| Нэмэгдсэн | 138,178 | 1,289,639 | 408,471 | 1,602,039 | 187,493 | 240,679 | 776,254 | 4,642,753 |
| Хасагдсан | (22,727) | (1,297,944) | (105,994) | (514,521) | - | - | - | (1,941,186) |
| Үндсэн хөрөнгө хооронд шилжсэн | - | 18,368 | (10,706) | 10,706 | - | (18,368) | - | - |
| **2023 оны 12 дугаар сарын 31** | **579,893** | **75,139,527** | **113,766,436** | **7,292,861** | **2,366,414** | **240,682** | **1,398,828** | **200,784,641** |
| Нэмэгдсэн | - | 2,631,793 | 9,817,327 | 1,644,140 | 140,000 | 973,399 | - | 15,206,659 |
| *Хөрөнгийн дахин үнэлгээ* | | | | | | | | |
| - Нийт дансны үнээс цэвэрлэсэн | - | (9,980,649) | - | - | - | - | - | (9,980,649) |
| - Дахин үнэлгээний нэмэгдэл | - | 32,341,972 | - | - | - | - | - | 32,341,972 |
| Хасагдсан | - | - | (218,234) | (652,891) | (231,728) | - | (45,998) | (1,148,851) |
| Үндсэн хөрөнгө хооронд шилжсэн | - | 155,492 | 70,986 | 14,201 | - | (240,679) | - | - |
| Ханшийн хөрвүүлэлтийн нөлөө | - | - | 52 | (72,366) | (5,566) | - | - | (77,880) |
| **2024 оны 12 дугаар сарын 31** | **579,893** | **100,288,135** | **123,436,567** | **8,225,945** | **2,269,120** | **973,402** | **1,352,830** | **237,125,892** |
| ***Хуримтлагдсан элэгдэл:*** | | | | | | | | |
| **2023 оны 01 дүгээр сарын 01** | **-** | **5,382,231** | **66,932,611** | **4,172,977** | **1,072,543** | **-** | **608,310** | **78,168,672** |
| Байгуулсан элэгдэл | - | 2,556,768 | 7,720,968 | 950,466 | 204,333 | - | 27,292 | 11,459,827 |
| Хасагдсан элэгдэл | - | (34,896) | (81,719) | (458,363) | - | - | - | (574,978) |
| Үндсэн хөрөнгө хооронд шилжсэн | - | - | (12,129) | 12,129 | - | - | - | - |
| **2023 оны 12 дугаар сарын 31** | **-** | **7,904,103** | **74,559,731** | **4,677,209** | **1,276,876** | **-** | **635,602** | **89,053,521** |
| Байгуулсан элэгдэл | - | 2,655,334 | 8,322,758 | 1,390,168 | 209,241 | - | 158,155 | 12,735,656 |
| *Хөрөнгийн дахин үнэлгээ* | | | | | | | | |
| - Нийт дансны үнээс цэвэрлэсэн | - | (9,980,649) | - | - | - | - | - | (9,980,649) |
| Хасагдсан элэгдэл | - | - | (218,235) | (614,198) | (225,635) | - | (5,724) | (1,063,792) |
| Үндсэн хөрөнгө хооронд шилжсэн | - | - | (5,570) | 5,570 | - | - | - | - |
| Ханшийн хөрвүүлэлтийн нөлөө | - | - | 63 | (25,570) | (5,566) | - | - | (31,073) |
| **2024 оны 12 дугаар сарын 31** | **-** | **578,788** | **82,658,747** | **5,433,179** | **1,254,916** | **-** | **788,033** | **90,713,663** |
| ***Дансны үнэ:*** | | | | | | | | |
| **2023 оны 01 дүгээр сарын 01** | **464,442** | **69,747,233** | **46,542,054** | **2,021,660** | **1,106,378** | **18,371** | **14,264** | **119,914,402** |
| **2023 оны 12 дугаар сарын 31** | **579,893** | **67,235,424** | **39,206,705** | **2,615,652** | **1,089,538** | **240,682** | **763,226** | **111,731,120** |
| **2024 оны 12 дугаар сарын 31** | **579,893** | **99,709,347** | **40,777,820** | **2,792,766** | **1,014,204** | **973,402** | **564,797** | **146,412,229** |

## 9. Үндсэн хөрөнгө (үргэлжлэл)

### 9.1 Барьцаалсан үндсэн хөрөнгө

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр нийт 109.3 тэрбум төгрөг (2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр нийт 67.8 тэрбум төгрөг)-ийн дансны үнэ бүхий газар, барилга, дуусаагүй барилга ба тоног төхөөрөмжийг банкны зээлд барьцаалсан (Тодруулга 15.1-г харна уу).

### 9.2 Группийн барилгын бодит үнэ цэнийн хэмжилт

Группийн барилга нь хуримтлагдсан элэгдэл болон үнэ цэнийн бууралтыг хассан дахин үнэлсэн дүнгээр тусгагдсан. Группийн барилга 2024 оны 12 дүгээр сарын 31-ны өдрөөр Группээс хараат бус мэргэжлийн үнэлгээчний тодорхойлсон бодит үнэ цэнээр дахин үнэлэгдсэн.

СТОУС 13 *Бодит үнэ цэнийн хэмжилт*-д тодорхойлсны дагуу хэмжигдсэн үндсэн хөрөнгийн үнэ цэнийг дараах бодит үнэ цэнийн шаталсан түвшнээр ангилсан.

| | **2024 оны 12 дугаар сарын 31** | | **2023 оны 12 дугаар сарын 31** | |
|---|---|---|---|---|
| | **Бодит үнэ цэнэ** | **Шатлал 2** | **Бодит үнэ цэнэ** | **Шатлал 2** |
| Барилга | 99,709,347 | 99,709,347 | 67,235,424 | 67,235,424 |
| | **99,709,347** | **99,709,347** | **67,235,424** | **67,235,424** |

Газар болон барилгын бодит үнэ цэнийг хэмжихдээ дараах үнэлгээний арга техникийг ашигласан:

| **Төрөл** | **Үнэлгээний арга техник** |
|---|---|
| Барилга | *Зах зээлийн харьцуулалтын арга:* Уг үнэлгээний загвар нь зах зээлийн жишиг үнэ байгаа үед ижил төрлийн зүйлсийн зах зээлийн үнийг, мөн тохиромжтой үед хорогдуулсан орлуулалтын өртгийг авч үздэг. Хорогдуулсан орлуулалтын өртөг нь биет хоцрогдол болон хуучралт, мөн үйл ажиллагааны болон эдийн засгийн хоцрогдол зэргийг авч үздэг. |
### 24.2 Борлуулсан бүтээгдэхүүний өртөг

| | 2024 | 2023 |
|---|---|---|
| Сүлжмэл бүтээгдэхүүн | 82,114,642 | 78,842,962 |
| Оёмол бүтээгдэхүүн | 26,088,883 | 21,782,380 |
| Нэхмэл бүтээгдэхүүн | 24,214,564 | 23,490,675 |
| Үйлчилгээний өртөг | 1,735,876 | 1,704,830 |
| Бусад | 4,398,376 | 5,190,498 |
| | **138,552,341** | **131,011,345** |

### 24.3 Зардлын шинж чанараар

| | 2024 | 2023 |
|---|---|---|
| Бараа материалын өөрчлөлт | 8,956,988 | 8,469,488 |
| Түүхий эд материал ба хангамжийн материал | 99,769,130 | 94,393,507 |
| Цалин ба түүнтэй холбоотой зардлууд | 49,933,543 | 45,207,429 |
| Элэгдэл ба хорогдол | 14,554,268 | 12,643,029 |
| Зар сурталчилгааны зардал | 10,615,113 | 28,114,648 |
| Хангамжийн зардал | 2,276,413 | 2,138,826 |
| Мэргэжлийн үйлчилгээний хөлс | 6,788,110 | 9,254,644 |
| Борлуулалтын идэвхижүүлэлтийн зардал | 3,816,946 | 3,898,759 |
| Тээврийн зардал | 2,146,819 | 4,063,595 |
| Бусад | 17,820,291 | 16,154,021 |
| **Нийт борлуулсан бүтээгдэхүүний өртөг, борлуулалт ба маркетингийн зардал, ерөнхий удирдлагын зардал** | **216,677,621** | **224,337,946** |

**24. Борлуулалтын орлого, өртөг, зардал (үргэлжлэл)**

**24.4 Борлуулалт ба түгээлтийн зардал**

| | 2024 | 2023 |
|---|---|---|
| Маркетинг ба зар сурталчилгааны зардал | 10,615,113 | 28,114,648 |
| Цалин ба түүнтэй холбоотой зардлууд | 16,840,124 | 15,547,966 |
| Харилцагчийн урамшууллын зардал | 5,404,245 | 4,968,082 |
| Мэргэжлийн үйлчилгээний хөлс | 5,133,062 | 8,081,869 |
| Борлуулалтын зардал | 3,816,946 | 3,898,759 |
| Элэгдэл ба хорогдлын зардал | 2,602,182 | 2,122,065 |
| Тээврийн зардал | 2,146,819 | 4,063,595 |
| Хангамжийн зардал | 2,093,598 | 2,045,054 |
| Бусад татвар | 1,104,788 | 1,248,430 |
| Томилолтын зардал | 640,340 | 808,326 |
| Богино хугацаат болон бага үнийн дүнтэй зүйлсийн түрээс | 462,757 | 190,602 |
| Даатгалын зардал | 458,414 | 445,889 |
| Ашиглалтын зардал | 419,194 | 387,825 |
| Хөдөлмөр хамгааллын зардал | 351,538 | 446,997 |
| Засвар үйлчилгээний зардал | 275,977 | 227,432 |
| Менежментийн зардал | 269,500 | 539,001 |
| Харилцаа холбооны зардал | 124,480 | 130,399 |
| Цэвэрлэгээ үйлчилгээ | 116,932 | 107,355 |
| Түлш, шатахууны зардал | 113,125 | 76,971 |
| Хүний нөөц ба бусад холбоотой зардлууд | 65,417 | 37,468 |
| Бусад зардал | 162,578 | 104,628 |
| | **53,217,129** | **73,593,361** |

**24.5 Еронхий удирдлагын зардал**

| | 2024 | 2023 |
|---|---|---|
| Цалин ба түүнтэй холбоотой зардлууд | 12,346,948 | 10,033,083 |
| Элэгдэл ба хорогдлын зардал | 2,027,434 | 1,357,897 |
| Мэргэжлийн үйлчилгээний хөлс | 1,655,048 | 1,172,775 |
| Бусад татвар | 1,479,048 | 1,028,769 |
| Лицензийн төлбөр | 1,296,241 | 224,118 |
| Хөдөлмөр хамгааллын зардал | 1,158,653 | 1,760,230 |
| Харуул, хамгаалалтын зардал | 880,292 | 880,619 |
| Засвар үйлчилгээний зардал | 564,970 | 675,114 |
| Хүний нөөц ба бусад холбоотой зардлууд | 506,599 | 353,076 |
| Хангамжийн зардал | 470,728 | 93,772 |
| Томилолтын зардал | 245,194 | 732,252 |
| Ашиглалтын зардал | 243,081 | 202,108 |
| Бараа материалын үнэ цэнийн бууралт (буцаалт) | 197,117 | (166,906) |
| Сургалтын зардал | 173,411 | 213,129 |
| Түлш, шатахууны зардал | 147,600 | 129,581 |
| Банкны үйлчилгээний шимтгэл | 112,855 | 69,044 |
| Даатгалын зардал | 109,415 | 83,664 |
| Харилцаа холбооны зардал | 98,086 | 78,597 |
| Бусад зардал | 1,195,431 | 812,318 |
| | **24,908,151** | **19,733,240** |





**25. Санхүүгийн орлого**

| | 2024 | 2023 |
|---|---|---|
| Хүүгийн орлого | 21,032 | 229,734 |
| Зээлээс үүссэн гадаад валютын ханшийн зөрүүний олз | 4,444,551 | - |
| | **4,465,583** | **229,734** |

**26. Бусад орлого, зардал**

**26.1 Бусад орлого**

| | 2024 | 2023 |
|---|---|---|
| Түрээс ба бусад орлого | 649,071 | 583,510 |
| Засгийн газрын хөнгөлөлт | 3,000,620 | 4,418,776 |
| Гадаад валютын ханшийн зөрүүний олз | - | 1,523,232 |
| | **3,649,691** | **6,525,518** |

**26.2 Бусад зардал**

| | 2024 | 2023 |
|---|---|---|
| Үндсэн хөрөнгө болон биет бус хөрөнгө данснаас хассаны гарз, цэвэр дүнгээр | 60,004 | 6,980 |
| Гадаад валютын хашийн зөрүүний гарз | 6,859,415 | - |
| | **6,919,419** | **6,980** |

**27. Санхүүгийн зардал**

| | 2024 | 2023 |
|---|---|---|
| Зээлийн хүүгийн зардал (Тодруулга 15.2) | 21,063,138 | 22,017,541 |
| Хөнгөлөлттэй зээлийн дискаунтын нөлөө (Тодруулга 15.2) | 3,000,620 | 4,418,776 |
| Бондын хүүгийн зардал (Тодруулга 15.2) | 620,388 | - |
| Зээлээс үүссэн гадаад валютын ханшийн зөрүүний гарз | - | 2,477,373 |
| Бусад өр төлбөрийн хүүгийн зардал (Тодруулга 15.2) | 6,953,576 | 8,043,236 |
| Түрээсийн өр төлбөрийн хүүгийн зардал (Тодруулга 15.2) | 329,689 | 196,421 |
| Бусад хүүгийн зардал | 1,150,689 | 893,638 |
| | **33,118,100** | **38,046,985** |

**28. Холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээ**

**28.1 Холбоотой талуудын үлдэгдэл**

| Холбоотой тал | Холбоо хамаарал |
|---|---|
| Хувьцаа эзэмшигчид | |
| Таван Богд Холдингс ХХК | Дээд шатны хянагч этгээд |
| Зэргэлдээ охин компаниуд | Дээд шатны хянагч этгээдийн охин компаниуд |
| Бусад холбоотой талууд | Хараат, хамтарсан компаниуд, үндсэн удирдлагын багийн гишүүдийн хяналтан дор байдаг бусад холбоотой талууд |

## 28. Холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээ (үргэлжлэл)

### 28.2 Холбоотой талуудын дансны үлдэгдэл

Тайлант хугацааны эцэст холбоотой талуудын үлдэгдэл дараах байдалтай байна:

| | 2024 | 2023 |
|---|---|---|
| **Холбоотой талуудаас авах авлага (Тодруулга 6)** | | |
| Бусад холбоотой талууд | 70,162 | 129,632 |
| **Холбоотой талд өгөх өглөг /Богино хугацаат/ (Тодруулга 13)** | | |
| Дээд шатны хянагч этгээд | 25,309,850 | 13,642,760 |
| Зэргэлдээ охин компаниуд | - | 10,630,000 |
| Бусад холбоотой талууд | - | 703 |
| **Холбоотой талд өгөх өглөг /Урт хугацаат/ (Тодруулга 16)** | | |
| Дээд шатны хянагч этгээд | - | 17,032,986 |
| **Холбоотой талаас авсан зээл (Тодруулга 15)** | | |
| Бусад холбоотой талууд | - | 20,475,228 |

Холбоотой талуудын дансны үлдэгдэлд барьцаагүй ба найдваргүй авлагын сан байгуулаагүй.

Холбоотой талд өгөх урт хугацаат өглөг нь Таван Богд Холдингс ХХК-аас Гоёо ХХК-ийн хувьцааг зээлээр худалдан авсантай холбоотой. Дэлгэрэнгүйг Тодруулга 16-с харна уу. Тус гэрээнд аливаа хөрөнгийг барьцаалаагүй.

### 28.3 Холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээ

Дараах ажил гүйлгээг Группийн толгой компани болох Таван Богд Холдингс ХХК-тай хийсэн байна:

| | 2024 | 2023 |
|---|---|---|
| Дээд шатны хянагч компаниас авсан урьдчилгаа | 177,957,846 | 200,750,000 |
| Дээд шатны хянагч компаниас авсан урьдчилгааны төлбөр | 183,297,808 | 200,750,000 |
| Дээд шатны хянагч компанид өгсөн урьдчилгаа | - | 18,950,000 |
| Дээд шатны хянагч компанид өгсөн урьдчилгааны төлбөр | - | 18,950,000 |
| Дээд шатны хянагч компаниас авсан худалдан авалт | 1,379,271 | 1,375,508 |
| Дээд шатны хянагч компанид хийсэн борлуулалт | 22,792 | 33,051 |
| Дээд шатны хянагч компанид төлөх хүүгийн зардал | 4,378,356 | 5,816,451 |
| Дээд шатны хянагч компанид төлсөн хүүгийн зардал | 4,378,356 | 5,816,451 |

Дараах ажил гүйлгээг Группийн нэгдсэн хяналтад байдаг бусад холбоотой талуудтай хийсэн байна:

| | 2024 | 2023 |
|---|---|---|
| Бусад холбогдох этгээдээс авсан санхүүжилт | 325,232,000 | 252,920,000 |
| Бусад холбогдох этгээдээс авсан санхүүжилтийн эргэн төлөлт | 335,862,000 | 242,290,000 |
| Бусад холбоотой талуудаас авсан худалдан авалт | 1,715,066 | 1,776,029 |
| Бусад холбоотой талаас авсан худалдан авалт | - | 25,932 |
| Бусад холбоотой талд хийсэн борлуулалт | 174,981 | 251,554 |
| Бусад холбоотой талаас авсан түрээсийн орлого | 304,733 | 292,062 |
| Бусад холбоотой талд төлөх хүүгийн зардал | 2,575,220 | 2,226,785 |
| Бусад холбоотой талд төлсөн хүүгийн зардал | 2,575,220 | 2,226,785 |







## 28. Холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээ (үргэлжлэл)

### 28.3 Холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээ (үргэлжлэл)

Дараах ажил гүйлгээг толгой компанийн хараат компани болох ХААН банктай хийсэн байна:

| | 2024 | 2023 |
|---|---|---|
| Хаан банкнаас авсан санхүүжилт (Тодруулга 15.2) | 148,311,216 | 81,700,000 |
| Хаан банкнаас авсан санхүүжилтийн эргэн төлөлт (Тодруулга 15.2) | 169,011,431 | 70,997,225 |
| Хаан банкинд хийсэн борлуулалт | 231,895 | 138,672 |
| Хаан банкинд төлөх хүүгийн зардал | 478,232 | 555,651 |
| Хаан банкинд төлсөн хүүгийн төлбөр | 531,164 | 524,089 |

Бүх холбоотой талын гүйлгээ нь харилцан тохиролцсон нөхцөлөөр хийгдсэн.

### 28.4 Үндсэн удирдлагын цалин, урамшуулал

Группийн удирдлага болон удирдлагын багийн гишүүдийн үндсэн болон нэмэгдэл цалин дараах байдалтай байна. Үүнд:

| | 2024 | 2023 |
|---|---|---|
| Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн цалин урамшууллын нийт хэмжээ | 285,104 | 223,885 |
| Удирдлагын ажилтнуудын цалин урамшууллын нийт хэмжээ | 2,468,732 | 2,119,517 |

## 29. Болзошгүй өр төлбөр ба үүрэг

Харилцагчдын санхүүгийн хэрэгцээ, шаардлагыг хангахын тулд Групп нь аливаа санхүүгийн үүрэг болон болзошгүй өр төлбөр хүлээж болно. 2024 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар (2023 онд байхгүй) Группд ямар нэг болзошгүй өр төлбөр, үүрэг үүсээгүй.

### 29.1 Болзошгүй өр төлбөр

Баталгаа нь тодорхой нөхцөлд холбоотой талын өмнөөс голдуу тендерийн үйл ажиллагаатай холбоотойгоор төлбөр хийх үүргийг Групп ногдуулж үүснэ. Баталгаа нь болзошгүй өр төлбөр боловч зээлийн эрсдэлтэй ижил эрсдэлийг агуулдаг. Эдгээр гүйлгээний улмаас материаллаг алдагдал гарахгүй гэсэн хүлээлттэй байна.

### 29.2 Санхүүгийн үүрэг

Санхүүгийн үүрэг гэдэг нь Группийн зүгээс зээл олгох, зээлийн шугам нээх гэрээт үүргүүдийг хүлээснийг илэрхийлдэг. Ийм үүргүүд нь тогтсон дуусах хугацаа эсвэл цуцлах бусад төрлийн заалтуудтай байдаг. Зээл аваагүй байтал зээлийн гэрээний хугацаа дуусах магадлалтай тул гэрээнд заагдсан мөнгөн дүн нь ирээдүйн зээлийн мөнгөн урсгалыг илэрхийлэхгүй юм. Эдгээр гүйлгээний улмаас нөлөө бүхий алдагдал гарахгүй гэсэн хүлээлттэй байна.

### 29.3 Шүүхийн нэхэмжлэл

Группийн бизнесийн хэвийн үйл ажиллагааны явцад хэрэг маргааныг шүүхээр шийдвэрлүүлдэг ба шүүхийн нэхэмжлэл гаргах, нэхэмжлэлийг хэрхэн барагдуулах талаар тогтсон дотоод журам, туршлагатай. Групп нь аливаа нэхэмжлэлийн өөрийн санхүүгийн байдалд үзүүлж болох сөрөг нөлөөллөөс хамгаалахдаа мэргэжлийн хууль зүйн туслалцаа авах нь эрсдэлийг бууруулдаг гэж үздэг. Тайлант жилийн эцэст Группд нөлөө бүхий үүрэг хүлээх шүүхийн нэхэмжлэл байхгүй байна.

## 30. Санхүүгийн хэрэглүүр ба санхүүгийн эрсдэлийн удирдлага

### Оршил

Группийн эрсдэлийн удирдлагын санхүүгийн эрсдэлүүдийн салшгүй гол эрсдэлүүд бол зээлийн эрсдэл, хөрвөх чадварын эрсдэл, зах зээлийн эрсдэлүүд байдаг. Зах зээлийн эрсдэл нь хүүгийн түвшин, гадаад валютын ханш гэх мэт зах зээлийн хүчин зүйлсийн өөрчлөлтийн улмаас Группийн орлого болон санхүүгийн хөрөнгийн үнэ цэнэ хэлбэлзэх эрсдэл юм.

Эрсдэлийн удирдлагын үндсэн зорилго нь эрсдэл/өгөөжийн харьцаатай уялдуулан бизнесийн сегментүүдэд хөрөнгө хуваарилах, тодорхойлох, хэмжих, хянах үйл явцаар Группийн эрсдэлд тохируулсан хөрөнгийн өгөөжийг нэмэгдүүлэх явдал юм. Эрсдэлийн удирдлагын энэхүү үйл явц нь Группийн тасралтгүй ашигт ажиллагаанд чухал ач холбогдолтой. Группийн ерөнхий үзэл баримтлал, чиглэлд нийцтэй удирдлагын тогтолцоог бүрдүүлэх, оролцогчдын эрх үүргийг тодорхойлон эрсдэлийн удирдлагыг амжилттай хэрэгжүүлэх, хэрэгжилтэд мониторинг хийж, тасралтгүй сайжруулахад оршино.

Группийн эрсдэлийн удирдлагын тогтолцоо нь эрсдэлийг арилгах зорилготой бус харин эрсдэл ба өгөөжийн харьцааг оновчтой байлгах зорилготой. “Эрсдэлийн удирдлагын бодлого” нь Группийн хэмжээнд эрсдэлийн удирдлагын бүтцийг гаргах, хэрэгжүүлэх, хянах, дүн шинжилгээ хийх, байнга сайжруулахад чиглэсэн үндсэн ба зохион байгуулалтын арга хэмжээнүүдийн цогц хамрах хүрээг багтаадаг.

Группийн зорилтууд нь эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэм хэмжээнд нийцсэн байдаг. Эрсдэлийн удирдлагад стратегийн эрсдэл, нийцлийн эрсдэл, санхүүгийн эрсдэл, үйл ажиллагааны эрсдэл, давагдашгүй хүчин зүйлийн эрсдэл болон бусад цаг үеийн шинж чанартай тулгарах эрсдэлүүдийг багтаадаг. Групп нь ТУЗ-өөс тогтоосон эрсдэлийн удирдлагын бодлогын хүрээнд эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэм хэмжээнд нийцүүлэн улирал бүр хянах байдлаар эрсдэлийг удирддаг. Эдгээр хүлээн зөвшөөрөх хэм хэмжээг Группийн бизнесийн стратеги, зах зээлийн нөхцөл байдал болон үйл ажиллагаандаа уялдуулан тогтоосон байдаг.

### Эрсдэлийн удирдлагын бүтэц, зохион байгуулалт

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн зүгээс хамтын хяналт, эрсдэлийн засаглалын хариуцлагыг тодорхой хэрэгжүүлэх нь үндсэн зорилтуудын нэг гэдгийг хүлээн зөвшөөрдөг.

Эрсдэлийн удирдлагын тогтолцоо нь засаглал, хэрэгжүүлэлт гэсэн үндсэн хоёр түвшнээс бүрддэг. Компанид эрсдэлийн удирдлагын тогтолцоог бүрдүүлэгч нь ТУЗ, түүний дэргэдэх Эрсдэл, аудитын хороо байна. Эрсдэлийн бодлогыг хэрэгжүүлэгч нь эрсдэлийн удирдлагын баг байх бөгөөд Гүйцэтгэх захирал багийн бүрэлдэхүүнийг “Эрсдэлийн удирдлагын бодлого”-д нийцүүлэн томилно.

Хамгаалалтын 1-р шугамд эрсдэлийг хариуцах нэгжийн удирдлага болон нийт ажилтнууд, 2-р шугамд Эрсдэлийн удирдлагын баг, 3-р шугамд Дотоод аудитын хэлтэс байна.

### ТУЗ-ийн Эрсдэл Аудитын Хороо

ТУЗ-ийн Эрсдэл Аудит Хороо нь дотоод хяналт ба зохицуулалт болон хууль, эрх зүйн шаардлагын хэрэгжүүлж байгаа эсэхийг ТУЗ-д танилцуулж ажилладаг.

### Дотоод аудит

Группийн эрсдэлийн удирдлагын үйл явцад Дотоод аудитын ажил үүргийг Эрсдэл Аудитын хорооноос өгсөн чиглэлийн дагуу ажилладаг. Группийн хэмжээнд нэвтрүүлэн хэрэгжүүлж буй бодлого дүрэм, журмуудын зохистой байдал хийгээд Групп эдгээрийг хэрхэн мөрдөж байгаад хяналт тавин үр дүнг ТУЗ-д тайлагнадаг.





## 30. Санхүүгийн хэрэглүүр ба санхүүгийн эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)

### Тогтвортой хөгжлийн хэлтэс

Энэхүү хэлтэс нь Тогтвортой хөгжлийн 17 зорилгын хүрээнд байгууллагын үйл ажиллагаатай уялдах байгаль орчин, нийгэм, засаглалын (БОНЗ) шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлж түүний хэрэгжилтийг хангах үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, хянах зорилготой. Эрсдэлийн удирдлагын хэрэгжилтийг энэхүү хэлтэс удирдан зохион байгуулдаг. Үүнд:

1. Группийн хэмжээнд эрсдэлийн нэгдсэн бүртгэл үүсгэн, эрсдэлийн нарийвчилсан анализ үнэлгээ хийх, эрсдэл удирдах төлөвлөгөө боловсруулан, удирдлагыг шаардлагатай мэдээллээр хангах, эрсдэлийн соёлыг түгээн дэлгэрүүлэхээр зохион байгуулагдан ажилладаг.
2. Эрсдэлийн удирдлагын бодлого журмын дагуу тодорхой эрсдэл байж болзошгүй орчинг илрүүлэн, түүнийг удирдах/бууруулах арга хандлага боловсруулан саналыг эрсдэлийн удирдлагын багт танилцуулдаг.
3. Эрсдэлийн хариу арга хэмжээний болон үйл ажиллагааны тайланг Эрсдэл аудитын хороонд улирал бүр танилцуулан чиглэл аван ажилладаг.

### Санхүүгийн эрсдэлийг бууруулах

Хүүгийн түвшний эрсдэл, гадаад валютын ханшийн өөрчлөлт, зээлийн эрсдэл болон ирээдүйн үйл ажиллагаанаас үүдэж болзошгүй эрсдэлийн хэмжээг мэдрэмжийн шинжилгээ хийн хянаж ажилладаг. Эрсдэлийг бууруулах зорилгоор тодорхой арга хэмжээг авдаг бөгөөд доор дэлгэрэнгүй тодруулав.

### Эрсдэлийн хэт төвлөрөл

Төвлөрөл нь ижил төрлийн бизнесийн үйл ажиллагаа эрхэлдэг, эсвэл нэгэн ижил газар зүйн бүсэд болон эдийн засгийн ойролцоо шинж чанартай бизнес эрхэлдэг хэд хэдэн харилцагчид улс төр, эдийн засаг болон бусад аливаа өөрчлөлт гарахад тэдгээрийн гэрээний үүргээ гүйцэтгэхэд ижил маягаар нөлөөлөхөөр байвал үүсдэг. Төвлөрөл нь тухайн нэгж салбарт болон газар зүйн байрлалд нөлөөлж буй нөхцөл байдалд Групп хэрхэн гүйцэтгэлээ хангах мэдрэмжийг илтгэнэ.

Эрсдэлийн хэт төвлөрлөөс зайлсхийх үүднээс Групп өөрийн бодлого, журамдаа олон төрлийн багцтай байх тодорхой удирдамжийг тусгасан байдаг. Тухайлбал, жижиглэнгийн борлуулалтыг онлайн болон дэлгүүрийн, захиалгын гэх сувгаар салган хөгжүүлэх, олон улсын өөр бүс нутгуудад салбар дэлгүүр нээх эсвэл маркетингийн оновчтой бодлого боловсруулах зэргээр үйл ажиллагааны төвлөрлийг хянаж удирдаг.

### 30.1 Зээлийн эрсдэлийн удирдлага

Зээлийн эрсдэл гэдэг нь гэрээ байгуулагч тал гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйгээс Группэд санхүүгийн алдагдал үүсэх эрсдэл юм.

### Зээлийн эрсдэлд өртөх байдал

Санхүүгийн хөрөнгийн дансны үнэ нь зээлийн хамгийн их эрсдэлийг илэрхийлж байдаг. Группийн хамгийн их хүлээх зээлийн эрсдэлийг санхүүгийн хөрөнгө тус бүрийн дансны үнээр илэрхийлэв:

| | 2024 | 2023 |
|---|---|---|
| Банк дахь харилцах данс (Тодруулга 5) | 4,283,219 | 9,459,561 |
| Түрээсийн дэлгүүрт байршуулсан барьцаа (Тодруулга 12) | 152,086 | 152,121 |
| Дансны ба бусад авлага* (Тодруулга 6) | 7,522,743 | 6,672,251 |
| | **11,958,048** | **16,283,933** |

*2024 оны 1,882,135 мянган төгрөг, 2023 оны 1,358,657 мянган төгрөгийн татварын авлагын дүн дээрх дүнд ороогүй болно.

## 30. Санхүүгийн хэрэглүүр ба санхүүгийн эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)

### 30.1 Зээлийн эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)

Ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрсөн санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын хасалдуулга дараах байдалтай байна:

| | 2024 | 2023 |
|---|---|---|
| Дансны болон бусад авлагын үнэ цэнийн бууралтын хасалдуулгын буцаалт | - | 9,266 |
| | **-** | **9,266** |

Тайлант өдөр дансны болон бусад авлагын зээлийн эрсдэлд өртөх дээд хэмжээ (татвараас бусад) газар зүйн бүс нутгаар дараах байдалтай байна:

| | 2024 | 2023 |
|---|---|---|
| Дотоод | 2,545,342 | 2,554,928 |
| Гадаад | 4,977,401 | 4,117,323 |
| | **7,522,743** | **6,672,251** |

Одоогийн байдлаар дотоодын зах зээл дээр зээлжих зэрэглэл тогтоох хараат бус үнэлгээний байгууллага байхгүй байна. Иймээс Группийн зүгээс удаан хугацаанд харилцсан, найдвартай харилцагчидтайгаа урьдчилан баталсан зээлийн дээд хэмжээний хүрээнд зээлээр борлуулалт хийх бодлогыг баримталдаг. Жил бүр борлуулалтын гэрээг харилцагчидтай байгуулж, шинэчлэн баталгаажуулж, гэрээний нөхцөлийн биелэлтэд байнгын хяналт тавьж ажилладаг.

Группийн санхүүгийн хөрөнгөтэй холбоотой зээлийн эрсдэлийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ байхгүй. 2024 болон 2023 онд даатгуулсан эсвэл аккредитив гэрээгээр баталгаажуулсан дансны авлага байхгүй.

Группийн удирдлага харилцах дансны зээлийн эрсдэлийг бага байлгаж удирдах үүднээс зээлжих зэрэглэл өндөртэй дотоодын банк, санхүүгийн байгууллагуудад мөнгөө байршуулдаг. Удирдлага тэдгээрийн дефолт болох магадлалыг бага гэж үнэлж байгаа ба үнэ цэнийн бууралтын сан байгуулаагүй.

Групп дансны авлагын хүлээгдэж буй алдагдлыг тооцоолохдоо харилцагч тус бүрийн бие даасан нөхцөл байдлын үнэлгээ, эдийн засгийн нөхцөл байдал болон салбарын нөхцөл байдал зэрэгт тулгуурлан тооцоолсон. Эдгээр тохиолдолд тухайн харилцагчдын авлагын үлдэгдэл, хамтын ажиллагааны түүх болон зах зээлийн мэдэгдэж буй хүчин зүйлс дээр үндэслэсэн эсрэг талын одоогийн санхүүгийн байдал, боломжит хамгийн сайн баримт, нөхцөлийг үнэлэн дүгнэлт хийсэн. Групп нь харилцагч бүрд хүлээгдэж буй эргэн төлөгдөх дүнг бууруулсантай холбоотойгоор тусгайлан нөөцийг бүртгэсэн. Энэхүү тусгайлсан хасагдуулгын тооцоолсон дүнд нөлөөлөхүйц аливаа өөрчлөлт гарвал түүнийг дахин тооцон үзэж тохируулдаг.

Групп нь харилцагч санхүүгийн хүнд байдалд орсон тухай мэдээлэл хүлээн авсан, авлагын эргэн төлөгдөх бодитой төлөв байхгүй үед, өөрөөр хэлбэл, эдгээр тохиолдолын аль нэг нь үүссэн буюу хариуцагч татан буугдсан, дампуурлын үе шатанд орсон, эсвэл борлуулалтын авлага нь арваас дээш жилийн насжилттай болсон тохиолдолд борлуулалтын авлагыг данснаас хасдаг.



ГОВЬ ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
2024 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)

## 30. Санхүүгийн хэрэглүүр ба санхүүгийн эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)

### 30.1 Зээлийн эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)

Зээлийн эрсдэлд өртөх байдал, дансны болон бусад авлагын хүлээгдэж буй зээлийн алдагдлын талаарх мэдээлэл дараах байдалтай байна:

| 2024 оны 12 сарын 31 | Нийт дансны үнэ | Хасалдуулгын нөөц | Зээлийн алдагдал |
|---|---|---|---|
| Хугацаа хэтрээгүй, үнэ цэнийн бууралт үүсээгүй | 7,463,161 | - | 0.00% |
| 0-30 хоногийн хугацаа хэтэрсэн | - | - | 0.00% |
| 31-60 хоногийн хугацаа хэтэрсэн | - | - | 0.00% |
| 61-90 хоногийн хугацаа хэтэрсэн | - | - | 0.00% |
| 91 хоногоос дээш хугацаа хэтэрсэн | 1,821,391 | (1,761,809) | 96.73% |
| | **9,284,552** | **(1,761,809)** | **18.98%** |

| 2023 оны 12 сарын 31 | Нийт дансны үнэ | Хасалдуулгын нөөц | Зээлийн алдагдал |
|---|---|---|---|
| Хугацаа хэтрээгүй, үнэ цэнийн бууралт үүсээгүй | 6,595,239 | - | 0.00% |
| 0-30 хоногийн хугацаа хэтэрсэн | - | - | 0.00% |
| 31-60 хоногийн хугацаа хэтэрсэн | - | - | 0.00% |
| 61-90 хоногийн хугацаа хэтэрсэн | - | - | 0.00% |
| 91 хоногоос дээш хугацаа хэтэрсэн | 1,838,821 | (1,761,809) | 95.81% |
| | **8,434,060** | **(1,761,809)** | **20.89%** |

***Дансны болон бусад авлагын үнэ цэнийн бууралтын нөөцийн хөдөлгөөн***

Дансны болон бусад авлагын үнэ цэнийн бууралтын нөөцийн хөдөлгөөн жилийн хугацаанд дараах байдалтай байна:

| | 2024 | 2023 |
|---|---|---|
| 01 дүгээр сарын 01-ний үлдэгдэл | 1,761,809 | 1,771,075 |
| Хасалдуулгын нөөцийн буцаалт | - | (9,266) |
| **12 дугаар сарын 31-ний үлдэгдэл** | **1,761,809** | **1,761,809** |

Дансны авлагын үнэ цэнийн бууралтын мэдээллийг Тодруулга 6-аас харна уу.

Группийн удирдлага нь бусад авлагын эргэн төлөгдөх магадлалыг үнэлэхдээ авлагын түүхэн мэдээлэл, хугацаа хэтэрсэн авлагын мэдээлэл, одоогийн болон ирээдүйг таамагласан мэдээллийг харгалзан тохируулах байдлаар багцалсан болон тусгайлсан үнэлгээг хийдэг. Группийн удирдлагын хийсэн үнэлгээгээр бусад авлагад анх бүртгэлд тусгаснаас хойш нөлөө бүхий зээлийн эрсдэл үүсээгүй гэж үнэлсэн ба эрсдэлийн түвшин нь өндөр бус учир үнэ цэнийн бууралт бүртгээгүй болно.

Дансны авлагын нөхцөл байдлыг үндэслэн зээлийн үнэлгээг тогтмол хийдэг ба шаардлагатай гэж үзвэл төлбөрийн эрсдэлийг даатгуулдаг. Мөн Групп худалдан авагчаас дараагийн захиалгыг гүйцэтгэхээс өмнө үлдэгдэл төлбөрөө төлсөн байхыг шаарддаг.

### 30.2 Хөрвөх чадварын эрсдэлийн удирдлага

Хөрвөх чадварын эрсдэл гэдэг нь Групп өөрийн санхүүгийн өр төлбөрийг барагдуулах үүргээ биелүүлэхэд хүндрэлтэй болох эрсдэл юм. Групп нь хэвийн болон онцгой нөхцөлд их хэмжээний алдагдалд орохгүйгээр, Группийн нэр хүндэд хохирол учруулах эрсдэлийг бий болгохгүйгээр өр төлбөрөө гэрээний хугацаанд төлж барагдуулахад хүрэлцэхүйц хөрвөх чадварыг тогтмол хангаж байх ёстой гэдэг зарчмаар хөрвөх чадварыг удирдан зохицуулдаг.

**30. Санхүүгийн хэрэглүүр ба санхүүгийн эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)**

**30.2 Хөрвөх чадварын эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)**

Группийн ТУЗ нь хөрвөх чадварын эрсдэлийн удирдлагыг хариуцдаг ба Группийн богино, дунд ба урт хугацааны санхүүжилт болон хөрвөх чадварын эрсдэлийн удирдлагын шаардлагад нийцсэн хөрвөх чадварын бүтцийг бий болгох үүрэгтэй. Групп санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрийн төлөгдөх хугацаа, банкнаас зээл авах чадавхи, зээлийн ашиглагдаагүй үлдэгдэл, мөнгөн урсгалын таамаглал болон гүйцэтгэлд үндэслэн хөрвөх чадварын эрсдэлийг удирддаг.

Хүснэгтэд Группийн үүсмэл бус санхүүгийн өр төлбөрийг гэрээгээр төлөх хугацаагаар нь ангилан тайлагнасан. Хүснэгтэн дэх мэдээлэл нь Группийн төлбөр төлөх шаардлагатай хамгийн эхний хугацаанд үндэслэсэн дискаунтлаагүй мөнгөн гүйлгээг харуулж байна. Энэхүү хүснэгтийн дүнгүүд нь үндсэн төлбөр болон хүүг агуулсан болно. Доорх хүснэгтэд АХБ болон ОУХОБ-ны зээлийн гэрээний шалгуур үзүүлэлтүүдийн зөрчлийн нөлөөллийг оруулаагүй бөгөөд эргэн төлөлтийн хуваарь дээр үндэслэн үндсэн төлбөр болон хүүг тодруулсан болно. Эдгээр зээлийг дуудахад эргэн төлөгдөх нөхцөлтэй гэж үзвэл 160,559,560 мянган төгрөгийн зээлийг (2023: 124,344,800 мянган төгрөг) доорх хүснэгтийн дуудахад эргэн төлөгдөх нөхцөлтэй болон сараас бага ангилалд оруулна.

| | **Дуудахад эргэн төлөгдөх нөхцөлтэй болон сараас бага** | **1-3 сар** | **3 сараас 1 жил хүртэл** | **1-5 жил** | **Нийт** | **Дансны үнэ** |
|---|---|---|---|---|---|---|
| ***2024 оны 12 сарын 31*** | | | | | | |
| Дансны болон бусад өглөг (урт хугацаат өглөг багтсан) * | 2,319,452 | 7,228,897 | 29,521,983 | - | 39,070,332 | 34,208,928 |
| Богино болон урт хугацааны зээл | 3,310,988 | 7,747,576 | 141,347,234 | 114,571,853 | 266,977,651 | 247,475,887 |
| Богино болон урт хугацаат түрээсийн өглөг | 125,723 | 251,447 | 1,119,105 | 2,226,430 | 3,722,705 | 3,026,029 |
| | **5,756,163** | **15,227,920** | **171,988,322** | **116,798,283** | **309,770,688** | **284,710,844** |

| | **Дуудахад эргэн төлөгдөх нөхцөлтэй болон сараас бага** | **1-3 сар** | **3 сараас 1 жил хүртэл** | **1-5 жил** | **Нийт** | **Дансны үнэ** |
|---|---|---|---|---|---|---|
| ***2023 оны 12 сарын 31*** | | | | | | |
| Дансны болон бусад өглөг (урт хугацаат өглөг багтсан) * | 8,754,777 | 12,221,818 | 18,703,249 | 17,417,889 | 57,097,733 | 51,366,793 |
| Богино болон урт хугацааны зээл | 79,057,909 | 30,405,374 | 48,900,870 | 124,704,197 | 283,068,350 | 242,389,573 |
| Богино болон урт хугацаат түрээсийн өглөг | 118,443 | 335,330 | 763,004 | 1,720,356 | 2,937,133 | 2,286,324 |
| | **87,931,129** | **42,962,522** | **68,367,123** | **143,842,442** | **343,103,216** | **296,042,690** |

*2024 онд 2,697,480 мянган төгрөг, 2023 онд 4,549,593 мянган төгрөгийн татварын өглөг болон засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн нөлөө 2024 онд 961,404 мянган төгрөг, 2023 онд 1,178,689 мянган төгрөгийг оруулаагүй болно.







**30. Санхүүгийн хэрэглүүр ба санхүүгийн эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)**

**30.3 Зах зээлийн эрсдэл**

Зах зээлийн эрсдэл гэдэг нь зах зээлийн үнийн өөрчлөлт тухайлбал хүүгийн түвшин, гадаад валютын ханш өөрчлөгдсөнөөр Группийн ашиг эсвэл эзэмшиж буй санхүүгийн хэрэглүүрийн үнэлгээнд сөргөөр нөлөөлөх эрсдэл юм. Групп нь зээлийн хүүгийн эрсдэл, гадаад валютын эрсдэл гэсэн хоёр зах зээлийн эрсдэлд анхаарлаа хандуулдаг. Эдгээр эрсдэлийн зорилго, менежментийг доор авч үзнэ.

**30.3.1 Зээлийн хүүгийн эрсдэлийн удирдлага**

Групп тогтмол болон хувьсах хүүтэй зээлүүдтэй учраас зээлийн хүүгийн эрсдэлтэй байна. Мөнгөн гүйлгээний хүүгийн түвшний эрсдэл нь хувьсах хүүтэй зээлээс үүссэн ба бодит үнэ цэнийн хүүгийн түвшний эрсдэл нь тогтмол хүүтэй зээлээс үүсдэг. Энэхүү эрсдэлийг Групп тогтмол болон хувьсах хүүтэй зээлийн зохистой байдлыг хангах замаар удирддаг. Зээлийн хүүгийн эрсдэлийг удирдахдаа хейджинг хэрэглүүрийг ашигладаггүй.

Тайлант өдөр Группийн хүүтэй санхүүгийн хэрэглүүрийн хүүгийн байдал нь:

| | **2024** | **2023** |
|---|---|---|
| **Тогтмол хүүтэй хэрэглүүр** | | |
| Санхүүгийн хөрөнгө | - | - |
| Санхүүгийн өр төлбөр | (193,506,982) | (244,948,409) |
| **Хувьсах хүүтэй хэрэглүүр** | | |
| Санхүүгийн хөрөнгө | - | - |
| Санхүүгийн өр төлбөр | (82,304,785) | (41,033,234) |
| | **(275,811,767)** | **(285,981,643)** |

**Зээлийн хүүгийн мэдрэмжийн шинжилгээ**

Доор дурдсан мэдрэмжийн шинжилгээг тайлант хугацааны эцэст байгаа үүсмэл бус хэрэгслүүд дэх хүүгийн түвшний нөлөөллийг үндэслэн тодорхойлдог. Тайлант хугацаанд хувьсах хүүтэй хэрэглүүрийг тогтмол хүүтэй болгож өөрчилсөн буюу тайлант хугацааны эцэст хувьсах хүүтэй хэрэглүүр байхгүй тул зээлийн хүүгийн эрсдэл байхгүй гэж үзсэн. Гүйцэтгэх удирдлагын түвшинд хүүгийн түвшний эрсдэлийг үнэлэхдээ хүүгийн түвшний боломжит өөрчлөлтийг 50 пунктээр өснө/буурна гэж үзсэн.

Хэрэв бусад бүх хувьсах үзүүлэлт тогтмол байх үед хүүгийн түвшинг 50 пунктээр өсч/буурвал 2024 оны 12 дугаар сарын 31-нээрх татварын өмнөх ашиг 411,524 мянган төгрөгөөр өснө/буурна (2023 онд 205,166 мянган төгрөг).

**30.3.2 Гадаад валютын эрсдэлийн удирдлага**

Группд төгрөгөөс өөр валютаар үүссэн худалдан авалт болон төлбөртэй холбоотойгоор гадаад валютын ханшийн эрсдэл үүсдэг. Групп нь гадаад валютын эрсдэлийг гадаад валютын дериватив хэрэгслийг ашиглан хянадаггүй.

## 30. Санхүүгийн хэрэглүүр ба санхүүгийн эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)

### 30.3 Зах зээлийн эрсдэл (үргэлжлэл)

#### 30.3.2 Гадаад валютын эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)

Группийн гадаад валютаар үүссэн санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрийг тайлангийн өдрийн байдлаар төгрөгөөр үзүүлбэл дараах байдалтай байна:

| **2024 оны 12 сарын 31** | **Ам. доллар** | **Евро** | **Юань** | **Бусад** |
|---|---|---|---|---|
| Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө | 492,459 | 900,834 | 504,060 | 181,531 |
| Дансны болон бусад авлага | 466,602 | 3,869,175 | 972,669 | 12,235 |
| Дансны болон бусад өглөг | (30,911,177) | (4,455,433) | (109,368) | (33,371) |
| Богино болон урт хугацааны зээл | (93,556,081) | (86,760,348) | - | - |
| | **(123,508,197)** | **(86,445,772)** | **1,367,361** | **160,395** |

| **2023 оны 12 сарын 31** | **Ам. доллар** | **Евро** | **Юань** | **Бусад** |
|---|---|---|---|---|
| Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө | 195,211 | 1,809,930 | 1,482,746 | 247,357 |
| Дансны болон бусад авлага | 957,665 | 2,853,995 | 1,412,036 | 9,053 |
| Дансны болон бусад өглөг | (34,903,250) | (2,751,869) | (323,527) | (524,624) |
| Богино болон урт хугацааны зээл | (41,033,234) | (88,081,315) | - | - |
| Түрээсийн өр төлбөр | - | (1,631,568) | - | - |
| | **(74,783,608)** | **(87,800,827)** | **2,571,255** | **(268,214)** |

Тайлант жилийн туршид хэрэглэсэн валютын ханш:

| | **Дундаж ханш** | | **Тайлангийн өдрөөрх ханш** | |
|---|---|---|---|---|
| *(төгрөгөөр)* | **2024** | **2023** | **2024** | **2023** |
| Ам доллар | 3,390 | 3,466 | 3,420 | 3,466 |
| Евро | 3,668 | 3,747 | 3,564 | 3,792 |
| Юань | 471 | 490 | 469 | 480 |

**Гадаад валютын мэдрэмжийн шинжилгээ**

Группийн гадаад валютын ажил гүйлгээ нь ихэнхдээ америк доллар, евро, юань, фунт болон иен (хамтад нь "Гадаад валют" гэх)-аар хийгддэг. Дээрх валютуудтай харьцах төгрөгийн ханш 10%-аар өсөх/буурах үеийн мэдрэмжийг доорх хүснэгтэд харуулав. Гүйцэтгэх удирдлагын түвшинд гадаад валютын эрсдэлийг үнэлэхдээ дээрх 10%-ийн мэдрэмжийг ашигладаг ба энэ нь гадаад валютын ханш дахь удирдлагын үнэлж буй боломжит өөрчлөлтийг илэрхийлнэ. Энэхүү мэдрэмжийн шинжилгээ нь зөвхөн гадаад валютаар илэрхийлэгдсэн тайлант хугацааны эцэс дэх мөнгөн зүйлсэд гадаад валютын ханшийн 10%-ийн өөрчлөлтийн нөлөөллийг үзүүлсэн.

Нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлангийн өдрийн байдлаар төгрөгийн ханш 10%-аар чангарах нь татварын өмнөх ашгийг доор үзүүлсэн хэмжээгээр нэмэгдүүлнэ. Энэхүү шинжилгээнд бусад бүх хувьсах хүчин зүйлсийг тогтмол байна гэж үзсэн.





ГОВЬ ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
2024 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)

## 30. Санхүүгийн хэрэглүүр ба санхүүгийн эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)

### 30.3 Зах зээлийн эрсдэл (үргэлжлэл)

#### 30.3.2 Гадаад валютын эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)

| | **2024 татварын өмнөх ашиг, (алдагдал)** | | **2023 татварын өмнөх ашиг, (алдагдал)** | |
|---|---|---|---|---|
| | **Чангарах (10% өсөлт)** | **Сулрах (10% буурах)** | **Чангарах (10% өсөлт)** | **Сулрах (10% буурах)** |
| Ам доллар | 12,350,820 | (12,350,820) | 7,478,361 | (7,478,361) |
| Евро | 8,644,577 | (8,644,577) | 8,780,083 | (8,780,083) |
| Юань | (136,736) | 136,736 | (257,126) | 257,126 |
| Бусад | (16,039) | 16,039 | 26,821 | (26,821) |

Нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлангийн өдрийн байдлаар Группийн эзэмшиж буй гадаад валюттай харьцах төгрөгийн ханш 10%-аар сулрах нь бусад бүх хувьсах хүчин зүйлсийг тогтмол байна гэж үзсэн тохиолдолд дээрхи мөнгөн тэмдэгтүүдэд дээр дурдсан дүнтэй тэнцүү боловч эсрэгээр нөлөөлнө.

### 30.4 Санхүүгийн хэрэгслийн бодит үнэ цэнэ

Групп нь үнэлгээний техникүүдийг ашиглан санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийг тодорхойлох, толилуулахдаа дараах шатлалуудыг хэрэглэдэг. Үүнд:

Зэрэглэл 1: Ижил төрлийн хөрөнгө, өр төлбөрийн зах зээлийн жишиг үнэ дээр суурилна;

Зэрэглэл 2: Бодит үнэ цэнийн хэмжилтэнд мэдэгдэхүйц нөлөөтэй зах зээлийн хамгийн бага өгөгдлийг шууд болон шууд бус мэдээлэлд жишиж харьцуулах боломжгүй үнэлгээний арга;

Зэрэглэл 3: Бодит үнэ цэнийн хэмжилтэнд мэдэгдэхүйц нөлөөтэй зах зээлийн хамгийн бага өгөгдлийг шууд болон шууд бус мэдээлэлд жишиж харьцуулах боломжгүй үнэлгээний арга.

Групп нэгтгэсэн санхүүгийн тайланд бодит үнэ цэнээрээ тусгагдаагүй тэдгээр санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийг дараах байдлаар тодорхойлсон.

(i) Бодит үнэ цэнэ нь дансны үнэтэйгээ ойролцоо санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрүүд

Нэг жилээс доош хугацаанд төлөгдөх болон нөхөгдөх санхүүгийн хөрөнгө, өр төлбөрүүдийн бодит үнэ цэнэ нь тэдгээрийн дансны үнэтэйгээ ойролцоо гэж авч үзсэн.

(ii) Тогтмол хүүтэй санхүүгийн хэрэглүүр

Хорогдуулсан өртгөөр бүртгэсэн тогтмол хүүтэй санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн бодит үнэ цэнийг анх хүлээн зөвшөөрч бүртгэх үеийн зах зээлийн хүү болон ижил төстэй санхүүгийн хэрэглүүрийн одоогийн хүүг харьцуулж тодорхойлдог.

Группийн санхүүгийн хэрэглүүр нь бусад хорогдуулсан өртгөөр бүртгэсэн санхүүгийн хөрөнгө болон санхүүгийн өр төлбөрөөс бүрдэнэ.

Удирдлага нэгтгэсэн санхүүгийн тайланд тусгагдсан тэдгээр санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийн дансны үнэ нь бодит үнэ цэнэтэй ойролцоо гэж үзэж байна.

**ГОВЬ ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД**
**2024 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД**
**(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

## 30. Санхүүгийн хэрэглүүр ба санхүүгийн эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)

### 30.4 Санхүүгийн хэрэгслийн бодит үнэ цэнэ (үргэлжлэл)

Нэгтгэсэн санхүүгийн тайланд тусгагдсан санхүүгийн хөрөнгө болон санхүүгийн өр төлбөрийн бодит үнэ цэнэ нь дараах байдалтай байна:

| | 2024 | | 2023 | |
|---|---|---|---|---|
| | **Дансны үнэ** | **Бодит үнэ цэнэ** | **Дансны үнэ** | **Бодит үнэ цэнэ** |
| **Хорогдуулсан өртгөөр бүртгэсэн хөрөнгө** | | | | |
| Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө | 4,326,046 | 4,326,046 | 9,491,111 | 9,491,111 |
| Дансны болон бусад авлага | 7,522,743 | 7,522,743 | 6,672,251 | 6,672,251 |
| | **11,848,789** | **11,848,789** | **16,163,362** | **16,163,362** |
| **Хорогдуулсан өртгөөр бүртгэсэн өр төлбөр** | | | | |
| Дансны болон бусад өглөг | 34,208,928 | 34,208,928 | 33,155,118 | 33,155,118 |
| Богино болон урт хугацаат зээл | 247,475,887 | 247,475,887 | 242,389,573 | 242,389,573 |
| Богино болон урт хугацаат түрээсийн өглөг | 3,026,029 | 3,026,029 | 2,286,324 | 2,286,324 |
| Бусад урт хугацаат өглөг | - | - | 17,032,986 | 17,032,986 |
| | **284,710,844** | **284,710,844** | **294,864,001** | **294,864,001** |

## 31. Сегментийн мэдээлэл

Үйл ажиллагааны шийдвэр гаргагч Гүйцэтгэх захиралд нөөцийн хувиарлалт болон сегментийн үйл ажиллагааны гүйцэтгэлийг үнэлэхдээ борлуулалтын төрөл дээр тулгуурладаг тул үйл ажиллагааны ерөнхий чиглэл болох “Дотоод борлуулалт” болон “Гадаад борлуулалт”-ын борлуулалтын орлого болон борлуулсан бүтээгдэхүүний өртгийн мэдээллийг бүтээгдэхүүний төрлөөр гаргаж цэвэр ашгийн маржины мэдээллийг тайлагнадаг.

Группийн удирдлага худалдан авагчдын төрөл, байршил, борлуулалтын хүргэлт болон төрөлд үндэслэн борлуулалтын орлогыг “Дотоод борлуулалт”, “Гадаад борлуулалт /бөөний/” болон “Гадаад борлуулалт /онлайн/” гэсэн үйл ажиллагааны 3 сегментээр бүтээгдэхүүний төрлөөр ангилж, удирдлагын шинжилгээ болон шийдвэр гаргалтдаа ашигладаг.

Дээрх сегментээр ангилсан борлуулалтын орлого болон борлуулсан бүтээгдэхүүний өртгөөс бусад орлого болон зардлыг сегментээр ангилж тайлагнадаггүй. Үүнтэй адилаар, Группийн гол удирдлагын зүгээс тогтмол хяналтыг хэрэгжүүлж байгаа боловч хөрөнгө болон өр төлбөрийг сегментээр ангилж тайлагнахгүй байхаар шийдвэрлэсэн байна.



**ГОВЬ ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД**
**2024 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД**
**(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

## 31. Сегментийн мэдээлэл (үргэлжлэл)

### 31.1 Сегментийн орлого ба ашиг

| | | Сегментийн орлого | | Сегментийн ашиг | |
|---|---|---|---|---|---|
| | | **2024** | **2023** | **2024** | **2023** |
| Дотоод борлуулалт | Сүлжмэл бүтээгдэхүүн | 80,142,126 | 74,779,042 | 40,969,643 | 39,476,917 |
| | Оёмол бүтээгдэхүүн | 39,415,981 | 33,619,320 | 18,042,646 | 16,769,500 |
| | Нэхмэл бүтээгдэхүүн | 38,054,927 | 32,291,323 | 18,804,465 | 15,675,431 |
| | Үйлчилгээний орлого | 1,695,077 | 2,002,583 | (40,799) | 297,753 |
| | Бусад | 4,050,699 | 4,304,406 | 6,628 | (52,857) |
| | | 163,358,810 | 146,996,674 | 77,782,583 | 72,166,744 |
| Гадаад/бөөний борлуулалт | Сүлжмэл бүтээгдэхүүн | 46,019,962 | 45,664,430 | 10,624,146 | 14,590,379 |
| | Оёмол бүтээгдэхүүн | 4,515,679 | 4,136,844 | 1,090,509 | 1,220,470 |
| | Нэхмэл бүтээгдэхүүн | 6,294,525 | 7,594,053 | 1,943,890 | 2,147,805 |
| | Бусад | 1,104,131 | 2,089,427 | 768,803 | 1,302,926 |
| | | 57,934,297 | 59,484,754 | 14,427,348 | 19,261,580 |
| Гадаад борлуулалт /онлайн/ | Сүлжмэл бүтээгдэхүүн | 21,294,266 | 40,494,554 | 13,747,923 | 28,027,768 |
| | Оёмол бүтээгдэхүүн | 2,423,259 | 4,091,370 | 1,132,881 | 2,075,184 |
| | Нэхмэл бүтээгдэхүүн | 1,998,268 | 4,543,578 | 1,384,801 | 3,115,043 |
| | Бусад | 17,417 | 39,586 | (1,560) | (7,148) |
| | | 25,733,210 | 49,169,088 | 16,264,045 | 33,210,847 |
| | | **247,026,317** | **255,650,516** | **108,473,976** | **124,639,171** |
| Бусад орлого | | | | 3,649,691 | 6,525,518 |
| Борлуулалт ба маркетингийн зардал | | | | (53,217,129) | (73,593,361) |
| Ерөнхий ба удирдлагын зардал | | | | (24,908,151) | (19,733,240) |
| Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын буцаалт | | | | - | 9,266 |
| Бусад зардал | | | | (6,919,419) | (6,980) |
| Санхүүгийн орлого | | | | 4,465,583 | 229,734 |
| Санхүүгийн зардал | | | | (33,118,100) | (38,046,985) |
| **Татварын өмнөх алдагдал** | | | | **(1,573,549)** | **23,123** |

2024 болон 2023 оны Группийн орлогын 10% ба түүнээс дээш хувийг дангаараа бүрдүүлсэн харилцагч байгаагүй.

**ГОВЬ ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД**
**2024 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД**
**(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

## 31. Сегментийн мэдээлэл (үргэлжлэл)

### 31.2 Газарзүйн мэдээлэл

Групп ноолууран бүтээгдэхүүнийг доорх газарзүйн байршил дахь худалдан авагчдад борлуулсан:

| | Харилцагчийн орлого | | Эргэлтийн бус хөрөнгө | |
|---|---|---|---|---|
| | 2024 | 2023 | 2024 | 2023 |
| Монгол улс | 163,358,810 | 147,064,251 | 157,231,518 | 118,606,628 |
| Ази, номхон далайн орнууд | 29,007,298 | 31,232,077 | 58,295 | 78,937 |
| Европын орнууд | 43,691,315 | 58,477,783 | 3,374,265 | 3,081,221 |
| Оросын Холбооны Улс | 1,200,745 | 1,429,718 | - | - |
| Хойд Америкийн улсууд | 9,768,149 | 17,386,232 | 806 | 5,038 |
| Австрали, Шинэ Зеланд | - | 60,455 | - | - |
| | 247,026,317 | 255,650,516 | 160,664,884 | 121,771,824 |

Дээрх хүснэгт нь гадаад зах зээлд хийгдсэн борлуулалтыг борлуулалт хийгдсэн газарзүйн байршлаар үзүүлсэн бөгөөд мөн эргэлтийн бус хөрөнгийн байршин буй газар зүйн байршлаар харуулсан.

Эргэлтийн бус хөрөнгөнд хойшлогдсон татварын хөрөнгө багтаагүй болно.

## 32. Капиталын эрсдэлийн удирдлага

Групп тасралтгүй үйл ажиллагаа явуулах зорилгоор өөрийн капиталыг удирдахын зэрэгцээ хувьцаа эзэмшигчийн өгөөжийг өндөр түвшинд байлгахын тулд зээл болон өөрийн хөрөнгийн харьцааг оновчтой байлгахыг зорьдог.

Группийн капиталын бүтэц нь цэвэр зээл (зээлээс мөнгөн хөрөнгийг хассан) ба өөрийн хөрөнгөөс бүрдэх бөгөөд өөрийн хөрөнгө нь дүрмийн сан, нөөц ба хуримтлагдсан ашгаас тус тус бүрддэг.

## 33. Гэрээний үүрэг

Групп 2024 болон 2023 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар гэрээгээр хүлээсэн томоохон үүрэг байхгүй.

## 34. Тайлангийн дараах үйл явдал

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 03 тоот тогтоолоор 2024 онд ногдол ашиг зарлахгүй гэж шийдвэрлэсэн.

## 35. Тайлангийн орчуулга

Эдгээр санхүүгийн тайлангуудыг Англи хэл дээр мөн бэлтгэсэн болно. Монгол, Англи хувиудын хооронд утга, агуулгын зөрүү гарах тохиолдолд Англи хэл дээрхи хувилбарыг баримтална.

67



# ДЭЛГҮҮРИЙН БАЙРШИЛ

## МОНГОЛ ДАХЬ ДЭЛГҮҮРҮҮДИЙН БАЙРШИЛ

**ҮЙЛДВЭРИЙН ДЭРГЭДЭХ ТӨВ ДЭЛГҮҮР**
Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, Чингисийн өргөн чөлөө, Үйлдвэрийн гудамж
Утас: 7004 8888

**ГАЛЛЕРИА УЛААНБААТАР САЛБАР**
Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Засгийн газрын ордны зүүн талд
Утас: 7004 8888

**ДАРХАН ХОТ САЛБАР**
Дархан хот, Шинэ Дархан Олон Улсын Худалдааны Төв
Утас: 9505 6656, 9937 6775

**ЧИНГИС ХААН ОЛОН УЛСЫН НИСЭХ БУУДЛЫН САЛБАР** /2025 оны 3-р сараас/
Чингис хаан олон улсын нисэх буудал, 2-р давхар, Зорчигчдын хүлээлгийн танхим
Утас: 7004 8888

## ГАДААД ДАХЬ ДЭЛГҮҮРҮҮДИЙН БАЙРШИЛ

### САЛБАР ДЭЛГҮҮРҮҮД

**BERLIN, GERMANY**
GOBI MONGOLIAN CASHMERE
Knesebeckstr.30, Berlin, Germany
www.gobicashmere.com/de
+49 (0)30 224 66510

**DÜSSELDORF, GERMANY**
GOBI MONGOLIAN CASHMERE
Grünstr.6, 40212 Düsseldorf, Germany
www.gobicashmere.com/de
+49 211 73288348

### ФРАНЧАЙЗ ДЭЛГҮҮРҮҮД

**ANKARA, TURKEY**
Beştepe mahallesi dumlupınar bulvarı b blok 6/136 söğütözü ankara
info@gobi.com.tr,
www.gobi.com.tr

**ISTANBUL, TURKEY**
MONGOLIAN CASHMERE GOBI
Ayazağa mahallesi Azerbaycan caddesi no:3j/7 Vadistanbul avm Sarıyer İstanbul
www.gobi.com.tr

**ISTANBUL, TURKEY**
Kanyon Avm Esentepe mahallesi büyükdere caddesi G kat no:185/124 Şişli İstanbul
www.gobi.com.tr

**TOKYO, JAPAN**
GOBI MONGOLIAN CASHMERE
Haneda Airport , 7 Terminal, Market place 4F
www.tokyo-haneda.com/en/

**SEOUL, SOUTH KOREA**
GOBI CASHMERE
Gobi store,130, Apgujeong-ro, Gangnam-gu,
Seoul, Republic of Korea
+02 518 0525
www.gobikorea.co.kr

**PUSAN, SOUTH KOREA**
GOBI CASHMERE
#2069, Punpo road 745, Nam-gu, Pusan, Korea
www.gobikorea.co.kr

**ILSAN, SOUTH KOREA**
GOBI CASHMERE
4th floor Lotte Department store, 1283, Jungang-ro, Ilsandong-gu, Goyang-si, Gyeonggi-do, Republic of Korea
www.gobikorea.co.kr

**DAEGU, SOUTH KOREA**
GOBI CASHMERE
17 48, Dalgubeol-daero,
Dalseo-gu, Daegu, Republic of Korea
www.gobikorea.co.kr

GOBI

“ГОВЬ” ХК,
ҮЙЛДВЭРИЙН ГУДАМЖ, 3-Р ХОРОО, ХАН-УУЛ ДҮҮРЭГ,
УЛААНБААТАР-17062, МОНГОЛ УЛС, Ш/Х 36/434

УТАС: +976 7013-9977, ФАКС: +976 7014-3081
И-МЭЙЛ: INFO@GOBI.MN